

БАТЛАН ХАМГААЛАХЫН ЭРДЭМ  
ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН  
ЖЕНЕВ ДЭХ ЗЭВСЭГТ ХҮЧИНД АРДЧИЛСАН  
ХЯНАЛТ ТАВИХ ТӨВ

**МОНГОЛЫН ЦЭРГИЙН  
ШИНЭЧЛЭЛ - АРДЧИЛСАН ИРГЭНИЙ  
ХЯНАЛТ**

*Редактор: Профессор Ш.Паламдорж*

Женев - Улаанбаатар

*Батлан Хамгаалахын Эрдэм Шинжилгээний  
Хүрээлэнгийн Цэрэг - Иргэний Харилцааны  
Судалгааны төвд эмхтгэв.*

*Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: Г.Ханджав*

*2003 он*

## ӨМНӨХ ҮГ

Ардчиллыг шинээр болон сэргээн хөгжүүлж буй орнуудын хувьд Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих асуудал бол онолын хувьд ээдрээтэй, практикийн хувьд бэрхшээлтэй, анхаарал татсан асуудал бөгөөд түүнийг амжилттай шийдвэрлэснээр иргэний, ардчилсан нийгэм төлөвшүүлэх, хөгжүүлэх туйлын зорилтод чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсын Зэвсэгт хүчин хэдийгээр том арми биш ч түүний монголын нийгэмд гүйцэтгэж ирсэн түүхэн уламжлал арвин, ард түмэнтэйгээ хүйн холбоотой, өнөө үеийн ойлголтоор иргэний болон ардчилсан хяналт эрт дээр үеэс хэлбэржиж байсан туршлагатай юм.

Иймээс Женев дэх Зэвсэгт хүчинд ардчилсан хяналт тавих олон улсын төв, пост коммунизмын орнууд дотроос Монголын Зэвсэгт хүчний шинэчлэл, түүнд ардчилсан хяналт тавих талаар хийж буй практик алхмуудыг сонирхож, Монголын Батлан хамгаалахын Эрдэм шинжилгээний хүрээлэнтэй хамтран ажиллаж энэ номыг гаргахаар шийдсэн юм.

Номын агуулгад оруулбал зохимжтой гэж үзсэн асуудлыг Женев дэх олон улсын төв гаргаж, дээрх хүрээлэнгийн судлаачид уг асуудлыг бүлэглэн, логик дараалалд оруулан бичсэн юм.

Номын агуулга дахь цэргийн шинэчлэл, ардчилсан хяналтын талаархи асуудлыг судлаачид өөр, өөрсдийн үнэлгээ, дүгнэлтээр гаргасан тул Монголын талын албан ёсны байр суурийг бүрэн томъёолоогүй, учир шалтгаанд тайлбар хийгээгүй болохыг тэмдэглэж байна.

Гэхдээ Монголын нийгэм дэх Зэвсэгт хүчний дүр төрх, шинэчлэлийн явц, үр дүн, нийгэм, улс төр, эдийн засгийн нөхцөл байдал, бэрхшээл, түүнд ардчилсан хяналтыг тавих эрх зүйн болон гадаад, дотоод орчин нөхцлийг ойлгомжтой гаргасан юм.

Хамтран гаргаж буй энэ ном, ардчиллыг шинээр болон сэргээн хөгжүүлж буй орон болон асуудлыг судлагч хэн бүхэнд танин мэдэхүйн болон сурталчилгааны ашиг тустай гэж үзэж байна.

Редактор

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.  
**МОНГОЛЫН ЦЭРЭГ - ИРГЭНИЙ ХАРИЛЦААНЫ  
ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ**

*Ph.D. Х.Шагдар*  
/БХЭШХ-ийн эрдэм  
шинжилгээний тэргүүлэх  
ажилтан/

Цэрэг ба иргэний гүн бат холбоо нь дайнд ялахын зайлшгүй нэгэн үндэс, дайны гүн ухааны мөнхийн сэдэв юм.

Нийгмийн бүлгүүд хоорондоо хямралтай буюу цэрэг иргэдийн санал сэтгэл зөрөөтэй, зэвсэгт хүчин ба ард түмний зорилго нэгдээгүй үед дайнд мордвол ялагдана гэж эртний хаад, жанжид үзэж цэрэг, иргэний холбоонд гоц анхаарал тавьдаг байжээ. Чингис хаан: “Цэргүүд ээ! Энх цагт энэрэл өршөөлийг гол болгон ард түмэнд догшин ааш, доромжлох авир гаргахыг чанга цээрлэгтүн” [2. 40] хэмээн зарлигдаж байжээ.

Монголын Юан гүрний (1260-1368) эзэн хаан, Чингис хааны ач Хубилай хаан цэрэг, иргэний харилцаанд гойд анхаардаг байв. Тэрбээр “Цэрэг захирагч жанжин нар иргэнийг басамжилж, тариа ба гэрийн аливаа юмыг авсан бөгөөс эзэн эзэнд нь буцааж өг!” хэмээн хатуу зарлиг буулгаж байжээ.

Энэ бүх цэрэг-иргэний харилцаа нь:

- 1/ Цэрэг арми үүсэхтэй хамт эхэлсэн асар урт хугацааны түүхтэй асуудал;
- 2/ Дайны гүн ухааны амин чухал мөнхийн сэдэв гэдгийг баталж байдаг юм.

Улс үндэстнүүдийн нийгэм, соёл иргэншлийн өвөрмөц онцлогоос хамаарч цэрэг-иргэний харилцаа нь улс бүхэнд өөр өөрийн замыг туулж ирсэн нь мэдээж юм. Түүхийг сөхөн үзвэл, асар уудам нутаг, хүн ам цөөн, нүүдлийн соёл иргэншилтэй монголчуудын хувьд энэ харилцаа үүсэн бүрэлдэж, хөгжиж ирсэн түүх нь өвөрмөц онцлогтой байжээ. Үүнд:

1. АТӨ III зууны монголчуудын Хүннү гүрнээс

авахуулаад эртний монголчуудын насанд хүрсэн эр бүр цэргийн үүрэгтэн байв. “Нуган (эр) үр нутгаа сахих ёстой” гэсэн бичигдээгүй хууль, ёс заншил ард түмэнд үйлчилж байв. Эрэгтэй хүүхдийг эцэг эх нь цэргийн үүрэгтнээр тооцож түүнийг хар багаас нь цэрэгт бэлтгэнэ. Монголд ирж, XIII зууны монголчуудын амьдралыг нүдээр үзэж түүхэн сурвалж бичиж үлдээсэн европын анхны хүн Плано Карпини: “Хүүхдээ хоёр, гурван нас хүрмэгц морь унуулан давхиулж сургах ба биед нь таарсан хавчаахай нум бариулан харвуулж сургадаг” [3. 216] хэмээн бичсэн буй. Ийнхүү тэрбээр 17-60 насны хооронд цэргийн данслагдсан үүрэгтэн байдаг байлаа. Бэлчээр хөөж нүүдэллэн, цөөнөөр амьдардаг монголчуудын хувьд ийм байхаас өөр аргагүй байснаас энэ нь ямарч шахалт шаардлагагүй бөгөөд ерөөс уламжлал, заншил болсон үйл хэрэг байв. Тэр ч байтугай эмэгтэйчүүд ч цэргийн үүрэгтэн байв. “Охид хүүхнүүд нь морь унан давхихдаа эрчүүдээсээ дутахгүй. Тэд мөн л эрчүүд шигээ нум сум агсана” гэж Плано Карпини тэмдэглэсэн байдаг. Дундад зууны хятадын сурвалж бичигт: “Цэрэглэхэд ч дээд, доорд гэхгүй ихэнх нь эхнэр хүүхдээ авч явна. Эмэгтэйчүүдэд хувцас хучлага ба эд таваарын хэргийг хариуцуулна. Бас гэр барих ба ачаа хөсгийн явдлыг хариуцуулна” хэмээн монголчуудын тухай тэмдэглэсэн бий. Энэ үүргийг нь Чингис хааны үед бүр хуульчилж, “Их засаг” хуульд: “Цэргийг дагаж яваа бүсгүйчүүдийн эрс нь байлдаанд орвол тэдгээр бүсгүйчүүд эрийнхээ ажлыг орлон хийж, албан тушаалыг нь гүйцэтгэх хэрэгтэй” [1. 41] гэж заасан байна.

**Энэ бүхнээс үзвэл эртний монголчуудад иргэн ба цэргийн зааг ялгаа бараг байсангүй**, монгол хүн хэн боловч уурга бариад мордвол адуучин – малчин, жад бариад мордвол цэрэг дайчин болдог байжээ.

2. Бүх нийтээр цэргийн үүрэгтэн учраас эртний монголчуудын цэргийн боловсрол нь бүх хүн амыг хамарсан, сургалтын тогтолцоотой байв.

Нум сум, жад, сэлэм зэрэг нь эртний монголчуудын байлдааны зэвсэг төдийгүй ан гөрөө хийж, хоол хүнс, дээл хувцсаа бэлтгэх амьдралын хэрэгсэл байсан юм. Хүүхдээ өсөөд ирэхэд аав нь ан гөрөөнд дагуулж, харайж яваа

амьтаныг морины давхиан дундаас харваж сургана. Хүүхэд хөгшид, эр эм гэхгүйгээр нум сум харваж, цэцээ тогтоон дадлагажих нь амьдралын хэрэгцээ байж, тийм урсгал атлаа байнгын бие даасан дадлага сургууль хэний ч шахалт шаардлагагүйгээр явж байжээ. Ийм нөхцөлд төрийн үүрэг нь хүн бүрийг хэрэгцээт зэвсгээр хангахад л оршиж байв.

Ав хомрого бол оператив, тактикийн ажиллагаа боловсруулах цэргийн маневр, цэрэг иргэний хүнс бэлтгэлийн арга, нийтийн зугаа цэнгэлийг хослуулж монгол ахуйгаас урган гарсан өвөрмөц үйл байв. Ав хомрогын энэхүү олон талын ач холбогдлыг Чингис хаан өндрөөр үнэлж “Агнаж гөрөөлөх бол цэргийн дарга ноён бологсдын гүйцэтгэвээс зохих үүрэг мөн. Ав хийх явцад ачтай тустай их юм сурч боловсрох нь цэргийн хүний заавал биелүүлэх хариуцлага мөн. Анчин хүн араатныг хэрхэн дагаж, хэрхэн барьж байгаа, жагсаалаа яаж жагсааж, хүнийхээ олон цөөнийг үзэж, хэрхэн хомроглож байгааг сурч мэдэх хэрэгтэй” хэмээн сургажээ.

Нум сум харвах, морь уралдах, бөх барилдах буюу монголчуудын эрийн гурван наадам нь бүх нийтийн цэргийн бэлтгэлийн хэлбэр юм. Цэргийн бэлтгэлийг ийнхүү тоглоом наадам, зугаа цэнгэлтэй холбож, үндэсний бахархал, баяр цэнгэл болгосон нь эртний монгол өвгөдийн ухаан билгийн гайхамшиг байжээ.

Ард түмний сайн дурын энэхүү сургалтыг төрөөс сорьж үзэж мэргэн харваачдын тэмцээнийг үе үе зохионо. 1225 оны үед ийм тэмцээнд Есүнгэ мэргэн 500 гаруй метр харвасан нь түүхэнд тодорхой үлдсэн байна. Хятадаас 1221 онд монголд ирсэн элч Жао Хуны тэмдэглэснээр Чингис хааны жанжид “өөрийн цэргээ ах дүү мэт сургадаг” байжээ. Чингис хаан жил бүр ноёдынхоо тайланг авч, цэргийн сургалтын байдлыг хянадаг байжээ.

Ийнхүү нүүдэлч монголын амьдрал, ахуйн онцлогоос шалтгаалан иргэний цэргийн боловсролын асуудлыг эртний монголчууд төсөр хялбар шийдэж байжээ.

3. Эртний монголчуудын цэрэг, засаг захиргааны зохион байгуулалт нь дорно дахины уламжлалт “хүрээ”-ний

болон “аравтын” зохион байгуулалт байсан юм.

“Хүрээ” гэдэг нь нэгэн овог угсаатны нэгдэл бөгөөд ойролцоогоор 1000 орчим хүнтэй, засаг захиргааны болон цэргийн зохион байгуулалтын нэгж юм. “Аравтын” систем нь аравт, зуут, мянгат, түмтийн (10.000 хүн) ноёд (дарга)-оос бүрдэх бөгөөд тухайн нэгжийн дарга нь өөрийн нэгжийн зэвсэг, уналга, хүнс, хувцасны асуудлыг өөрсдөө дотроо шийднэ. Чингис хааны “Их засаг” хуульд энэ үүргийг хуульчилж “Дайны үед өтгөс залуус, эрхэм доорд ялгалгүй байлдагч болж дайнд оролцох хэрэгтэй. Хүн бүрийн хэрэглэх аливаа зэр зэвсэг ба уналга морь, ачаа хөсгийг хүртэл аравт, зуутаар хувилан өгөх хэрэгтэй бөгөөд цэрэг цуглаж шалган үзэх тэр өдөр цэргийн хэрэгсэл бүхнээ авч гарах хэрэгтэй. Хэрэв бага ч болов дутаж эвдэрсэн аваас хариуцах хүнийг хүндээр яллах хэрэгтэй” [1. 41] хэмээн заасан байна. Ийнхүү иргэн бүр байлдааны цагт цэрэг, тайван цагт малчин хоёрдмол үүргийг толгой даан хариуцаж гүйцэтгэдэг байв.

Тодруулан хэлбэл, өнөөгийн адил цэргийн хангалтын асуудлыг иргэд даадаг байсангүй, цэрэг-иргэн хоёр нь гарын ар, өвөр мэт нэгдмэл байв.

Ийнхүү: 1/ Цэргийн үүрэг, 2/ Цэргийн сургалт, 3/ Цэргийн бүх төрлийн хангалт гурвуул бүх нийтийн бөгөөд нэгдмэл байсан энэхүү онцлогийг нэг талаас нь харвал, **цэрэг-иргэний харилцааны сонгодог хэлбэр эртний монголд байжээ** гэж үзэх боломжийг олгож байна. Нөгөө талаас, орчин үеийн цэрэг, иргэний харилцааг боловсронгуй болгох асуудал нь эртний монголынхтой төстэй, цэргийн үүрэгтэн бүр иргэн ч байх, цэрэг ч байх хэлбэр агуулгын эрэл хайгуул болно гэж хэлэх үндэстэй байна.

Монгол орны нөхцөлд цэрэг-иргэний харилцааны тухай асуудал нь: **нэгд:** Монголд байнгын арми буй болсон цагаас; **хоёрт:** арми зохион байгуулагдан дайн байлдаанд мордсон ийм хоёр нөхцөлд **хурцаар товойн гарч** байжээ.

Монголын түүхэнд **байнгын армийн зарим шинжийг хадгалсан** цэрэг байгуулсан нь **нэгд:** XIII зууны эхээр Чингис хааны үед; **хоёрт:** XIX зууны эхээр Олноо өргөгдсөн Монгол



улсын (1911-1921) үед тохиожээ.

**Нэгд:** Чингис хаан 1206 онд Их Монгол улсыг байгуулан тунхаглаад ард түмэн, цэрэг армия зохион байгуулахдаа цэрэг, засаг захиргааны овгийн байгууллаас улбаатай “хүрээ”-ний зохион байгуулалтыг бүрмөсөн таягдан хаясан төдийгүй эртний дорно дахин ба монголд байсан “аравтын” тогтолцоонд өөрийн шинэчлэлийг оруулсан юм. Энэ нь:

- ❖ 10.000 хүнээс бүрдсэн “Хишигтэн” хэмээх цэргийг байгуулав. “Хишигтэн”-г албадлагын ба сайн дурын журмаар бүрдүүлэх бөгөөд тэдний уналга, хүнс, хувцас тэргүүтнийг гадаад мянгатуудаас татварлан авна. Тэд бусад мянганаас илүү эрх дарх эдэлнэ, зэвсгээрээ төрөлжин нэгдэж, хааны зарлиг-цэргийн дүрмээр алба хаана. Хааны дэргэд байнга байрлаж, байлдааны байнгын бэлэн байдалд байж хааны бие ба ордыг хамгаалах үүрэг гүйцэтгэнэ.

Тиймээс хишигтэн нь, тухайн үедээ байнгын армийн зарим шинжийг хадгалсан цэрэг байсан юм. “Хишигтэн” буюу “байнгын арми” байгуулсан цагаас Чингис хаанд хишигтэн ба бусад цэрэг, иргэдийн харилцааны асуудалд анхаарал тавих шинэ шаардлага тулгарсан нь түүхэн баримтуудаас илт байдаг. Энэ нөхцөлд Чингис хаан юуны өмнө “байнгын арми”-ийнхаа нэр хүндийг өргөх арга хэмжээ авч “гадаад мянганы” буюу цэрэг, иргэдийн ноёдоос миний хишигтэн эрхэм бөгөөд гадаад мянганы ноёд (захирагч) миний хишигтэнтэй тэнцэж хэрэлдвэл мянганы ноёныг шийтгэ” [5. 199] гэсэн хууль гаргажээ. “Гадаад мянган” нь дайчилгаа зарласан цагт аравт, зуут, мянгатаараа байлдааны бүрэн бэлэн байдалтай цуглаж, байлдааны үүрэг гүйцэтгэх зориулалттай иргэд юм. Энэ үзэгдэл нь байнгын цэрэг байгуулмагц цэрэг, иргэний харилцааг зохицуулах шаардлага яах аргагүй гардаг бөгөөд тус харилцааг зохицуулахад юуны өмнө төрийн хүчтэй нударга (хууль, цааз) хэрэгтэй болсныг харуулж байна.

- ❖ Их Монгол улсаа Чингис хаан цэрэг-засаг захиргааны аравтын тогтолцоонд шилжүүлж, цэрэг эр нэг аравтаас нөгөө аравтад шилжих болон тухайн аравт, зуут, мянгатын ноёд нөгөөгөөс цэрэг

элсүүлэн авахыг хорьж, өөрийн аравт, зуут, мянгатын бүх төрлийн хангалт, байлдааны бэлэн байдлын бүхий л асуудлыг тухайн нэгжийн захирагч бүрэн хариуцах хатуу үүрэг ногдуулсан юм. Доод нэгжийн захирагч нь дээд нэгжийн захирагчдаа үг дуугүй захирагдах болгож, цэргийн нэгдмэл, цомхон удирдлагын тогтолцоог бүрдүүлэв. Ингэж Чингис хаан цэргийн үүрэг, сургалт, бүх төрлийн хангалт гурвыг мөн л иргэнтэй холбон нэгтгэснээс гадна цэрэг, иргэний хариуцлагыг дороос дээш, дээрээс доош хүлээх босоо үзүүртэй нэг шугамд холбосон юм.

Чингис хааны энэ шинэчлэл нь Их Монгол улсыг бүхэлд нь дайны лагерь болгон хувиргасан бөгөөд энэ нь түүний гадаадад хийсэн дайны ялалт амжилтын нэгэн гол эх сурвалж болсон байна. Цэрэг, иргэний харилцааны ийм нэгдмэл чанар нь тухайн цаг үед улс орныхоо аюулгүй байдлыг хангах шилдэг арга болж байжээ.

Хорьдугаар зуунд Герман орныг Гитлер дайны лагерь болгон хувиргаснаас XIII зуунд Монголыг дайны лагерь болгосон Чингис хааны арга нь өмнөө тавьсан зорилгоор өөр бөгөөд амьдрах чадвар, уян хатан чанараараа илт илүү, тухайн үеийн монголын хөрснөөс ургасан “ургац” байжээ.

- ❖ Эртний монголын Хүннү гүрэн нутгаа баруун, зүүн гар ба төв гэсэн гурван бүс нутагт хуваан хамгаалж сахидаг байв. Хожим Чингис хаан нутгаа баруун, төв, зүүн, ойн хэмээх дөрвөн бүст хувааж шилдэг дөрвөн жанжнаар захируулсан юм. Энэ нь бүсийн тоог нэмсэн төдий өөрчлөлт бус байлаа. Тэрбээр эдгээр бүс нутгийн иргэд ба армийг бүсээсээ халин нүүхийг хорьж, тэр газартай нь хадаж өгсөн нь чухал шинэчлэл байсан бөгөөд үүнийг өнөөгийн ойлгоцоор үзвэл “Орон нутгийн тогтолцоо” гэж хэлж болох юм.

Өнөөгийн Монгол Улсын төр засгаас дэвшүүлээд байгаа монголын бүсчилсэн хөгжлийн бодлого нь мөн чанартаа Чингис хааны бүсчлэлийн суурьтай тохирч байгаа

бөгөөд төрийн цэргийн бодлогод орж ирж байгаа “Батлан хамгаалах орон нутгийн тогтолцоо” гэдэг нэр томъёоны хэлбэр, агуулга нь Чингис хааны дээрх 4 бүсийн “Орон нутгийн тогтолцоо”-ны хөрсөн дээр буух юм.

Цэргийг ийнхүү бүсчлэн орон нутагт суулгах нь:

- Цэргийг татах ба халах, хүнс, хувцасны зэрэг цэргийн хангалтуудыг зохион байгуулах, цэргийг шаардлагатай чиглэлд татан шилжүүлэх зэрэг олон төрлийн ажилд арми зардал чирэгдэл багатай байх;

- Тухайн бүсэд шаардлагатай үед байлдааны үүрэг гүйцэтгэх үүрэгтэй цэрэг эрс бүсийнхээ цаг уурт дасан зохицох ба газар орноо сайтар судлан мэдэх;

- Мөн тухайн бүсийн цэрэг нь нутгийн иргэд ард түмнийхээ дунд байж тэдэнтэй улс төр, эдийн засаг, нийгмийн тал бүрийн харилцаанд орж, харилцан туслалцаж, цэрэг-иргэний харилцааг ойртуулах болон түүнийг зөв голдирлоор хөгжүүлэхэд онцгой ач тустай юм.

Дүгнэн үзвэл, XIII зууны Монгол оронд анхдагч илрэлээ олж гарч ирсэн цэрэг, иргэний харилцааны асуудлыг Чингис хаан шийдэхдээ:

- 1/ Төрийн хууль цаазаар зохицуулах;
- 2/ Засаг захиргаа, цэргийн зохион байгуулалтын системийг нэгтгэх;
- 3/ Орон нутгийн цэргийн тогтолцоог бүрдүүлэх замаар зохицуулан шийдэж байсан бөгөөд энэ нь тухайн цаг үе, монгол орны нөхцөлд дээд зэргээр тохирсон арга байжээ гэсэн дүгнэлт гарч байна.

**Хоёрт:** Богд хаант Монгол Улс буюу Олноо өргөгдсөн Монгол улс (1911-1921)-ын үед цэрэг, иргэний харилцааны асуудал дахин тодорч ирсэн юм. Түүхээс үзвэл, Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яамны шийдвэрээр 1912 онд Түшээт хан, Сэцэн хан хоёр аймгаас тус бүр 1500 цэрэг татаж, аймгийн цэргийг тус бүр 3 хороо болгон зохион байгуулжээ. Цэргийн боловсон хүчин бэлтгэхийн тулд

Хужирбуланд бага даргын сургууль нээжээ. Тиймээс олноо өргөгдсөн Монгол улсын цэрэг нь байнгын цэрэг байсан юм. Үүнээс өмнөх манжийн захиргааны үед монголд байнгын цэрэг байгаагүй бөгөөд монголчуудыг цэргийн албан хаагч хэмээн тооцож дайчилгааны үед өөрийн уналга, зэвсэг хэрэглэн, нутаг дэвсгэрийн шинжээр байгуулсан тусгай отрядуудад хувааж тэдгээрийг аравт, зуут, мянгатын дарга нар баг, сум, аймгийн эрэмбээр захиран даргалдаг байжээ.

Байнгын цэрэг байгуулмагц Богд хаанд цэрэг, иргэний харилцааг зохицуулах шаардлага тулгарчээ. Ийм нөхцөлд Богд хаан:

1/ Чингис хааны адил төрийн хууль, цаазаар зохицуулах арга хэмжээ авчээ. Энэ нь Богд хааны “Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг” хэмээх хуульд дараахь заалт оруулснаар илэрч байна. Үүнд: Алдар цол, албан тушаал харгалзахгүйгээр цэргийн үүрэгтэн байх ёстойг тунхаглаж, “аливаа, засаг, ван, бэйл, бэйс, гүн, тайж нар цэрэгт яваагүй бол зэргийг нь эвдэж, цэрэгт илгээ” гээд хэрвээ тэд болзооны газар хоцорч ирвэл хоцорсон хоногийн тоог харгалзан цалингий нь хасч шийтгэхээр заажээ. Түүнчлэн “Түшмэлүүд цэрэгт нийлүүлэн өгвөл зохих цэргийн зэвсэг, цалин, аму зэрэг зүйлийг хүргэхэд тогтоосон өдрийг зөрчиж алгуурлаваас (хоцроовоос-Х.Ш) аливааг (хэн ч байсан-Х.Ш) 100 ташуур жанч! Саатуулсан хүнийг ялла!” хэмээн зааж байснаас тодорхой байна.

2/ Насанд хүрсэн эр хүн бүр цэргийн үүрэгтэн байх Чингис хааны аргыг цэрэг-засаг захиргааны зохион байгуулалтын нэгдлээр хангахыг Богд хаан бас чармайжээ.

Богд хаан улсаа 119 хошуунд хуваасан бөгөөд энэ нь цэрэг-засаг захиргааны нэгдмэл нэгжийн хэлбэртэй, хошууны захирагч цэргийн хэргийг голлон хариуцдаг байв. Хошуу захирагч нь хошуунаас мордох цэргийн тоог гаргаж, тэдгээрийн хэрэглэх гэр орон, дээл олбог, хуяг зэвсэг, морь уналгыг яв цав бэлэн байлгах тухай дээрх хуулинд заалт буй.

3/ Хошууны доорхи засаг-захиргааны нэгж нь 150 цэрэг гаргах үүрэг бүхий сум, сумын доорхи анхан шатны

нэгж нь арван гэр бөгөөд энэ нь 3 эрийг цэрэгт мордуулах үүрэг хүлээх юм.

Хошуу бүр жил тутам зохих тооны цэрэг дайчлан сургуулилдаг байв.

Энэ бүхнээс үзвэл, цэрэг-иргэний харилцааг зохистой шийдвэрлэх асуудлыг Богд хаан:

1/ Төрийн хуулиар зохицуулах;

2/ Засаг захиргаа-цэргийн зохион байгуулалтын системийг Чингис хааны үе шиг бүрэн нэгтгэж чадаагүй, тийм нөхцөл боломж байгаагүй ч гэсэн тэр тогтолцоонд ойртуулсан;

3/ Орон нутгийн цэргийн тогтолцоог бүрдүүлэх замаар зохицуулан шийдэж байжээ.

Чингис хаан, Богд хаан хоёр хоорондоо 700 жилийн зайтай ч цэрэг-иргэний харилцааг зохицуулах арга нь ийнхүү нэгэн адил байгаа нь:

- Цэрэг, иргэний харилцааг шийдвэрлэх монголчуудын шилдэг арга олон зуун жилийн турш уламжилж, тогтвортой байсан;
- Дурьдсан хоёр хаан уг асуудлыг шийдвэрлэхдээ хоёул монголын нийгэм ахуйн онцлог хөрснөөс ургуулан гаргаж чадсаны гэрч болох юм.

Эртний монгол цэргийн түүхийн хувьд цэрэг, иргэний харилцааны асуудал гарч ирдэг хоёрдугаар нөхцөл нь **дайн байлдаанд мордсон үед** тохиодгийг дээр өгүүлсэн билээ. Дайны эгзэгтэй үед цэргээс харийн ч бай, өөрийн ч бай нутгийн ард иргэдтэй харьцах харилцаанд онцгой анхаарал тавьдаг байсныг түүх гэрчилнэ. Чингис хаан 1217 онд өөрийн жанжин Мухулайд Алтан улсын фронтыг даатган үлдээхдээ нутгийн зүрчид, хятад иргэдэд хааны хүний адил өршөөл ивээлтэй явахыг захисан бөгөөд Мухулай ч хааны үгээр явж үй олон иргэдийг өршөөл ивээлээрээ татаж байв. 1220 онд Зэв, Сүбэдэй, Тогучар нарыг Сартуулын зугтсан шахыг нэхүүлэхээр мордуулахдаа нутгийн иргэдийн эд хөрөнгө, амь насанд халдахыг хатуу цаазлан, сануулсан юм. Гэтэл Тогучар жанжин нь Хорасаны иргэдийн тариаг гишгүүлсэн сургаар Чингис хаан Тогучарыг албан тушаалаас нь буулган шийтгэж байлаа.

Чингис хаанаас хагас зуун жилийн хойно Хубилай хаан: “Хэдийгээр дайн байлдааны цаг боловч ямагт энэрэнгүй өршөөлт сэтгэлийг өвөрлөж, үлэмж өглөгөөр өргөн түмнийг тэтгэ!” хэмээн зарлиг буулгаж байсан байна. Гэтэл ХХ зууны эхний Богд хааны хуульд: “Цэрэг өнгөрөхөд иргэний тариа амуг бүү гишгүүлэгтүн. Бүү эд юмыг булаан авагтун! Бүү иргэний гэрийг эвдэгтүн! Бүү эмсүүдийг дарлагтун!” [6. 135] хэмээн заасан нь Чингисийн зарлигтай ихэр мэт адилхан байгаа нь үнэндээ хуулбар бус, дайны цагт цэрэг, иргэний харилцаанд гоц анхаарах ёстой дайны гүн ухаан л 700 жилийн зайтай хоёр хааныг нэг амаар дуугаруулж буй хэрэг юм.

**Монгол улсад 1921 оноос жинхэнэ байнгын арми байгуулж эхэлсэн цагаас цэрэг-иргэний харилцааны асуудал цоо шинэ утгаараа тавигдсан юм.**

**1921-1990 оны хоорондын монголын цэрэг, иргэний харилцааны онцлог нь:**

**1. Цэрэг, иргэний харилцааг нэг намын хатуу захиргаагаар зохицуулж байсны зэрэгцээгээр энэ харилцааг идэвхжүүлэх шинэ субъектууд-төрийн болон олон нийтийн байгууллагууд гарч ирсэнд оршино.** Үүний ууган нь 1929 онд байгуулагдсан Улсыг Батлан хамгаалахад Туслах Нийгэмлэгийн суурь байсан бөгөөд энэ нь ард иргэдийг цэргийн хэрэгт сургах, цэрэг-ардын холбоог бэхжүүлэх шаардлагын үүднээс байгуулагджээ. 1940 он гэхэд энэ байгууллага нь 413 анхан шатны товчоодын 12094 гишүүнийг эгнээндээ багтааж байсан ба 1940-1944 онд орон нутгийн түр сургалтад нийт 16622 залуусыг хамарч байсан нь цөөн хүн амтай монголын хувьд их тоо юм.

1942 онд энэ байгууллагыг өргөтгөн “Ардын өөрийгөө хамгаалах сайн дурын морьт отряд”-ыг байгуулжээ [7. 176]. Энэ байгууллагын үүрэг нь ардын армийн хүчийг сэлбэх, дайсны агаарын дайралт, химийн хордолтоос хамгаалахад ард түмнээ сурган дадлагажуулахад оршив. Тиймээс отрядууд нь хөдөлмөрчдийг тусгай программаар буудлага, гранат, жагсаал, биеийн тамир, зэвсэг, техникийн бие анги, хүчин чадлыг судлуулж, хориглолт, гардан байлдааны арга барилд сургаж байв. Энэ нь угтаа орон нутгийн цэргийн сургалтын байгууллага байсан бөгөөд энэ нь сүүлийн

жилүүдэд ард түмнийг цэргийн эрдэмд сургах үндсэн маяг болж нийт хүн амын 20-иос илүү хувь буюу 80 мянга гаруй хүн хамарсан олон нийтийн том байгууллага болсон байв.

Улсыг батлан хамгаалахад туслах нийгэмлэг нь 1955 оноос цэргийн насны залуусын цэрэг, техникийн мэдлэгийг хөгжүүлэхэд ажлаа чиглүүлж авто, мото, буудлага, шүхэр, радио, морин спортын төв клубууд байгуулан ажиллаж, 1970-1990 оны завсарт л гэхэд автын жолооч 20 мянга, мотоциклч 30 мянга, тракторчин 10 мянга, холбоочин 500, шүхэрчин 1500 орчмыг сурган бэлтгэжээ.

Тус нийгэмлэгийн техникийн спортын тамирчид олимп, тив, дэлхий, олон улсын тэмцээнд 80 гаруй удаа оролцож эх орныхоо нэрийг олон улсын тавцнаа сурталчилж байсан нь тус нийгэмлэг улсдаа төдийгүй дэлхий нийтийн цэрэг, иргэний харилцаанд оролцож байсан жишээ юм.

Цэрэг, иргэний харилцаа холбоог бэхжүүлэх ийм үзэл санааг жанжин Д.Сүхбаатар баримталж байсан юм. Тэрбээр 1922 онд хоёр талын хээрийн сургуулийг санаачлан хийсэн бөгөөд энэ нь 1920-1930-аад онд “маневрын сургууль” нэрээр уламжлал болсон юм.

Өрлөг жанжин Г.Дэмидийн үед энэ сургуулийг ард түмний нүдэн дээр нээлттэй хийж, эцэст нь хурдан болоод хатирч морины уралдааныг цэрэг ба орон нутгийн ард түмний дунд зохион байгуулж төгсгөдөг байлаа.

Өнөөгийн Монгол Улсад жил бүрийн 7 дугаар сарын 11-нд хийдэг Үндэсний их баяр наадмыг 1922-1932 он хүртэл Цэргийн наадам, 1932 оноос цэрэг-ардын наадам нэрээр хийж байсан нь цэрэг-иргэний харилцааг бэхжүүлэх гол зорилго, агуулгатай байсан юм [8. 291].

1930-1937 онд Бүх цэргийн жанжин байсан Г.Дэмид цэрэг, иргэний харилцаанд онцгой анхаардаг хүн байлаа. Г.Дэмид: “тус улсын нийт ард иргэдийг цэргийн эрдэмд сургах явдал нь батлан хамгаалах хэргийг улам зузаатгах нэг нөхцөл мөн” [9. 52] гэж сургаж байлаа. Тэрбээр эл зорилтыг ард түмний дунд цэргийн эрдмийн талаар ухуулан таниулах, баг,

сум, аймгийн төв, албан газруудад цэргийн бүлэг, цэргийн хэрэгт сургах бүлгэм, Улсыг батлан хамгаалах эвлэл зэргийг байгуулах, сургуулиудад цэргийн эрдмийн үндсэн зүйлүүдийг судлах цаг гаргаж өгөх зэргээр гүйцэтгэнэ гэж байв.

Өсвөр үе, залуучуудыг цэрэг-эх оронч үзлээр хүмүүжүүлэхэд гарамгай гавъяа байгуулсан байгууллага бол монголын залуучуудыг бараг бүрэн хамарч байсан Монголын хувьсгалт залуучуудын эвлэл юм. Тус байгууллага эх орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнолыг хамгаалахад томоохон хувь нэмэр оруулсны жишээ нь Монгол улсын баатар Ч.Шагдарсүрэн, Ш.Гонгор, Л.Дандар, П.Чогдон, Л.Аюуш, Ц.Олзвой, Г.Гиваан, Д.Самдан, Т.Бор, Д.Данзанваанчиг нарын олон баатрууд түүний эгнээнд явсанд оршино.

Ардын цэргийн хэрэг эрхлэх яамны харъяанд 1960 онд Батлан хамгаалах хөдөлмөр нийгэмлэгийг байгуулсан юм. Энэ нийгэмлэг нь хүн амд цэргийн ба техникийн мэргэжил эзэмшүүлэх, үй олноор хөнөөх зэвсгээс хүн ам, улсын чухал объектыг хамгаалахад сургах, улс орныг батлан хамгаалах болон иргэний хамгаалалтын чиглэлээр ухуулга, сурталчилгаа сургалт явуулж байв. 1964 онд энэ нийгэмлэгийн бүтцэд иргэний хамгаалалтын алба байгуулж, түүнд байгалийн гэнэтийн аюултай тэмцэх, учирсан хохирлыг арилгахад цэргийн үүрэгтнүүдийг татан оролцуулах, үй олноор хөнөөх зэвсгээс ард иргэд, улс ардын аж ахуйг хамгаалах хэрэгт бүх ард иргэдийг сурган бэлтгэх үүрэг хүлээлгэсэн нь өнөөгийн Улсын иргэний хамгаалалтын газрын (УИХГ) суурийг тавьсан хэрэг байв.

УИХГ нь 1972-1977 онд 6 аймгийн 8 сая 278 мянга орчим га талбайд мэрэгчдийг, 183 мянган га талбайд царцаа устгах ажил хийж байв. Зөвхөн 1976-1980 онд улсын хэмжээнд иргэний хамгаалалтын нийтийн сургалтад дунджаар 500-600 мянган хүнийг хамарсан нь монголын хүн амын гуравны нэгтэй тэнцэж байгаа юм.

Батлан хамгаалах яам, Ардын боловсролын яам, Улсыг батлан хамгаалахад туслах нийгэмлэг, Монголын хувьсгалт залуучуудын эвлэлийн байгууллагууд хамтран 1975 оноос 10 жилийн дунд сургуулийн сурагчдын дунд “Бид ардын армийн залуу халаа” бүлгэм байгуулах, цэрэг-спортын



“Дөл” тоглолт зохиох, яруу алдрын хөшөө дурсгалыг хүндэтгэн хүндэт харуул ажиллуулах зэрэг сонирхолтой хэлбэрийн ажлууд зохиох болжээ.

“Ардын армийн залуу халаа” бүлгийг ерөнхий боловсролын сургууль бүхэнд ардын армийн анги, цэргийн сургуулийг түшиглүүлж, 5-8 дугаар ангийн 25-33 сурагчийн бүрэлдэхүүнтэй байгуулж байв. Бүлгийн үүрэг нь сурагчдыг хөдөлмөрч, дайчин уламжлалаас суралцуулах, тэдэнд эх орноо хамгаалахад хэзээд бэлэн байх үзэл төлөвшүүлэх, цэргийн хэргийн анхны мэдлэгтэй, улс төр, ёс суртахуун, бие бялдрын хувьд зохих бэлтгэлтэй болгон хүмүүжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэхэд оршин байв.

“Дөл” цэрэг-спортын тоглолтын зорилго нь ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад цэрэг, эх оронч хүмүүжил олгох, хамт олонч үзэл, тэсвэр хатуужил, авхаалж самбааг төлөвшүүлэн тогтоож, тэднийг “Хөдөлмөр батлан хамгаалахад бэлэн” тэмдгийн анхан шатны нормативыг биелүүлэх, техник спортын мэдлэг чадварыг хөгжүүлэн, цэргийн хэргийн анхан шатны мэдэгдэхүүнтэй болгоход оршиж байв.

Дунд сургуулийн 12-18 насны сурагчдын идэвх чармайлтыг “Хөдөлмөр батлан хамгаалахад бэлэн” тэмдгийн 3 шаттай норм биелүүлэх хөдөлгөөн ихэд өрнүүлж байв. Тус тэмдгийн нормыг сурагч бүхэн биелүүлж, I, II, III зэргийн тэмдгийг зүүхийн төлөө хичээнгүйлэн зүтгэдэг байв. Тэмдгийн болзлыг биелүүлэх нормд гүйлт, кросс, урт өндрийн харайлт, бөөрөнцөг шидэлт, цана, тэшүүр, олсонд авирах, дүүжинд суниах зэргээс эхлэн III зэрэг нь бага калибрын буугаар буудах хүртэл охид, хөвгүүдээр ялган тогтоосон хэмжээ дүрэмтэй байлаа.

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд зохиодог байсан дээрх ажлууд нь цэрэг, иргэний харилцааг өсвөр үетэй холбосон сонирхолтой, үр ашигтай хэлбэрүүд байлаа.

**2. Цэргийн алба нь цэрэг, иргэний давхар шинж олсон буюу цэргийн албыг иргэншүүлэх хандлага гарч,**

**улс орны бүтээн байгуулах үйлсэд томоохон хувь нэмэр оруулсанд оршино.**

Дэлхийн II дайн дууссаны дараагаар армийг их хэмжээгээр цомхотгов. Офицер боловсон хүчин олноор халагдаж хөдөөг зорин сум, нэгдэл, сангийн аж ахуйн удирдлагад очжээ. Тэдгээрийг халах ажилд төр засгаас онцгой анхаарч тэтгэмж, тэтгэлэг олгож, хүрэх замын дагууд өртөө гарган үйлчилж, орон нутагт нь улсын зардлаар хүргэж байв. Энэ нь армийн нэр төрийг иргэдийн дунд өргөх чухал бодлого байсан бөгөөд улс ардын аж ахуйд очсон олон дарга нэр төрөө мандуулж, хөдөлмөрийн алдар цуутнууд болсон нь армийнхаа нэр сүрийг өргөсөөр байлаа. Мөн цэргээс цомхотголоор халагдсан жолооч, хүн, малын эмч, холбоочин зэрэг мэргэжилтнүүд улс ардын аж ахуйд очжээ.

1955 оноос цэрэгт мал аж ахуй, тариалангийн үндэс, хөдөө аж ахуйн техникийн хичээл оруулах болж, төгсгөлд 45 хоногийн дадлага хийлгэн халах болов.

1956 оноос арми нь тариалан бригадын дарга, цахилгаанаар хонь хяргагч мэргэжилтэн, жолооч, комбайнч, тракторч, кино механикч, барилгын багийн дарга зэрэг мэргэжилтнийг цэргээс бэлтгэх үүрэг авч, хэд хэдэн зуун мэргэжилтнийг төгсгөн хөдөөд илгээв.

Цэргийн ангиуд түр курс зохион байгуулан хөдөө аж ахуйд хэрэгтэй мэргэжилтнүүдийг төгсгөн гаргах болов. Цэргийн ангиуд сангийн аж ахуйд очиж өвс хадаж, бухалдах, тариа ногоо хураах ажилд туслан амжилтаараа манлайлж байв. Түүнчлэн хашаа барих, худаг гаргах, тариалангийн талбайн зэрлэг ургамал зулгаах зэрэг юу чадах бүхнээрээ хөдөө аж ахуйд туслан хөдөлмөрлөв.

1950-иад оноос барилгын цэрэг үүсч бэхжсэн нь монголын цэрэг, иргэний харилцааны түүхэнд шинэ хуудас нээсэн үзэгдэл байв. 1947-1960 оны хооронд барилгын цэрэг эх орондоо шаварчин, өрлөгчин, мужаан, цахилгаанчин, будагчин, токарьчин зэрэг барилгын төрөл бүрийн мэргэжилтэн 3000 гаруйг бэлтгэн өгсөн бол 1961-1969 онд арми холбоочин, жолооч, комбайнч, тракторч болон барилгын

төрөл бүрийн мэргэжилтэн 9000-аад хүнийг бэлтгэн улс ардын аж ахуйд илгээжээ.

“1956 оноос Монголын агаарын цэргийн хүчин үндэсний агаарын тээврийн байгууллага болон хувирч арми иргэний агаарын тээврээр хөдөлмөрчиддөө үйлчлэх болсон” [10; 407] нь бас нэгэн шинэ алхам байв. Цэргийн тээвэрчид улсдаа ихийг бүтээж байв.

Барилгын цэрэг байгуулагдсан цагаасаа хойшхи 60 жилд (1936-1996) эх орондоо 5000 шахам том жижиг, барилга байгууламжийг барьж ашиглалтад өгчээ.

1947-1960 онд армиас халагдсан номын багш 317, кино механик 52, хүн эмнэлгийн бага мэргэжилтэн 436, мал эмнэлгийн бага мэргэжилтэн 187, холбооны 1394, автомашины 2423, аж ахуйн 392 бага мэргэжилтнийг улс ардын аж ахуйд шилжүүлж байжээ.

Армийн цэрэг, иргэний ийм давхар үүрэг, зориулалт, улс орноо ч, армиа ч хөгжүүлэхэд өгүүлж баршгүй их нэмэр болж байлаа.

### **3. Бүх нийтийн цэргийн албаны хуулийн дагуу бүх нийтийн боловсрол олгох асуудалд шийдвэртэй алхам хийсэнд оршино.**

Монголын ардын армиас иргэд ард түмэндээ бүтээсэн баларшгүй нэгэн гавъяа бол ард түмнээ бичиг үсэгтэн болгоход оруулсан хувь нэмэр юм. 1925 онд 2175 цэргийг бичиг үсэгт сургасан бол 1930 онд 3000 цэргийг бичиг үсэгтэн болгон халж улс ардын аж ахуйд шилжүүлж байв. МАХЦ-ээс 1930-аад онд жил бүр 3-4 мянган хүн хугацаа дуусган халж байсны 80-90 хувь нь бичиг үсэгтэн болж байв. Эдгээр бичиг үсэгтэн цэргүүд халагдаж хөдөө орон нутагт очихдоо бичиг үсгийн багш болох нь олонтаа байлаа.

МАХЦ-т зөвхөн дарга, цэргүүдийг бичиг үсэгт сургаад зогсохгүй дарга нарын гэр бүлийн эмэгтэйчүүдийг бичиг үсэгт сурган ерөнхий эрдмийн хичээл зааж байв.

1950-иад онд бүх офицеруудыг ерөнхий боловсролын бүрэн бус дунд сургуулийн бэлтгэлтэй болгох зорилтыг арми

өөрийн дотор зохион байгуулан үндсэнд нь шийдвэрлэсэн юм.

Ийнхүү арми бие бүрэлдэхүүнээ бичиг үсэгт сургах замаар ерөнхий боловсролтой болгосон үйл хэргийг монгол улсын боловсролын байгууллагын ачааг хөнгөлж өгсөн төдийгөөр дүгнэж болохгүй юм. Цэрэгт ийнхүү боловсрол эзэмшигчдийг улсын сургуулиар бэлтгэсэн бол ихээхэн цаг хугацаа хөрөнгө шаардах байсан. Гэтэл эх орноо батлан хамгаалах хэрэгт сургахын зэрэгцээгээр цэрэг дарга нарыг бичиг үсэгт сурган, иргэний ерөнхий боловсрол олгож иргэний давхар үүрэг гүйцэтгэж байсан нь нийгмийн дэвшилд оруулсан эрхэм гавъяа байсан юм.

Ард иргэд, залуус, ялангуяа ерөнхий боловсролын дунд сургууль, их, дээд сургуулийн **залууст цэргийн боловсрол олгох нэгдсэн тогтолцоот ажлыг 1911-1994 оны хооронд зохион байгуулан өрнүүлжээ.** 1980-аад онд үүнийг “Цэргийн гадуур сургалт” гэж нэрлэж байлаа. Үүнд:

а/ 1911-1942 онд ард иргэдийг орон нутгийн цэргийн сургалтад хамруулах явдал нь цэргийн орон нутгийн сургалт, Улсыг батлан хамгаалах эвлэлийн сургалтын хэлбэрээр хэрэгжиж байв.

Богд хаант Монгол Улсад бүрэлдэж байсан байнгын ба нутгийн цэргийн тогтолцоог 1921 оноос Ардын засаг уламжлан авчээ. Бүх цэргийн жанжин Д.Сүхбаатар “Түмэн ардыг цэргийн явдалд урьдаас боловсруулж дайсныг халдан ирэх цагт улсын боловсон (байнгын-Х.Ш) цэрэгтэй хүч хавсруулан эсэргүүцэн сөнөөх чадвартай болгох” [11. 255] зорилгоор 1921-1922 онд 18-30 насны залуусыг зуны цагаар аймаг, хошуудын төвд цуглуулан богино хугацаагаар сургуулилуулж, явган жагсаал хийх, сэлэм, винтовын бие анги судлах, буудлага хийх зэрэг цэргийн хэргийн анхан шатны мэдэгдэхүүнд сургаж байв.

1925 оноос хөдөө орон нутагт цэргийн анги байгуулан, тэр ангийг түшиглэн ард иргэдийг сургах болжээ. Ийнхүү цэргийн ангийг түшиглэн түр сургуулиар сургах нь:

- Байнгын цэргээр сургах зардлыг хорогдуулах;
- Цэргийн алба хаах хугацааг богиносгох;

- Олон залуусыг аж ахуйн ажлаас хөндийрүүлж ажлыг нь алдагдуулахаас ангижирсан сайн арга байжээ. Хөдөөгийн цэргийн ангиуд 21-35 насны залууст 45-120 хоногийн хугацаагаар цэргийн түр сургалтыг зохион байгуулж байлаа. Ийм түр сургалтад 5 жил дараалан хамрагдсан хүнийг цэргийн алба хаасанд тооцдог журам тогтоов. Зөвхөн 1940-1944 онд орон нутгийн ийм түр сургалтад нийт 16622 хүн хамрагджээ.

1930-аад оноос Монгол Улсад Японы түрэмгийлэгчдийн аюул нүүрлэн ирсэн үед ард түмнийг цэргийн хэрэгт бүрэн сургах асуудал тулгамдсан зорилт болсон учир олон түмнийг цэргийн анхан шатны бэлтгэлтэй болгох ажилд туслах үүрэг, зорилготой Улсыг хамгаалах явдалд туслалцах сайн дурын эвлэл гэдэг олон нийтийн байгууллагыг байгуулав. Энэ байгууллага нь Халхын голын дайны жилүүдэд Улаанбаатарын залуучуудыг нэгтгэж хороо, дивизийг зохион байгуулан цэргийн хэрэгт сургаж байв. 1940 онд тус байгууллага нь 413 анхан шатны товчоодын 12094 гишүүнийг эгнээндээ багтааж байв.

б/ 1942-1957 онд сайн дурын морьт отрядын сургалтад иргэдийг хамруулж байсан ба ерөнхий боловсролын сургуульд цэргийн сургалт оруулах ажлыг туршсан байна.

1942 оноос Улсыг хамгаалах явдалд туслах сайн дурын нийгэмлэгийн үүргийг Сайн дурын морьт отряд уламжлан авав. Энэ байгууллага нь 1942-1957 онд оршин тогтнож аймаг, сум, үйлдвэрийн газруудад өөрийн штабыг байгуулан, дайсны агаарын дайралт, химийн хордолтоос хамгаалахад ард түмнээ сурган дадлагажуулах үүрэг хүлээж байв. 1944 онд тус отряд нь монголын хүн амын 20 хувь буюу 80 мянга гаруй хүнийг эгнээндээ нэгтгэн цэргийн сургалтад хамруулж байлаа.

1940-өөд онд олон тооны бага, дунд сургууль, техникумуудтай болсон үед тэднийг цэргийн хэрэгт сургах асуудал шинээр тавигдсан тул Ардын сайд нарын зөвлөл 1944 оны 9 дүгээр сард “Дунд сургууль, техникумуудын сурагчдыг цэргийн бэлтгэлтэй болгох тухай” тогтоол гаргаж

энэ тогтоолын дагуу дунд сургуулийн 5-10 дугаар анги, техникумуудын сурагчдын анхан шатны ба цэрэгт татагдахын өмнөх бэлтгэлийн тухай дүрмийг батлан гаргав. Дүрэм ёсоор дунд сургуулийн 5-7 дугаар ангид цэрэгжлийн хичээлийг 7 хоногт 2-3 цаг, 8-10 дугаар анги, техникум, их дээд сургуулийн сурагч оюутнуудад 7 хоногт 3-4 цагийн хичээл оруулж байх болжээ.

в/ 1957-1980 он бол цэргийн гадуур сургалтын тогтолцоо өргөжин хөгжсөн үе байлаа.

- “ 1957-1980-аад онд цэргийн гадуур сургалтын тогтолцоо нь:
- Батлан хамгаалахад туслах нийгэмлэгийн сургалт;
  - Их, дээд сургуулийн цэргийн тэнхимийн сургалт;
  - Их, дээд сургуулийн иргэний хамгаалалтын тэнхим (төв)-ийн сургалтаас бүрдэж бүтэн тогтолцоог үүсгэжээ” [11. 281].

Батлан хамгаалахад туслах нийгэмлэгийн сургалтын талаар дээр өгүүлсэн билээ. Энэ үеийн их, дээд сургуулийн цэргийн тэнхимийн сургалт нь 1961-1962 оны хичээлийн жилээс бүх шатны сургуулиудад эхэлсэн юм.

Монгол Улсын их сургуульд цэргийн тэнхим байгуулж, 6 жилийн сургалттай ангиудад 320-348 цагийн цэргийн сургалт явуулж, төгсөхөөс нь өмнө нэг сарын хугацаатай цугларалт хийлгэн, амжилттай төгсөгчдөд офицерийн цол олгодог болжээ. Ерөнхий боловсролын дунд сургуулиудын 8-10 дугаар ангийн болон тусгай мэргэжлийн сургууль, дээд сургуулиудын эрэгтэй оюутан, сурагчидтай цэргийн анхан шатны бэлтгэл сургалтыг 3 жилд 116 цагаар явуулах болов. Энэ сургалтыг 1963-1964 оны хичээлийн жилээр тасалбар болгон зогсоов.

1965-1966 оны хичээлийн жилээс Иргэний хамгаалалтын хичээлийн программ боловсруулан мөрдөж, дээд сургууль, тусгай мэргэжлийн техникумын оюутан сурагчдад заах цэрэгжлийн хичээлийг өөрчилж, Монгол Улсын их сургуулийн цэргийн кафедрийг иргэний хамгаалалтын тэнхим болгож, ерөнхий боловсролын дунд

сургуулиудын 7 дугаар ангиас эхлэн иргэний хамгаалалтын хичээл оруулах болов.

Оюутан, сурагчдын иргэний хамгаалалтын сургалт 1980-аад оны байдлаар 5 их, дээд, 24 тусгай мэргэжлийн дунд, 35 техник мэргэжлийн, 426 ерөнхий боловсролын сургуулийн 56.3 мянган оюутан, сурагчийг хамарч байлаа.

1980-1994 онд бүх шатны сургуулиудад цэргийн сургалтыг дахин сэргээж түүнд мянга, мянган сурагч, оюутан хамрагдаж цэргийн анхан шатны мэдэгдэхүүнээс авахуулаад цэргийн дунд, дээд мэргэжилтэн, цэргийн боловсон хүчин бэлтгэж байлаа.

“1980-1981 оны хичээлийн жилээс бүх их, дээд сургуульд цэргийн тэнхим, Батлан хамгаалах яаманд Цэргийн гадуур сургалтын хэлтэс байгуулж, их дээд сургуульд 500 цагийн, тусгай мэргэжлийн дунд сургууль, техник мэргэжлийн болон ерөнхий боловсролын бүрэн дунд сургуульд нийт 140 цагийн хичээл оруулах болов” [10. 488].

1985 оны байдлаар цэргийн анхан шатны бэлтгэл сургалт 2-3 жилийн хугацаанд 140 цаг, үүнээс ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангид 7 хоногт 2 цаг, тусгай дунд, техник мэргэжлийн сургуульд 7 хоногт 2-4 цаг, эрэгтэй нь 18 цагийн цугларалт хийж байв.

“1984-1985 оны хичээлийн жилд их, дээд сургуульд цэргийн 11 мэргэжлээр оюутны цэргийн бэлтгэл сургалт хийж дунджаар 10 мянга гаруй оюутныг хамарч, цугларалтад 1220 оюутан оролцсоноос 1104 нь бэлтгэл офицерийн болзлыг хангаж байлаа” [11. 267].

Цэргийн анхан шатны бэлтгэл сургалтад 1985 оны байдлаар техник мэргэжлийн 37, тусгай дунд сургууль, ерөнхий боловсролын 300 гаруй сургуульд 70 гаруй мянган охид, хөвгүүд хичээллэж байв.

1970-1980-аад онд аймаг, үйлдвэр, аж ахуйн газруудын удирдлагыг цэргийн хэрэгт сургах семинар, дамжааг ч олонтаа зохион байгуулж байлаа.

Гэтэл 1990 оноос Монголын нийгэм, төрийн байгуулал өөрчлөгдсөн тул ард нийтийн иргэний хамгаалалтын сургалтаас бусад хэлбэр хаагджээ.

Гадуур сургалт бол цэрэг, иргэний харилцааг боловсронгуй болгох, залуу хойч үеийн сэхээтнүүдэд цэргийн боловсрол олгох үр ашигтай хэлбэр байлаа.

#### **4. Хоёр дайны нүүр үзсэн нь цэрэг, ард түмний нягт хамтран ажиллахын чухлыг нотлон харуулсанд оршино.**

1939 оны Халхын голын дайны үед байлдаж байгаа арми, фронтыг шаардагдах бүх зүйлээр саадгүй хангах явдал ялалтын гол нөхцөл мөн гэдэг үзлийг Монгол Улсын Засгийн газар тууштай баримталж байв.

Дайны үеийн цэрэг-иргэний харилцаанд ард түмнээс цэрэг рүүгээ хандсан харилцаа давамгайлж ирдэг хуультай ажээ. Фронтыг хэрэгцээт зүйлээр хангахад төмөр замын станцаас 750 гаруй км хол байсан ба фронтын талбар нь хүн ам, аж үйлдвэр, эдийн засгийн гол районоос ихэд алслагдмал байсан нь ихээхэн бэрхшээл учруулсан ч төр, ард түмний нэгдмэл тэмцлээр амжилттай даван туулсан юм.

Улс ардын аж ахуйн бүх салбарт улсын төлөвлөгөөт зорилтыг давуулан биелүүлэх хөдөлгөөнийг өрнүүлэхийн зэрэгцээгээр үйлдвэр аж ахуйн байгууллага, цэргийн ангиуд хоорондоо шефийн холбоо гэдэг найрсаг харилцааны шинэ хэлбэрийг олжээ.

Дайны жилүүдэд “Бид бүхий л зүйлээр тусална. Хүчээ нэгтгэн дайсныг бут цохино” гэсэн утгатай захидал фронт руу урсаж байхад фронтоос хариуд нь: “Бид та нарын итгэл найдварыг хөсөрдүүлэхгүй, дайсныг заавал бут ниргэнэ” гэсэн үгтэй захидлууд цувж байжээ.

Энэ бүхэн нь монголын ард түмэн эх орондоо хязгааргүй хайртай, ард түмэн ба арми бат нэгдэлтэй, ард түмэн армия хайрлан дэмжиж байдгийн тод илрэл мөний дээр дайны үеийн цэрэг, иргэний харилцаа нь иргэн, цэрэг хоёр нэг зорилгод нэгдвэл дайснаа ялж, амжилт ололтод хүрдгийг



амьдрал дээр нотолсноороо түүхэн ач холбогдолтой юм. 1939 оны Халхын голын дайны үеэс тогтон уламжилсан монголын цэрэг, иргэний гүн бат холбоо, найрсаг харилцаа нь 1945 оны чөлөөлөх дайнд ч хэвээр хадгалагдан, армия хэрэгцээт бүх зүйлээр тасралтгүй хангахад монголын ард түмэн бэлэн байсан билээ.

Дэлхийн II дайны жилүүдэд монголын ард түмэн зөвхөн өөрийн армидаа төдийгүй байлдаж буй Зөвлөлтийн (Оросын холбооны улсын) улаан армид сэтгэл харамгүй халуун тусламж үзүүлж байсан юм.

“Монголын ард түмнээс 1941-1945 онд Зөвлөлтийн улаан армийн дайчдад зориулан хуримтлуулсан зүйлүүдийн бүх үнэ тэр үеийн ханшаар 65 сая төгрөгт хүрсэн бөгөөд 32538 шилдэг морьдыг бэлэг болгон илгээсэн юм” [7. 191]. Энэ бол тухайн үеийн монголын хүн амын тоотой харьцуулан жишвэл асар их хөрөнгө байсан билээ.

**5. Цэргийн зүгээс иргэд буюу ард түмэн рүүгээ чиглэсэн харилцаа идэвхжиж шинэ шинэ хэлбэрүүдийг төрүүлэн хэрэгжүүлсэнд оршино.**

1923 онд цэргийн комиссаруудын анхдугаар хурал болж “Нутгийн ардуудын болон халагдах цэргийн дунд зохиох улс төр, ухуулгын ажлын тухай” асуудал хэлэлцсэн нь ард түмэн рүү цэрэг өөрөө ихээхэн хандах ёстой гэдгийг тунхаглан зарласан анхдагч уриа байжээ.

Тус хурлаас нутгийн ардын дунд зохиох ажлыг комиссаруудад үүрэг болгон хариуцуулж, тэдний дунд сонин хэвлэл, зурагт хуудас тараах, жүжиг тоглох, бичиг үсэгт сургах, эмнэлгийн тусламж үзүүлэх ажлыг цэргийн ангиас зохион байгуулж найр наадам хийх, овоо тахих зэрэг хүн олноор цугларсан газарт ухуулга яриа хийж байхыг зөвлөжээ. Түүнчлэн нутгийн ардууд нүүж суух, тариа тарих ба хураах, хадлан бэлтгэх зэрэг ажилд цэргийн анги хөсөг тээвэр, хүн хүчний тусламж үзүүлж байхыг зүйтэй гэж үзэв. Мөн ахмад дайчдыг халахад онцгой анхаарал тавихыг даалгасан нь ард түмний дотор армийнхаа нэр хүндийг өргөх бодлого байжээ. Арми, ард түмний холбоог бэхжүүлэхэд цэргийн сонин онцгой үүрэгтэй гэж үзсэн учир Зэвсэгт хүчний төв хэвлэлийн ууган

дугаарыг 1924 онд “Ардын цэрэг” нэрээр гаргажээ.

Энэ сонин нь армийн амьдрал үйл ажиллагааг ард түмний дотор сурталчлах үүргийг эдүгээ хүртэл гүйцэтгэсээр байна. Түүнчлэн “Ухуулагч”, “Цэргийн бодлого”, “Байлдааны бэлтгэлийн төлөө” сэтгүүлүүдийг олон мянган хувиар хэвлэн тарааж байлаа.

1960-1980-аад оны хооронд армийг ард түмний дунд сурталчлах ажлын зохистой хэлбэрүүд гарсаар байв. “Арми сурталчлах сарын ажил”, “Эцэг, эх-цэрэг хүүгийн уулзалт”, “Цэрэг, дайчдын урлагийн тоглолт”, “Спортын нөхөрсөг уулзалт”, цэргийн ар гэрт албан захидал илгээх зэрэг нь цэрэг, иргэний харилцааг бэхжүүлэх зохистой хэлбэрүүд байжээ.

“Арми сурталчлах сарын ажил”-ын үеэр армийн командлалын төлөөлөгчид, цэрэг дайчид, аймаг, сумын төв, бүр алсын хот айлд хүрч армийн хөгжлийн талаар ухуулга яриа, уулзалт хийж, хөдөлмөрчдийн санал сэтгэгдлийг судлан тэдэнд урлаг, спортоор үйлчилдэг байлаа.

“Эцэг, эх, цэрэг хүүгийн уулзалт”-ыг аль нэгэн аймгийн төвд зохион байгуулан, цэргийн эцэг, эхчүүдийг хот, хөдөөгөөс цуглуулан ирүүлж, цэрэг хүүтэй нь уулзуулан мөн урлаг, спортоор үйлчлэн, уулзалт үдэшлэг зохион байгуулдаг байсан нь цэрэг, түрүүч нарыг үндсэн хөдөлмөр – цэргийн албанаас нь чөлөөлөхгүйгээр эцэг, эхтэй нь уулзуулдгаараа үр ашигтай хэлбэр байсан юм.

“Спортын нөхөрсөг уулзалт” нь цэргийн ангиудаас хот, хөдөөгийн үйлдвэр, албан газрын албан хаагчид, сургуулиудын оюутан сурагчидтай хамтран зохиодог, өрсөлдөөнтэй, сонирхолтой хэлбэр байв.

“Цэрэг-дайчдын урлагийн тоглолт”-ыг цэргийн нэгтгэл, ангиудаас зохион байгуулан хэдэн аймаг, сумын нутаг дамжуулан урт хугацаагаар аялуулж байсан нь армия ард түмэнд сурталчлах зохистой арга хэмжээ болж байлаа.

Иргэд, ард түмэн рүүгээ хандах ажлын эдгээр арга хэлбэрүүдийн үр дүн талаар өнгөрөөгүй нь мэдээж юм.

## ДҮГНЭЛТ

- ❖ Цэрэг, иргэний харилцааг зөв зохион байгуулах нь түүхийн туршид улс орныхоо тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хангах нэгэн гол нөхцөл байсаар ирсэн, байсаар ч байх ажээ.
- ❖ Монголчууд цэрэг, иргэний харилцааны олон зуун жилийн түүхтэй бөгөөд энэ харилцааг зохицуулахдаа олон арга хэлбэрийг ашиглаж байжээ.
- ❖ Монголын цэрэг, иргэний харилцааг зохицуулах үүргийг төр ямагт үүрсээр иржээ.
- ❖ Түүхийн тодорхой хугацаанд монголын цэрэг, иргэний харилцааг зохицуулан хөгжүүлэхэд хажуугийн субъект-төр, олон нийтийн байгууллагууд үүсэн үйлчилж байжээ.
- ❖ Цэрэг, иргэний харилцааг зөв төлөвшүүлэхэд цэргийн албыг иргэншүүлэх, иргэний сургалтыг цэрэгжүүлэх, өөрөөр хэлбэл, сургалтын цэрэг, иргэний давхар тогтолцоо, хоёрдмол технологи чухал суурь эзлэх аж.
- ❖ Цэргийн сургалтын орон нутгийн тогтолцоог бүрдүүлэх нь улс төр, эдийн засаг, нийгмийн үр ашигтай бөгөөд цэрэг, иргэний зохистой харилцааг тогтоох нэгэн арга юм.
- ❖ Цэрэг, иргэний харилцааг зөв төлөвшүүлэхэд армийн нэр хүнд өндөр байх нь чухал хүчин зүйл бөгөөд армийг цомхотгосон энх тайван нөхцөлд армийн нэр хүндийг бууруулахгүй байх арга нь цэргийн албыг иргэншүүлэх, улс орны бүтээн байгуулалтад армийг өргөнөөр оролцуулах явдал чухал байр эзэлнэ.
- ❖ Дайны ба энхийн аль ч цагт арми өөрийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэлтэй байж олон түмний дунд үйл ажиллагаагаа сурталчилж, залуу хойч үеийг цэрэг эх оронч хүмүүжлээр хүмүүжүүлэх сонирхолтой хэлбэрийн ажлууд зохиож байх нь хэтийн үр ашигтай гэсэн дүгнэлтүүд гарч байна.

## **АШИГЛАСАН НОМ, БҮТЭЭЛ, СУРВАЛЖ, СУДАЛГААНЫ МАТЕРИАЛ**

1. Эртний цэргийн эрдмийн гурван бичиг. Хөх хот., 1986.
2. В.Нанзад (Х.Шагдар). Чингисийн сургаал, гэрээслэл. УБ., 1991.
3. Х.Шагдар. Чингисийн байлдааны цадиг. УБ., 1993.
4. Жиовани дель Плано Карпини. Монголчуудын түүх. Гильем де Рубрук. Дорнод этгээдэд зорчсон минь. УБ., 1988.
5. Монголын нууц товчоо. УБ., 1990.
6. С.Гангааням. Монголчууд тусгаар тогтнолоо хамгаалан тэмцсэн нь (1911-1921). УБ., 1993.
7. Монголын ардын армийн 50 жил. УБ., 1971.
8. С.Ганболд. Нийгмийн дэвшил – Зэвсэгт хүчин - “Хорьдугаар зууны монгол цэрэг. УБ., 2001.
9. Г.Дэмид Илтгэл, өгүүлэл, хэлсэн үг (1930-1937). УБ., 1991.
10. Монгол цэргийн түүхийн товчоон. Дэд дэвтэр. УБ., 1996.
11. Х.Шагдар. Цэргийн сургалт -“Хорьдугаар зууны монгол цэрэг. УБ., 2001”.
12. Ж.Лхагвасүрэн. Тулалдаант он жилүүд. УБ., 1995.
13. Д.Сүхбаатар (намтар). УБ., 1967.
14. Ц.Самдангэлэг. Монголын ардын арми үүсэн байгуулагдсаны түүх (1921-1924 он). УБ., 1980.
15. Ардын армийн залуу халаа. УБ., 1983.
16. Хилийн цэргийн 50 жил. УБ., 1983.
17. Монголын ардын армийн түүхэнд холбогдох баримт бичгүүд. УБ., 1973.

ХОЁРДУГААР БҮЛЭГ.  
**МОНГОЛ УЛСЫН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ШИНЭЧЛЭЛИЙН  
ЯВЦ, ТҮҮНИЙ ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА**

*Ph.D Ш.Паламдорж*

/Батлан хамгаалахын их  
сургуулийн дэд захирал бөгөөд  
Батлан хамгаалахын эрдэм  
шинжилгээний хүрээлэнгийн  
захирал/

Монгол Улсын түүхэн замналын урт удаан хугацаанд түүний Зэвсэгт хүчин нь төр улсдаа тулгуур хүч, түмэн арддаа өмөг түшиг болж ирсэн баатарлаг, баялаг [1] түүхтэй юм. Монгол түмэнг дэлхийн их гүрэн байгуулахад, тэр нь хөгжин мандах, задран унахад, Манж гүрний эрхшээлд ороход, тусгаар тогтнол, эрх чөлөөгөө байлдан олоход, Социализм байгуулах их туршилтад, өнөөгийн ардчилал, чөлөөт зах зээлийн нийгмийн үед ч ард түмэнтэйгээ хүйн холбоотой байж, тусгаар тогтнол, эрх чөлөөт байдлыг хангахын төлөө тэмцэж ирсэн билээ.

Дэлхийн хоёр туйлт системийн тэмцэл оргил үедээ хүрч байсан 1950-аад оны дунд үеэс 1980-аад оны төгсгөл хүртэлх хугацаанд цэргийн шинэчлэл буюу Монголын Зэвсэгт хүчнийг өргөтгөн зохион байгуулах ажлыг тасралтгүй явуулж, “Арми – дивиз – хороо – батальон” гэсэн нэгдмэл бүтэцтэй, бие бүрэлдэхүүн олонтой, тэр үеийн цэргийн сонгодог урлагийг эзэмшсэн цэрэг болон төлөвшсөн байна. Манай цэргийн түүхчид энэ үеийн цэргийг өргөтгөн зохион байгуулсан үйл явцыг гурван шаттай хэрэгжсэн гэж үздэг юм [2. 419]. Монголын Ардын Арми нь дан ганц “батальоны” тогтолцоо (1956 он)-ноос завсрын “батальон – бригадын” тогтолцоо (1964 он)-нд, дараа нь “батальон – хороо – дивиз – арми”-ийн тогтолцоо (1979 он)-нд шилжиж байжээ.

Энэ үеийн цэргийн шинэчлэл, Зэвсэгт хүчний өргөтгөн зохион байгуулалт нь хэд хэдэн онцлогтой явагдсан гэж үздэг. Үүнд: *нэгд*, хэрэг дээрээ бүрэн татан буугдсан морьт цэргийг биш шинэ маягийн мотобуудлагын цэрэг байгуулах зорилт тавьсан, *хоёрт*, Зэвсэгт хүчнийг өргөтгөн зохион

байгуулснаар цоо шинэ зэвсэг техникээр хангагдаж, хүчин чадал, байлдах чадварын хувьд урьд өмнө байгаагүйгээр олон дахин өссөн, *гуравт*, байлдааны бэлтгэл сургалтын шинэ тогтолцоог бүрдүүлсэн, *дөрөвд*, цэргийн боловсон хүчнийг бэлтгэх асуудлыг зохистойгоор шийдвэрлэсэн, *тавд*, Зэвсэгт хүчний байнгын бие бүрэлдэхүүний ахуй хангалт, байр орон сууц, цалин мөнгө, шагнал урамшил, хувцас формын талаар дорвитой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн, *зургаад*, Зэвсэгт хүчнийг өргөтгөн зохион байгуулахдаа улс орныхоо эдийн засгийн чадавх, үйлдвэрлэх хүчнийхээ хөгжлийн төвшинг бага харгалзсан, ЗХУ-ын ах дүүгийн өгөөмөр тусламжид хэт найдсан, интернационалист, социалист үзэл суртал, цэргийн номлолд хөтлөгдсөн шинжтэй байв.

Энэ үеийн Монголын Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалт, бие бүрэлдэхүүн, зэвсэглэл техникийн тухай мэдээлэл [3] зэрэг өргөн хэрэглээний гарын авлага, лавлагааны материалуудад гарсан тул тоон талын үзүүлэлтийг дээрхи бүтээлүүдэд харуулснаар хязгаарлаад харин 1990-ээд оноос хойш дээрх бүтэц, зохион байгуулалттай байсан Зэвсэгт хүчнийг хэрхэн яаж шинэчлэх талаар явуулсан Монголын төрийн бодлого, үйл ажиллагааны агуулга, мөн чанарыг товчхон өгүүлье.

Зөвлөлт Холбоот Улс болон төв, зүүн европын социалист орнуудад 1980 - аад оны дунд үеэс өрнөсөн өөрчлөн байгуулалт нь социалист системийг задалж, улмаар монголын нийгмийн байгуулалд нөлөөлсөн юм. Монгол Улсын гадаад, дотоод байдал хувьсан өөрчлөгдөж, нийгмийн хэрэгцээ шаардлагад зохицсон эрх зүйн шинэлэг үндэс тавихыг шаардаж эхэлсэн байна. Ийм нөхцөл байдалд Монгол Улс 1992 онд шинэ Үндсэн хуулиа баталж, **“иргэний хүмүүнлэг ардчилсан нийгэм байгуулах зорилт тавин”** [4] өмчийн олон хэлбэрийг хүлээн зөвшөөрч, нийгмийн тогтолцоогоо социалист “зохиомол” хэв загвараас хүний нийгмийн хөгжлийн “нийтлэг” хэв загвар - чөлөөт зах зээлд шилжүүлж эхлэв. Нийгмийн байгуулалд хувьсгалын шинж чанартай өөрчлөлтүүд гарч эхэлсэн нь батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчнийг тойрсонгүй, түүний суурь, үндсийг ч өөрчлөхөд хүргэв.

Шинэ үндсэн хууль [4]-иар Зэвсэгт хүчний зориулалтад чанарын өөрчлөлт оруулж, **зөвхөн өөрийнхөө эх орныг батлан хамгаалах үндсэн үүрэгтэй болгов.** Зэвсэгт хүчний чиг үүргийг ийнхүү тодруулан тогтоосон нь урьд өмнөх үеийн социалист системийн орнуудын алс дорнодын хилийг хамгаалах интернационалист үүрэг зориулалтаас зарчмын ялгаатай болсон юм.

Үндсэн хуулиар Зэвсэгт хүчний үүргийг тодорхойлон гаргасан тул төрөөс түүний талаар баримтлах бодлогоо **“Монгол Улс тайван цагт улс орныхоо батлан хамгаалах хэрэгцээ, шаардлага, эдийн засгийн боломжид нийцсэн цомхон, чадварлаг, мэргэжлийн чиг баримжаатай Зэвсэгт хүчинтэй байна”** гэж тодорхойлсон юм [5. 13].

Зэвсэгт хүчний **тайван цагт гүйцэтгэх үүргийг** “Төрийн цэргийн бодлого” баримт бичигт тодорхойлохдоо: эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг гаднын зэвсэгт түрэмгийллээс хамгаалахад бэлэн байх; улсын хил хамгаалах, агаарын хилийн халдашгүй дархан байдалд хяналт тавих; улсын онц чухал объектыг хамгаалах; хөнөөх хэрэгслийн хөнөөл, байгалийн болон нийтийг хамарсан гамшиг, үйлдвэрийн ослын аюулаас хүн ам, эд баялагийг хамгаалахад туслах; дайчилгааны нөөцийг бүрдүүлж, хүн амыг цэргийн хэрэгт сургах; хүмүүнлэгийн үйл ажиллагаанд туслалцаа дэмжлэг үзүүлэх; Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах хүчний хүрээнд үүрэг гүйцэтгэх зэрэг хуулиар тогтоосон бусад үүрэг байхаар тогтоосон юм [5. 14-15].

**Энэхүү шинэ үүрэг, зориулалтаа хэрэгжүүлэхэд Зэвсэгт хүчний тухайн үеийн байгуулалтын бүтэц; бүрэлдэхүүн; зэвсэглэл, техник; цэргийн сургалт бэлтгэлийн тогтолцоо; түүний урлаг; цэргийн алба хаах журам; цэргийн нэгтгэл, ангийн бүтэц, зохион байгуулалт, байршил; цэргийн албан хаагчдын нийгмийн баталгаа; төсөв хөрөнгийн байдал зохицохгүй болсон байна.**

Зэвсэгт хүчнийг мэргэжлийн цэргийн чиг баримжаатай, цомхон, чадварлаг болгон шинэчлэх гэдгийг бид Зэвсэгт хүчний байгуулалтын үндсэн асуудлаар өөрөөр хэлбэл түүний **эрх зүйн орчин, бүтэц, зохион байгуулалт; зэвсэглэл техникийн байдал; бие бүрэлдэхүүн; цэргийн сургалт бэлтгэлийн тогтолцоо; ахуй хангамж; цэрэг, иргэний харилцаа; Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналт зэрэг асуудлаар зарчмын болон чанарын өөрчлөлт хийж, мэргэжлийн армийн шинж чанар, жишигт ойртуулан өөрчилж, төлөвшүүлэн хөгжүүлэхийг ойлгож байгаа юм.**

Шинэчлэлийн үр дүнд Зэвсэгт хүчний монголын нийгэмд эзлэх байр суурь улам батжин бэхжиж, тайван цагийн бүтэц, зохион байгуулалтаараа өөрт ногдсон үүргийг гүйцэтгэх бүрэн чадвартай, харьцангуй богино хугацаанд өргөтгөн зохион байгуулагдаж байлдааны үүрэг гүйцэтгэхэд бэлэн болох нөхцөл боломжийг хангасан байхаар төсөөлсөн юм.

Нийгмийн байгуулал өөрчлөгдөхөд эсвэл зэвсэг, техникт хувьсгал гарахад, цэргийн шинэчлэл явагддаг нийтлэг зүй тогтолын дагуу манай оронд нэг дэх нөхцлөөр цэргийн шинэчлэлийг энэ үед хийх шаардлага, хэрэгцээ гарсан юм.

Дэлхий нийтийн жишиг, өөрийн орны түүхэн замналаас харахад **цэргийн шинэчлэлийг эрх баригч дээд байгууллага - төр, засгийн газрын шийдвэрээр, эрх зүйн үндсийг бүрдүүлж, улс орны эдийн засаг, үйлдвэрлэх хүчнийхээ хөгжлийн төвшинд зохицуулан явуулдаг.** Гэхдээ шинэчлэлийг улс төрийн бодлого, зэвсэгт тэмцэл явуулах хэрэгсэл, арга тактикаа нийцүүлж явуулахыг улс гүрэн бүхэн зорьдог байна. Манай улсын хувьд энэ л зүй тогтлын дагуу Зэвсэгт хүчнийхээ шинэчлэлийг явуулахдаа эрх зүйн орчинг хэрхэн бүрдүүлснийг бид энэ номын гуравдугаар бүлэгт илэрхийлсэн болно. Энэ үеийн цэргийн шинэчлэлийг эхлэхдээ эрх зүйн үндсийг зохих төвшинд бүрдүүлсний үндсэн дээр, ардчилсан нийгмийн ёс жаягаар явуулсан онцлогтой гэж үзэх үндэстэй юм. Шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойш “Батлан хамгаалах тухай” (1993), “Монгол Улсын хилийн тухай” (1993), “Монгол Улсын аюулгүй



байдлын үзэл баримтлал” (1994), “Монгол Улсын цэргийн номлолын үндэс” (1994), “Төрийн албаны тухай” (1994), “Иргэний хамгаалалтын тухай” (1994), “Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай” (1992), “Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай” (1994), “Онц байдлын тухай” (1995), “Төрийн нууцын тухай” (1995), “Төрийн нууцын жагсаалт батлах тухай” (1995), “Дайн бүхий байдлын тухай” (1997), “Дайны байдлын тухай” (1997), “Дайчилгааны тухай” (1997), “Гадаадын цэргийн хүчнийг байрлуулах, дамжин өнгөрүүлэх тухай” (1997), “Монгол Улсын төрийн цэргийн бодлогын үндэс”(1998), “Зэвсэгт хүчний тухай” (2002), “Цэрэг, цагдаагийн албан хаагчийг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай “ (2002) **зэрэг хуулиуд болон үзэл баримтлалуудыг батлан гаргасан нь цэргийн шинэчлэлийг явуулах эрх зүйн үндэс болсон юм.**

Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штабаас дээрх үзэл баримтлал, хууль, тогтоомжуудыг хэрэгжүүлэх үүднээс “Батлан хамгаалах салбарын хууль, тогтоомжийн эмхтгэл”, “Монгол Улсын Зэвсэгт хүчний эрх зүйн үндэс” гэсэн хууль тогтоомж, эрхийн актын эмхтгэлийг 1995, 1998, 2002 онуудад хэвлэн гаргасан байна. Эдгээр хууль, тогтоомжуудыг офицер, ахлагч, төрийн болон цэргийн албан хаагчдаар судлуулах, тэдний өдөр тутмын үйл ажиллагаанд гарын авлага болгох үүднээс тэдгээрийн агуулга, ач холбогдол, хэрэглээний давтамж, тогтвортой үйлчлэх магадлал зэргийг нь харгалзан хэсэг бүлэг болгон ангилсан байна. Энэ нь Зэвсэгт хүчний талаар гарсан эрх зүйн актуудыг тогтолцоо, бүтэц талаас нь танин мэдэх, баримт бичгийг ашиглах нөхцөл, боломжийг хөнгөвчилсөн нь арга зүйн ач холбогдолтой болсон юм.

Батлан хамгаалах тухай хуулиар “Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог тогтоож, төрийн байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн эх орноо батлан хамгаалах талаар хүлээх үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж” [6] өгөв. Улс орноо батлан хамгаалах тогтолцоог зөвхөн Зэвсэгт хүчний тусламжаар бүрдүүлж чадахгүй тул

энэ хуульд **“батлан хамгаалах нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг гадны зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалахад улс орны бэлэн байдлыг хангах, хамгаалах зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн нэгдмэл арга хэмжээ мөн”** гэж тодорхойлсон байна. Ийнхүү улс орноо батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг хангах зорилгоор төр, засаг, орон нутгийн засаг захиргааны нэгж, ард иргэдээс хэрэгжүүлэх улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүйн болон цэргийн арга хэмжээг улсын хэмжээнд нэгтгэн төлөвлөх, уялдуулан зохицуулах нэгдсэн тогтолцоо бүрэлдэх үндэс тавигдсан байна.

Монгол Улсын Зэвсэгт хүчний тухай хуульд Зэвсэгт хүчний байгуулалтын үндэс, зарчмыг тогтоосны дагуу цэргийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлсэн юм. Зэвсэгт хүчний байгуулалтын зарчим нь тухайн улс орны улс төр, нийгмийн тогтолцооноос хамаарч тодорхойлогддог байна.

Манайх Зэвсэгт хүчнийхээ шинэчлэлийг явуулахдаа Зэвсэгт хүчний шинэ байгуулалтын дараахь зарчимд тулгуурлаж байна.

- *зэвсэгт хүчин нь иргэний хяналтад байх*, Энэ зарчим нь иргэний ардчилсан нийгмийн Зэвсэгт хүчний байгуулалтын түгээмэл зарчим хэмээн үзэж шинээр томъёолон оруулсан юм. Зэвсэгт хүчинд тавих хяналтыг иргэд чөлөөт сонгуулиар сонгон байгуулсан төрийн эрх барих байгууллагаараа дамжуулан хэрэгжүүлдэг. Урьд нь цэргийн дэглэмтэй байсан, аль эсвэл түүхэн хөгжлийн тодорхой үедээ милитарист, фашист бодлого баримтлан дэлхий дахин, бүс нутаг, эх орондоо гамшиг, сүйрэл дагуулсан зарим улс оронд парламентынхаа дэргэд Зэвсэгт хүчинд иргэний хяналт тавих үүрэг, зорилго бүхий хүчтэй аппарат байгуулан ажиллуулдаг хувилбарыг сонгох шаардлага хэрэгцээгүй гэж манай төр, засаг үзсэн байна. Манай улсын хувьд иргэний хяналтыг хэрэгжүүлэх үндсэн субъект нь Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-аас байгуулсан Засгийн газар, батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байх болж байна. Энэ талаар бид энэ номын дөрөвдүгээр бүлэгт тодорхой гарган өгүүлсэн болно. Зэвсэгт

хүчинд тавих иргэний хяналт нь цэргийн байгууллагын “төвлөрүүлэн удирдах, нэгтгэн захирах” зарчимтай уялдаж, Зэвсэгт хүчний үйл ажиллагааны тодорхой хүрээг хамарч байгаа юм. Энэ үүднээс авч үзвэл Зэвсэгт хүчний иргэний хяналтын үндсэн объект нь *нэгд*, Зэвсэгт хүчинд төрийн хууль тогтоомж хэрхэн хэрэгжиж байгаа байдал, *хоёрт*, цэргийн мэргэжлийн удирдлагын чанар, үр дүн, цэргийн удирдах бүрэлдэхүүний ёс зүй, *гуравт*, цэргийн байгууллагын төсвийн санхүүжилтын ашиглалт, зарцуулалтын байдал гэж үзэж болно. Иргэний хяналтыг төлөвшүүлэхэд захиргааны батлан хамгаалахын мэргэжлийн хяналтын албаны гүйцэтгэх үүрэг чухал хэмээн үзэж, ийм албыг шинээр байгуулсан юм. Харин эдгээр асуудлаар хийсэн иргэний хяналт, шалгалтын дүн, мэдээлэл нийт иргэдэд бүрэн нээлттэй байлгахыг чухалчилж байна.

- *Зэвсэгт хүчнийг төрөөс удирдах* зарчим нь Зэвсэгт хүчнийг гагцхүү төрөөс удирдаж, түүний байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон бүхий л харилцааг зөвхөн төрийн хууль тогтоомж, цэргийн дүрмээр зохицуулж, хэрэгжилтэд нь төр, захиргааны хатуу хяналт тавьж байхыг онцгойлон үздэг.

- *Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалт, зэвсэглэл нь түүний тайван цагт болон дайны үед гүйцэтгэх үүрэгт зохицсон байх* нь Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалт, зэвсэглэл юуны түрүүнд зэвсэгт хүчинд төрийн хууль тогтоомжоор ногдуулсан чиг үүргээс хамаарч тодорхойлогдохыг зааж байна. Зэвсэгт хүчнийг байгуулах, хөгжүүлэх явцад энэхүү зарчмыг ямар нэг хэмжээгээр гажуудуулваас “Зэвсэгт хүчин үндсэн үүргээ биелүүлэхэд байнга бэлэн байх” зэрэг бусад зарчмуудын хэрэгжих баталгаа алдагдахад хүргэнэ. Ийм ч учраас энэ зарчмыг Зэвсэгт хүчний байгуулалтын тулгуур зарчмуудын нэг гэж үздэг.

- *Зэвсэгт хүчин үндсэн үүргээ биелүүлэхэд байнга бэлэн байх* зарчмыг тухайн цэргийн байгууллага, нэгжийн өөрт ногдуулсан үүргийг биелүүлэх бэлтгэлжилтийн төвшинг тодорхойлох төвлөрүүлсэн илэрхийлэл гэж ойлгодог. Цэргийн “бэлэн байдал”-аар даалгасан үүрэг, үйл ажиллагааны бүх талыг жигд хамарсан байх, цаг хугацаа,

орон зайн хүчин зүйлд зохицсон байх, үйл явдлын болзошгүй өрнөлийн хамгийн хүнд хувилбарт нийцэж байх, цагийн байдлын өөрчлөлтөд уян хатан зохицож байх гэсэн үндсэн шаардлагыг тавьдаг юм. Түүнчлэн цэргийн “бэлэн байдал”-ыг тодорхойлох төвлөрүүлсэн илэрхийлэл нь тоон болон чанарын үзүүлэлттэй, шинж чанарын болон цаг хугацаа, орон зайн хамааралтай байна. Иймд цэргийн анги, салбарын зориулалт, үүрэг, бүтэц, зохион байгуулалт, тэдгээрээс шууд хамааралтай тогтоогдох байлдааны болон тусгай үүрэг гүйцэтгэх бэлтгэлжилтийн төвшинг тодорхойлох төвлөрүүлсэн илэрхийллийг цэргийн анги, салбарийн зориулалт, төрөл, бүтцийн ангиллаар нь ялгавартайгаар тогтоох ёстой болсон юм. Энэ үндсэн дээр цэргийн бэлэн байдлын тухай асуудалд бодиттой, тодорхой хандах боломжтой болсон байна.

- *Зэвсэгт хүчний бүх төрлийн хангалтыг төрөөс баталгаажуулах зарчим нь* Зэвсэгт хүчнийг байгуулан хөгжүүлэх, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцлийг хангах үүргийг төр өөрөө, төрийн захиргааны байгуулагаараа дамжуулан хариуцаж байхыг ойлгож байна. Энэ зарчмыг мөрдсөнөөр Зэвсэгт хүчин нь төрийн байгууллага байх үндэс бүрддэг. Ийм учраас цэргийн албан хаагчдын улс төрийн зорилгоор эвсэлдэн нэгдэх, улс төрийн үйл ажиллагаа явуулдаг нам, эвсэл, холбооны гишүүн байх, төрийн бодлого, цэргийн удирдлагын шийдвэр, захирагч, даргын тушаалыг эсэргүүцэх, захирагч, даргын зөвшөөрөлгүйгээр цэргийн дүрэмд зааснаас бусад жагсаал, цуглаан зохион байгуулах, түүнд оролцох зэрэг эрхийг төрийн хуулиар хязгаарласан юм.

- *Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг цэрэг татлагаар болон сайн дурын үндсэн дээр гэрээгээр нөхөн хангах*, зарчим нь Зэвсэгт хүчнийг мэргэжлийн армийн шинж чанар, жишигт ойртуулан өөрчлөн хөгжүүлэх төрийн бодлогоос урган гарч, сайн дурын үндсэн дээр гэрээгээр алба хаах болон байнгын бүрэлдэхүүний эзлэх хувийг нийт бүрэлдэхүүнд нэмэгдүүлэх бодлого баримтлах нөхцлийг бүрдүүлж байна.

- *цэргийн албан хаагч бүр цэргийн мэргэжилд заавал сурах* зарчмын дагуу Зэвсэгт хүчин нь цэргийн албан хаагчид

цэргийн мэргэжил заавал эзэмшүүлэх үүрэгтэйгээс гадна цэргийн албанд орж цэргийн тангараг өргөсөн иргэн бүр цэргийн мэргэжил заавал эзэмших үүрэгтэй болгосон юм.

- *хууль дээдлэх, чанд сахилга, өндөр зохион байгуулалттай байх* зарчим нь төрийн хүчний үндсэн байгууллага - Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, төрийн тусгай албан хаагч учраас төрийн хууль дээдлэх, өндөр зохион байгуулалттай байх, цэргийн сахилгыг чанд сахих эрх зүйн байдлаар тодорхойлогдож байгаа юм. Ийм ч учраас цэргийн алба хаах иргэн бүр “... Монгол Улсын Үндсэн хуулиар хүлээсэн иргэний цэргийн үүргээ үнэнчээр биелүүлж, өвөг дээдсийнхээ ариун гал голомт болсон Монгол Улсынхаа халдашгүй дархан байдлыг амь бие үл хайрлан батлан хамгаалахаа эх орон, ард түмэндээ андгайлан тангараглаж...” цэргийн албаа эхэлдэг юм [7].

- *төвлөрүүлэн удирдах, нэгтгэн захирах*, зарчим нь монголын цэргийн байгууллагад тавьж ирсэн өнө эртний уламжлалтай зарчим юм. Зэвсэгт хүчин нь юуны түрүүнд улс оронд гадны зэвсэгт түрэмгийлэл учирвал түрэмгийллийг цэргийн хүчээр саатуулан няцаах төрийн цэргийн үндсэн байгууллага учир түүний дотоод харилцааг төвлөрүүлэн удирдах, нэгтгэн захирах зарчимд тулгуурлах нь практик ач холбогдолтой. Энэ зарчмыг гуйвалтгүй мөрдөх нь Зэвсэгт хүчний төрийн захиргааны удирдлагыг цэргийн мэргэжлийн удирдлагаас зааглахыг бас давхар нөхцөлдүүлсэн болно.

- *Зэвсэгт хүчин нэгдмэл байх* зарчим нь иргэний нийгэм байгуулах, эрх зүйт төр тогтоох, эдийн засгийн зах зээлийн харилцаанд шилжих, улсынхаа оршин тогтнохын аюулгүй байдлын дотоод хүчин зүйлийг хангах зорилтыг хэрэгжүүлж байгаа бага, буурай манай улсын хувьд Зэвсэгт хүчин нэгдмэл байх нөхцлийг бүрдүүлж өгсөн юм [8. 95-102].

Дээрхи зарчмууд нь Зэвсэгт хүчнийг шинэчлэх, цаашид хөгжүүлэн бэхжүүлэх бодлого, үйл ажиллагаандаа хатуу мөрдлөгө болгож байх манай төрийн бодлого мөн бөгөөд манай улсын төр, нийгмийн шинэчлэлийн давхар илэрхийлэл болж байгаа юм.

Эдгээр эрх зүйн өөрчлөлтүүд нь нэг талаас цэргийн шинэчлэлийн бодит тусгал болж өгөхийн зэрэгцээ түүнийг явуулах үндэс, бусад хууль, цэргийн дүрмүүдийг өөрчлөх эхлэл болсон байна. “Цэргийн дүрмүүд” (1999), “Цэргийн цол олгох тухай” (1994), “Монгол Улсын бүх цэргийн хар сүлд, төрийн ёслолын цагаан тугийн дүрэм” (1992) зэрэг олон дүрэм, журмыг батлуулан мөрдөж байна.

Цэргийн шинэчлэлийг хэрэгжүүлэхдээ “Батлан хамгаалах үйл ажиллагаа, Зэвсэгт хүчин бусад цэргийг шинэчлэх талаарх “Засгийн газрын хөтөлбөр” (1994 он), “Цэргийн шинэчлэлийн бодлого” (1997 он), “Цэргийн байгуулалтыг 2005 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр” (2002) гэсэн баримт бичгүүдийн дагуу явуулсан юм. Цэргийн шинэчлэлийн гол зорилго нь Зэвсэгт хүчнийг мэргэжлийн чиг хандлагатай, чадварлаг болгон шинэчлэх, улсын хил хамгаалалтыг бэхжүүлэхэд чиглэсэн байна.

Батлан хамгаалах тухай хууль [6. 37-44]-уар **Зэвсэгт хүчний удирдлагын төвшин, зааг ялгааг тогтоосон** нь цэргийн шинэчлэлийг удирдлагаас эхлэх таатай боломжийг бүрдүүлсэн юм. Батлан хамгаалах яамны чиг үүрэг үндсэндээ өөрчлөгдөж, цэргийн яамнаас иргэний яам болон хувирах шаардлагатай болсон байна. Түүний батлан хамгаалах салбарт явуулах бодлого, үйл ажиллагааны дийлэнх хэсэг нь иргэний нийгэм, байгууллагад хандсан, багаахан хэсэг нь Зэвсэгт хүчнийг захиргааны удирдлагаар хангах, иргэний хяналт тавихад чиглэгдэх эхлэл тавигдсан байна. Харин Батлан хамгаалах яам 1993 оноос энэхүү шинэчлэлийг эхлэхгүй 3–4 жил болсон бөгөөд түүнийг 1997 оноос “Ардчилсан холбоо” эвслийн Засгийн газраас явуулж эхэлсэн боловч мөнөөх цэргийн яамны үүргээс нь бүрэн салж чадалгүй удаашруулсан байна. Өнөөгийн байрнаас харвал Батлан хамгаалах яам төлөвшиж, үйл ажиллагаа нь төлөвлөсөн голдрилийн дагуу явж эхэллээ.

Нэгэнт Батлан хамгаалах яам энгийн иргэний яамдын адил төр, нийгэм, иргэний байгууллагатай голлон харьцаж, улс орны батлан хамгаалах бодлого, түүний хэрэгжилтийн зохицуулалтыг хийх, Зэвсэгт хүчинд иргэний хяналт тавих болсон учир энэ асуудлыг хариуцсан засгийн газрын гишүүн,

батлан хамгаалахын сайд цэргийн жанжин байхаасаа улс төрийн зүтгэлтэн – энгийн иргэн хүн байх нь илүү тохиромжтой болов.

Цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллага - Зэвсэгт хүчний Жанжин штабын гүйцэтгэх ажлын хүрээ, чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт нь зөв, төлөвшилт нь харьцангуй богино хугацаанд, хурдацтай явагдаж байна.

Бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийн улмаас буурсан Зэвсэгт хүчний чадавхийг түүний үйл ажиллагааны болон агуулгын шинэчлэлээр эсвэл зэвсэглэл, техникийн шинэчлэлээр нөхөж чадсан тохиолдолд цэргийн шинэчлэл жинхэнэ утгаараа биелэлээ олох ёстой байлаа.

Энэ үеийн цэргийн шинэчлэлийн практик ажиллагаа нь цэргийн болон Зэвсэгт хүчний байгуулалтын асуудлыг юуны түрүүнд голлон хөндсөн чиг хандлагатай байв. Улс орон зах зээлийн харилцаанд шилжих үед, гадаад зээл, тусламж, дэмжлэгт тулгуурласан төсөв тасарч эхлэхэд түүнд томоохон байр суурь эзэлж байсан батлан хамгаалах зардлыг улсын төсөв даах чадваргүй болж эхэлсэн юм. Иймээс эхэн үедээ цэргийн шинэчлэлийг **зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалтыг хураангуйлах, цомхон болгоход голлон чиглүүлсэн байна.** Энэ үйл ажиллагаа “Монгол Улсын төрийн цэргийн бодлогын үндэс” дэх “Монгол Улс тайван цагт улс орныхоо батлан хамгаалах хэрэгцээ шаардлага, эдийн засгийн боломжид нийцсэн цомхон . . . Зэвсэгт хүчинтэй байна” гэсэн заалтад тулгуурласан юм [5. 13].

Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалт нь түүний тайван цагт болон дайны байдлын үед гүйцэтгэх үүргээс шууд хамааралтай бөгөөд эдгээр үндсэн чиг үүргээс Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалт, төрөл, мэргэжлийн цэргийн хоорондын тооны харьцаа, тэрчлэн зэвсэгт тэмцэл явуулах стратеги, тактик, хүмүүнлэгийн үүрэг гүйцэтгэх ажиллагааны арга, хэлбэр тодорхойлогдсон байна.

*Зэвсэгт хүчин нь зохион байгуулалтын хувьд мотобуудлага, төрөл мэргэжлийн цэргийн бусад нэгтгэл, ангиудаас болон ар тал-техникийн, сургалт-бэлтгэл, соёл,*

*сурталчилгаа-хүмүүжлийн, хүн эмнэлэг, аж ахуйн-үйлчилгээний анги, байгууллагаас бүрдэж байна.* Цэргийн нэгтгэл, ангиудын тайван цагийн бүтэц, зохион байгуулалт, байршилтад 1997 оноос зарчмын өөрчлөлт оруулсан байна. Цэргийн нэгтгэл, ангийг дивиз-хороо-батальоны бүтцээс батальоны цомхон бүтцэд шилжүүлснээр Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийг тоо болон бие бүрэлдэхүүний байдлыг 1980–аад оныхыг нь 2000 оныхтой харьцуулахад нэгтгэл, ангиудын тоо 30 хувиар, бие бүрэлдэхүүний тоо 2,5 дахин цөөрсөн байна. Ингэснээр Зэвсэгт хүчний “батальон – хороо – дивиз – арми” гэсэн бүтцийг “батальон – хороо” гэсэн энгийн бүтцэд шилжүүлсэн бөгөөд нэгтгэл, ангийн байршилд өөрчлөлт оруулав. Цэргийн шинэчлэл агуулгын гэхээсээ хэлбэрийн шинж чанартай явагдаж эхэлсэн гэдгийн агуулга үүнд оршиж байгаа юм.

Зэвсэгт хүчин нь **өөрийгөө хамгаалах бодлогод зохицсон зэвсэглэл, байлдааны техниктэй** байхад нийцүүлэн цэрэг-техникийн бодлогоо тодорхойлсон юм. Манай зэвсэглэлд байгаа зэвсэг, байлдааны техникийн дийлэнхи загварууд хуучин ЗХУ-д 60-70-аад онд үйлдвэрлэсэн, сүүлийн жилүүдэд технологийн дагуу сэргээн сайжруулах засвар, техникийн үйлчилгээ хийгдээгүй хэдий ч ашиглалтын зохих нөөцтэй, технологийн чанар байдлын хувьд зориулалтаар нь ашиглах боломжтой, гэхдээ тэдгээрт сэргээн сайжруулах техникийн үйлчилгээ зайлшгүй хийх шаардлагатай байгаа зэвсэглэл техник юм. Зэвсэг, байлдааны техникийн зарим хэсэгт сэргээн сайжруулалт хийх шаардлагатай болсон бөгөөд үүнийг үйлдвэрлэгч орны бэлэн технологи, мэргэжилтний оролцоотойгоор дотооддоо хэрэгжүүлэх үйлдвэрлэлийн материаллаг бааз, мэргэжлийн боловсон хүчинтэй. Зарим төрөл, загварын зэвсэглэл, цэргийн техникийг зайлшгүй шинэчлэх шаардлага байгаа юм. Иймд эн тэргүүнд Зэвсэгт хүчний зэвсэглэл, байлдааны техникийг шинэчлэх Засгийн газрын дунд хугацааны хөтөлбөрийг батлан мөрдөх хэрэгтэй гэж цэргийн командлал үздэг. Зэвсэг, цэргийн техникийн хадгалалт, арчлан хамгаалалт, техникийн үзлэг, үйлчилгээг үндсээр нь сайжруулж, шууд зориулалтаар нь ашиглах боломжийг хадгалах нь манай цэрэг-техникийн бодлогын үндэс болдог.



Манай улсын эдийн засгийн эдүгээгийн нөхцөл байдал нь цэргийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг идэвхжүүлэх, түүний дотор цэрэг-техникийн хамтын ажиллагааг өргөтгөн, энэ үндсэн дээр гадаад орны дэмжлэг, туслалцаанд тулгуурлан зарим төрлийн зэвсэг, техникийг шинэчлэх зорилт тавин идэвхтэй ажиллахын чухал болохыг нөхцөлдүүлж байна.

Монголын Зэвсэгт хүчний өөрийгөө хамгаалах зэвсэгт тэмцэл явуулах хэрэгсэл, зэвсэглэл, техникт болон арга тактикт эхнээсээ чанарын өөрчлөлт хийгээгүй бөгөөд хийх ч эдийн засгийн чадавхи болон оюун санааны боломж бүрдээгүй юм.

Цомхон, чадварлаг Зэвсэгт хүчинтэй байх төрийн бодлого зөвхөн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийж, зэвсэглэл, техникийн тоог цөөрүүлж, чанарыг сайжруулснаар хязгаарлагдахгүй, гол нь **цэргийн анги, салбарын сургалт, бэлтгэлжилт, чадавхийг** мэргэжлийн армийн шинж чанар, жишигт ойртуулан шинэчлэхэд оршиж байна. *Энэ нь Зэвсэгт хүчнийг бүтцийн өөрчлөлтөөс үйл ажиллагааны шинэчлэлд шилжүүлэх зорилтын үндсэн агуулга болж байгаа юм.* 1998 оноос цэргийн сургалтын агуулга үндсэндээ шинэчлэгдэж, сургалтын технологийг боловсронгуй болгох, сургалтын шинэ дэвшилттэй арга хэлбэрийн эрэл, хайгуул идэвхжив. Өнгөрсөн хугацаанд нэг бүрийн болон жижиг салбарын мэргэжлийн бэлтгэл дээр тулгуурласан сургалтын тогтолцоог үндсэндээ бүрдүүлж чадлаа. Энэ тогтолцоог цаашид улам төгөлдөржүүлэн хэрэгжүүлж чадваас байлдааны болон тусгай ямар ч үүрэг гүйцэтгэх чадвартай цэргийн шилмэл анги, салбаруудтай болж, энэ хэрээр Зэвсэгт хүчин бүхэлдээ чадварлаг болох анхан шатны нөхцлүүд бүрдэх юм.

Зэвсэгт хүчний байнгын бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлийг тэдний бүтцийн ангиллаар, мэргэжил, албан тушаалаар, алба хаасан хугацаагаар ялгавартай тогтоож, тасралтгүй явуулах журамд шилжүүлэх бодлогын чиглэлийг 1998 оноос тодорхойлон хэрэгжүүлж байна. Өнгөрсөн хугацаанд цэргийн албан хаагчдын сургалт, бэлтгэлээр хүрсэн байх төвшин, цэргийн ангиудын сургалт, бэлтгэлийн явц байдал, үр дүнг шалгаж үнэлэх заавар, төрөл бүрийн

сургалтын хөтөлбөрүүдийг шинэ шаардлагад нийцүүлэн шинэчлэн мөрдүүлэх талаар дэс дараатай арга хэмжээ авч байна. Цэргийн анги, салбарын сургалт, бэлтгэлийг хугацаат албаны цэргийн албан хаагчдын сурлагын үзүүлэлтээр үндсэндээ хэмжиж байсныг эдүгээ байнгын бүрэлдэхүүн болсон офицер, ахлагч, гэрээт цэргийн албан хаагчдын бэлтгэлжилт, анги, салбарын жигдрэлтийн төвшингээр дүгнэх болов.

Зэвсэгт хүчин нь тайван цагт улсын хил хамгаалахад оролцох томилгоот бүрэлдэхүүнийг улсын хил хамгаалах арга тактикт сургах, байгалийн болон нийтийг хамарсан гамшиг, үйлдвэрийн ослын аюулаас хүн ам, эд баялгийг хамгаалахад туслах мэдлэг, дадлагыг нийт бие бүрэлдэхүүнд эзэмшүүлэх, олон улсын зэвсэгт мөргөлдөөний хуулийг байлдааны анги, салбарын цэргийн албан хаагчдаар судлуулах, НҮБ-ын энхийг сахиулах хүчний хүрээнд үүрэг гүйцэтгэх арга ажиллагааны үндсийг нийт офицер, ахлагч нарт зааж эзэмшүүлэх зэрэг шинэ шаардлагыг цэргийн сургалт, бэлтгэлийн төлөвлөлтөд тусган хэрэгжүүлж эхлэв. Төсөв, хөрөнгө мөнгө хязгаарлагдмал байгаа хэдий ч цэргийн сургалтын материаллаг баазаа бэхжүүлэх талаар доороос санаачлага, хөдөлгөөн гаргаж байгаа нь шинэ шаардлага хангахуйц сургалтын материаллаг бааз цэргийн нэгтгэл, ангийн эдүгээгийн зайлшгүй хэрэгцээ болж байгааг харуулж байна.

Цэргийн мэргэжлийн зэргийн үнэлэмжийг мэдэгдэхүйц нэмэгдүүлж, зэрэгтэнд тавих шаардлага, шалгуур үзүүлэлтийг мэргэжлийн армийн жишигт ойртуулан шинэчлэн мөрдүүлснээр цэргийн мэргэжлийн зэрэг эзэмшсэн цэргийн албан хаагчийн нэр хүнд дээшилж байна. Энэ бол Зэвсэгт хүчинд цэргийн мэргэжлийн зэрэгтний тоо богино хугацаанд өсч, энэ чанараараа нийт цэргийн албан хаагчдыг чадваржуулахад чухал хөшүүрэг болох ирээдүйн төлөв харагдаж байна.

Ийнхүү цэргийн анги, салбарын өдөр тутмын үндсэн үйлдвэрлэл болсон цэргийн сургалт, бэлтгэлийн тогтолцоог шинэчлэх нь Зэвсэгт хүчний байгуулалтыг төгөлдөржүүлэх гол зорилт болон дэвшигдэж байгаа бөгөөд энэ нь нэг

дайралтаар хялбар шийдвэрлэгдэх асуудал биш, ихээхэн хүчин чармайлт, бага бус хөрөнгө шаардсан амаргүй зорилт болох нь харагдаж байна. Энэ зорилтыг хангахын тулд *нэгд*, цэргийн сургалтын зорилтыг цэргийн албан хаагчийн бүтцийн ангилал, мэргэжил, албан тушаал, алба хаасан хугацааг харгалзан сургуулийн үе шат нэг бүрээр зөв тодорхойлж хэвших; *хоёрт*, сургалтын дээрхи зорилт, суралцагсдын эзэмшсэн байх мэдлэг, чадвар, дадлагын бүх үзүүлэлтийг багтаасан агуулга бүхий сургалтын хөтөлбөрийг хичээл тус бүрээр боловсруулан мөрдүүлэх, түүнийг байнга тодотгон шинэчилж байх; *гуравт*, сургалтын материаллаг баазыг орчин үеийн эрэлт, шаардлагад нийцүүлэн бэхжүүлэх; *дөрөвт*, сургалтад баримтлах зарчмыг бие бүрэлдэхүүний ангиллаар ялгавартай тогтоож, үүнтэйгээ уялдуулан сургалтын эрэмбэ дараалал, үе шат, арга хэлбэр, зохион байгуулалтыг тодорхойлж явуулах; *тавд*, цэргийн сургалтыг бүх шатны захирагч, штабаас байнгын удирдлагаар хангах; *зургаад*, сургалтын явцад хийх хяналт шинжилгээ, үе шатны төгсгөлд өгөх үнэлгээ, дүгнэлтийг бодитой болгохоос өөр арга замгүй гэж манай Зэвсэгт хүчний удирдлага үзэж байна.

Офицер, ахлагчийн сургалтад нэгд, шинжлэх ухаанч байх; *хоёрт*, албан тушаалын үүргээ мадаггүй гүйцэтгэхэд сургах; *гуравт*, суралцагсдын идэвх, ухамсрын үндсэн дээр сургах; *дөрөвт*, сургалтад систем дараалалтай, иж бүрэн хандах; *тавд*, суралцагсдын бололцоог дээд зэргээр дайчлан сургах; *зургаад*, мэдлэг, дадлага, чадвар гүн бат, бүтээлч байх; *долоод*, сургалтад нийтээр болон нэг бүрчлэн хандах зарчим баримтлах нь оновчтой гэж үздэг.

Харин байлдагч, түрүүч нарын сургалтад нэгд, орчин нөхцөл бүрдүүлсэн байх; *хоёрт*, цэргийн мэргэжилд заавал сургах; *гуравт*, цэргийн хэргийн зайлшгүй шаардлагатай бүхэнд сургах; *дөрөвт*, систем дараалалтай байх; *тавд*, хялбар дөхөм байх; *зургаад*, ухамсарлуулан идэвхжүүлж эрчимтэй сургах; *долоод*, гүн бат мэдлэг, бүтээлч байх зарчим баримтлах нь зүйтэй гэж үздэг. Эдгээр зарчмууд нь цэргийн сургалтыг зохион байгуулахдаа туйлын бүтээлчээр хандахыг манай цэргийн ангийн захирагч, штабаас шаардаж буй хэрэг юм.

Цэргийн сургалт, бэлтгэлийн тогтолцоог шинэчлэн

хэрэгжүүлж чадваас дараахь үр дүнд хүрнэ гэж цэргийн командлал төсөөлж байна. Үүнд:

*Нэгдүгээрт*, цэргийн сургалтын агуулга, хэлбэр, бүтэц, зохион байгуулалтад зарчмын болон агуулгын өөрчлөлт орж, сургалтын процесс эрчимжинэ.

*Хоёрдугаарт*, өнөөгийн цэргийн сургалтад ноёрхсон субъект-объектын харилцаа субъект-субъектийн харилцаа болж, суралцагсдын бүтээлч сэтгэлгээ мэдэгдэхүйц хөгжинө.

*Гуравдугаарт*, цэргийн албан хаагчийн өөрийгөө хөгжүүлэх, мэдлэг, чадвар, дадлагаа байнга нэмэгдүүлж байх орчин, нөхцөл бүрдэнэ.

*Дөрөвдүгээрт*, цэргийн сургалтын процесс эрчимжиж, хамгийн бага цаг хугацаа, зардлаар дээд үр дүнд хүрэх нөхцөл бий болно.

*Тавдугаарт*, багш, сурган хүмүүжүүлэгч болсон офицерын бүрэлдэхүүний мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх хөшүүрэг бий болж, тэд өөрийгөө хөгжүүлэхээс өөр аргагүй болох орчин бүрдэнэ.

*Зургаадугаарт*, сургалтын үр дүнг хэмжих үзүүлэлтүүд тодорхой болж, цэргийн бэлтгэл, бэлэн байдалд өгөх үнэлгээ, дүгнэлт бодитой болно.

*Долоодугаарт*, цэргийн хөдөлмөрийг үнэлэх эдийн засгийн хөшүүрэг бий болж, сургагч, суралцагсдын идэвхийг өрнүүлэх урамшууллын болон хариуцлагын тогтолцоо бүрдэнэ.

*Наймдугаарт*, хамгийн чухал нь Зэвсэгт хүчнийг мэргэжлийн армийн чиг хандлагатай чадварлаг болгох төрийн бодлого үндсэндээ хэрэгжих болно [8. 114,115].

Цэргийн шинэчлэлийн бодлого дотор цэргийн боловсон хүчний сургалт, цэргийн сургуулийн асуудал чухал байр эзэлсэн юм. Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн хуралдаанаар сүүлийн арван жилд Цэргийн нэгдсэн дээд сургууль (ЦНДС)-тай холбоо бүхий асуудлыг бараг жил

тутам хэлэлцэж, ЦНДС–ийг Цэргийн их сургууль (ЦИС) болгох (1991), түүний дэргэд адъюнктур (доктрантур) –ын сургалт эхлүүлэх (1992), цэргийн шинжлэх ухаан, техникийн ухааны мэргэжлийн ангиллаар эрдэм (дэд доктор)–ийн зэрэг хамгаалуулах төрөлжсөн зөвлөл байгуулах (1995), ЦИС-ийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчилж (1996), Цэргийн эрдэм шинжилгээний хүрээлэн (ЦЭШХ), Команд штабын институт (КШИ), Хилийн цэргийн дээд сургууль (ХЦДС), ерөнхий цэргийн факультет, техникийн факультет, Цэргийн хөгжмийн сургууль, Ахлагч бэлтгэх төв, Алдар спорт клуб зэрэг үндсэн нэгжтэй болгосон ба хожим нь ЦИС-ийг Батлан хамгаалахын их сургууль (БХИС) болгож, харъяа болон бүрэлдэхүүндээ хүрээлэн, сургууль, коллеж, төвүүдтэй байхаар зохион байгуулах (1999) зэргээр цэргийн сургуулийн бүтэц, сургалтыг “ЦИС” хөтөлбөр (1998), “БХИС – 2005 хөтөлбөр (2001)-ийн дагуу боловсронгуй болгож ирлээ.

***Зэвсэгт тэмцлийг явуулах арга тактик*** нь хэдийгээр зэвсэглэл, техникийн чанар байдалтай холбоотой ч түүний зорилго, төрийн бодлогоос хамааралтай юм. Чухамхүү энэ учир байдлаас хамаарч цэргийн урлагт өөрчлөлт шинэчлэл хийхийг монголын төрийн бодлогоор шаардсан байна. Цэргийн урлагаас ялангуяа цэргийн стратеги, тактикийн онол, практикийн нэлээд тулгуур асуудлыг дахин эргэж харах, шинээр боловсруулах хэрэгцээ, шаардлага гарсан юм. Зах зээлийн шилжилтийн үед Зэвсэгт хүчний байнгын бие бүрэлдэхүүний оюуны чадавхийн нэлээд хэсэг нь орон тоо зохион байгуулалтын, эдийн засаг, нийгмийн хамгааллын байдлаас хамаарч цэргээс халагдсан ба үлдсэн хэсэгт шинэлэг сэтгэлгээ, нөөц бололцоогоо ашиглах хөшүүрэг, механизм дутагдсанаас онолын талаар өөрчлөлт шинэчлэл удаашралтай явагдсан байна. Өөрөөр хэлбэл цэргийн урлагийн онолын асуудлыг манай офицерууд өмнө нь Зөвлөлтийн цэргийн урлагаас хуулбарлах, бэлэнчлэх сэтгэлгээгээр “хөгжүүлж” ирснээс нийгмийн шинэчлэлийн цоо шинэ зорилттой уялдуулан өөрийн орны өвөрмөц онцлогт нийцүүлэн түүнийг хөгжүүлэх ажиллагаа эхэн үедээ удаашралтай, далайц, хэмжээ багатай явагджээ. Монголын эртний уламжлалт цэргийн урлагаа социалист армийн европ маягийн цэргийн урлагаар бүрэн сольсон нь шинэ нөхцөл байдалд тэдгээрийн ололттой талуудыг зохистойгоор авч

ашиглахад бэрхшээл учруулав. Цэргийн урлагийн уламжлалт болон сонгодог хэлбэрийн аль алиныг харьцуулан судлах хэрэгцээ шаардлагатай тулгарсан байна. Батлан хамгаалах салбарын цэргийн эрдэмтэн судлаачид [ 9. 10. 11. 12. 13] цэргийн урлагийг улируулан, харьцуулан судалж, бүтээлээ хэвлүүлснээр офицеруудын онолын сэтгэлгээ хөгжих, цэргийн сургалт, түүний агуулгад нөлөө үзүүлэх эхлэл болсон юм. Түүний нэг илрэл нь цугларалт, сургалтаар тактикийн сонгодог хувилбаруудаас гадна “тогтоон барих байлдаан”, “түйвээх байлдаан”, “сөрөг давшилт”, “терроризмтай тэмцэх тактик” -ийн онол, практикийн асуудлыг судалж, жижиг бүлгээр үүрэг гүйцэтгэх, террорист бүлэглэлтэй тэмцэх, энхийг сахиулах, хүмүүнлэгийн ажиллагаанд болон гамшиг ослын хор уршгийг арилгахад цэргээ сургаж эхэлсэн явдал юм.

Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнтэй зохиох **соёл, хүмүүжлийн ажлын агуулга, арга хэлбэрийг цэргийн шинэчлэлтэй нийцүүлэн өөрчлөх үйл ажиллагаа** эхлэл төдий байна. Бие бүрэлдэхүүнтэй зохиох мэдээлэл, сурталчилгаа, соёл, хүмүүжлийн ажлыг зохион байгуулах, шалгаж үнэлэх заавар зэрэг удирдлагын баримт бичгийг шинэчилжээ. Энэ үйл ажиллагаа сааталтай явагдахад нөлөөлсөн хэд хэдэн сөрөг үр дагавар байсан байна. Нийгмийн байгууллын өөрчлөлт, зах зээлийн шилжилтийн эхэн үед Зэвсэгт хүчнийг улс төрийн хүчнүүдийн бодлогоос ангид байлгах гэсэн сонирхол, МАХН-ын үзэл сурталд үнэнч цэргийн улс төрийн ажилчдаас түргэн салах гэсэн оролдлогоос үүдэлтэй зохион байгуулалтын алдаа гаргасантай холбоотой ажээ. Тухайлбал, Зэвсэгт хүчний байнгын бие бүрэлдэхүүнийг хуулиар намын харъяалалгүй болгосон атал, Зэвсэгт хүчний дотор улс төрийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагыг татан буулгахдаа түүнд багтаж байсан мэдээлэл, сурталчилгаа, соёл, хүмүүжлийн ажлыг зохион байгуулж явуулах байгууллага, ажилтан нарыг хамтад нь бараг үүрэгт ажлаа явуулах бололцоогүй болгосон явдал юм.

Цэргийн шинэчлэлээр шийдвэрлэх зорилтын нэг нь олон улсын өнөө үеийн нийтлэг чиг хандлага, улс орныг батлан хамгаалах эрх ашигт нийцүүлэн **цэргийн албыг** олон

хувилбараар хаах нөхцөл, бололцоог бүрдүүлэх явдал байв. Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд, сайн дурын үндсэн дээр гэрээгээр Зэвсэгт хүчинд алба хаах, цэргийн албыг дүйцүүлэн хааж болох тухай заалт бүхий нэмэлт өөрчлөлт оруулав. Үүний дагуу холбогдох дүрэм, журмыг боловсруулан түүнийг хэрэгжүүлж эхэлсэн байна. Иргэдийг гэрээт цэргийн албанд сонгон элсүүлэх, тэдний сургалт, алба, ахуй хангалтыг зохион байгуулах ажлыг шаардлагын төвшинд явуулахад ихээхэн бэрхшээлтэй тулгарсан байна.

**Харин цэргийн шинэчлэлийн бодлоготой уялдан батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх, төлөвшүүлэх асуудлаар судалгаа шинжилгээний ажлыг явуулж ирсэн байна. Батлан хамгаалах нэгдмэл тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг өөрийн ард иргэдийг батлан хамгаалах үйл хэрэгт бэлтгэх, улс орныхоо эдийн засгийг батлан хамгаалахад зохицуулах, нутаг дэвсгэрээ батлан хамгаалах эрх ашигт нийцүүлэн бэлтгэх, Зэвсэгт хүчнээ цомхон, чадварлаг болгон шинэчлэх, батлан хамгаалах удирдлагын тогтолцоог бүрдүүлж төлөвшүүлэх асуудлаар онолын боловсруулалт хийснээр эдгээр судалгаа шинжилгээний ажил үр дүнгээ өгчээ. Харин түүнийг амьдрал практикт хэрэгжүүлэх эрх зүйн болон зохион байгуулалтын ажиллагаа удаашралтай явагдаж байна.**

1990-ээд оноос эхэлсэн **Монголын цэргийн шинэчлэлийн үр дүнг шинэ зууны эхээр нэгтгэн үзвэл Монгол Улсын батлан хамгаалах болон цэргийн чадавх буурсан байдалтай байна** гэсэн дүгнэлтэд хүрнэ.

XXI зууны эхээр цэргийн шинэчлэлийг жинхэнэ утга агуулгаар нь төгс гүйцэт явуулж, Монгол Улсын төрийн цэргийн бодлогын үндэст заасан “ . . . цомхон, чадварлаг, мэргэжлийн чиг баримжаатай зэвсэгт хүчинтэй” [4. 13] *больё гэвэл хэлбэрийн шинэчлэлийг агуулгын, зохион байгуулалтын шинэчлэлийг үйл ажиллагааны шинэчлэл болгох шаардлагатай* байгаа бөгөөд Зэвсэгт хүчнийг тайван цагт болон дайны үед гүйцэтгэх үүрэгт нь зохицсон зэвсэглэл, байлдааны техникээр хангах хэрэгтэй болохыг

бид дээр дурдсанаар илэрхийлж байна.

XX зууны сүүлчээр Монгол Улсын цэргийн шинэчлэлийг явуулж эхэлсэн оролдлого, үр дүнгийн туршлагаас харвал, цэргийн шинэчлэлийг явуулахын өмнө юуны түрүүнд үзэл баримтлал /концепция/-аа баттай, үнэн зөв тодорхойлох, эрх зүйн орчин бүрдүүлэх, хэрэгжүүлэх хөтөлбөр боловсруулахаас эхлэх бөгөөд эдгээр нь дараахь багц асуудлыг агуулж байна.

**Нэгдүгээрт.** Монголын хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм, төрийн байгууллын онцгой эрх ашгийг хүчирхийллийн хэрэгслээр хамгаалах цэрэг – улс төрийн ойлголт, түүнээс урган гарах Зэвсэгт хүчний зориулалт, үүрэг, зорилго, хамаарлыг шинээр тодорхойлох Монгол Улсад учирч болзошгүй цэргийн аюулыг бодитой тогтоох, түүнтэй холбоо бүхий асуудалд хандах арга хэлбэрийг зөв зохистой илэрхийлэх асуудал юм. Цэрэг–улс төрийн энэ мэт асуудлыг шийдвэрлэснээр цэргийн шинэчлэлийг явуулах үндсэн гол чиг шугамыг тогтоодог байна. Эдгээрийн утга санаа, агуулга нь: Үндсэн хууль дахь Зэвсэгт хүчний зориулалт, үүрэг, төрийн эрх барих байгууллага /институт/-уудын эрх мэдлийн хуваарилалтыг хуульчилж өгснөөр, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Төрийн цэргийн бодлого, Зэвсэгт хүчнийг ашиглах номлол, Гадаад бодлогын үзэл баримтлал зэрэг тулгуур баримт бичигт тусгаснаар гарна. Эрх мэдлийг гартаа авсан субъектүүд цэргийн шинэчлэлийн бодлого, хөтөлбөрийн агуулгаар нэгдсэн ойлголт, “зөвшилд” хүрснээр, түүнийг хэрэгжүүлэх ажиллагаа тууштай явагдах үндэс бүрддэг байна.

**Хоёрдугаарт.** Цэрэг – эдийн засгийн багц асуудал орно. Цэргийн амьдрал, ахуй хангалт, сургалт, шинжилгээ судалгаа, зэвсэглэл техникийн шинэчлэл, хангалт зэрэг түүний амьдралын бүхий л хүрээг хамарсан эрс тэс өөрчлөлтийн асуудал багтана. Энэ нь эдийн засгийн өөрчлөлтийг төлөвлөх – хөтөлбөржүүлэх - үйл ажиллагааг санхүүжүүлэх, нөөц бүрдүүлэлтийг зохион байгуулах, цэргийн хэрэгцээг хангах, худалдан авах, захиалга, шаардлагыг биелүүлэх гэх мэт олон арга хэмжээг цоо шинэ арга хэлбэрээр хэрэгжүүлснээр бодит биелэлээ олно.



**Гуравдугаарт.** Зэвсэгт хүчний байгуулалт өөртэй нь холбоо бүхий багц асуудал. Зэвсэгт хүчнийг цомхон чадварлаг болгох. Үүний тулд сайн дурын үндсэн дээр нийтээр татаж бүрдүүлдэг Зэвсэгт хүчнийг, сайн дурын үндсэн дээр гэрээ, хэлцлээр бүрдүүлэх мэргэжлийн чиг хандлагатай Зэвсэгт хүчин болгох үйл ажиллагааг явуулна. Цэргийн шинэчлэлийн сүүлчийн удаагийн бодлогын онцлог болох цэргийн удирдлагын байгууллагуудын чиг үүргийг юуны түрүүнд ялган салгаж тусгаарлах, Зэвсэгт хүчин, төрөл, мэргэжлийн цэрэг, цэргийн нэгтгэл, ангийн харьцаа, бүтэц, бүрэлдэхүүн, орон тоо, зохион байгуулалтыг шинэчлэх, цэргийн стратеги, оперативын урлаг, байлдааны ажиллагааны тактикийн үндэс, цэргийн сургалтын арга технологи, хангалтын журам зэргийн агуулгыг шинэчлэн өөрчлөх асуудал багтдаг байна.

**Дөрөвдүгээрт.** Нийгмийн болон цэргийн эрх зүйн зохицуулалтын багц асуудал. Цэргийн хууль, дүрэм, заавар зэрэг эрхийн актын зохицуулалтыг шинэчлэх, ингэснээрээ цэргийн албан хаагчдын нийгмийн хамгааллыг төр нь ивээлдээ аван хамгаалж, тэднийг “алдахгүй” байх боломжийг бүрдүүлнэ. Цэргийн шинэчлэлийг явуулахад цэргийн хэргийн өндөр боловсролтой, шинэ зорилго, зорилтоо зөв танин мэдсэн, зохион байгуулах ур чадвартай, даргалах бүрэлдэхүүн гол үүрэг гүйцэтгэнэ. Тэдний үйл ажиллагааг идэвхжүүлэхэд нийгмийн болон эрх зүйн хамгаалалт чухал юм.

**Тавдугаарт,** Ёс суртахуун, сэтгэл зүйн багц асуудал. Хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийн ардчилсан төрийн Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний ёс суртахуун, сэтгэл зүй социалист нийгмийн Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийхээс чанарын ялгаатай байна. Үүнийг бурхан багш бий болгохгүй, гагцхүү нийгэм, төрийн нөлөө, тодорхой чиглэл, зорилготой, цэгцтэй бодлого, хөтөлбөрөөр, идэвхтэй үйл ажиллагаа явуулснаар бүрэлдүүлнэ. Үүнийг хэрэгжүүлэхдээ нийгмийн сэтгэл зүй, социологи, эрх зүй, мэдээлэл, шашин, нийгэм – Зэвсэгт хүчний харьцаа, эх оронч хүмүүжил зэрэг асуудлаар шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа шинжилгээний ажлыг явуулж, тэдгээрийн үр дүнд тулгуурладаг байна.

Эх оронч, мэргэшсэн, эв нэгдэлтэй бүлэг хүчин цэргийн шинэчлэлийг хийдэг байна. Цэргийн шинэчлэлийг амжилттай явуулахын тулд төрийн энэ чухал үүргийг эрх баригчид юун түрүүнд ойлгон ухамсарлах, ач холбогдол өгөх; хоёрт, цэргийн шинэчлэлийн салаа, салбар, зангилаа асуудал бүрийг боловсруулж чадах, хүчтэй оюуны чадавхийг бүрдүүлэх, гуравт, цэргийн шинэчлэлийг төрийн бүтэц дэх бүх байгууллагын дэмжлэг, ардчилсан нийгмийн өргөн олон түмний оролцоо, ил тод байдлыг хангах явдал юм.

Цэргийн шинэчлэл нь цэргийн албан хаагчдад хамгийн ойлгомжтой, ойр дөт явагдаж, офицер, ахлагч нэг бүрт өөрсдийнх нь хувийн материаллаг хангалт, мэргэшил, оюун санааны сонирхолд нийцэж, нийгмийн бааз суурь болох өргөн олон түмний зүгээс дэмжлэг авснаар хэрэгжих үндэс нь бүрддэг байна.

**АШИГЛАСАН НОМ БҮТЭЭЛ, СУРВАЛЖ,  
СУДАЛГААНЫ МАТЕРИАЛ**

1. Монгол цэргийн түүхийн товчоон. Тэргүүн дэвтэр. УБ., 1996. – 514 х. ба Дэд дэвтэр. УБ., 1996. – 570 х.
2. Хорьдугаар зууны Монгол цэрэг.
3. Defense white paper. Second edition. The ministry of defense. Mongolia. 2001. 144 pages.
4. Монгол Улсын Үндсэн хууль . УБ., 1992. – 104 х.
5. Монгол Улсын төрийн цэргийн бодлогын үндэс. УБ., 1998. – 40 х.
6. Монгол Улсын Зэвсэгт хүчний эрх зүйн үндэс. УБ., 2002. - 308х
7. Цэргийн тангараг.
8. Ц.Дашзэвэг. Зэвсэгт хүчнийг шинэчлэх бодлого, зорилт, үйл ажиллагаа. УБ., 2002. - 216х
9. Сарт Боржигин Жамбын Базарсүрэн. Чингис хааны цэргийн зэр зэвсэг. УБ., 2000. - 238 х.
10. Олхонууд Хайнзангийн Шагдар. Монголчуудын аян дайн, цэргийн урлагийн түүх (XIII зуун). Тэргүүн, дэд боть. УБ., 2000. – 840 х.
11. Ш.Паламдорж. Орчин үеийн дайн, зэвсэгт мөргөлдөөний тухай онолын асуудалд. УБ., БХИС. 2001. – 328 х.
12. Д.Мягмар, Б.Түмэн. Хууль бус (террорист) зэвсэгт бүлэглэлтэй тэмцэхэд цэргийн анги, салбарыг ашиглах нь. УБ., 2002. - 88 х.
13. Ш.Паламдорж. Терроризм, түүнээс сэргийлэх. УБ., 2003. 96 х.

ГУРАВДУГААР БҮЛЭГ  
**МОНГОЛЫН ЦЭРЭГ - ИРГЭНИЙ ХАРИЛЦААНЫ  
ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ БҮРДЭЛТ**

*Ph.D Г.Мягмаржав*  
*/БХЭШХ-ийн ЦИХСТ-ийн дарга/  
Б.Нэргүй*  
*/ЦИХСТ-ийн эрдэм*  
*шинжилгээний ажилтан/*

1990 оноос өмнө Монголын Цэрэг-иргэний харилцааг гол зохицуулж, үйлчилж байсан бодлогын чанартай баримт бичиг нь МАХН-ын мөрийн хөтөлбөр, түүнд туссан цэргийн бодлого байв. Түүнчлэн Бүх нийтийн цэргийн үүрэгтний тухай, Батлан хамгаалах тухай хууль зэрэг эрх зүйн баримт бичгүүд байв. Эдгээр баримт бичгүүд нь Социалист нийгмийн үзэл сурталжсан бодлогыг агуулж байсан юм [14. 27-28].

1992 онд Монгол Улсын Үндсэн Хууль батлагдан гарснаар эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх, Ардчилсан Цэрэг-Иргэний харилцааны эрх зүйн орчинг бүрдүүлэх үндэс болж өгсөн юм. Уг хуулийн арван нэгдүгээр зүйлийн 1-д: “*Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн*” Мөн зүйлийн 2-т: “*Монгол Улс нь өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчинтэй байна. Зэвсэгт хүчинд алба хаах журмыг хуулиар тогтооно*” гэж заасан байна. Энэ нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах, Батлан хамгаалах найдвартай тогтолцоог бүрдүүлэх, иргэний нийгэм дахь эх оронч сэтгэлгээг хөгжүүлэх үндэс суурь болж цэрэг, иргэний харилцаанд ардчилсан, шинэ зарчим үйлчилж эхлэх үндэслэл болсон юм.

Монгол Улсын шинэ нийгмийн харилцаатай уялдуулан батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчин, түүний зориулалт, гүйцэтгэх үүрэг, тэдгээртэй холбогдолтой харилцааг зохицуулж баталгаажуулсан нийтлэг хэрэглээний зарим хуулиудаас дурдвал: Монгол Улсын Үндсэн Хууль, Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал /1994/, Монгол Улсын Зэвсэгт хүчний тухай хууль /2002/, Монгол

Улсын Цэргийн номлолын үндэс /1994/, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хууль /1993/, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль /1993/, Монгол Улсын Их Хурлын тухай хууль /1992/, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль /1993/, Монгол Улсын Иргэний хамгаалалтын тухай хууль /1993/, Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль/1992/, Цэрэг, Цагдаагийн албан хаагчийг Нэгдсэн Үндэстний Байгууллага болон бусад олон улсын үйл ажиллагаанд оролцуулах тухай Монгол Улсын хууль /2002/, Монгол Улсын Хилийн тухай хууль /1993/ зэрэг олон чухал үзэл баримтлал, хууль батлагдан гарсан юм. Эдгээр хууль тогтоомж батлагдсантай холбогдуулж бусад холбогдох хууль тогоомжуудад өөрчлөлт орсон байна. /Нэгдүгээр хавсралт/

Дээрх хууль тогтоомж нь өнгөрсөн 10 гаруй жилийн хугацаанд Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний нийгмийн шинэ харилцаанд зохицсон Эрх зүйн шинэчлэл хийхэд дорвитой хувь нэмэр оруулж байна. Батлагдан гарч байсан хууль тогтоомжийг олон улсын аюулгүйн шинэ орчин бүрдэж буй үйл явц, батлан хамгаалах шинэ стратеги, цаг үеийн олон нийтийн санал бодол, хэрэгцээ шаардлагыг тусган, олон улсын практик туршлагад тулгуурлан, шинжлэх ухааны үндэслэлтэй нарийн судалгаануудыг үндэслэн боловсруулж байсан юм. Үүний хандлагыг өнгөрсөн хугацаанд улс орныхоо батлан хамгаалах тогтолцооны хийгээд Зэвсэгт хүчний удирдлагын үндэс, улс орноо дайны байдалд шилжүүлэх үед авах арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх бэлтгэлийг тайван цагт хангах үеийн төрийн захиргаа, цэргийн удирдлагын байгууллагын бүрэн эрх, байгууллага, аж ахуй нэгж, иргэдийн хүлээх үүрэг, Зэвсэгт хүчний үндсэн чиг үүрэг, зохион байгуулалтын бүтэц, бүрэлдэхүүн, цэргийн албан хаагчдын эрх зүйн байдлыг ардчилсан нийгмийн тогтолцоо, зах зээлийн эдийн засгийн харилцаанд нийцүүлэн хуульчилж, хэрэгжүүлэх харилцааг зохицуулахад чиглэсэн үйл ажиллагаа гэж хэлж болно. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд Монгол Улсын хууль, эрхийн актуудаар зохицуулан эрх мэдлийн хуваарилалтын тогтолцоог бүрдүүлсэн байна. Хууль тус бүрээр нь авч үзвэл:

**1. Монгол Улсын Үндсэн Хууль:** Ардчилсан шинэ үндсэн хуульд эх орныхоо тусгаар тогтнолыг батлан

хамгаалах нь төрийн үүрэг болохыг зарлан тунхаглаж, Монгол Улс өөрийгөө хамгаалах Зэвсэгт хүчинтэй байх, түүний бүтэц, зохион байгуулалт, цэргийн алба хаах журмыг хуулиар тогтоох, иргэн бүр эх орноо батлан хамгаалах ба бүх нийтээр хуулийн дагуу цэргийн алба хаах үүрэгтэйг хуульчлан баталгаажуулсан. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгч Зэвсэгт хүчний ерөнхий командлагч байхаар, үүрэгт ажлынхаа зэрэгцээ Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг даргалж байхаар тогтоож, улс орны батлан хамгаалах хүч чадлыг бэхжүүлэх бүрэн эрхийг Засгийн газарт ногдуулснаар Зэвсэгт хүчин бусад цэргийг ганцхан ард түмнээс сонгогдсон төр, засаг удирдах төрийн байгуулалтын шударга зарчмын эрх зүйн үндсийг бүрдүүлэв.

**2. Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал:** нь улс орны төр, нийгэм, эдийн засгийн тухайн үеийн нөхцөл байдлаас үл хамааран төрийн бодлогын нэгдмэл чанараа хадгалж, төр засаг, нийт иргэдийн эрх ашгийн тусын тулд үе улиран мөрдөгдөж, удаан хугацаагаар үйлчлэх шинж чанарыг өөртөө агуулж байгаа юм. Энэ үзэл баримтлалын үндэслэл нь:

- ...”Монгол Улсын үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ. Үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын үзэл бодлын үндэс нь эх оронч үндэсний үзэл байна”.
- “Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд Монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох; Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдал, эдийн засгийн харьцангуй бие даасан байдал; экологийн тэнцвэрт хөгжил; үндэсний эв нэгдэл багтана. Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхол нь төр, ард түмний онцгой анхаарал хамгаалалтад байна”.
- “Үндэсний аюулгүй байдлыг хангах гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хамгаалан бэхжүүлж тал бүрийн баталгаа буй болгоход

чиглэсэн төрийн бодлого, төр, түүний байгууллага, албан тушаалтнаас авч буй, иргэдээс хэрэгжүүлж буй арга хэмжээг хэлнэ. Эдгээр арга хэмжээ нь урьдчилан сэргийлэх, бүтээн байгуулах чиг хандлагатай байна. Монгол Улс нь эдийн засаг, соёл, шинжлэх ухаан-технологи, боловсрол зэрэг салбарт олон улсын хэмжээнд өрсөлдөх чадвартай байхыг чухалчилна.”...гэж тодорхойлогджээ. Үүнээс үзэхэд үндэсний язгуур эрх ашиг, сонирхол нь төр, иргэдийн онцгой анхаарал, хамгаалалтанд байх ба үндэсний аюулгүй байдлыг нийгэм, эдийн засаг, улс төр-дипломатын, цэрэг-улс төрийн, тагнуул, хууль зүй зохион байгуулалтын аргаар дангаар буюу олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар хангах зэрэг олон талт боломжийг хуульчилжээ. Энэ нь ч цэрэг, иргэний харилцааны шинэ шатанд гарах бас нэгэн том хөрс суурь нь болсон.

### ***3. Монгол Улсын Төрийн цэргийн бодлогын үндэс:***

Манай улс анх удаагаа төрийн цэргийн бодлогыг албан ёсоор тодорхойлон “Монгол улсын цэргийн номлолын үндэс” (1994) батлан гаргасан нь төр, нийгмийн шилжилтийн нөхцөлд Зэвсэгт хүчнийг шинэчлэх бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн нэгэн чухал алхам болсон юм. Үүнээс өмнө өөрийн гэсэн цэргийн номлолгүй байв. Варшавын гэрээний орнууд хориглон хамгаалах цэргийн номлолоо зарлах хүртэл бид цэргийн номлолын тухай судалж, боловсруулж байгаагүй юм. Энэ нь Монгол Улсад цэргийн номлолыг тусгайлан боловсруулах шаардлага байгаагүйтэй, нөгөөтэйгүүр БНМАУ-ын цэргийн бодлого ЗХУ-ын алс дорнодод явуулах цэрэг-стратегийн бодлогын салшгүй нэгэн хэсэг байсантай холбоотой байсан юм.

1998 онд УИХ-аас “Монгол Улсын Төрийн цэргийн бодлогын үндэс” баримт бичгийг батлан гаргасан юм. Үүнтэй холбогдуулан “Зэвсэгт хүчнийг ашиглах номлол”-ыг батлан мөрдүүлэхийг Ерөнхийлөгчид зөвшөөрсөн байна. Тодруулбал улс орныг батлан хамгаалах, зэвсэгт хүчнийг байгуулж, бэхжүүлэх талаар төрөөс баримтлах улс төрийн хийгээд цэрэг-улс төрийн бодлогыг “Монгол Улсын Төрийн

цэргийн бодлогын үндэс” баримт бичгээр, зэвсэгт хүчний байгуулалтыг цаашид төгөлдөржүүлэх, хөгжүүлэх, түүнийг тайван цагт болон дайны үед ашиглах талаар бодлого үзэл баримтлалыг “Зэвсэгт хүчнийг ашиглах номлол”—оор тогтоож байхаар шийдвэрлэсэн байна. Монгол Улсын Төрийн цэргийн бодлогын үндэс баримт бичиг нь Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлалд тулгуурлан гарсан, улс орны батлан хамгаалах болон зэвсэгт хүчнийг шинэчлэх бодлогыг тодорхойлох, аливаа зэвсэгт түрэмгийлэлд төрөөс хандах хандлага, дайн, зэвсэгт мөргөлдөөний аюулаас сэрэмжлэх, улс орноо гадны зэвсэгт түрэмгийллээс хамгаалах бодлогын үндсэн чиглэл, цэргийн байгуулалт, зэвсэгт тэмцэл явуулах арга хэлбэрийн талаар баримтлах албан ёсны үзэл юм. Мөн батлан хамгаалах үйл ажиллагааны хүрээнд Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээ, хэлэлцээрийн үндэс болж байна.

Монгол Улсын Төрийн цэргийн бодлогын үндэс баримт бичигт *“Тайван цагт улс орныхоо хэрэгцээ, шаардлага, эдийн засгийн боломжид нийцсэн цомхон, чадварлаг, мэргэжлийн чиг баримжаатай Зэвсэгт хүчинтэй байна ”* гээд Зэвсэгт хүчин тайван цагт дараахь үүргийг хүлээхээр хуульчилжээ:

- *Эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг гаднын зэвсэгт түрэмгийллээс хамгаалахад бэлэн байх;*
- *улсын хил хамгаалат, агаарын хилийн халдашгүй дархан байдалд хяналт тавих;*
- *улсын онц чухал объектын хамгаалалт;*
- *хөнөөх хэрэгслийн хөнөөл, байгалийн болон нийтийг хамарсан гамшиг, үйлдвэрийн ослын аюулаас хүн ам, эд баялгийг хамгаалахад туслах;*
- *дайчилгааны нөөцийг бүрдүүлж, хүн амын цэргийн хэрэгт сургах;*
- *хүмүүнлэгийн үйл ажиллагаанд туслалцаа дэмжлэг үзүүлэх;*
- *Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах хүчний хүрээнд үүрэг гүйцэтгэх, хуулиар тогтоосон бусад үүрэг гүйцэтгэнэ;*
- *Зэвсэгт хүчин нь болзошгүй зэвсэгт түрэмгийллийг*



*саатуулан няцаах үүргээ биелүүлэхэд шаардагдах бэлтгэлийг тайван цагт хангасан байна [5.28-29] /Хоёрдугаар хавсралт/.*

#### **4. Монгол Улсын Батлан хамгаалах тухай хууль:**

Улс орны оршин тогтнохуйн аюулгүй байдлыг хангах улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн арга хэмжээг улс орны түүхэн уламжлал, гадаад нөхцөл байдалтай уялдуулан тайван цагт бүрдүүлдэг нь олон улсын практикт түгээмэл байдаг үзэгдэл юм. Харин манай улсын энэ хууль нь батлан хамгаалах тогтолцоог тогтоож, төрийн байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, аж ахуй нэгж, байгууллага иргэдийн эх орноо батлан хамгаалах талаар хүлээх үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж байна. Тус улс нь эх орныхоо батлан хамгаалах тогтолцоог дан ганц цэргийн арга хэрэгслээр хангах бололцоо найдвар бага тул энэ хуульд “...батлан хамгаалах нь Монгол Улсын Тусгаар Тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг гадны зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалахад улс орны бэлэн байдлыг хангах, хамгаалах зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн нэгдмэл арга хэмжээ мөн...” гэж тодорхойлсон юм. Өөрөөр хэлбэл эх орноо гадны зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалахад улс орны бэлэн байдлыг хангах зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн арга хэмжээг улс орны хэмжээнд нэгтгэн төлөвлөх, тэдгээр арга хэмжээг уялдуулан зохицуулж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг батлан хамгаалах нэгдмэл тогтолцоо ба улс төр-дипломатын, цэрэг-стратегийн, зохион байгуулалтын, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар хангахыг хэлж байна.

*Монгол Улсын Батлан хамгаалах удирдлагын тогтолцоо* нь Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, түүний тэргүүлсэн Үндэсний Аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газар, Захиргааны төв байгууллага, Зэвсэгт хүчний Жанжин штаб, цэргийн удирдлагын байгууллагууд, аймаг, нийслэлийн батлан хамгаалах газар, сум, дүүргийн батлан хамгаалах товчооноос бүрдэж байна.

*Батлан хамгаалах улс төрийн тогтолцоо* нь нэгдмэл

тогтолцооны үндсэн хэсэг болохынхоо хувьд улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг гадны зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалах зорилго агуулж байдаг. Батлан хамгаалах улс төрийн тогтолцоо нь үндэсний эрх ашгийг хангахад чиглэсэн гадаад бодлого баримтлах, олон улсын нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм, хэмжээ өөрийн орны тулгуур хууль тогтоомжуудад нийцсэн батлан хамгаалах бодлогын эрх зүйн үндсийг бүрдүүлэх, шинээр гаргаж байгаа хуулиудад улс орноо батлан хамгаалах эрх ашгийг тусгах, цэргийн байгууллагуудын үйл ажиллагаанд иргэний хяналт тавих зэрэг үндсэн асуудлуудыг хамаарна.

*Батлан хамгаалах эрх зүйн тогтолцоонд* Монгол Улсын Үндсэн Хууль, Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал, Төрийн цэргийн бодлогын үндэс зэрэг тулгуур баримт бичгүүдийн үзэл санаанд нийцүүлэн улс орны батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцааг зохицуулах зорилгоор төр засгаас батлан хэрэгжүүлж буй хууль тогтоомжийн нэгдлийг ойлгож байна.

*Батлан хамгаалах нийгмийн тогтолцоо* нь иргэдийг боловсрол, эрүүл мэнд, хүмүүжил, ёс суртахуун, сэтгэл зүйн талаар батлан хамгаалахад урьдчилан бэлтгэх, цэргийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад чиглэсэн цогц арга хэмжээг багтаана.

*Батлан хамгаалах эдийн засгийн тогтолцоо* нь батлан хамгаалах эдийн засгийн чадавхийг бүрдүүлэх явдал бөгөөд улс орны эдийн засгийн чадавхийг бэхжүүлж, тайван ба дайны цагт эдийн засгийн бүх салбар, аж ахуй нэгжийн хөдөлмөр, материал санхүүгийн нөөцийн хуваарилалтанд онцгой дэглэм тогтоож, зэвсэгт хүчний хэрэгцээг хангахад чиглэсэн зохион байгуулалтын цогц арга хэмжээ юм.

*Батлан хамгаалах цэргийн тогтолцоо* нь батлан хамгаалах нэгдмэл тогтолцоонд тэргүүлэх байр эзэлнэ. Энэ улс орны аюулгүй байдлыг цэргийн хүчээр хамгаалах, цэргийн болон зэвсэгт хүчний байгуулалтын үндсэн арга хэмжээнүүдийг өөртөө агуулж, тэдгээрийг хэрэгжүүлэх арга зам, зохион байгуулалтыг тодорхойлсон, тус тусдаа бие

даасан байдлаар бус, өөр хоорондоо харилцан нягт уялдаа холбоотой асуудлуудын нийлмэл цогц юм.

**5. Зэвсэгт хүчний тухай Монгол Улсын хууль:** Энэ хууль нь 2002 онд батлагдан мөрдөгдөж байгаа бөгөөд энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Зэвсэгт хүчин, түүний чиг үүрэг, байгуулалтын үндэс, бүтэц, зохион байгуулалт, зэвсэгт хүчинд тавих иргэний хяналт, зэвсэгт хүчний талаарх төрийн байгууллага, албан тушаалтны болон цэргийн мэргэжлийн удирдлагын байгууллагын бүрэн эрхийг тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршиж байна.

Зэвсэгт хүчний үндсэн чиг үүргийг эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг гадны зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалах явдал, мөн дээрх үүргээс гадна улс орны тайван цагт зэвсэгт хүчний гүйцэтгэх үүргийг тодорхойлоод Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн зөвшөөрөл, батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрийн дагуу зэвсэгт хүчний бэлэн байдлыг алдагдуулахгүйгээр цэргийн зарим анги, байгууллагыг аж, ахуй бүтээн байгуулалтын ажилд оролцуулж болно гэж тодорхойлсон байна. Мөн Зэвсэгт хүчний байгуулалтын үндэс нь, “төрийн хууль тогтоомж, Төрийн цэргийн бодлогоор тодорхойлогдоно”, бүтэц нь, “улс орны тайван цагт ерөнхий зориулалтын, хилийн, дотоодын цэрэг мэргэжлийн бие даасан үйл ажиллагаа явуулах”, зохион байгуулалтын хувьд, “Зэвсэгт хүчин нь Зэвсэгт хүчний Жанжин штаб, төрөл мэргэжлийн цэргийн болон ар тал, техникийн нэгтгэл, ангиуд, цэргийн сургууль, сургалт-эрдэм шинжилгээ, соёл, урлаг, эмнэлэг, хэвлэл мэдээлэл, аж ахуй, үйлчилгээний байгууллагатай байна”, нэгтгэл, ангиуд нь, “тайван цагт бүрэн хураангуй, нэн хураангуй зохион байгуулалттай байж болно”, бие бүрэлдэхүүний хувьд, “цэргийн албан хаагч болон цэргийн анги, байгууллагад гэрээгээр ажиллагсдаас бүрдэнэ”; Зэвсэгт хүчний удирдлагын хувьд, “ерөнхий болон цэргийн мэргэжлийн удирдлагаас бүрдэнэ” гэж тус тус хуульчилсан байна [5. 4-6].

Монгол Улсын Зэвсэгт хүчний тухай хуульд үндсэн

чиг үүргээс гадна тайван цагт дараахь үүрэг хүлээнэ гэж тодорхойлсон байна.

- *Эх орноо гадны зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалах бэлтгэлийг хангах;*
- *улсын хил хамгаалалтад дэмжлэг үзүүлэх, агаарын хилийн халдашгүй дархан байдалд хяналт тавих;*
- *байгалийн болон нийтийг хамарсан гамшиг, үйлдвэрийн ослын аюул, хөнөөх хэрэгслийн хөнөөх голомтод байгаа хүн ам, эд баялагийг авран хамгаалахад болон тогтоосон хорио цээрийн дэглэмийг сахиулахад туслах;*
- *дайчилгааны нөөцийг бүрдүүлэх, хадгалах, сольж шинэчлэх;*
- *дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтад дэмжлэг үзүүлэх;*
- *улсын онц чухал объектыг хамгаалахад дэмжлэг үзүүлэх;*
- *хүмүүнлэгийн үйл ажиллагаанд туслалцаа, дэмжлэг үзүүлэх;*
- *энхийг сахиулах олон улсын хамтын ажиллагаанд оролцох*

зэрэг хуулиар тогтоосон бусад үүрэг гүйцэтгэнэ. Мөн энэ хуульд Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагуудын тайван цагийн болон дайны байдлын үеийн орон тоо, зохион байгуулалтыг зэвсэгт хүчний Жанжин штаб тогтооно гэж заасан байна [5. 46].

***6. Монгол Улсын Иргэний Цэргийн үүргийн болон Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль:***

Монгол Улсын Үндсэн Хуульд “Эх орноо батлан хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах”-ыг Монгол Улсын иргэний үндсэн үүргийн нэг байхаар заасан. Иргэн энэ үндсэн үүргээ биелүүлэн эх орноо батлан хамгаалах бэлтгэл эзэмших, цэргийн алба хаахтай холбогдсон харилцааг зохицуулах, цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлыг тогтооход, тэдгээрийн хүрээн дэх холбогдох асуудлуудыг шийдвэрлэхэд энэ хуулийн гол зорилт оршиж байгаа юм. Монгол Улсын иргэний цэргийн үүрэг, цэргийн жинхэнэ алба, энэ албанд татах, албанаас чөлөөлөх, цэргийн албыг бусад хэлбэрээр хаах, цэргийн бэлтгэл алба, бэлтгэл албаны үүрэг

гүйцэтгэхтэй холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулж байгаа юм.

*Иргэний цэргийн үүрэг* гэж иргэн цэргийн албан хаагчдаас цэргийн алба, цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын талаарх хууль тогтоомж, хуулиар олгосон эрх бүхий байгууллагаас гаргасан эрх зүйн бусад актуудаар тогтоосон журмыг сахин биелүүлэхийг хэлж байна.

Монгол Улсын иргэн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол ялгаварлахгүйгээр цэргийн үүрэг хүлээнэ.

Цэргийн алба нь цэргийн жинхэнэ болон бэлтгэл албанаас бүрдэж байна. Монгол Улсын иргэн Зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд цэргийн үүрэг гүйцэтгэхийг цэргийн жинхэнэ алба гэнэ. Харин хуульд заасан бэлтгэл албаны насны эрэгтэйчүүд, цэрэгт бүртгэлтэй мэргэжил бүхий эмэгтэйчүүд цэргийн тоо бүртгэлд байж, дайчилгааны сургууль, цугларалтаар цэргийн албаны үүрэг болон хуульд заасан бусад үүрэг гүйцэтгэхийг цэргийн бэлтгэл алба гэнэ.

Иргэний Цэргийн үүргийн болон Цэргийн Албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар цэргийн албыг иргэн дүйцүүлэн хаах харилцааг шинээр зохицуулав.

Ийнхүү иргэн дүйцүүлэх албыг “*Монгол Улсын 18-25 насны, цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэг бүхий иргэн шашин шүтлэг-ёс зүйн шалтгаанаар цэргийн албыг дүйцүүлэн хааж болно. Цэргийн албыг дүйцүүлэн хаах хүсэлтэй иргэн Иргэний хамгаалалтын мэргэжлийн анги, Байгалийн гамшигтай тэмцэх салбар, Хилийн цэрэгт туслах хүчин болон хүмүүнлэгийн бусад байгууллагад алба хаана. Уг албыг хаах хугацаа 24 сар байна. Цэргийн албыг дүйцүүлэн хаах журам, алба хаах иргэний тооны дээд хязгаарыг Засгийн газар тогтооно*” гэж тогтоов. Нэгэнт татгалзагч нар буюу цэргийн насны залуусыг бүгдийг цэргийн алба хаалгах боломжгүй тул сайн дурын үндсэн дээр Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр

орлуулан хаах тогтолцоог “байлдагч түрүүчийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн цэргийн алба хаагаагүй иргэн хуулиар тогтоосон хугацаат цэргийн албыг биеэр хаагаагүйн төлөө мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзлыг Улсын Их Хурал, мөнгөн төлбөрийн хэмжээг Засгийн газар тогтооно” гэж тогтоосон байна. Хуулийн дээрх заалтыг цэргийн жинхэнэ албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хааж байгаа хэрэг биш, харин цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хааж байна гэж ойлгох хэрэгтэй юм. Өөрөөр хэлбэл тэдний нэг хэсэг нь цэргийн жинхэнэ албыг 12 сарын хугацаагаар хааж, зарим хэсэг нь шашин шүтлэг-ёс зүйн шалтгаанаар цэргийн албыг 24 сараар мөн мөнгөн төлбөрийн хэлбэрээр дүйцүүлэн хаах бололцоотой болж байгаа юм.

Иргэний Цэргийн үүргийн болон Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлыг тодорхойлж, энэ хууль болон “Төрийн албаны тухай хууль”, “Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”, бусад хуулиудийн холбогдох заалтуудаар цэргийн албан хаагчийн давуу эрх, хөнгөлөлтийг тогтоож өгсөн нь шудрага ёст, эрх зүйт төрийн үе дэх цэрэг, иргэдийн хоорондын шилжилт хөдөлгөөнийг сайжруулахад шууд нөлөөлөх хүчин зүйл болсон. Цэргийн албан хаагч нь Монгол Улсын Үндсэн Хууль бусад хуульд заасан иргэний нийтлэг эрх, эрх чөлөөг эдэлж, цэргийн албаны үүрэг гүйцэтгэж буйн хувьд зарим давуу эрх, хөнгөлөлт эдлэхийн зэрэгцээ зэвсэгт хүчний зориулалт, цэргийн албаны онцлогтой холбогдуулан тэдэнд эрх зүйн зарим хязгаарлалтыг энэ хуулиар тогтоосон байдаг.

#### ***7. Дайны байдлын тухай Монгол Улсын хууль:***

Манай улс 1924, 1940, 1960 оны үндсэн хуульд дайны байдал зарлах, цуцлах асуудлыг төрийн эрх барих дээд байгууллагын онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэхээр заасан боловч түүнтэй холбогдсон олон талт харилцааг зохицуулах, тэр дундаа иргэний нийгмийн эрх барих дээд байгууллагын хууль тогтоомж урьд өмнө нь гарч байгаагүй юм. Монгол Улсын Үндсэн Хуулийн хоринтавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын нийт нутаг дэвсгэрт зарим хэсэгт нь нийтийн эмх замбараагүй байдал үүсч, зэвсэгт

*мөргөлдөөнд хүрсэн, тийм мөргөлдөөн гарах бодит аюул бий болсон, бусад улсаас цэргийн хүчээр түрэмгийлэн халдсан, эсвэл тийнхүү халдах нь бодитой болсон үед дайны байдал зарлаж болно” гэж заасан байдаг. Манай улсад ийм нөхцөл байдал үүсэх магадлал бага хэдий ч, үүсэхгүй гэсэн баталгаа байхгүй байна.*

Дайны байдал гэж Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан нөхцөл бий болох үед төрийн эрх барих дээд байгууллагаас Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт тогтоох улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн онцгой дэглэмийг хэлнэ гэж энэ хуулинд тодорхойлсон байдаг. /Гуравдугаар хавсралт/

Дайны байдал зарлах тухай Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын зөвлөл хэлэлцэж, гаргасан шийдвэрийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлснээр, дайны байдал зарлах эсэхийг Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэх, хэрэв УИХ-ын чөлөө цагт, хойшлуулшгүй тохиолдолд Монгол Улсын Ерөнхийлөгч дайны байдал зарлах тухай зарлиг гаргах бөгөөд УИХ онцгой чуулган товлохгүйгээр хуралдаж уг зарлигийг хэлэлцэн 7 хоногийн дотор батлах, эсвэл хүчингүй болгох, харин дайны байдал зарласан онцгой нөхцөл байдал бүрэн арилсан тухай Үндэсний Аюулгүй байдлын хороо санал гаргавал түүнийг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлснээр УИХ дайны байдлыг цуцлах шийдвэр гаргана гэж зааж өгчээ.

*Монгол Улсын Их Хурал дайны байдлын үед төрийн эрх барих дээд байгууллагынхаа хувьд бүрэн эрхийг хэрэгжүүлж, төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг дайны байдлын нөхцөлд нийцүүлэн тогтоох, энэ бодлогынхоо хүрээнд гадаад улс оронтой цэрэг-улс төрийн холбоо харилцаа тогтоох, цэргийн эвсэл холбоонд элсэн орох эрх зүйн үндсийг бүрдүүлэх, дайны байдлын үед бусад улс оронтой байгуулсан цэргийн хамтын гэрээг батлах, гадаадын цэргийн хүчнийг өөрийн нутаг дэвсгэрт байрлуулах, дамжин өнгөрүүлэх хууль гаргах зэрэг эх орноо батлан хамгаалах асуудалтай холбогдсон хууль тогтоох эрх мэдлээ хэрэгжүүлж, хэрэгжилтэнд нь төрийн хатуу хяналт тогтоох зэрэг олон харилцааг зохицуулна.*

*Монгол Улсын Ерөнхийлөгч* дайны байдлын үед Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын хороо, цэргийн дээд командлалын байгууллагыг тэргүүлэхийн зэрэгцээ Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийнхаа хувьд гүйцэтгэх үүргийг нь тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлах, зэвсэгт тэмцлийг ерөнхий удирдлагаар хангах зэрэг олон харилцааг зохицуулна.

*Монгол Улсын Засгийн газар* улс орныг дайны байдалд шилжүүлэх ажиллагааг удирдан зохион байгуулж, эдийн засаг, нийгмийн үндсэн салбар болон дэд бүтцийн тогтвортой ажиллагааг хангах, түүнчлэн Нэгдсэн Үндэстний Байгууллага болон олон улсын бусад байгууллага, дэмжигч бусад орнуудаас бүх талын тусламж, дэмжлэг авах, хууль тогтоомжийн дагуу гадаадын цэргийн хүчнийг нутаг дэвсгэртээ байрлуулах ажлыг зохион байгуулах, зэвсэгт хүчний байлдааны ажиллагаанд шаардагдах санхүү, эд хөрөнгийн нөөц, хүн амын амьжиргааны зайлшгүй хэрэгцээт зүйлийг бэлтгэх, хуваарилах, онцгой журам тогтоох, хэрэгжилтийг зохион байгуулах, дайны байдлын үеийн нийгмийн дэг журмыг сахиулах зэрэг хуульд заасан олон харилцааг зохицуулна.

**8. Дайн бүхий байдлын тухай Монгол Улсын хууль:** Энэ хуулийн зорилт нь дайн бүхий байдал зарлах, цуцлах үндэс, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд аюул занал учруулсан, зэвсэглэн халдсан улс, түүний холбоотонтой харилцах харилцааг зохицуулахад оршино.

Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд аюул занал учруулж, зэвсэглэн халдсан улс, түүний энэхүү зэвсэгт халдлагад холбоотон нь болж байгаа этгээдийг “Дайсан” гэнэ гэж тодорхойлжээ. Дайн бүхий байдал гэж тэрхүү дайсан этгээдтэй дайн бүхий байдал зарласан мөчөөс түүнийг цуцлах хүртэл харилцах харилцааны онцгой хэлбэрийг хэлж байна.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс дайн бүхий байдал зарлах нөхцөл бүрдсэн тухай оруулсан санал



дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлсэнээр УИХ хэлэлцэж, дайн бүхий байдлыг зарлах, эсэх талаар шийдвэр гаргах болно. УИХ өөрийн онцгой нөхцөл байдал бүрдсэн гэж үзвэл өөрийн онцгой бүрэн эрхийн дагуу дайн бүхий байдлыг шууд зарлаж болох юм байна. Монгол Улс зарим улстай зэвсэгт тэмцэл явуулахгүйгээр дайн бүхий байдалтай байж болохыг үгүйсгээгүй байна.

Дайн бүхий байдал зарласан үед дайсан этгээдтэй байгуулсан хоёр талын гэрээ хэлэлцээрийг цуцлах, үйлчлэлийг түр зогсоох, эсхүл улс төр, эдийн засаг, нийгмийн салбарт тогтсон бүх төрлийн харилцааг таслах, түүнчлэн дайн бүхий байдал зарласан нөхцөл байдлын улмаас Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнээс түүнд заагдсан журам, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмуудын дагуу гарах, үйлчлэлийг түр зогсоох арга хэмжээг нэн даруй авах болж байна [14. 78-79].

**9. Монгол Улсын Хилийн тухай хууль:** Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах зорилгоор хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх, хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх, хил хамгаалах байгууллагын тогтолцоо, бүрэн эрхийг тодорхойлох, хил хамгаалалтад иргэн, байгууллагыг оролцуулах, хилийн тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагатай холбогдсон харилцааг зохицуулахад энэ хуулийн зорилт оршино [5, 66].

Монгол Улсын нутаг дэвсгэрийн хязгаарыг газрын гадаргуу, усны мандал дээр хил залгаа улсын нутаг дэвсгэрийн хязгаараас зааглаж, Монгол Улсын олон улсын гэрээгээр тодорхойлж, тогтоосон шугамыг Монгол Улсын хил гэж томъёолсон байна. Уг шугамаас эгц дээш агаарын, мөн шугамаас эгц доош газрын хэвлийн хил байна. Улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа болон мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх журмыг тогтоох, өөрчлөхдөө *нэгд*, үндэсний аюулгүй байдлыг хангах; *хоёрт*, гадаад улстай харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэх; *гуравт*, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн бүтэн байдал, улсын хилийн

халдашгүй дархан байдлыг хангах зарчмыг баримталж байхаар хуульд заасан байна.

Газар, усан дээрх улсын хил нь хилийн цэргийн, агаарын хил нь агаарын довтолгооноос хамгаалах цэргийн хяналт, хамгаалалтад байна. Шаардлагатай үед Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн зөвшөөрснөөр ерөнхий зориулалтын цэргийн зарим анги, салбарыг улсын хил хамгаалах зорилгоор ашиглаж болно. Энэ нь ерөнхий зориулалтын цэргийн томилгоот анги, салбар, бие бүрэлдэхүүнийг улсын хил хамгаалах арга, тактикт сургасан байхыг шаардаж байна. Хуулиар хилийн цэргийн зохион байгуулалт, чиг үүрэг, улсын хилд албан үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн албан хаагч, иргэний эрх зүйн баталгааг тодорхойлсны гадна агаарын довтолгооноос хамгаалах цэргийн чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх харилцааг зохицуулжээ [14. 84-86].

**10. Цэрэг, Цагдаагийн албан хаагчийг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай Монгол Улсын хууль:** Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын цэрэг, цагдаагийн албан хаагч, цэрэг, цагдаагийн багийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Тус хуулиар цэрэг, цагдаагийн албан хаагч нарын НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд, мөн олон улсын бусад ажиллагаанд оролцуулахтай холбогдсон удирдлага, зохион байгуулалтын (Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрх, гадаад хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх, батлан хамгаалахын болон хууль эрх зүйн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний бүрэн эрх, Мэргэжлийн удирдлага, бэлтгэлийн холбогдолтой харилцаа) холбогдолтой харилцааг, мөн тус үйл ажиллагаанд оролцогч цэрэг, цагдаагийн албан хаагч нарын цалин хангамж, тус хууль тогтоомжийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага, тэдгээртэй холбогдолтой үйл ажиллагааг зохицуулахад чиглэсэн зүйл заалтууд орсон байна [5. 89-92].

1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн Хуулинд **Шүүх** эрх мэдлийг Шүүх байгууллагад эдлүүлж байхаар

заасан байдаг. Монгол Улсад Цэргийн үйл ажиллагаатай холбогдолтой харилцааг хянан шийдвэрлэх, шүүх ажиллагааг доорхи байдлаар шийдвэрлэдэг.

Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний офицер, ахлагч, цэрэг түрүүч, энгийн албан хаагч, бусад цэрэг, батлан хамгаалах салбарын албан хаагч нарын үйл ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн Хууль, түүнд нийцүүлэн гаргасан Батлан хамгаалахтай, Зэвсэгт хүчинтэй, Үндэсний аюулгүй байдалтай, Монгол Улсын бусад хуулиудтай холбогдолтой хууль, тогтоомж, дүрэм, журмыг зөрчсөн нь гэмт хэргийн шинжтэй бол Монгол Улсын Үндсэн Хууль, түүнд нийцүүлэн гаргасан Монгол Улсын Эрүүгийн хууль, Монгол Улсын Иргэний хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Монгол Улсын Шүүх тухай хууль гэх мэт холбогдох хууль тогтоомжийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Харин хууль, тогтоомж, дүрэм журмыг зөрчсөн нь гэмт хэргийн шинжгүй бол холбогдох хууль, тогтоомжийн дагуу захиргааны хариуцлага хүлээлгэнэ [9].

Монгол Улсад тусгайлсан Цэргийн шүүх байхгүй бөгөөд Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнтэй холбогдолтой хэрэг, зөрчил, гэмт хэргийг Монгол Улсын Иргэний хууль, Монгол Улсын Эрүүгийн хууль, Монгол Улсын Иргэний Шүүхийн дагуу шийдвэрлэдэг. Монгол Улсын Эрүүгийн хуулийн аравдугаар хэсэгт Цэргийн гэмт хэрэг гэж тусгай анги оруулсан байдаг. Цэргийн гэмт хэргийн ойлголтыг тодорхойлохдоо *“Монгол Улсын иргэн зэвсэгт хүчин, бусад цэрэг, цэргийн үүрэгтэн дайчилгаа, сургууль, цугларалтын үед цэргийн алба хаах талаар хуулиар тогтоосон журмыг зөрчиж энэ хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийг үйлдсэн бол цэргийн гэмт хэрэг гэнэ”* [7] гэж заасан байна. Харин дайны байдлын үед гэмт хэрэг үйлдвэл *“Дайны байдалд буюу дайн бүхий байдал зарласан үед цэргийн алба хаах талаар тогтоосон журам зөрчсөн гэмт хэрэг, түүнд хүлээлгэх хариуцлагыг тухайн үед батлагдсан Монгол Улсын хуулиар тогтооно”* [7] гэж заасан байна. Мөн энэ хуулийн арван нэгдүгээр хэсэгт Хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг гэсэн тусгай анги оруулсан байна. Энэ хэсэгт дайны болон цэргийн үйл ажиллагаатай холбогдолтой зүйл заалтууд орсон байна.

Мөн Зэвсэгт хүчин, бусад цэргийн байгууллагуудын дотоод харилцааг зохицуулах онцлогтой Монгол Улсын Цэргийн дүрмүүд байна. Монгол Улсын Цэргийн дүрмийг Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ ёсоор батлан гаргадаг. Монгол Улсын Цэргийн дүрэм нь Зэвсэгт хүчний дотоод үйл ажиллагаа, албан тушаалтан, албан хаагч, цэрэг гэх мэт субъектүүдэд үйлчилдэг болохоор бодит иргэний хяналт, цэрэг, иргэдийн харилцаа ямар хэмжээнд, ямар хандлагатай байна, үнэхээр засаглал хуваах тэр зарчим нь шудрага зах зээлийн зарчмаар үйлчилж байна уу?, үгүй юу? гэдгийг илэрхийлэгч толь болно. Монгол Улсын цэргийн дүрмүүд:

**1. Цэргийн дотоод албаны дүрэм:** Монгол улсын цэргийн албан хаагчдын нийтлэг үүрэг, эрх, тэдний хоорондын харилцаа, цэргийн анги салбарын дотоод дэг журам, албан тушаалтны үүргийг тодорхойлно. Дайны болон дайн бүхий байдлын үед дотоод албыг байлдааны дүрэм болон энэ дүрмээр зохицуулна.

**2. Цэргийн сахилгын дүрэм:** Энэ дүрэм нь цэргийн сахилгын агуулга, түүнийг сахин биелүүлэх талаар цэргийн албан хаагчдын хүлээх үүрэг, сайшаал ба шийтгэлийн төрөл, тэдгээрийг хэрэглэх захирагч /дарга/ нарын эрхийг тодорхойлж, амжилт гаргагчдад сайшаал хүртээх, сахилгын зөрчил гаргагчидтай шийтгэл оногдуулахтай холбогдсон харилцааг зохицуулна. Түүнээс гадна энэ дүрмийг цэргийн албанаас халагдсан цэргийн дүрэмт хувцас өмсөх эрх бүхий иргэд, түүнийг хэрэглэх үедээ мөрдлөг болгоно.

**3. Цэргийн хүрээний ба харуулын албаны дүрэм:** Энэ дүрэм нь цэргийн хүрээний ба харуулын албыг зохион байгуулах, гүйцэтгэх, цэргийн оролцоотойгоор явуулж байгаа хүрээний арга хэмжээг зохион байгуулах журам, цэргийн хүрээний албан тушаалтан болон энэ албыг гүйцэтгэж байгаа цэргийн албан хаагчийн үүрэг, эрхийг тодорхойлно.

**4. Цэргийн жагсаалын дүрэм:** Энэ дүрэм нь цэргийн албан хаагчдын зэвсэгтэй, зэвсэггүй жагсаалын ажиллагаа, хөдөлгөөн, анги, салбарын явган болон машинтай жагсаал, ёсолж хүндлэх, жагсаалын үзлэг явуулах болон Байлдааны тугийг залж гаргах, жагсаалд байрлуулах, буцааж оруулах

журам, жагсахын өмнө болон жагсаалд цэргийн албан хаагчдын гүйцэтгэх үүргийг тодорхойлсон байна [10].

Цэргийн дүрэм зөрчсөн нь гэмт хэргийн шинжтэй бол Монгол Улсын Иргэнийг Монгол Улсын Эрүүгийн хуулийн Цэргийн гэмт хэрэг, Хүн төрөлхтний аюулгүй байдал энх тайвны эсрэг гэмт хэрэг, бусад хэсэгт хамааруулан эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Ардчилсан нийгмийн цэрэг, иргэний харилцааны эцсийн гол үр дүн нь Аюулгүй байдал, бага зардлаар батлан хамгаалах, эдийн засаг, бизнесийн хамтын ажиллагаа юм бол манай оронд ч тэр, дэлхийн улс оронд ч тэр геополитика, геоэкономика, геостратеги, бүс нутгийн байдлын хандлага тэдгээр улсуудын үйл ажиллагаа, эрх зүйн хөтөлбөр, хамтын ажиллагааны үндэс болох нь ойлгомжтой. Бага ч болов тийм үндсэн дээр Монгол Улсын цэрэг, эрх зүйн шинэтгэл явагдаж байна.

Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Батлан хамгаалах тухай хууль, Төрийн цэргийн бодлогын үндэс зэрэг баримт бичигт бүс нутгийн геополитик, геоэкономик, геостратегийн хандлага тусгалаа олох үндэслэл нь дээрхээр тодорхойлогдож байгаа юм. Үүнээс улбаалаад Монголын аюулгүй байдал, цэргийн бодлого, үйл ажиллагаа, иргэдийн холбоо хамаарал дээрхээр тодорхойлогдох юм.

Төр засгаас улс орны аюулгүй байдлын асуудал, батлан хамгаалах хүч, чадлыг зохих төвшинд байлгах, цэргийн байгуулалтыг боловсронгуй болгох, цэрэг, иргэний харилцааг төлөвшүүлэх, төгөлдөржүүлэх чиглэлээр багагүй анхаарал тавьж ирсний дүнд зэвсэгт хүчнийг мэргэжлийн чиг баримжаатай, цомхон, чадварлаг болгох эрх зүйн орчинг бүрдүүлээд байна.

Тухайлбал 1992 оноос хойшхи хугацаанд цэргийн шинэчлэлийн арга хэмжээг эрчимжүүлэхтэй холбогдсон баримт бичгийг гурван удаа /1993, 1997, 2002 онд/ боловсруулан төр засгийн хэмжээнд баталгаажуулан хэрэгжилтийг зохион байгуулсан. Монгол Улсын Ерөнхийлөгч,

Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч “Цэргийн байгуулалтыг 2005 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийг батлан хэрэгжилтийг зохион байгуулж эхлээд байна.

Гэвч улс орны эдийн засгийн чадавхи, бололцоо, манай оронд явагдаж буй нийгэм, эдийн засгийн асар их өөрчлөлтийн нөлөө, батлан хамгаалах салбарын өөрийгөө тэтгэх боломж хязгаарлагдмал байдаг зэргээс шалтгаалан цэргийн байгуулалтыг иж бүрнээр нь шинэчлэх үйл явцад тодорхой бэрхшээлүүд учирч, дээрх бодлогын баримт бичгүүдэд тусгасан ажил, арга хэмжээ зарим талаар хэрэгжиж чадахгүйд хүрэх тохиолдол байгааг үгүйсгэхгүй байна.

Батлан хамгаалах бодлогын үндсэн асуудал болох эрх зүйн шинэчлэл, түүнийг төгөлдөржүүлэх, тус хүрээн дэх улс орны аюулгүй байдал, батлан хамгаалах салбарын шинэчлэл, цэрэг, иргэний харилцааны хөгжил, түүний эрх зүйн орчинг улам боловсронгуй болгох явдлыг төр, засгийн анхаарлын төвд байнга байлгаж, салбарын холбоотой эдгээр асуудлуудыг иж бүрнээр шийдвэрлэх шаардлага зүй ёсоор урган гарсаар байна. Тухайлбал, Зэвсэгт хүчинд ажиллаж буй ажилчин, албан хаагч (энгийн)-дын эрх зүйн байдал, Монгол Улсын агаарын орон зайг ашиглах тухай, Улсын нислэгийн тухай хууль, тэдгээрийн эрх зүйн байдлыг боловсруулан гаргах шаардлага хэрэгцээ байна.

**АШИГЛАСАН НОМ, БҮТЭЭЛ, СУРВАЛЖ,  
СУДАЛГААНЫ МАТЕРИАЛ**

1. Батлан хамгаалах салбарын хууль тогтоомжийн эмхтгэл. I, УБ., 1995. -340х
2. Батлан хамгаалах салбарын хууль тогтоомжийн эмхтгэл. II, УБ., 1998. -241х
3. Д. Лүндээжанцан. Аюулгүй байдал, Төр, Эрх зүй. (эмх), УБ., 2002. -268х
4. Монгол Улсын Үндсэн Хууль. -104х
5. Монгол Улсын Зэвсэгт хүчний эрх зүйн үндэс. (эмх), УБ., 2002. -304х
6. Монгол Улсын Иргэний хууль .
7. Монгол Улсын Эрүүгийн хууль.
8. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль.
9. Монгол Улсын Шүүх тухай хууль.
10. Монгол Улсын Цэргийн дүрмүүд.
11. Mongolia An International Annual of Mongol Studies. VOL. 7(28), 1996. -288х
12. Mongolia An International Annual of Mongol Studies. VOL. 9(30), 1999. -666х
13. Цэргийн шинэчлэл. (сэт) I, II, III, IV 2001., I, II. 2002.
14. Ц. Дашцэвэг. Зэвсэгт хүчнийг шинэчлэх бодлого, зорилт үйл ажиллагаа. УБ., 2002. -216х
15. Цэрэг, иргэний харилцааны онол, практикын тулгамдсан асуудлууд. (эмх), УБ., 2002. -248х
16. Улс төрийн шинжлэх ухаан. МУИС., УБ., 2001. -450х
17. Seminar in Civil and military Relations. Mongolia. UB., 2001. - 24х

1 дүгээр хавсралт

Батлан хамгаалах салбарын холбогдолтой хууль,  
ТОГТООМЖЫН ЖАГСААЛТ

№	Хуулийн нэр	Батлагдсан он	Нэмэлт өөрчлөлт орсон он
<b>Төрийн цэргийн бодлого</b>			
1.	Монгол Улсын Үндсэн хууль	1992	-
2.	Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал	1994	-
3.	Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал	1994	-
4.	Монгол Улсын төрийн цэргийн бодлогын үндэс	1998	-
5.	Үндэсний аюулгүй байдлын тухай Монгол Улсын хууль	2001	-
6.	Үндэсний аюулгүй байдлыг хангах тухай Монгол Улсын хууль	1992	-
7.	Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн тухай Монгол Улсын хууль	1992	1995, 1998, 1999
<b>Батлан хамгаалах тухай</b>			
8.	Монгол Улсын Батлан хамгаалах тухай Монгол Улсын хууль	1993	2002
9.	Зэвсэгт хүчний тухай Монгол Улсын хууль	2002	-
10.	Монгол Улсын Их Хурлын тухай Монгол Улсын хууль	1992	2001




11.	Ерөнхийлөгчийн тухай Монгол Улсын хууль	1993	1997
12.	Засгийн газрын тухай Монгол Улсын хууль	1993	1996, 2001
13.	Монгол Улсын Хилийн тухай хууль	1993	1996, 1999, 2000, 2001, 2002
14.	Цэрэг, цагдаагийн албан хаагчийг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад үйл ажиллагаанд оролцуулах тухай Монгол Улсын хууль	2002	-
15.	Төрийн нууцийн тухай Монгол Улсын хууль	1995	-
16.	Хувь хүний нууцийн тухай Монгол Улсын хууль	1995	-
<b>Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдал</b>			
17.	Төрийн албаны тухай Монгол Улсын хууль	1995	2002
18.	Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай Монгол Улсын хууль	1992	1993, 1995, 1997, 1998, 2000, 2002
19.	Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай Монгол Улсын хууль	1994	1995, 1999, 2000, 2002
20.	Цэргийн албан хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай Монгол Улсын хууль	2002	-
21.	Офицерын алба хаах журам	2001 оны 325 тоот тушаал	-
22.	Ахлагчийн алба хаах журам	2001 оны 370 тоот тушаал	-


23.	Гэрээт цэргийн албан хаагчаар иргэнийг сонгон шалгаруулах журам	1998 оны 95 тоот тушаал	-
24.	Цэргийн цол олгох журам	1999 оны 41-р зарлиг	-
25.	Цэргийн албыг сайн дурын үндсэн дээр гэрээгээр хаах журам	ЗГ, 1999 оны 5-р тогтоол	-
26.	Зэвсэгт хүчин бусад цэргийн албан хаагчийн цэргийн цолны цалингийн хувь хэмжээний тухай Засгийн газрын тогтоол	ЗГ, 1999 оны 38-р тогтоол	-
27.	Офицер, ахлагч гэрээт цэргийн албан хаагчид цэргийн мэргэжлийн зэрэг олгох тухай журам	2000 оны 77 тоот тушаалын хавсралт	-
28.	Цэргийн дүрэмт хувцас хэрэглэлийн норм	ЗГ, 1999 оны 16-р тогтоол	-
29.	Зэвсэгт хүчин, хилийн цэргийн офицер, ахлагч нарт төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам	ЗГ, 2000 оны 3-р тогтоол	-
30.	Зэвсэгт хүчин бусад цэргийн офицер, ахлагч, гэрээт цэргийн албан хаагчид онцгой нөхцлийн нэмэгдэл олгох журам	ЗГ, 2001 оны 261-р тогтоол	-
<b>Зэвсэгт хүчний сургалт, бэлтгэлийн тухай</b>			
31.	Дайны байдлын тухай Монгол Улсын хууль	1998	2002
32.	Дайчилгааны тухай Монгол Улсын хууль	1998	2002
33.	Дайн бүхий байдлын тухай Монгол Улсын хууль	1998	-
34.	Гадаадын цэргийн хүчнийг байрлуулах, дамжин өнгөрүүлэх тухай Монгол Улсын хууль	1998	-

35.	Онц байдлын тухай Монгол Улсын хууль	1995	-
36.	Дайчилгааны зарлан мэдээлэл явуулах журам	ЗГ, 1999 оны 200-р тогтоол	-
37.	Дайчилгаатай сургууль явуулах журам	ЗГ, 1999 оны 200-р тогтоол	-
38.	Дайчилгаатай сургуульд татан оролцуулсан бэлтгэл офицер, цэргийн бэлтгэл үүрэгтэнд цалин олгох хэмжээ, журам	ЗГ, 1999 оны 200-р тогтоол	-
39.	Техник хэрэгслийг дайчилгаатай сургуульд оролцуулсны хөлсийг төлөх журам	ЗГ, 1999 оны 200-р тогтоол	-
40.	Ерөнхий зориулалтын цэргийн анги, салбарыг улсын хил хамгаалалтад оролцуулах журам	1999 оны 134 тоот тушаал	-
41.	Цэргийн мэргэжлийн нэмэгдлийг шинэчлэн тогтоох тухай засгийн газрын тогтоол	ЗГ, 1999 оны 123-р тогтоол	-


### ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТАЙВАН ЦАГИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО



**ДАЙНЫ БАЙДЛЫН ҮЕД ЗЭВСЭГТ ХҮЧНИЙГ  
УДИРДАХ ЗАГВАР**



### ЗЭВСЭГТ ХУЧИНД ИРГЭНИЙ ХЯНАЛТ ТАВИХ ЗАГВАР



ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.  
**ЗЭВСЭГТ ХҮЧИНД ИРГЭНИЙ ХЯНАЛТЫГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХЭД УЛС ТӨРИЙН  
СУБЪЕКТҮҮДИЙН ҮҮРЭГ ОРОЛЦОО**

*Ц.Цэвээнсүрэн*  
/БХИС-ийн тэргүүн дэд захирал/

Монгол Улс түүхэн хөгжлийнхөө явцад ардчилал, зах зээлийн харилцааны шинэ замыг эргэлт буцалтгүй сонгосон өнөөгийн нөхцөлд батлан хамгаалах тогтолцоо, Зэвсэгт хүчний байгуулалтын эрх зүйн үндсийг шинээр авч үзэж, түүнийг төлөвшүүлэн бүрдүүлэх асуудал дэвшигдэж энэ нь Монгол Улсын Үндсэн хууль, Батлан хамгаалах тухай хууль болон батлан хамгаалах салбарын багц хуулиудад тусгалаа олон хэрэгжиж байна.

Аливаа улс орны Зэвсэгт хүчний хөгжилд түүний байгуулалтын асуудал чухал байр суурийг эзэлдэг бөгөөд дэлхий дахины болон бүс нутгийн цэрэг-улс төрийн байдал, тухайн улс орны улс төр, нийгмийн байгуулал, төрийн гадаад, дотоод улс төрийн бодлогоос шалтгаалан тэр нь байнга боловсронгуй болон хөгжиж байдаг зүй тогтолтой юм.

Монгол Улс өмнөх нийгмийн байгууллаас эрс ялгаатай улс төр, нийгмийн цоо шинэ тогтолцоонд шилжиж байгаа нөхцөлд социалист маягийн арми, Зэвсэгт хүчний байгуулалтын онол, ЗХУ-ын (хуучин нэрээр) цэрэг, Зэвсэгт хүчний байгуулалтын туршлагад тулгуурлан хөгжиж ирсэн манай зэвсэгт хүчний хувьд хөгжлийнхөө нэгэн шинэ үеийг туулж байна гэж үзэж болох юм.

Социалист, интернационалист үүргийг биелүүлж байсан Монголын Зэвсэгт хүчин өнөөдөр “Монгол Улс өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчинтэй байна” [1. 10] гэсэн шинэ заалтыг Үндсэн хуулиндаа анх удаа тунхаглан хэрэгжүүлж байна.

1993 онд батлагдсан “Монгол Улсын Батлан хамгаалах тухай хууль”-д Зэвсэгт хүчний байгуулалтын зарчмуудыг

шинэ нөхцөл байдалд хуульчлан баталгаажуулж өөр хоорондоо харилцан уялдаа холбоо бүхий 9 зарчмыг авч үзсэн нь эрх зүйн шинэчлэл, Зэвсэгт хүчний байгуулалтын онолын цаашдын хөгжил хандлагад шинэ үзэл баримтлал болж өгсөн юм. Нэгэнт энэхүү судалгааны өгүүлэлд цэрэг, иргэний харилцаа, иргэний хяналтын тухай авч үзэж буй учир холбогдол бүхий зарчмыг эш татвал: “зэвсэгт хүчин, бусад цэргийн үйл ажиллагаа иргэний хяналтад байх” [2. 68] гэж анх удаа хуульчилсан нь Зэвсэгт хүчинд тавих ардчилсан иргэний хяналтын эрх зүйн үндэс байлаа.

Тоталитар дэглэмийн үед төржсөн намын зүгээс Зэвсэгт хүчинд тавих хяналтын бүхэл бүтэн тогтолцоо оршин тогтнож, шууд МАХН-ын Төв хороо болон түүний дэргэдэх Намын хянан шалгах хороо, Ардын армийн Улс төрийн газрын дэргэдэх Намын комисс, намын анхан шатны байгууллагууд, ардын хянан шалгах хороо, бусад олон нийтийн байгууллагуудын шугамаар хяналтыг хэрэгжүүлдэг байсан. Түүнчлэн төр, захиргааны байгууллага, төрийн төлөөлөгчдөөр дамжуулан хяналтыг хэрэгжүүлдэг байсан билээ.

Эдгээр хяналт нь цар хүрээ, арга хэлбэрээрээ ялгаатай байсан хэдий ч агуулга, мөн чанарын хувьд МАХН-ын дээд байгууллага дээр зангидагдаж, бүхэлдээ үзэл сурталчсан, захиргаадалтын шинжтэй байлаа. Тэр үед хот, хөдөөгийн үйлдвэр, аж ахуйн байгууллага, иргэд хамт олны зүгээс цэргийн анги, салбаруудтай харилцан холбоотой ажиллах олон хэлбэрүүд, нэн ялангуяа шефийн холбоо ихээхэн хөгжиж байсан юм.

Энэ үед Зэвсэгт хүчин нь үндсэндээ нэг намын бодлогын хүрээнд үйл ажиллагаа явуулж, тэрхүү намын зүгээс голчлон хяналт тавьдаг байсан учраас намын дотоод хяналт хэлбэртэй, арми зэвсэгт хүчний үйл ажиллагаатай холбоотой дутагдал зөрчлийг ард иргэдэд мэдээлж хүргэхийг хүсдэггүй, нэгэнт ийм болохоор Зэвсэгт хүчний талаар мэдээлэл хомс, тоталитар дэглэм маань цэрэг зэвсгийн хүчийг батлан хамгаалах гол арга хэрэгсэл болгодог учраас цэргийн асуудалд онцгой эрх дарх өгдөг байсан билээ. Батлан хамгаалах бодлогын асуудал бүхэлдээ шүүмжлэлийн гадна байсан гэж хэлж болох талтай.



Цэргийн хэргийн мэдлэг, чадвартай, цэргийнхэнтэй хамтран ажиллаж, арми зэвсэгт хүчний онцлог, тулгамдсан асуудлын талаар өргөн цар хүрээтэй хяналтыг хэрэгжүүлж чадахуйц иргэд, мэргэжилтнүүдийг татан ажиллуулах явдал ч бараг байгаагүй юм. Иргэдийн зүгээс хийх хяналтад төдийлөн дасаагүй цэргийнхэн ч энэ талаар олигтой санаачилга гаргадаггүй байв.

Өөрөөр хэлбэл тэр үед Зэвсэгт хүчний иргэний хяналт нь олон нийтийн биш, төржсөн намын, сайндаа төрийн хяналт л байсан гэж үзэж болно. Иргэд, ард түмэн Зэвсэгт хүчний талаар маш бага мэдээлэлтэй учраас жинхэнэ иргэний хяналт хэрэгжихгүй, Зэвсэгт хүчний байдал, үүрэг зориулалт нийгмийн эрх ашигт нийцэж байна уу гэдгийг л тэд өнгөцхөн ойлгодог байлаа.

Иргэд, олон түмэн өөрсдийнхөө ашиг сонирхлын үүднээс армийн үйл ажиллагаанд нөлөөлөх эрх зүйн механизм бүрдээгүй байсан юм. Зэвсэгт хүчинд үндсэн хууль, бусад хуулиудын хэм хэмжээ, цэргийн дүрмийн заалт, шаардлага хэрхэн биелэгдэж байгааг иргэд олон түмэн тэр бүр мэддэггүй, армийн бие бүрэлдэхүүн болохоор улс төрийн дээд удирдлагын шийдвэрээр л зэвсэг хэрэглэнэ гэдгийг хатуу ойлгодог байлаа. Ийм учраас зарим үед цэргийн командлалын бараг оролцоогүйгээр улс төрийн дээд удирдлагаас цэрэг хэрэглэх тухай шийдвэрүүд гаргаж байсан жишээ баримтууд байдгийг бид өмнөх түүхээс мэднэ.

Өнөөгийн манай нийгмийн шилжилтийн үед Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналт бүрэн гүйцэд хэрэгжээгүй ч нийгэм, улс төр, хууль, эрх зүйн томоохон эхлэл алхмууд хийгдээд байна.

Нийгмийн шинэ харилцаа бүрэлдэж эхэлсэн анхны жилүүдэд батлан хамгаалах тогтолцоо, Зэвсэгт хүчний эрх зүйн үндсийг юуны түрүүнд бүрдүүлэх зорилт дэвшигдэж, Батлан хамгаалах тухай хуулийг УИХ-аар батлуулсан нь манай салбарын цаашдын хөгжилд шинэ эргэлт болсон гэж үзэж болох талтай. Энэхүү хуулинд: “Зэвсэгт хүчин, бусад цэргийн ерөнхий удирдлагыг Монгол Улсын Их хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Батлан хамгаалах асуудал

эрхэлсэн Засгийн газрын гишүүн Үндсэн хууль, энэ хууль, бусад хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд хэрэгжүүлж, иргэний хяналт тавина” [2. 69] гэж иргэний хяналтын субъектүүдийг тодорхойлсон юм. 2002 онд УИХ-аар батлагдсан Монгол Улсын Зэвсэгт хүчний тухай хуульд: “Зэвсэгт хүчин нь иргэний хяналтад байх” [6. 24] гэж Зэвсэгт хүчний өөрийнх нь байгуулалтын зарчим болгон хуульчлаад түүнтэй холбогдуулан баталсан Батлан хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд иргэний хяналтын субъектүүдийн эрх, үүргийг шинээр тодруулан заажээ. Энэхүү хуулинд “Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналт нь төрийн хууль тогтоомжийн биелэлт, зэвсэгт хүчний цэргийн мэргэжлийн удирдлагын үйл ажиллагаа болон төсвийн санхүүжилт, зарцуулалтыг нээлттэй, ил тод хянах үйл ажиллагаа мөн” [6. 4] гэж иргэний хяналтын объектыг шинэчлэн тодорхойлсон байна.

Дээрх хуулиудад зааснаар Монгол Улсын зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтын субъект нь Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, түүний бүтцийн байгууллагаас бүрдэх бөгөөд төрийн бус байгууллага, хэвлэл, мэдээллийн байгууллага, улс төрийн нам, жирийн иргэд хүртэл энэхүү тогтолцоонд хамаарч болох юм.

Зэвсэгт хүчний иргэний хяналтыг хэрэгжүүлэх, улс төрийн субъектүүдийн үүрэг оролцоог авч үзье.

**Монгол Улсын их хурал** Зэвсэгт хүчний үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох, төрийн бодлогын үндэс, зэвсэгт хүчнийг бэхжүүлэх үндсэн чиглэлийг тодорхойлох, улс орныг батлан хамгаалах арга хэмжээний төсвийг батлах зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлж байгаагаараа Зэвсэгт хүчнийг шууд удирддаг [13.16].

Үндсэн хуулийн 20 дугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална” [1. 25] гэж тодорхойлсноос үзэхэд Монгол Улс бол парламентын засаглалтай улс юм.

Ийм учраас Монгол Улсын парламент, Ерөнхий сайд

тэргүүтэй Засгийн газраа томилох, өөрчлөх, огцруулах, мөн түүнчлэн Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсөн хууль гаргах, чөлөөлөх, огцруулах эрх бүхий байгууллага мөн.

Тэрчлэн Үндсэн хуулийн 25 дугаар зүйлд зааснаар УИХ нь *“төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэх эрхтэй”* бөгөөд улс орны аюулгүй байдал, батлан хамгаалах бодлоготой холбогдсон дараахь онцгой бүрэн эрхийг эдэлдэг. Тухайлбал: *төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох; -Улсын Их Хурлын Байнгын хороо, Засгийн газар, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүтцийг тогтоох, бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх, огцруулах; - төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах; - хууль, тогтоол, шийдвэрийн биелэлтийг хянан, шалгах; Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, бүрэн эрхийг тогтоох; - Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд аюул занал учруулж, зэвсэглэн халдвал дайн бүхий байдал зарлах, цуцлах; - онцгой нөхцөлд улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь онц болон дайны байдал зарлах, эсхүл энэ тухай гаргасан Ерөнхийлөгчийн зарлигийг батлах, хүчингүй болгох зэрэг эрхтэй байдаг.*

Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу, Улсын Их Хурал нь *“батлан хамгаалах тогтолцооны эрх зүйн үндсийг тогтоож, зэвсэгт хүчин, бусад цэргийн үйл ажиллагаанд иргэний хяналт тавих”* [2.62], эрх бүхий субъект болж хуульчлагдсан юм. 1993 онд батлагдсан хуульд ийнхүү тусгагдсан нь зэвсэгт хүчний иргэний хяналтын шинэ тогтолцоог төлөвшүүлэхэд зарчмын ач холбогдолтой болсон бөгөөд дээр өгүүлсэнчлэн иргэний хяналтад байх нь зэвсэгт хүчний байгуулалтын зарчим болсноор энэ заалт өөрчлөгдсөн юм. Тэрчлэн дайны аюулыг сэрэмжлэх, бусад улс оронтой маргаантай асуудлыг улс төрийн аргаар шийдвэрлэх, Монгол Улсын Төрийн цэргийн бодлогын үндсийг тодорхойлох, улс орныг батлан хамгаалах арга хэмжээний

*төсвийг батлах, батлан хамгаалах хүч чадлыг бэхжүүлэх үндсэн чиглэлийг тодорхойлох, цэргийн албан хаагчдад онцгой эрх олгох, тэдний эрх, эрх чөлөөг хязгаарлах талаар цэргийн нийтлэг дүрмүүдийн хэм хэмжээний эрх зүйн үндсийг тогтоох, цэргийн албан хаагчдын нийгмийн хамгаалалт, эрх зүйн баталгааны үндсийг тодорхойлох, батлан хамгаалах хамтын ажиллагааны талаарх Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон батлах, цуцлах; цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлыг албаны онцлогт нь тохируулж тогтоох; цэргийн дээд цол бий болгох; гадаадын цэргийн хүчнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлуулах, дамжин өнгөрүүлэх болон өөрийн цэргийн анги, салбарыг олон улсын энхийг сахиулах болон хүмүүнлэгийн үйл ажиллагаанд оролцуулах асуудлыг шийдвэрлэх зэрэг эрхээр хангагддаг [17. 3].*

2002 онд Улсын Их Хурлаар Монгол Улсын Зэвсэгт хүчний тухай хуулийг баталсан нь Зэвсэгт хүчний үйл ажиллагааг хуулийн дагуу зохицуулах, иргэний хяналтыг хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой болсон юм. Өөрөөр хэлбэл Зэвсэгт хүчин анх удаа хуультай болсон нь Улсын Их Хурал өөрийнхөө бүрэн эрхийн хүрээнд иргэний хяналтыг хэрэгжүүлж байгаагийн тод жишээ мөн.

Ийнхүү Улсын Их Хурал нь Үндсэн хууль болон бусад хуулиудын дагуу дэлхийн олонх парламентын нэгэн адил “1/ батлан хамгаалах салбартай холбогдсон хууль, төсвийг батлах, 2/ хууль, тогтоомж бусад шийдвэрийн биелэлтийг хянан, шалгах, 3/ батлан хамгаалахын сайдыг томилох, өөрчлөх, 4/ онц байдал, дайн бүхий байдал зарлах эрхийг хэрэгжүүлэх үүргийг хүлээсэн байна.

Түүнчлэн Ерөнхийлөгчийг түр эзгүйд бүрэн эрхийг нь Улсын Их Хурлын дарга хэрэгжүүлэх, Засгийн газар нь төрийн хууль биелүүлэх ажлыг УИХ-ын өмнө хариуцах, үйл ажиллагаагаа УИХ-д тайлагнах, “Ерөнхийлөгч Улсын Их Хуралд ажлаа хариуцах”[1.43] зэрэг заалтуудыг харгалзан үзвэл УИХ нь “төрийн эрх барих дээд байгууллага”-ын хувьд Зэвсэгт хүчинд иргэний хяналтыг хэрэгжүүлэх төдийгүй төрийн удирдлагын хамгийн дээд субъект юм.

**Монгол Улсын Ерөнхийлөгч** нь Зэвсэгт хүчнийг тайван цагт болон дайны байдлын үед удирдах харьцангуй бүрэн эрхээр хангадсан байдаг. Үндсэн хуулиар "...Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч..."[1.36], бүх ард түмнээр сонгодсон төрийн дээд элч төлөөлөгчийн хувьд зэвсэгт хүчинд иргэний хяналтыг хэрэгжүүлэгч онцгой эрх бүхий субъект болдог. Ерөнхийлөгч нь энэ үүргээ хэрэгжүүлэхэд Монгол Улсын Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч байхаар хуульчилсан явдал чухал нөлөө үзүүлсэн юм. Үндсэн хуулийн 35 дугаар зүйлд заасан Ерөнхийлөгчийн бүрэн эрхээс батлан хамгаалах салбартай холбоотой эрхийг дүгнэн авч үзвэл: *"Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих, өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Засгийн газарт чиглэл өгөх..., ...цэргийн дээд цол хүртээх, одон, медалиар шагнах, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлэх, Бүх нийтийн буюу хэсэгчилсэн цэргийн дайчилгаа зарлах, ... онцгой нөхцөл бий болбол Улсын Их Хурлын чуулганы чөлөө цагт, хойшлуулшгүй тохиолдолд улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь онц болон дайны байдал зарлах, түүнчлэн цэрэг хөдөлгөх захирамж өгөх...зэрэг онцгой бүрэн эрхийг эдэлдэг.* Харин Монгол Улсын "Батлан хамгаалах тухай" хуулийн 7 дугаар зүйлд Ерөнхийлөгч Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн хувьд бүрэн эрхийг тодотгон зааж өгсөн нь түүнээс Зэвсэгт хүчнийг удирдах, иргэний хяналтыг хэрэгжүүлэхэд илүүтэй чиглэгдэж байна. Тэрээр *"Монгол Улсын Төрийн цэргийн бодлогын хэрэгжилт, улс орныг батлан хамгаалахад зайлшгүй шаардагдах материаллаг нөөцийн бүрдүүлэлтэд хяналт тавих, батлан хамгаалах арга хэмжээний төсвийн талаар Улсын Их Хуралд санал дүгнэлт оруулах, цэргийн нийтлэг дүрмүүдийг батлах, цэргийн албан хаагчид цэргийн цол олгох журмыг тогтоох,"* [2.63] зэрэг бүрэн эрхүүд нь иргэний хяналтын чухал эх сурвалж болж байна. Энэхүү бүрэн эрхийнхээ дагуу жил бүрийн батлан хамгаалах арга хэмжээний төсвийг УИХ-аар хэлэлцэх үед Ерөнхийлөгч үг хэлж, санал дүгнэлтээ гарган толилуулдаг нь цэргийн төсвийг үндэслэлтэй батлахад түлхэц нөлөө үзүүлж байна.

"Зэвсэгт хүчний тухай" хуулийн 13 дугаар зүйлд

зааснаар Ерөнхийлөгч зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хувьд Зэвсэгт хүчний тайван цагийн болон дайны байдлын үеийн зохион байгуулалтын бүдүүвчийг батлах; Зэвсэгт хүчнийг дайнд ашиглах төлөвлөгөөг баталж, цэргийг байлдааны бэлэн байдлын дээд зэргүүдэд шилжүүлэх, байлдааны ажиллагаа эхлэх шийдвэрийг холбогдох хууль тогтоомжийн дагуу гаргах; Зэвсэгт хүчнийг дайны байдлын үеийн бүтэц, зохион байгуулалтад шилжүүлэх шийдвэр гаргах; Зэвсэгт хүчнийг ашиглах номлолыг батлах; Рэвсэгт хүчний Жанжин штабын дүрмийг батлах; Зэвсэгт хүчний Жанжин штабын даргыг Улсын Их Хуралтай зөвшилцөн томилох; улсын хил, онц чухал объектын хамгаалалтад ерөнхий зориулалтын цэргээр дэмжлэг үзүүлэх шийдвэр гаргах; Зэвсэгт хүчний анги, байгууллагыг аж ахуй, бүтээн байгуулалтын ажилд оролцуулах журмыг тогтоох эрх эдэлдэг. Тэрчлэн Монгол Улсын Ерөнхийлөгч нь олон улсын болон бүс нутгийн цэрэг, улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан, технологи, цэргийн хэрэгт гарч буй өөрчлөлттэй уялдуулж, тодотгол хийх саналыг УИХ-д оруулахаар заасан байна [9.23].

Энэ бүхнээс үзэхэд Монгол Улсын Ерөнхийлөгч нь **нэгдүгээрт**: Зэвсэгт хүчний ерөнхий командлагч байх, **хоёрдугаарт**: Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлэх, **гуравдугаарт**: дайчилгаа зарлах, УИХ-тай харилцан зөвшилцсөний дагуу дайн бүхий байдал зарлах, **дөрөвдүгээрт**: цэргийн хүчийг хөдөлгөх эрхтэй, тайван болон дайны цагт иргэний хяналтыг хэрэгжүүлэгч субъект болно.

**Засгийн газар**: Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Засгийн газар нь “төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн” [1. 45]. Засгийн газар нь “төрийн хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүрэгтэй” [1. 45]-ээс гадна батлан хамгаалах салбартай холбоотой нилээд үүргүүдийг хүлээж ажилладаг. Тухайлбал, Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах, ...улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж Улсын Их Хуралд өргөн барьж, гарсан шийдвэрийг биелүүлэх, салбарын ба салбар хоорондын... асуудлаар арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх, улсыг

батлан хамгаалах хүчин чадлыг бэхжүүлж, үндэсний аюулгүй байдлыг хангах зэрэг болно.

Мөн Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 13 дугаар зүйлд зааснаар Засгийн газар нь улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангах талаар дараахь бүрэн эрхийг эдэлдэг. Үүнд:

“Улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангах болон цэргийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх, Зэвсэгт хүчнийг бэхжүүлэх арга хэмжээ авах, Улсын хилийг хамгаалах ажлыг чиглүүлэн удирдах, Улсын аюулгүй байдлыг хангах арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх, Улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангахад зайлшгүй шаардагдах материалын нөөцийн санг бүрдүүлэх, нөхөн сэлбэх арга хэмжээ авах, Төрийн нууцыг хамгаалах ажлыг чиглүүлэн удирдах” [5. 4] гэж заасан байна.

Хүн амыг байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, түүний хор уршгийг арилгах арга хэмжээ авч, иргэний хамгаалалтын ажлыг удирдан зохион байгуулах үүргийг мөн энэ хуулиар Засгийн газарт оногдуулжээ.

Батлан хамгаалах тухай хуульд Засгийн газрын бүрэн эрхийг нилээд дэлгэрэнгүйгээр зааж өгсөн байдаг. Үүнд:

- *“улс орныг батлан хамгаалах болон орон нутгийн хамгаалалтын асуудлаар төрийн захиргааны байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх [17. 3];*
- *“батлан хамгаалах арга хэмжээний төсвийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;*
- *цэргийн анги, байгууллагыг байгуулах, татан буулгах асуудлыг Зэвсэгт хүчний ерөнхий командлагчтай зөвшилцөн шийдвэрлэх, цэргийн анги байгууллагын байршлыг тогтоох, батлан хамгаалах хэрэгцээний эзэмшил газрын зөвшөөрөл олгох;*
- *төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн дайчилгааны даалгаврыг батлах;*
- *улсын болон зэвсэгт хүчний дайчилгааны*

*материаллаг нөөцийн хэмжээг тогтоож, түүнийг бүрдүүлэх, зарцуулах арга хэмжээг зохион байгуулах;*

- *тайван цагт улсын дайчилгааны бэлтгэлийг хангах, шаардлагатай үед Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн шийдвэрийн дагуу улс орныг дайны байдалд шилжүүлэх [2.64];*
- *иргэдийг эх оронч үзлээр хүмүүжүүлэхэд төрийн бүх шатны болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааг нэгтгэн чиглүүлэх, цэрэг иргэний харилцааг төлөвшүүлэх;*
- *Иргэдээс цэргийн үүргээ биелүүлэх хүсэл сонирхол, эрмэлзлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх” [17. 3];*
- *“жил бүр цэргийн жинхэнэ албанд татах, дайчилгааны сургууль, цугларалтад оролцуулах хүний тоо, цэрэг татлага явуулах хугацааг Зэвсэгт хүчний ерөнхий командлагчтай зөвшилцөн тогтоох;*
- *цэрэг, цэрэг-техникийн хамтын ажиллагааны асуудлаар өөрийн бүрэн эрхийн хүрээнд бусад улсын Засгийн газартай хэлэлцээр байгуулах;*
- *хилийн болон иргэний хамгаалалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагуудыг байгуулах, тэдгээрийн дарга нарыг Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн томилох, чөлөөлөх;*
- *Зэвсэгт хүчин, бусад цэргийг зайлшгүй шаардлагатай бүтээгдэхүүнээр хангах асуудлыг шийдвэрлэх;*
- *гадаад улсаас авах цэргийн зэвсэг, байлдааны техникийн төрөл, тоог тогтоож, Улсын Их Хурлын зөвшөөрснөөр санхүүжүүлэх” [2. 64] зэрэг болно.*

Монгол Улсын Засгийн газар нь 1/ батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны талаарх УИХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, 2/ төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн дайчилгааны даалгаврыг биелүүлэх, 3/ улс орныг батлан хамгаалах болон зэвсэгт хүчнийг бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх зэрэг үүрэгтэй



байдаг. Эндээс үзэхэд Засгийн газар нь батлан хамгаалах талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэх, батлагдсан төсөв, санхүүг зохицуулах, Зэвсэгт хүчний бэлэн байдлыг хангах, үйл ажиллагааг чиглүүлэх, хянаж шалгах замаар нэг талаас бүрэн эрхээ, нөгөө талаас иргэний хяналтыг хэрэгжүүлдэг субъект юм. Засгийн газрын эдгээр үүргийг биелүүлэхэд батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын үүрэг өндөржсөн нь Зэвсэгт хүчинд захиргааны болон иргэний ардчилсан хяналтыг хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлж байна.

**Батлан хамгаалах яам:** Батлан хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлд Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу Батлан хамгаалах яам нь:

- улсыг батлан хамгаалах бодлого, улсын дайчилгааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

- Зэвсэгт хүчнийг зэвсэг техник, бусад материал, хэрэгслээр хангах санал боловсруулах, гарсан шийдвэрийн хэрэгжүүлэх;

- батлан хамгаалах салбарын боловсон хүчнийг сургаж бэлтгэх, цэргийн албан хаагчийн хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хамгаалах;

- батлан хамгаалах салбарт техник, технологийн дэвшлийг хангаж, зэвсэг, техникийг шинэчлэн сайжруулах бодлого боловсруулах, энэ талаар гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;

- батлан хамгаалах салбарт судалгаа шинжилгээний ажил явуулах бодлогыг тодорхойлж, хэрэгжилтийг зохион байгуулах;

- улсыг батлан хамгаалах арга хэмжээний төлөвлөлтөд шаардагдах мэдээ, судалгааны нэр төрлийг тогтоож, төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагаас гаргуулж авах;

- хугацаат цэргийн алба хаах иргэний тоо, цэрэг татлага явуулах ээлж, хугацааг тогтоох санал бэлтгэж Засгийн газарт оруулах;

- гэрээт цэргийн алба хаах мэргэжил, тооны дээд хязгаарыг санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран жил бүр тогтоох [17. 4] үүргийг

хэрэгжүүлж байна.

Батлан хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлд: “Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн-улс төрийн албан тушаалтан нь цэргийн жинхэнэ албанаас ангид байна” [17. 3] гэж заагаад түүний бүрэн эрхийг тодорхойлон заажээ. Тэрээр:

- “улсыг батлан хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

- батлан хамгаалах тогтолцоог боловсронгуй болгох саналыг Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд оруулах, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчид өргөн мэдүүлэх;

- цэргийн нийтлэг дүрмүүдийг батлуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн барих;

- батлан хамгаалах асуудлаар бусад улстай хамтран ажиллах талаар Засгийн газраас олгосон эрхийн хүрээнд хэлэлцээр байгуулах;

- батлан хамгаалах арга хэмжээний төсвийн төслийг Засгийн газарт оруулах, батлагдсан төсвийг зарцуулалтад хяналт тавих;

- батлан хамгаалах улсын байцаагчийг томилох, чөлөөлөх;

- батлан хамгаалах хууль тогтоомж, батлан хамгаалах асуудлаарх Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын болон өөрийн шийдвэрийн биелэлтийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгжид шалган танилцаж, биелэлтийг хангах талаар үүрэг даалгавар өгч гүйцэтгүүлэх;

- батлан хамгаалах салбарын төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах, устгах, шилжүүлэх, шинээр авах асуудлыг шийдвэрлэх, захиалгыг хянаж батлах;

- батлан хамгаалах салбарын төрийн өмчит хуулийн этгээд, эд хөрөнгийг хувьчлах саналаа Засгийн газарт оруулах” [17. 4] чиг үүрэгтэй.

Зэвсэгт хүчний тухай хуульд зааснаар батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд зэвсэгт хүчний байгуулалтын нийгэм, эдийн засаг, эрх зүйн үндсийг хангах бодлого боловсруулж, хэрэгжилтийг зохион

байгуулах; зэвсэгт хүчнийг бэхжүүлэх саналыг Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд оруулах, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчид өргөн мэдүүлэх; ерөнхий зориулалтын цэргийн зэвсэг, техник, материал хэрэгслээр нөхөн хангах ажлыг зохион байгуулах; ерөнхий зориулалтын цэргийн зэвсэг, техникийг шинэчлэн сайжруулах саналыг Засгийн газарт өргөн мэдүүлж, шийдвэрлүүлэх; ерөнхий зориулалтын цэргийн батлагдсан төсвийн ангилал хооронд зохицуулалт хийх эрх олгожээ.

Батлан хамгаалах асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний удирдлага доор үйл ажиллагаагаа явуулах Батлан хамгаалах яам нь улсын хэмжээнд төрийн батлан хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг удирдах, зохицуулах, шаардлагатай зүйлээр хангах, Зэвсэгт хүчний үйл ажиллагаанд иргэний хяналтыг хэрэгжүүлэгч үндсэн субъект болж байна.

**Үндэсний аюулгүй байдлын зөвлөл:** Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл нь үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн нэгдмэл бодлого боловсруулах үйл ажиллагаа болон түүнийг хэрэгжүүлэх ажлыг уялдуулан зохицуулах, энэхүү зохицуулалт нь хэрхэн хангагдаж байгаад хяналт тавих төрийн зөвлөлдөх байгууллага ажээ. Энэ зөвлөл нь ажлаа УИХ-ын өмнө шууд хариуцдаг. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нар ордог. Зөвлөлийн тэргүүн нь Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Монгол Улсын Ерөнхийлөгч байх бөгөөд тэрээр зөвлөлийн ажлыг бүхэлд нь удирдах, хэлэлцэх асуудлыг тодорхойлох, хуралдааныг даргалах, зөвлөлийг төлөөлөх, ажлын хэсэг байгуулах эрхийг эдэлдэг байна.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар *“өөрийн орны улс төр, нийгмийн амьдралд дүн шинжилгээ хийж, Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдлыг бэхжүүлэх, Үндсэн хуулиар тодорхойлсон төр, нийгмийн байгууллыг бататгах..., төрийн батлан хамгаалах бодлогыг тодорхойлж, зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгон бэхжүүлэх, улс төрийн гадаад нөхцөл байдлыг харгалзан*

*төрийн цэргийн бодлогын үндсийн талаарх саналыг бэлтгэж, Монгол Улсын Ерөнхийлөгчөөр уламжлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, Монгол Улсын үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдлын ашиг сонирхлын үүднээс олон улсын нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, технологи, цэрэг, улс төрийн байдалд дүн шинжилгээ хийж, шаардлагатай арга хэмжээг тодорхойлох” [8. 47] зэргээр үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогыг зохицуулах, хэрэгжилтэнд хяналт тавих үүрэгтэй байна.*

ҮАБЗ-д зөвлөлийн гишүүд, нарийн бичгийн дарга, зөвлөх, илтгэгч, шинжээчийн хэсэг хамаардаг бөгөөд нарийн бичгийн дарга нь Зөвлөлийн үндсэн чиг үүрэгт хамаарах асуудлаар судалгаа хийх, үнэлэлт, дүгнэлт гаргах, шийдвэрийн үндэслэлийг боловсруулах, биелэлтэд хяналт тавих ажлыг зохион байгуулж, Зөвлөлийн гишүүд бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь тусалж, тэднийг үндэсний аюулгүй байдлын талаарх судалгаа, мэдээллээр хангах дотоод ажлыг эрхэлнэ.

Улсын Их Хурлын дэд дарга, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ахлагч нар зөвлөлийн хуралдаанд зөвлөх эрхтэй оролцдог.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Зэвсэгт хүчний жанжин штабын дарга болон тусгай газрын дарга нар Зөвлөлийн илтгэгч байх бөгөөд тэдгээр нь тус тусын хариуцсан салбар, хүрээнд үндэсний язгуур ашиг сонирхол, аюулгүй байдлыг хангахтай холбоотой асуудлыг судалж зохих илтгэл, санал, шийдвэрийн төслийг боловсруулан Зөвлөлд оруулж, гарсан шийдвэрийг эрхэлсэн салбар, хүрээндээ хэрэгжүүлэх ажлыг хариуцна.

Зөвлөлийн шинжээчээр өндөр мэргэшлийн эрдэмтэн, мэргэжилтнийг орон тооны ба орон тооны бус журмаар томилон ажиллуулна. Тэдгээр нь үндэсний аюулгүй байдлыг хангах тодорхой асуудлаар болон Зөвлөлийн шийдвэрийн төслийн талаар шинжилгээ, судалгаа хийсний үндсэн дээр мэргэжлийн дүгнэлт гаргаж, түүний үндэслэлийг хариуцна.

Зөвлөл нь үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд онцгой ач холбогдол бүхий чиглэл, дотоодын болон олон улсын үйл явдал зэрэг шаардлагатай гэж үзсэн асуудлаар ажлын хэсэг байгуулах, судалгаа явуулах эрдэм шинжилгээний бие даасан нэгжтэй байж болохоор Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуульд заасан байна. Энэ хуулийн дагуу зөвлөл нь дараахь бүрэн эрхийг эдэлнэ. Үүнд:

- *“үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, холбогдох хуулийн биелэлтийн явцыг хэлэлцэж дүгнэлт гаргах;*

- *үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн дотоод, гадаад, батлан хамгаалах бодлогын үндсийг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон онц чухал асуудлыг шийдвэрлэх чиглэл өгөх;*

- *зөвлөлийн чиг үүрэгт хамаарах асуудлаар холбогдох байгууллагыг шалгах, танилцах, тэдгээрийн удирдагчдын илтгэл, мэдээллийг сонсох, зөвлөмж, заалт, чиглэл өгөх;*

- *үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлогыг хэрэгжүүлэх үүрэгтэй байгууллагад эрх хэмжээнийхээ дагуу үүрэг даалгавар өгөх, шаардлага тавих;*

- *даалгавар, зөвлөмж болон гэрээний үндсэн дээр холбогдох байгууллагаас шаардлагатай судалгаа, мэдээг гаргуулан авах, үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд онцгой ач холбогдол бүхий асуудлаар стратегийн судалгаа хийх ажлыг ивээл, хяналтдаа авах, эрдэм шинжилгээний төслийн хэлбэрээр санхүүжүүлэх”* зэрэг болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болсны улмаас онц байдал зарлах тухай шийдвэр буюу ерөнхийлөгчийн зарлиг хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн онц байдал үргэлжлэх хугацаанд Зөвлөл онц байдлыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах онцгой чиг үүрэг гүйцэтгэнэ.

Хэдийгээр зөвлөлийн шийдвэр нь зөвлөмжийн шинж чанартай байх боловч, уг шийдвэрийг төрийн дээд, төв байгууллагын шийдвэр байдлаар баталгаажуулж, шийдвэрийн хэрэгжилтийн талаар тогтоосон хугацаанд мэдээлж байхаар хуульчлан зааж өгсөн байна. Төрийн холбогдох байгууллагууд ҮАБЗ-ийг шаардагдах мэдээллээр

хангах бөгөөд мэдээллийн нэгдсэн санг дээрх хууль болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 155 дугаар зарлигаар батлагдсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын дотоод журмын дагуу байгуулан ажиллуулж байна.

*“Төрийн цэргийн бодлогын үндэс”* баримт бичигт зааснаар ҮАБЗ нь “...Төрийн цэргийн бодлогыг хэрэгжүүлэх явдлыг хууль тогтоомжоор зохицуулж, эдгээр хууль тогтоомжид төрийн цэргийн бодлого хэрхэн тусч байгаад хяналт тавих” [7. 7] үүрэгтэй байна.

Улсын Их Хурал нь Засгийн газар болон Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулж зэвсэгт хүчний үйл ажиллагааг хянах эрх мэдлээр хангагдсан бол Ерөнхийлөгч нь зэвсэгт хүчний ерөнхий командлагч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүний хувьд зэвсэгт хүчнийг байнгын удирдлагаар хангах, цэргийн мэргэжлийн удирдлагыг хэрэгжүүлэхэд шаардагдах эрх зүйн баримт бичгийг хянан боловсруулах, батлах, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, батлан хамгаалах асуудлаар Засгийн газартай зөвшилцөх, чиг үүрэг өгөх эрхийг эдэлдэг байна. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл нь үндэсний аюулгүй байдалтай холбоотой аливаа асуудлаар зөвлөлдөх гол байгууллага байхын зэрэгцээ зөвлөлийн ажлын алба нь хэрэгцээтэй мэдээлэл, зөвлөгөөгөөр төр, засгийн удирдлагыг хангах үүрэгтэй байгууллага юм. Ийнхүү Монгол Улсад батлан хамгаалах салбарын бодлого, үйл ажиллагаа болон зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтын эрх зүйн тогтолцоо амжилттай бүрдэж, сүүлийн арав гаруй жилийн хугацаанд эдгээр эрх зүйн үндсэн баримт бичгүүдийг хэрэгжүүлэх талаар иргэний болон цэргийн удирдлага бүтээлчээр хамтран ажиллаж ирсэн гэж дүгнэж болно. Монгол Улсын Их Хурал нь орчин үеийн парламентын хяналтыг зэвсэгт хүчинд хэрэгжүүлэх замаар батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, нөлөөлөх, Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтын механизмыг төлөвшүүлэхэд чухал үүрэгтэй нийгмийн институт гэсэн дүгнэлт гарч байна.

**Улсын Их Хурлын хяналтын тогтолцоо:** Монгол Улсын Зэвсэгт хүчинд иргэний хяналтыг ард түмэн өөрсдийн төлөөлөн сонгосон Ерөнхийлөгч, УИХ-аар дамжуулан хэрэгжүүлэх бөгөөд Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч, УИХ, Засгийн газраас хэрэгжүүлж буй иргэний хяналт нь харилцан уялдаатай, бие биесээ нөхсөн шинжтэй байдаг. УИХ нь Зэвсэгт хүчинд тавих гол тулгуур хяналтыг засаглалын өөр субъекттэй хуваалцахгүйгээр хэрэгжүүлж байгаа учраас Монгол Улсын Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтын хамгийн чухал салшгүй хэсэг нь парламентын хяналт гэж үзэж болно. *Удирдагч ба төлөөлөгч* гэсэн загварын үүднээс энэ харилцааг судлах нь нэлээд зохимжтой билээ. УИХ *удирдагчийн* хувьд Зэвсэгт хүчнийг хянах эрх мэдлээ Засгийн газар, түүний бүрэн эрхт гишүүн (*төлөөлөгч*)-ээр төлөөлүүлэн хэрэгжүүлж болдог. Байнгын хороо нь Улсын Их Хурлын баталсан хууль, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих, гүйцэтгэх засаглалын явуулж буй бодлого, үйл ажиллагаанд нөлөөлөх бүрэн эрх дархаар хангагддаг. Ингэхдээ УИХ нь Зэвсэгт хүчинд хэрэгжүүлэх иргэний хяналтыг Байнгын хороод, Засгийн газар, түүний батлан хамгаалах асуудал эрхэлсэн гишүүн /батлан хамгаалахын сайд/-ээр дамжуулан хэрэгжүүлж байна.

Улсын Их Хурал нь батлан хамгаалах салбарын эрх зүйн үндсийг бүрдүүлэх, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоход онцгой үүрэг гүйцэтгэж байна. 1990 оныг хүртэл “БНМАУ-ын бүх нийтийн цэргийн үүргийн тухай” (1981 он) хуулиас өөр батлан хамгаалах салбарын харилцааг зохицуулах хууль, эрх зүйн акт үндсэндээ байгаагүй юм. Ийм учраас Монгол Улсын Үндсэн хуулийн батлан хамгаалах салбартай холбоотой заалт, Аюулгүй байдлын үзэл баримтлал, цэргийн номлол, Батлан хамгаалах тухай хууль, Хилийн тухай хууль, Иргэний хамгаалалтын тухай хууль, Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг боловсруулах ажил 1990 оноос эхэлсэн билээ.

Ингээд Монгол Улсын Их хурал Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Иргэний цэргийн үүргийн болон Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг 1992 онд, Батлан хамгаалах тухай хууль, Хилийн тухай хуулийг 1993

онд, Иргэний хамгаалалтын тухай хууль, Цэргийн албан хаагчдын тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал, Цэргийн номлолын үндэс баримт бичгийг 1994 онд, Зэвсэгт хүчний тухай хуулийг 2002 онд тус тус батлан гаргаснаар манай салбарын эрх зүйн үндэс бүрдсэн гэж үзэж болох юм.

**Байнгын хороо:** УИХ-ын Байнгын хороо нь УИХ-ын ажлын зохион байгуулалтын нэг онцгой хэлбэр юм. Парламентын нийтлэг жишгийн дагуу УИХ-ын ажлын гол ачааллыг байнгын хороод үүрдэг бөгөөд Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтыг гол хэрэгжүүлэгч нь мөн байнгын хороод болдог. УИХ үйл ажиллагааныхаа салбар чиглэлээр 7 байнгын хороотой ажиллаж байна. Байнгын хороодын эрхлэх асуудлын хүрээнд батлан хамгаалах салбартай холбогдсон асуудал хэрхэн хамрагдаж байгаа байдлыг авч үзвэл,

1/ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо:

- *Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, түүнийг хангах бодлого;*
- *Монгол Улсын батлан хамгаалах, зэвсэгт хүчин;*
- *Төрийн нууцын хадгалалт, хамгаалалт;*
- *Монгол Улсын хил, түүний хамгаалалт;*

3/ Нийгмийн бодлогын байнгын хороо:

- *...цэргийн албан хаагчийн нийгмийн хамгаалалт;...*
- *...хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр хамгаалалт.*

4/ Төрийн байгуулалтын байнгын хороо:

- *... гүйцэтгэх дээд байгууллага, Ерөнхийлөгчийн байгуулалт;*
- *Монгол Улсын засаг захиргаа, ... түүний удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа ...;*
- *төрийн алба;*
- *... төрийн байгууллага....*

5/ Төсвийн байнгын хороо:

- *улсын төсөв, төсвийн орлого, зарлага;*
- *төсвийн нэгтгэл, гүйцэтгэл, хяналт;*

6/ Хууль зүйн байнгын хороо:

- *Монгол Улсын эрх зүйн бодлого;*

зэрэг асуудлын хүрээнд бүрэн эрхээ хэрэгжүүлэн ажиллаж байна. Эдгээр хороод нь УИХ-ын хувьд батлан хамгаалах асуудлыг тухайн үеийн “чуулганаар хэлэлцэх асуудлыг



*боловсруулах, урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гаргах, түүнчлэн эрхлэх асуудлынхаа хүрээнд Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлэх нийтлэг чиг үүрэгтэй” [3. 3]. Үүнийг Их хурлын тухай хуулийн 13 дугаар зүйлд дэлгэрэнгүй заасан байна. Байнгын хороод нь тус тусын эрхлэх асуудлын хүрээнд тодорхой бүрэн эрхтэй.*

Эдгээрийн дотроос УИХ-ын бүрэн эрхийн хүрээнд иргэний хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон заримыг тоймлон авч үзвэл хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтэд болон Улсын Их Хуралд ажлаа шууд тайлагнадаг байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлэх, Засгийн газар, түүний гишүүн, Улсын Их Хурлаас байгуулдаг бусад байгууллагын эрх баригчдын мэдээллийг сонсож хэлэлцэх, асуулт, асуулга тавьж, хариулт авах, тэднийг томилох, сонгох, огцруулах тухай санал дүгнэлт гаргах, *Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх асуудлаар болон хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийн талаар судалгаа, тайлан, мэдээ, дүгнэлт зэрэг баримт сэлтийг холбогдох байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авах, тэдний мэдээллийг сонсох, Улсын Их Хурлаас тавих хяналтыг хэрэгжүүлэх, хуулийн төслийн талаар дүгнэлт гаргахад туслалцаа авах зорилгоор мэргэжлийн байгууллага болон олон нийтээс санал авах, шинжээч, мэргэжилтнээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж ажиллуулах* зэрэг болно. Ийнхүү байнгын хороо нь Улсын Их Хурлын баталсан хууль, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих, гүйцэтгэх засаглалын явуулж буй бодлого, үйл ажиллагаанд нөлөөлөх бүрэн эрх дархаар хангагджээ.

Байнгын хорооны бүрэн эрхийн дагуу Батлан хамгаалахын сайд, ЗХЖШ-ын даргад асуулга тавих, тэдний илтгэл, мэдээллийг сонсох, батлан хамгаалах салбар, зэвсэгт хүчний талаар иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх зэрэг нь иргэний хяналтыг хэрэгжүүлэх үр дүнтэй арга хэлбэр болон тогтмолжиж байна. Тэрчлэн Батлан хамгаалахын сайдын илтгэлийг УИХ-ын нэгдсэн хуралдаан болон тодорхой асуудлаар ҮАБЗөвлөл дээр сонсож, үүрэг чиглэл өгөх хэлбэрийг өргөн ашиглаж байна.

Парламентын засаглалтай улсын хувьд, батлан

хамгаалах асуудал эрхэлсэн байнгын хороод нь Монгол Улсын Засгийн газраар дамжуулан Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтыг хэрэгжүүлэх явдал илүү зохимжтой байдлаар төлөвшиж байна гэж үзэж болох юм. Түүнчлэн Улсын Их Хурал нь Төрийн хянан шалгах хороо /хуучин нэрээр/-той хамтран шалгалт явуулах, тэдний явуулсан шалгалтын үр дүнтэй танилцах, түүний мөрөөр тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломжтой байдаг.

Төрийн хянан шалгах хороо /хуучин нэрээр/ нь улсын төвлөрсөн төсвийн орлогын бүрдүүлэлт, төсвийн хөрөнгийн хуваарилалт, зарцуулалтыг хянан шалгах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналт шалгалтыг хэрхэн хэрэгжүүлж байгааг хянан шалгах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэхийг шалгаж дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий төрийн байгууллага байсан юм. Төрийн хянан шалгах хорооны төсвийг Улсын Их Хурал баталж, түүний үйл ажиллагааг улсын төвлөрсөн төсвөөс санхүүжүүлэн Төрийн хяналт шалгалтын тухай хууль /одоо хүчингүй болсон/-ийн 6 дугаар зүйлийн 5 дугаар хэсэгт заасан ёсоор Төрийн хянан шалгах хороо жил бүр Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг, энэ утгаараа парламентын хяналтыг хэрэгжүүлэхэд тус дөхөм үзүүлдэг байсан аж.

Төрийн хяналт шалгалтын тухай хууль өөрчлөгдсөнөөр ТХШХ-г Үндэсний аудитын газар болгон өөрчилж, ажлын чиг үүрэг ч өргөссөн байна. Эдүгээ Төрийн хяналт шалгалтын тухай /2003/, Төрийн аудитын тухай /2003/ шинэ хуулиудаар энэ харилцааг зохицуулж байна.

Энэ хуулиудад зааснаар: “Төрийн хяналт шалгалт нь Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Төрийн аудитын байгууллага болон төрийн захиргааны байгууллагын хяналт шалгалт/цаашид “мэргэжлийн хяналт” гэх/, Үндсэн хуулийн цэц, шүүх, прокурорын хяналт, нутгийн өөрөө удирдах байгууллагаас энэ хуулийн дагуу хэрэгжүүлэх хяналт шалгалтаас бүрдэнэ” [19. 40] гэжээ. “Төрийн аудитын байгууллагын тогтолцоо нь төрийн аудитын төв, орон нутгийн байгууллагаас бүрдэнэ. Төрийн аудитын төв байгууллага нь Үндэсний аудитын газар, орон нутгийн байгууллага нь аймаг, нийслэлийн аудитын газар

байна” [20. 45]. Төрийн хяналт шалгалтын тухай хуульд зааснаар: Засгийн газар нь “Захиргааны хяналтын үр ашигтай тогтолцоо бий болгох арга хэмжээ авч, мэргэжлийн хяналтын байгууллагуудын харилцан ажиллагааг нийтлэг зорилгод чиглүүлэн зохицуулна” [19. 41], яам, агентлаг нь “Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг харьяа байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хянан шалгаж, шаардлагатай бол тэдгээрийн удирдлагын илтгэл, мэдээллийг сонсоно” [19. 41]. Мэргэжлийн хяналтын төв байгууллага нь: “хууль тогтоомж болон түүнийг үндэслэн төрийн эрх бүхий байгууллагаас нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон журмын биелэлтэд хяналт тавих” [19. 42] гэх мэтээр хооронд нь уялдуулж өгсөн нь мэргэжлийн хяналтаар дамжуулан иргэний хяналтыг хэрэгжүүлэхэд дөхөмтэй болж байна. Төрийн аудитын тухай хуульд: “тагнуулын байгууллага, зэвсэгт хүчин, цагдаагийн гүйцэтгэх албанд зориулсан төсвийн хөрөнгийн зарцуулалтад Монгол Улсын Ерөнхий аудитор болон Улсын Их Хурлаас итгэмжилсэн ажилтан аудит хийнэ” [20. 48], “Үндэсний аудитын газар болон Монгол Улсын Ерөнхий аудиторовын үйл ажиллагаанд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дарга, Улсын Их Хурлаас бусад байгууллага, албан тушаалтан хяналт тавих, үүрэг даалгавар өгөхийг хориглоно” [20. 45] гэж хөндлөнгийн хяналтын эрх хэмжээг үлэмж дээгүүрт тавьж өгчээ.

Аливаа хяналт, шалгалтыг явуулах нь их хэмжээний цаг хугацаа, хүн хүч шаардсан ажил бөгөөд Улсын Их Хурал нь одоогийн байдлаар хуулийн хэрэгжилтийн талаар бодитой шалгалт явуулахад бэрхшээлтэй байгаа тохиолдолд Төрийн хянан шалгах тухай хуульд заасны дагуу Төрийн хянан шалгах хороотой хамтран хяналт шалгалт явуулах, эсвэл тодорхой асуудлыг шалгуулахаар хүсэлт гаргадаг тогтолцоонд шилжих боломжтой, ингэх нь үр дүнд хүрэх нэг алхам байж болох юм.

**УИХ-ын гишүүд** нь парламентийн хяналт, түүний дотор Зэвсэгт хүчинд иргэний хяналтыг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Барууны орнуудтай харьцуулахад манай улсад батлан хамгаалах аж үйлдвэр хөгжөөгүй, цэргийн анги байгууллагад энгийн иргэдийг ажиллуулах нь харьцангуй бага

тул их хурлын гишүүдийн сонгуулийн тойрогтой батлан хамгаалах салбарын асуудал бараг холбогдолгүй байдаг. Иймд батлан хамгаалах салбар, зэвсэгт хүчинтэй холбоотой асуудлыг хэлэлцэхээсээ илүү тухайн гишүүний ажиллах 4 жилийн хугацаанд зайлшгүй шийдэх бусад олон асуудал тэдний сонгогдсон тойрогт байдаг. Эдгээр асуудлуудыг хэрхэн шийдвэрлэснээс тухайн гишүүний дараагийн сонгуулийн үр дүн ч мөн хамаардаг байна. Ийм нөхцөл байдлаас болоод Улсын их хурлын гишүүд батлан хамгаалах асуудлыг сонирхохгүй байх нь нэг талаар барууны парламентуудад элбэг тохиолдох “микро менежмент”-ийн асуудал үүсэхгүй байх ашигтай хэдий боловч улс орны аюулгүй байдлыг хангах асуудлыг цаг үеийн ашиг сонирхолд нийцүүлэх аргагүй учраас их хурлын гишүүдийг салбарын мэдээллээр хангах, ойлгуулах асуудал чухлаар тавигддаг юм.

Зэвсэгт хүчин, цэргийн албан хаагчдын эрх ашгийг хууль тогтоох байгууллагад төлөөлдөг албан тушаалтан, алба байхгүй учраас УИХ батлан хамгаалах салбарын талаар оновчтой бодлого явуулахад зарим талын бэрхшээл учруулдаг тал бий. Улсын Их Хуралд цэргийн төлөөллийг бий болгохын тулд цэргийн албан хаагчид парламентын сонгуульд өрсөлдөх, улмаар зохих үр дүнд хүрч болохыг 2000 оны сонгуулийн дүн харуулсан. Цэргийн алба хаасан, цэргийн байгууллагад ямар нэг хугацаагаар алба хашиж байсан зэрэг шалтгаан нь улс орны аюулгүй байдал, батлан хамгаалах асуудлаар мэргэжсэн төрийн болон төрийн бус байгууллага, судалгааны байгууллагаас илүү мэдээлэл, зөвлөмжөөр их хурлын эрхэм гишүүдийг хангах боломжгүй нь ойлгомжтой.

Цэргийн албан хаагчид парламентын сонгуульд өрсөлдөж, парламентад цэргийн төлөөллийг бий болгох, төрийн цэргийн бодлого, батлан хамгаалах, зэвсэгт хүчний асуудлыг сайтар ойлгон дэмждэг гишүүд олонхи байх нь улс орны батлан хамгаалах салбарын үйл ажиллагааг нэгдсэн бодлогоор хангах, төсөв хөрөнгийг оновчтой хуваарилах, зарцуулалтад хяналт тавихад дөхөмтэй байдаг.

Засгийн газар улс орныг батлан хамгаалах, зэвсэгт хүчнийг шинэчлэх, бэхжүүлэх талаарх үндсэн үүргийг

хүлээж, энэ эрх мэдлээ батлан хамгаалах яамаараа дамжуулан хэрэгжүүлдэг. Тэрчлэн Засгийн газрын хэрэг эрхлэх газрын Төрийн захиргааны төв байгууллагуудын хэлтэст батлан хамгаалах салбарыг хариуцсан референт ажиллаж тус салбартай холбогдолтой асуудлыг зохицуулан Засгийн газрын шийдвэрийн төслийг боловсруулах, мэдээ, судалгаа гаргах зэргээр бодлогын удирдлагаар хангаж байна.

Иргэний ардчилсан нийгэмд Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Батлан хамгаалах яам нь Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд чухал байр суурийг эзэлдэг байна. Энэ үйл ажиллагааны эрх зүйн үндсийг дээр авч үзсэн ба БХЯ нь Зэвсэгт хүчинд иргэний хяналтыг хэрэгжүүлэхдээ захиргааны удирдлагаар хангах, цэргийн боловсон хүчнийг сургаж бэлтгэх, цэргийн албан хаагчдын эрх ашиг сонирхлыг хамгаалах, батлан хамгаалах, цэргийн бодлогыг ард иргэдийн дотор сурталчилж, шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, “Батлан хамгаалахын Цагаан ном”-ыг эрхлэн гаргах, Зэвсэгт хүчний байлдааны болон дайчилгааны бэлэн байдал, сургалт бэлтгэл, зэвсэглэл-техник, материал хэрэгслийн хангалтын байдалд хяналт тавих, цэргийн үйл ажиллагааны бодит үр дүнд дүгнэлт хийх байдлаар ажиллаж байна.

Иргэний батлан хамгаалахын сайд нь Зэвсэгт хүчинд тавих парламентын хяналтыг гардан хэрэгжүүлэгч нь юм. Засгийн газрын тухай хуулиар Батлан хамгаалахын сайд нь улс орныг батлан хамгаалах бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалт, хэрэгжилт, улсын хяналт шалгалтын болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрхлэн зохион байгуулж байна.

Монгол Улсын Засгийн газраас анх 1996 онд энгийн батлан хамгаалахын сайдыг томилон ажиллуулсан бөгөөд 1996-2000 оны хугацаанд Эвслийн Засгийн газар гурван удаа огцорч батлан хамгаалахын сайд богино хугацаанд өөрчлөгдөж байсан нь салбарын үйл ажиллагаатай танилцаж, тогтвортой үйл ажиллагаа явуулах, иргэний хяналтыг тууштай хэрэгжүүлэх боломж олгохгүй муу талтай байлаа. Тэрчлэн энэ нь нэгдүгээрт, энгийн улс төрийн албан тушаалтнуудад батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаатай танилцах

боломж олгохгүй байх, хоёрдугаарт, цэргийнхэнд улс төрийн албан тушаалтнууд түр зуурын албан тушаалтнууд болж ойлгогдох, эцэст нь, ардчиллын үнэ цэнэ унах зэрэг сөрөг үр дагавартай байсан юм. Энгийн батлан хамгаалахын сайд нь иргэний хяналтыг төрийн захиргааны нэгжид хэрэгжүүлэгч мөн бөгөөд манай нөхцөлд түүний эрх, үүргийг хуулиар тодорхойлж, ажлын аппаратыг батлан хамгаалах асуудлаар мэргэжсэн төрийн захиргааны албан хаагчдаар бэхжүүлэх нь зүйтэй гэсэн дүгнэлтэд зүй ёсоор хүрч байна. Парламентын гишүүн - Батлан хамгаалахын сайдтай байх тухай ч яригдаж байсан бөгөөд энэ нь нэг талаас парламентын гишүүнийг батлан хамгаалах асуудлаар мэргэшүүлэх сайн талтай байхад нөгөөтэйгүүр парламентын гишүүн сайд нь батлан хамгаалах яам дээр ажиллах цаг хугацаа багатай учраас батлан хамгаалах салбарын өдөр тутмын үйл ажиллагаанд иргэний хяналтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад бэрхшээл учрах сул талтай юм.

Батлан хамгаалахын сайд нь Зэвсэгт хүчинд иргэний хяналт тавих талаар олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд батлан хамгаалах салбарын үйл ажиллагаанд хяналт тавих зорилго бүхий Батлан хамгаалахын захиргааны хяналтын албыг Батлан хамгаалах яамны харъяанд байгуулан ажиллуулсан нь иргэний хяналтыг хэрэгжүүлэх үүргээ биелүүлэхэд түлхэц болсон юм. Батлан хамгаалахын сайдын тушаалаар батлагдсан “Батлан хамгаалахын захиргааны хяналтын албаны түр дүрэм”-ээр Батлан хамгаалахын захиргааны хяналтын алба нь батлан хамгаалах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулж буй хууль, тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, Батлан хамгаалахын сайдын тушаал, эрх бүхий дээд байгууллагаас баталсан дүрэм, журмын хэрэгжилтэд батлан хамгаалах салбарын болон төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагын хэмжээнд хяналт тавих, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүний шалтгааныг тогтоох, хохирлыг арилгуулах замаар батлан хамгаалах зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий байгууллага болно. Тус алба нь хяналт шалгалтын ажлыг чиг үүргийнхээ хүрээнд өөрийн төлөвлөгөө, санаачилгаар, түүнчлэн эрх бүхий байгууллага, албан тушаалтны даалгавар, иргэдийн мэдээллийг үндэслэн явуулна гэж тодорхойлжээ. Энэ нь анх удаа батлан хамгаалах салбарын үйл ажиллагаанд иргэд

захиргааны хяналтын албаар дамжуулан хяналт, шалгалт хийх бололцоог олгосон билээ. Хяналт шалгалтын байгууллагуудын давхардал хааяагүй нилээд байсан, мэргэжлийн хяналтын чанар, үр нөлөөг дээшлүүлэх үүднээс төрийн бодлогын төвшинд уг асуудлыг судлан үзэж Монгол Улсад хяналт шалгалтыг нэгдсэн бодлогоор явуулах зорилго бүхий Улсын мэргэжлийн хяналтын газрыг байгуулан тэнд батлан хамгаалахын улсын хяналтын байцаагч ажиллах тогтолцоонд шилжсэнээр дээрх алба татан буугдсан юм.

Улсын Их Хурал нь батлан хамгаалах салбарын талаар хүлээсэн хууль тогтоох үүргээ амжилттай биелүүлж байгаа боловч хяналтын үүргээ биелүүлэх, хэрэгжүүлэх тогтолцоо бүрдээгүй гэж дүгнэж болно. Харин зэвсэгт хүчний үйл ажиллагааг удирдах, иргэний удирдлагаар хангах үүргийг ерөнхийлөгчийн институт сайтар биелүүлдгийг дараахь судалгаанаас харж болно.

Ерөнхийлөгч П.Очирбат “Монгол Улсын Төрийн цэргийн бодлого” баримт бичгийг санаачлан боловсруулж, батлан хамгаалах салбартай холбоотой эрх зүйн баримт бичгийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн батлуулсан байна. Түүнчлэн, батлан хамгаалах салбарын гадаад харилцааг хөрш хоёр улстай хөгжүүлэх, барууны өндөр хөгжилтэй улсуудтай батлан хамгаалах салбарт харилцаа тогтоож, цэргийн итгэлцлийг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн байна.

1997 оны 5 дугаар сарын 18-нд Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоёр дахь удаагийн сонгууль болж, парламент дахь суудал бүхий МАХН-аас нэр дэвшигдсэн Н.Багабанди тус улсын хоёр дахь Ерөнхийлөгчөөр сонгогдсон билээ. Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди 1997 оны сонгуулийн хөтөлбөртөө: “Зэвсэгт хүчин, бусад цэргийг мэргэжсэн чадварлаг болгон шинэчлэх чиг бодлогыг тууштай баримтлах, төрөөс зэвсэгт хүчин, бусад цэргийг удирдах тогтолцоог боловсронгуй болгож төлөвшүүлэхийн төлөө хүчин зүтгэх, батлан хамгаалах үйл ажиллагаа, цэргийн албаны болон цагдаа, хилчдийн бие бүрэлдэхүүний нийгэм, эрх зүйн баталгааг хангах” гэсэн гурван зорилтыг дэвшүүлсэн байна. Тэрээр 2001 оны ерөнхийлөгчийн сонгуулиар улиран

сонгогдсон нь энэхүү шилжилтийн үед Зэвсэгт хүчинд иргэний хяналтын тогтолцоог бэхжүүлэхэд эерэг нөлөө үзүүлсэн болно. *Нэгд*, батлан хамгаалах салбар, аюулгүй байдал, гадаад бодлогын талаар батлагдсан хуулиуд, үзэл баримтлал, цэргийн номлолын шинж чанартай эрх зүйн баримт бичгүүдийг хэрэгжүүлэх, батлан хамгаалах салбарын шинэчлэлийг гүнзгийрүүлэх “алтан үе” байсан билээ. Түүнчлэн энэ үед ерөнхийлөгч нь Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн үүрэг гүйцэтгэдэг цэргийн удирдлагын иргэнлэг хэлбэрийн тогтолцоо төлөвшиж эхэлсэн байна.

Ерөнхийлөгч Н.Багабанди 1997-2001 оны хугацаанд Зэвсэгт хүчний нэгдмэл шинжийг хадгалах талаар тууштай бодлого явуулж байсан нь тэрээр батлан хамгаалах бодлого, зэвсэгт хүчний асуудлаар нэлээд мэргэжсэнтэй холбоотой. Иймд түүний улиран сонгогдсоноор гүйцэтгэх засаглалын залгамж чанар сайжирч, батлан хамгаалах салбарын шинэ бүтэц, тогтолцоо төлөвшихөд чухал үүрэг гүйцэтгэсэн юм. *Хоёрт*, Монгол Улсын Ерөнхийлөгч нь үндэсний аюулгүй байдлын зөвлөлд тулгуурлан улс орны аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын асуудлыг тодорхойлох, эрх зүйн баримт бичгийг санаачлан боловсруулж, улс орны батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг цаг үеийн асуудал болон улс төрийн ашиг сонирхлоос ангид байлгах, цэргийн албан хаагчдын эрх ашгийг хамгаалах асуудлыг гардан хариуцдаг *практик* тогтолцоог буй болгосон байна. *Гуравт*, Зэвсэгт хүчинд иргэний ардчилсан хяналтыг хэрэгжүүлэгч - иргэний удирдлагад цэргийн мэргэжлийн зөвлөгөө шаардлагатай болохыг ухаарч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн шадар туслахтай байхын сацуу Ерөнхийлөгчийн цэргийн бодлогын зөвлөхийн албан тушаалыг 2000 онд баталж, цэргийн дээд албан тушаалын офицерыг уг албан тушаалд томилон ажиллуулж байна. Энэ нь *нэгдүгээрт*, Ерөнхийлөгч зэвсэгт хүчний асуудлаар цэргийн мэргэжлийн зөвлөгөө авах боломжтой болох, *хоёрдугаарт*, иргэний удирдлага нь батлан хамгаалах салбарын талаар оновчтой бодлого явуулах нөхцөл бололцоог нэмэгдүүлэх зэрэг чухал ач холбогдолтой болсон юм.

Ерөнхийлөгч нь хууль санаачлагч субъектын хувьд батлан хамгаалах салбарын эрх зүйн баримт бичгийг ажлын



хэсэг томилон боловсруулж, Улсын Их Хуралд танилцуулж байгаа нь парламентын гишүүдийн анхаарлыг уг асуудалд төвлөрүүлэх, батлан хамгаалах салбар, зэвсэгт хүчин, цэргийн албан хаагчдын эрх ашгийг парламентад хамгаалах боломжийг бүрдүүлж байна. Тухайлбал, Монгол Улсын Ерөнхийлөгч 1997-2001 оны хугацаанд 6 хуулийн төслийг мэргэжлийн хүмүүсийг багтаасан ажлын хэсэг байгуулан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн барьсан байна. Монгол Улсын Ерөнхийлөгч нь цэргийн номлол, зэвсэгт хүчний шинэчлэлийн хөтөлбөр гэх мэтийн олон асуудлаар ажлын хэсэг байгуулж, санал зөвлөмжийг сонсох, Батлан хамгаалахын сайд, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга нарын илтгэл, мэдээллийг сонсох, Зэвсэгт хүчний анги, байгууллагаар зочлох, үйл ажиллагаатай нь танилцах зэргээр батлан хамгаалах салбарын талаар өргөн мэдлэг, мэдээлэлтэй болох бодлого чиглэлийг баримтлан үр дүнд хүрч байна. Тухайн салбарын талаар өргөн мэдлэг, ойлголттой болсны үндсэн дээр бодлогын чанартай оновчтой шийдвэр гардаг. Бусад шилжилтийн үеийн орнуудын гүйцэтгэх засаглалын байгууллагуудтай харьцуулахад Монгол Улсын Ерөнхийлөгчийн институт нь Үндсэн хууль, бусад хуулиар сайтар тогтоогдсон эрх, үүрэгтэй, зэвсэгт хүчинтэй холбогдсон гол асуудлуудыг улс төрөөс ангид байдлаар зохицуулж, баталгаажуулах боломжтой байна. Тухайлбал, Монгол Улсын Ерөнхийлөгч нь “Монгол Улсын Зэвсэгт хүчнийг ашиглах номлол”, “Цэргийн байгуулалтыг 2005 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”, “Цэргийн цол олгох журам”, “Цэргийн анги, байгууллагыг аж ахуйн ажилд оролцуулах журам” зэргийг батлан мөрдүүлж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч нь засаглалын бусад институтуудтэй харьцуулахад Зэвсэгт хүчний үйл ажиллагаанд арай өргөн хүрээтэй хяналтыг тавьдаг. Тухайлбал, Ерөнхийлөгч 2000 онд батлан хамгаалах хууль, тогтоомжийн биелэлт, Батлан хамгаалах төсвийн санхүүжилт, зарцуулалт, Зэвсэгт хүчин, бусад цэрэг хуулиар тогтоосон чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгаа байдлыг илтгэж, мэдээлж байх хугацааг тогтоож өгсөн байна. Түүнчлэн Ерөнхийлөгчөөс баталсан журам, хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг тогтмол авч, шаардлагатай асуудлыг ҮАБЗ-ийн хуралдаанаар хэлэлцдэг байна. 1997 оны 8 дугаар

сараас 2001 оны 3 дугаар сар хүртэлх хугацаанд Ерөнхийлөгч Зэвсэгт хүчний 16 анги, Батлан хамгаалахын их сургууль, Хилийн цэргийн болон дотоодын цэргийн 12 анги, сумангийн үйл ажиллагаатай танилцаж, иргэний хамгаалалтын болон цэргийн хээрийн сургуулийн явцтай танилцах, Зэвсэгт хүчний удирдах ажилтны зөвлөлгөөнд оролцсон байна. Зөвхөн энэ тооноос харахад Ерөнхийлөгч нь Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч болсноор Зэвсэгт хүчний үйл ажиллагаанд иргэний хяналтыг хэрэгжүүлэх, Зэвсэгт хүчнийг улс төрөөс ангид байлган зэвсэгт хүчин, улмаар батлан хамгаалах салбарын эрх ашгийг хамгаалахад эерэг нөлөө үзүүлж байна.

Товчоор дүгнэн үзвэл, Монгол Улсад ардчилсан хэлбэрийн парламентын засаглал байгуулагдсанаас хойш 10 гаруй жилийн туршлага хуримтлуулсан бөгөөд энэ нь барууны орнуудын парламенттай харьцуулбал харьцангуй богино хугацаа юм. 1992 оноос хойш парламентын гурван удаагийн сонгууль болж өнгөрлөө. Батлан хамгаалах салбартай холбогдсон олон хууль, эрх зүйн баримт бичгийг батлан гаргалаа. Өөрөөр хэлбэл, манай улсын парламентаас Зэвсэгт хүчинд иргэний хяналтыг хэрэгжүүлэх эрх зүйн тогтолцоог бүрдүүлсэн юм.

Иргэний хяналтыг хэрэгжүүлэгч гол субъект болох өнгөрсөн зарим парламентуудын батлан хамгаалах салбарын чиглэлийн асуудлыг хэлэлцэж байгаа байдлыг ажиглахад УИХ-ын гишүүд аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын талаар төдийлөн ач холбогдол өгөхгүй байна уу? гэсэн сэтгэгдэл төрдөг байв. Учир нь батлан хамгаалах салбараас өргөн барьсан хуулийн төслүүдийг хэлэлцэхгүй удаашруулах, хойшлуулах, хоорондоо уялдаа холбоо муутай хууль батлагдан гарах тохиолдол ч гарч байсан юм.

Батлан хамгаалах салбартай холбогдсон олон чухал хууль, эрх зүйн баримт бичгийг батлан гаргадаг боловч эдгээр хууль, эрх зүйн актуудыг тууштай хэрэгжүүлэхийн оронд салбар, байгууллагын явцуу эрх ашгийн үүднээс хандан харилцан сөргөлдөх, хүчний гэгдэх зарим байгууллагууд салж нийлэх явдал ажиглагдсаар байна. Энэ нь хууль, тогтоол шийдвэр “цоорхой”-той байснаас

шалтгаалсан байхыг ч үгүйсгэх аргагүй.

Улсын Их Хурлын гишүүдийг Зэвсэгт хүчинд иргэний ардчилсан хяналтаа хэрэгжүүлэх, тэднийг улс төрийн удирдлагаар хангахад туслах зорилготой мэдээлэл, зөвлөгөө өгөх механизм бүрэн бүрдээгүй байна. Дээр өгүүлснийг судлаач Р.Болд олон жилийн өмнө гярхай ажиглаж, “салбар, мэргэжлийн эрх ашгийг хамгаалсан мэргэжлийн лоббистүүдэд түшиглэн хууль, төсөв баталдаг хандлага давамгайлсан одооны УИХ батлан хамгаалах хэрэгт улс төрийн бодлого болох талаас нь хандаж чадсангүй. Ийм ч учраас жижиг улсын зэвсэгт хүчнийг мэргэжлийн ялгаагаар нь улам жижиглэн бутаргасан хуулиуд гаргасаар байгаа нь УИХ цэргийн бодлогоос үлэмж хөндий байгаатай холбоотой. Энэ нөхцөлд батлан хамгаалахын холбогдолтой мэдээллээр гишүүдийг хангахад УИХ-ын судалгааны төвийн үүрэг асар их юм” гэжээ [18. 256]. Улсын Их Хурлын Судалгаа, лавламжийн алба нь Улсын Их Хурлын гишүүдийг шаардлагатай мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах, чуулганаар хэлэлцэх хууль, бусад шийдвэрийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдэд судалгаа гаргах, ном, хэвлэл, архивийн материалаар лавлагаа бэлтгэх үндсэн чиг үүрэгтэй болно. Судалгаа, лавламжийн алба нь судалгааны болон номын сан, архивын гэсэн хоёр хэсгээс бүрддэг. Судалгааны ажлын хэсэг нь:

- Улсын Их Хуралд өргөн барьсан хуулийн төслийг боловсронгуй болгох, батлагдсан хуулийг хэрэгжүүлэхэд шаардагдах судалгаа, шинжилгээ, санал боловсруулах,

- Парламент судлалын асуудлаар судалгаа хийж, түүний үр дүнгийн талаар мэдээлэл гаргах, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, гадаад орны парламентын ижил чиг үүргийн байгууллагатай мэдээлэл солилцох, хамтран судалгаа хийх, ажил хэргийн харилцаа тогтоох,

- Улсын Их Хурлын Тамгын газрын дотоод мэдээллийн сүлжээнд шаардлагатай мэдээллийг гадаад, дотоодын байгууллагаас авч түгээх,

- Судалгааны ажлын явц, үр дүнгийн талаарх мэдээлэл, лавлагаа, саналыг Улсын Их Хурлын гишүүн, бусад холбогдох албан тушаалтанд танилцуулж, тэдний зөвшөөрснөөр сурталчлах үүргийг гүйцэтгэдэг.

Судалгаа, лавламжийн алба нь нийт 15 албан хаагчтай бөгөөд 8 нь судалгааны хэсэгт ажилладаг. Судалгааны хэсгийн албан хаагчдын 75 хувь нь философич, социологичийн мэргэжилтэй, үлдсэн хувь нь хуульч, инженерийн мэргэжилтэй байна.

Улс орны аюулгүй байдал, батлан хамгаалах салбарт хамаарахгүй асуудал бараг үгүй учраас энэ хүрээний харилцааг зохицуулах хууль, тогтоол шийдвэрийг гаргахад өргөн хэмжээний мэдээлэл, судалгаа, тооцоо шаардагдах нь ойлгомжтой. Гэтэл шаардлагатай мэдээллийн хэмжээгээр аппарат, орон тоо нэмэх боломжгүй учраас бусад судалгаа шинжилгээний байгууллага, эрдэмтэн судлаачид, янз бүрийн салбарын мэргэжилтнүүд, иргэд олон түмний санал дүгнэлтийг хүлээн авах, нэгтгэн судалж үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах салбарын асуудлыг боловсруулахад харгалзан үзэх, оновчтой байдлаар тусгаж байх нь чухал юм. Энэ нь нөгөө талаар үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах, зэвсэгт хүчний холбогдолтой асуудлыг бусад байгууллага, иргэд олон нийт хэрхэн ойлгож, ямар мэдээлэлтэй байгаад судалгаа, дүгнэлт хийх, өөрөөр хэлбэл, иргэний хяналтыг хэрэгжүүлэх, төр засаг, ард иргэдийн холбоог бэхжүүлэх нэг гол гүүр болох юм.

Хуулийг УИХ өөрөө санаачлан боловсруулах бус харин ихэнх тохиолдолд өргөн барьсан хуулийг хэлэлцэн баталж байгаа нь нэг талаар тухайн салбарын асуудлыг хууль, шийдвэрийн төсөлд гүнзгий тусгадаг сайн талтай боловч зохицуулах харилцааг тал бүрээс нь өргөн хүрээтэй авч үзэх талаар учир дутагдалтай байна. Ийм учраас УИХ-ын бүтцэд батлан хамгаалах салбарын холбогдолтой хууль амьдралд хэрэгжиж байгааг хянах, бодлогын залгамж чанарыг хадгалах, улс орны нийтлэг бус тухайн яам, агентлагийн эрх ашгийг хамгаалсан хууль гаргахаас сэргийлэх, бүх салбарын бодлого, үйл ажиллагаатай уялдуулах ажлыг хариуцсан нэгж, албан тушаалтны орон тоо, эсвэл тийм тогтолцоо нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай юм. Энэ нь хэдийгээр төсөв хөрөнгийн боломжоос шалтгаалах боловч бодлого, үйл ажиллагаа зөв бол хэтдээ үр дүнг тооцож, эцсийн дүндээ хөрөнгө хэмнэх боломжтой юм.

Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтыг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоо чухал агаад тэдгээр нь ардчилсан сонгуулийн үр дүнд сонгогдсон төрийн эрх барих дээд байгууллага-УИХ, нутгийн өөрөө удирдах ёсны бүх шатны байгууллагууд болон итгэмжлэгдсэн төлөөллөөрөө дамжуулах, “Батлан хамгаалахын Цагаан ном”, хэвлэл мэдээллийн хэрэгслийн үнэн бат мэдээллийг судалж, зэвсэгт хүчний бүх шатны үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, төрийн бус олон нийтийн байгууллагуудын шугамаар хамтран ажиллах, батлан хамгаалах болон цэргийн зардлын төсвийг хэмнэхэд холбогдох байгууллагуудыг татан оролцуулах зэрэг арга механизмыг ашиглаж болох юм.

Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналт нь түр зуурын арга хэмжээ, төлөвлөгөөт шалгалт, хяналтын ажил огт биш, иргэний ардчилсан нийгмийн тогтолцоо, төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх субъектүүдийн үйл ажиллагааны төлөвшил, эрх зүйн зохицуулалтаас гадна төрийн бүх шатны албан тушаалтнуудын мэдлэг чадвар, сахилга хариуцлага, иргэд, байгууллагуудын улс төрийн соёл, нийгмийн ухамсар, санаа бодлоос шалтгаалах байнгын цогц үйл ажиллагаа юм.

Бүх ард түмнээс сонгогдсон Ерөнхийлөгч, ардчилсан сонгуулийн үр дүнд бий болсон Парламент, түүний байгуулсан Засгийн газар, гүйцэтгэх засаглалын төв, нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаатай холбогдсон субъектив иргэний хяналтын тогтолцоо төлөвшиж, үйлдвэрлэгч-бүтээгч-татвар төлөгчдийн хуулийн дагуу шударга хөдөлмөр, татвар төлөлтийн үр дүнд бий болсон төсвийн хөрөнгийн хангамж хүрэлцээтэй, түүний хуваарилалт, зарцуулалт оновчтой болж, цэрэг арми мэргэжлийн ур чадвар, бэлэн байдлаа дээшлүүлэхийн төлөө тууштай ажиллаж баймааж нь Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналт баталгаажиж “цомхон, чадварлаг, мэргэжлийн зэвсэгт хүчин”-тэй болох билээ. Ийм Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтын баталгаа нь улс орныхоо аюулгүй байдлыг ямар ч нөхцөлд хамгаалахад бэлэн байх, мэргэжлийн өндөр чадавхи бүхий Зэвсэгт хүчин юм. Өөрөөр хэлбэл иргэний хяналт нь бүхэлдээ ийм Зэвсэгт хүчинтэй байхад л чиглэгддэг бөгөөд энэ нь дээрх субъектүүдийн цогц үйл ажиллагааны үр дүнд хангагдах учиртай.

Монгол Улсын шинэ Үндсэн хуульд: “Эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно” гэж тунхаглан хөгжлийн шинэ хандлагыг тодорхойлсон юм.

Иргэний ардчилсан нийгмийн тогтолцооны үед Зэвсэгт хүчин нь улс төрийн үйл ажиллагааны гадна байж, улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах үүргээ амжилттай биелүүлэхэд бэлэн байхын тулд мэргэжлийн ур чадвараа байнга нэмэгдүүлж байх шаардлагатай билээ.

Тоталитор нийгмийн тогтолцооны Зэвсэгт хүчин нь төржсөн нэг намын хараа хяналтад байдаг бол иргэний ардчилсан нийгмийн тогтолцооны үед түүнийг төрөөс удирдаж, үйл ажиллагаа нь иргэний хяналтад байх зарчимд тулгуурладаг дэлхий нийтийн жишиг байна. Судлаач, доктор, профессор Д.Мягмар “Ардчилсан нийгэмд иргэний хяналт гэдгийг юуны өмнө Зэвсэгт хүчний байгуулалтыг хэрэгжүүлэхдээ тулгуур болгох үндсэн зарчмуудын нэг гэж ойлгодог. Гэтэл зарим хүн захиргааны, зарим тохиолдолд улс төрийн хяналтын хэлбэр гэж ойлгоод байх шиг. ...Үнэн чанартаа иргэний хяналт гээд байгаа зүйл маань ардчилсан, эрх зүйт төрийн нөхцөлд цэрэг, иргэний харилцааг хууль, тогтоомжоор зохицуулах тухай л асуудал байдаг” [21. 52] гэжээ. Ийм учраас энэхүү өгүүлэлд иргэний хяналтын субъектүүдийг Монгол Улсын холбогдох хуулиудын хүрээнд авч үзсэн бөгөөд тоталитор нийгмийн тогтолцооноос ангижраад удаагүй манай орны тухайд иргэний ардчилсан хяналтыг бүрэлдүүлэхэд шинэ шинэ зорилт тулгарч байгаа билээ.

Энэ зорилтын хүрээнд иргэний хяналтыг хэрэгжүүлэх зарим асуудлыг практик талаас нь авч үзвэл:

1. Төвлөрсөн болон төвлөрсөн бус хяналтыг зөв хослуулах явдал юм. Өөрөөр хэлбэл, хууль тогтоох болон гүйцэтгэх дээд байгууллагын зүгээс хийх хяналтыг тодорхой зорилт, үүрэг бүхий анхан шатны болон шүүхийн байгууллагын хяналттай зөв хослуулбал эдгээр нь бие биедээ туслах, нөхөн гүйцээх замаар цэрэг, армийн амьдрал, үйл ажиллагааны алдаа дутагдлыг илрүүлэн засах,

арилгахад үр дүнтэй болох талтай.

2. Цэргийн удирдлагын зүгээс улс төрийн бодлогод хэт хутгалдаж, улмаар цэргийн байгууллагууд төр, засгийн зарлиг, хууль, тогтоомж, удирдамжийг шуурхай хэрэгжүүлэхгүй байх тийм нөхцөл байдалд орохоос нийгэм, олон түмэн байнга урьдчилан сэргийлэх нь иргэний хяналт хэрэгжих нэг чухал шижим болно. Энэ хүрээнд зэвсэгт хүчний өмнө хэд хэдэн шаардлага тавигддаг. Үүнд:

а/ Зэвсэгт хүчин нь Үндсэн хуулиар тогтоогдсон төрийн байгуулалтыг шууд бөгөөд тууштай хамгаалах;

б/ Зэвсэгт хүчний үйл ажиллагаа нийгмийн өмнө нээлттэй, ил тод байж, түүний талаар иргэд, олон түмэн өргөн мэдээлэлтэй байх;

в/ Өөрийг нь ханган барьж байдаг иргэд /шууд бус утгаар/, нийгмийн зүгээс зэвсэгт хүчний талаар хийсэн үнэн зөв, шударга шүүмжлэлийг мэдрэн хүлээж авдаг, түүнээс суралцдаг байх;

г/ Аль нэг нам, хөдөлгөөний зүгээс зэвсэгт хүчнийг улс төрийн тэмцэлд татан оруулах, ялангуяа түүний удирдлагыг хагалан бутаргах аливаа оролдлогын эсрэг цэргийн дээд удирдлагаас эхлээд анги, салбарын захирагч, дарга нар тууштай зогсох чадвартай байх;

д/ Цэргийн албан хаагчдын зүгээс иргэний хяналтад үл итгэх байдлаар бус цэрэг, иргэдийн үр ашигтай хамтран ажиллах зайлшгүй нөхцөл гэж ойлгож хүлээн зөвшөөрч байх зэрэг болно.

3. Амьдрал практикаас үзэхэд Зэвсэгт хүчнийг хэн удирдаж байна вэ?, бүр тодруулбал БХЯ-ыг хэн толгойлж байна вэ? иргэний хүн үү? цэргийн хүн үү? гэдгээс иргэний хяналтын үр өгөөж ихээхэн хамаардаг байна.

Иргэний хяналтыг хэрэгжүүлэхэд Батлан хамгаалахын сайд энгийн хүн байх нь бараг зайлшгүй хүчин зүйл юм байна. Иймд Батлан хамгаалахын сайдаар жинхэнэ улс төрч, томоохон улс төрийн зүтгэлтнийг ажиллуулж байх нь зарчмын ач холбогдолтой. Манай өнгөрсөн жилүүдийн сургамж, нөхцөл үүнийг харуулж байгаа бөгөөд өөрийн орны өвөрмөц онцлогийг цаашид улам сайн харгалзах шаардлагатай байна.

БХЯ иргэний удирдлагатай байхын гол давуу тал нь Зэвсэгт хүчний байгуулалтад ардчилсан эхлэлүүдийг тусган хэрэгжүүлэх, нэн ялангуяа цэргийн албан хаагчдын нийгэм, оюун санааны амьдрал, тэдний хоорондын харилцаа, цэргийн мөрдөлтэй хүмүүсийн эрх, эрх чөлөөг хангахад ихээхэн тус дөхөм үзүүлдэгт оршиж байна.

Тэрчлэн арми, нийгэм олон түмний холбоог бэхжүүлэх, зэвсэгт хүчний хаалттай байдлыг нээхэд чухал үүрэгтэй байна.

4. Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналт нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалын бүх салаа мөчрөөр, тэрчлэн төрийн бус олон нийтийн байгууллагуудын оролцоотойгоор хэрэгжих учиртай. Энэ чиглэлээр өмнө зарим зүйлийг авч үзсэн болно. Харин олон нийтийн байгууллагуудын тухайд хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүд, оюутнуудын болон ҮЭ-ийн байгууллагуудын үйл ажиллагааг иргэдийн цэрэг, эх оронч хүмүүжлийг төлөвшүүлэх, ялангуяа залуучуудыг ардчиллын үнэт зүйлст сургах, хүмүүжүүлэхэд чиглүүлэх механизмыг бүрдүүлэх шаардлагатай юм.

5. Цэргийн албыг иргэншүүлэх, хүмүүнлэгжүүлэхэд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл онцгой үүрэгтэй. Нэн ялангуяа иргэний хяналтыг үр дүнтэй болгоход бие даасан сэтгүүлчид асар их үүрэг рольтой ажээ [14 .313]. Олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд нь төр, засгийн байгууллагууд албан ёсоор хүлээж авахуйц бодитой мэдээллийг олны хүртээл болгоход онцгой анхаардаг байна. Тухайлбал, ХБНГУ-ын Бундестагийн батлан хамгаалахын бүрэн эрхт нь хэвлэл, радио, телевизийн нийтлэлийн мөрөөр идэвхтэй ажиллаж, маш хүчтэй шүүмжлэл, хэлэлцүүлгийг өрнүүлдэг нь үр дүнтэй байна.

Энэ арга замыг сөрөг хүчний нам, хүчнүүд болон олон нийтийн байгууллага, хөдөлгөөнүүд ч өргөн ашигладаг аж.

Гэхдээ Зэвсэгт хүчний бүх үйл ажиллагааг олон нийтийн өмнө ил тодоор дэлгэн тавих, эсэх тухай асуудал нь ардчилал хөгжсөн улс орнуудад ч гэсэн маргаантай асуудлын нэг байдаг байна. Ер нь Зэвсэгт хүчин нээлттэй байх, нууцыг хадгалах эрмэлзэл хоёрын хоорондын зөрчил



зарчмын хувьд хэзээ ч шийдэгддэггүй байна. Хэдий тийм боловч бундесверийн удирдлагын зүгээс нээлттэй байдлыг аль болохоор нэмэгдүүлэх чиглэл хандлагыг тууштай барьж байна [14. 314].

Манай орны тухайд энэ асуудлыг судлан боловсруулах, иргэд, нийгмийн зүгээс хэвлэл, мэдээллийн хэрэгсэлтэй ажиллах, түүнийг ашиглах соёл, сэтгүүлч, сурвалжлагч, хэвлэн нийтлэгч нарын мэдлэг чадварыг дээшлүүлэхэд ёс зүйн хэм хэмжээг тогтоон мөрдүүлэх шаардлагатай байна.

6. Иргэний хяналтыг хэрэгжүүлэх, тэр нь дээд зэргийн үр өгөөжтэй байхын тулд дараахь үндсэн шаардлагуудыг авч үзэх нь зүйтэй юм. Үүнд:

а/ Цэргийн удирдлагын бүх байгууллагуудад энэ хяналтыг иж бүрнээр зохион байгуулах;

б/ Цэргийн байгууллагуудын үйл ажиллагаанд иргэний хяналтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн эрх зүйн бичиг баримтуудыг нэн яаралтай батлуулан гаргаж мөрдүүлэх;

в/ Мөрдөж байгаа хууль, тогтоомжуудад нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр нь оруулж байх;

г/ Цэргийн байгууллагад хэрэгжүүлэх иргэний хяналтын тогтолцоог бүрдүүлж, бүтэц зохион байгуулалтыг уян хатан зохицуулах зэрэг болно.

7. Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналт нь цэргийн шинэчлэлийн бодлоготой нягт уялдаатайгаар түүний нэг бүрэлдэхүүн хэсэг болон хэрэгжих ёстой. Өөрөөр хэлбэл, өнөөгийн нөхцөлд цэргийн шинэчлэлийг амьдралд хэрэгжүүлэхэд Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналт юу юунаас чухал үүрэг нөлөөтэй гэж үзэх үндэстэй юм.

## **АШИГЛАСАН НОМ, БҮТЭЭЛ, СУРВАЛЖ, СУДАЛГААНЫ МАТЕРИАЛ**

1. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1998.
2. Монгол Улсын Батлан хамгаалах тухай хууль. Батлан хамгаалах салбарын хууль тогтоомжийн эмхтгэл. УБ., 1995. х 60-71.
3. Монгол Улсын Их Хурлын тухай хууль. УБ., АЭ. 1992. №67
4. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль. УБ., АЭ. 1993. №90.
5. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль. УБ., АЭ. 1993. №78.
6. Монгол Улсын Зэвсэгт хүчний тухай хууль. УБ., Соёмбо. 2002. №24, 25.
7. Монгол Улсын төрийн цэргийн бодлогын үндэс
8. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хууль. Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл. УБ.,2002. 11,5 хх.
9. Монгол Улсын Зэвсэгт хүчний эрх зүйн үндэс. УБ., 1998. 40х.
10. Иргэний нийгмийн онол, практикийн зарим асуудал. /Шинэ үндсэн хууль,Иргэний нийгэм/ Монгол Улсын Шинжлэх ухааны академи.Түүхийн хүрээлэн. УБ., 1997.
- 11.Гомбосүрэн Д. Монгол Улсын Зэвсэгт хүчний байгуулалтын түүх. УБ., 1998.
12. Цэрэг-иргэний харилцаа, иргэний хяналтын тулгамдсан асуудал. /эмхэтгэл/ БХЭШХ. УБ., 2001.
13. Зэвсэгт хүчний байгуулалтын зарим асуудал. ЗХЕШ. УБ., 2001.
14. Золотарев В.А. Военная безопасность государства российского. М., Кучково поле. 2001. стр.309-316.
15. Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналт, хэрэгжүүлэх арга зам. БХИС. БХЭШХ. Тайлан. УБ., 2002.
16. Цэрэг, иргэний харилцааны онол, практикийн тулгамдсан асуудал /эмхтгэл/. УБ., 2002.
17. Батлан хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль.УБ.,2002.№24,25.
18. Болд.Р. Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналт. Монголын аюулгүй байдлын орчин, батлан хамгаалах бодлогын зарим асуудалд. УБ., 1996.х 256.

19. Төрийн хяналт шалгалтын тухай. Монгол Улсын хууль. Төрийн мэдээлэл. УБ.,2003. №2. 40-44 х.
20. Төрийн аудитын тухай. Монгол Улсын хууль. Төрийн мэдээлэл. УБ., 2003.№2. 45-50 х.
21. Д.Мягмар. Батлан хамгаалах салбар, зэвсэгт хүчний шинэчлэлийн тухай бодол эргэцүүлэл. Монгол Улсын Батлан хамгаалахын их сургууль. УБ., 2002. 156 х.

ТАВДУГААР БҮЛЭГ.  
**МОНГОЛ УЛС, ИРГЭДИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН  
ОРЧИН**

*Ph.D А.Түвшинтөгс*  
*/ССХ-ийн дэд захирал/*  
*Ph.D З.Болдбаатар*  
*/БХЭШХ-ийн Батлан хамгаалах  
бодлого судлалын төвийн дарга/*

**Нэг. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал**

Монгол Улс ардчиллын замд эргэлт буцалтгүй зогсч эдийн засаг, улс төрийн шинэчлэлийг тууштай явуулах болсноор хувь хүний аюулгүй байдлыг улс орны аюулгүй байдлын анхдагч бүрдэл хэсэг гэж үзэх, хувь хүн ба нийгэм, төрийн аюулгүй байдал, тэрчлэн нийгмийн ба төрийн аюулгүй байдлын агуулга, харьцааны асуудлаар ардчилсан орнуудын туршлагыг судлах, уламжлал шинэчлэлийг хослуулан шинжлэх ухааны үндэстэй асуудлыг боловсруулах шаардлагатай болж энэ чиглэлээр ихээхэн ажил өрнүүлж байна.

Монгол Улсын Үндсэн Хууль (1992), Үндэсний аюулгүй байдлын болон Гадаад бодлогын үзэл баримтлал [1.] (1994), тэрчлэн “Төрийн цэргийн бодлогын үндэс” (1998) зэрэг нь шинэ нөхцөлд аюулгүй байдлын салбарт төрөөс нэлээд удаан хугацаанд тогтвортой баримтлах бодлого, чиглэлийг анх удаа боловсруулж, ардчилсан ёс, хууль тогтоомжийн актын хэлбэрээр тодорхойлж өгсөн баримт бичгүүдтэй болсон юм.

Үндэсний аюулгүй байдал нь:

1. Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдал;
2. Нийгэм-төрийн байгууллын аюулгүй байдал;
3. Иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал;
4. Эдийн засгийн аюулгүй байдал;
5. Шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал;
6. Мэдээллийн аюулгүй байдал;
7. Монгол соёл иргэншлийн аюулгүй байдал;
8. Хүн ам, удмын сангийн аюулгүй байдал;

9. Экологийн аюулгүй байдал гэсэн хэсгүүдээс бүрддэг.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (ҮАБҮБ) нь: нийтлэг үндэслэл, үндэсний аюулгүй байдлын бүтэц; үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлүүд; үндэсний аюулгүй байдлыг хангах арга зам, баталгаа; үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо; үндэсний аюулгүй байдлын мэдээллийн сан; Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдал; нийгэм төрийн байгууллын аюулгүй байдал; иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал; эдийн засгийн аюулгүй байдал; шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал; мэдээллийн аюулгүй байдал; монгол соёл иргэншлийн аюулгүй байдал; хүн ам, удмын сангийн аюулгүй байдал; экологийн аюулгүй байдал гэсэн хэсэг, бүлгүүд, бусад заалттай болно. Юуны өмнө уг үзэл баримтлал нь монголын олон зууны түүхэнд анх удаа бие даан, хамтын оролцоотой боловсруулж, ардчилсан ёсоор хууль эрх зүйн актын төвшинд баталгаажуулсан баримт бичиг болохыг тэмдэглүүштэй. Иймд түүнийг нийгмийн зөвшил гэх үндэстэй.

Товчоор хэлбэл уг үзэл баримтлалыг монгол дахь аюулгүй байдлын ойлголт ухааралд гарсан шинэ ололт төдийгүй дотооддоо харьцангуй тогтвортой байх, олон улсын тавцанд үндэсний язгуур ашиг сонирхлыг чухалчилсан, бие даасан, нээлттэй гадаад бодлогыг хэрэгжүүлж аюулгүй байдлаа улс төр, дипломатын аргаар хангах анхны бололцоо олгосон улс төрийн баримт бичиг гэж үнэлж байгаа юм [2.7].

Үзэл баримтлалын онцлог зүйлд дор дурдсаныг хамааруулж болох юм:

- **“Монгол Улсын үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ”** гэж тодорхойлсон бөгөөд түүний бүрдэл хэсгүүдийг нь “хувь хүн, нийгэм, төрийн” болон “язгуур ашиг сонирхол”, “аюул занал хамгаалалт” гэсэн гурвал загвараар авч үзэн, аюулгүйн гадаад, дотоод орчин, хангах арга зам, тогтолцооны асуудлыг нийтлэг үзэл санаа, өөрийн орны онцлогийг харгалзан томъёолсон;

- Монгол Улсын эрхэмлэдэг хамгийн үнэт зүйлийг “ардчилал”, “монгол хүн, түүний амьдрах баталгаатай аюулгүй орчин” гэсэн агуулгаар тодорхойлсон, үүнтэй уялдан улс үндэстэн оршин тогтнох гадаад, дотоод таатай нөхцлийг бий болгох, бэхжүүлэх зорилт нь эн тэргүүнд тавигдсан;

- цэргийн аюулгүй байдлыг үзэл баримтлалын “бүлэг, үндсэн бүрдлийн” төвшинд авч үзээгүй боловч Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдлыг түүнд хамгийн түрүүнд хөндсөн;

- хөршүүдийн хувьд улс төрийн ялгавартай хандах сэтгэлгээг халж тэдэнтэй харилцахдаа тэнцвэртэй харилцах зарчим (адил зай барих, бүх асуудлаар адил байр суурьтай байх бус, хоёулантай нь итгэлцлийг бэхжүүлэх, сайн хөршийн найрсаг харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх) баримтлах, хоёр хөршийн маргаанд төвийг сахих, монголын хэрэгт тэдний зонхилон нөлөөлөх явдалд сөрөг “жин” тэнцвэр бий болгох;

- улс төр, дипломатын аргаар аюулгүй байдлаа хангах эрх ашгийн үүднээс эвсэлд үл нэгдэх, хязгаарлагдмал төвийг сахих, өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчинтэй байх, тэрчлэн үндэсний аюулгүй байдлын баталгааг “монголын ард түмэн, монголын төр, олон улсын нийгэмлэг” гэсэн утгаар тодорхойлсон зэргийг хамааруулж болох юм [3.2]. Манай ҮАБҮБ-ыг бид ерөнхийдөө барууны буюу дэлхийн олон улсын нийгэмлэгийн аюулгүйн онол, улс төрийн либерал үзэл санаа, үндэсний аюулгүй байдлын болон жижиг орны аюулгүй байдлын тухай ерөнхий онол, орчин үеийн үзэл баримтлалын хандлага, монголын түүхэн уламжлал, өнөөгийн онцлогийг харгалзсан шинжлэх ухааны үндэстэй гэж үздэг. Гэхдээ энэ нь сонгомол, хэзээд ч өөрчлөгдөшгүй хувилбар гэсэн үг биш бөгөөд үүнийг ч үзэл баримтлалын нэг давуу тал гэж хэлж болно.

Үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын үзэл бодлын үндэс нь эх оронч, үндэсний үзэл байна.

Монгол Улсын үндэсний ашиг сонирхолд монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдал, эдийн засгийн харьцангуй бие даасан байдал, экологийн

тэнцвэрт хөгжил, үндэсний эв нэгдэл багтана. Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхол нь төр, ард түмний онцгой анхаарал хамгаалалтад байна.

Үндэсний аюулгүй байдлыг хангах гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хамгаалан бэхжүүлэх тал бүрийн баталгаа буй болгоход чиглэсэн төрийн бодлого, төр, түүний байгууллага, албан тушаалтнаас авч буй, иргэдээс хэрэгжүүлж буй арга хэмжээг хэлнэ.

ҮАБҮБ-ыг боловсруулж бэлтгэхэд ямар субъект оролцох талаар хууль тогтоомжид заасан тодорхой заалт байхгүй боловч ерөнхийлөгчийн захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг гүйцэтгэдэг. Ажлын хэсэг нь нэлээн өргөн төлөөлөлтэй бөгөөд түүний бүрэлдэхүүнд ерөнхийлөгчийн зөвлөх, УИХ, Засгийн газрын төлөөлөл, батлан хамгаалах, улсын аюулгүй байдлыг хангах газар зэрэг хүчний байгууллага, Монгол Улсын ШУА-ийн удирдлагын албан тушаалтнууд багтдаг юм.

ҮАБҮБ-ыг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хуралдаанаараа хэлэлцэн сайшаасны дараа УИХ-ын чуулганы хуралдаанаар хэлэлцэж тогтоол гарган батламжилдаг. Одоо мөрдөж буй Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг УИХ-ын 1994 оны 56 дугаар тогтоолоор баталсан юм.

Үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлийг эх сурвалжаар нь дотоод, гадаад, цаг хугацааны хувьд гэнэтийн, тодорхой хугацааны, түүхэн нэг үеийн, мөнхийн гэж ангилах ба Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхол нь мөнхийн ангиллын ашиг сонирхол мөн.

Үндэсний аюулгүй байдалд сөрөг нөлөөлж болох хүчин зүйлийг шинж чанарын үүднээс объектив, субъектив, учруулах аюулын магадлалаар нь бодит болон болзошгүй гэж ангилна. Үндэсний аюулгүй байдлыг хангах, бэхжүүлэх бодлого нь аливаа аюулыг “болзошгүй” үед нь тодруулан тогтоож арилгах, субъектив аюулыг цаг тухайд нь арилгах замаар объектив аюулыг багасгах, урьдчилан сэргийлэхэд чиглэдэг.

ҮАБҮБ-д үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх гадаад хүчин зүйлийн талаар “Монгол Улсын үндэсний аюулгүй байдал нь олон улсын аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг мөн бөгөөд түүнээс шууд хамаарна. Улс төрийн орон зайн хувьд аюулгүй байдлыг дэлхийн, бүс нутгийн, салбар бүс нутгийн гэж ангилна” хэмээн тодорхойлсон.

Үзэл баримтлалд үндэсний аюулгүй байдлыг хангах арга зам, баталгааны талаар тодорхой заасан байдаг. Үндэсний аюулгүй байдлыг хангах үндсэн арга хэрэгсэл нь баттай мэдээлэл, нарийн судалгаа, тооцооны үндсэн дээр үйл явдлын өрнөлт, хөгжлийг урьдаас харж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах явдал гэж тодорхойлсон.

Үндэсний аюулгүй байдлын үндсэн баталгаа нь монголын ард түмэн өөрөө, Монгол Улсын төр байх ба олон улсын баталгаа нь улс төр, хууль зүй, ёс суртахуун-сэтгэл зүйн баталгаанаас бүрдэнэ. Олон улсын баталгааг дангаар, хоёр болон олон талын арга хэмжээг хослуулан авах замаар буй болгож бэхжүүлэхийг заасан. Ингэхдээ цэрэг-улс төрийн аюулгүй байдлын баталгааг хамтын хүчээр аюулгүй байдлыг хангах тогтолцоо бүрдүүлэх, оролцох замаар хангана.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгагдсан үндсэн бүтэц, тэдгээрийн агуулгад дэлхий дахины, бүс нутгийн болон улс орны байдал, хөгжил, өрнөлтийн чиг хандлагад гарч байгаа өөрчлөлттэй уялдаж Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн санал болгосноор Улсын Их Хурал зохих нэмэлт, өөрчлөлт оруулж байна.

Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль, тогтоомжид үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг хэрэгжүүлэхтэй холбогдсон нэлээд заалт бий (Эдгээрийг нэгдүгээр хавсралтанд тусгав)

#### **Хоёр. Аюулгүй байдлын гадаад орчин**

Манай улсын аюулгүй байдлын орчин нь дэлхийн болон бүс нутгийн улс төр, эдийн засаг, нийгэм, цэргийн үйл явцаас гадна хоёр хөрш болох ОХУ, БНХАУ-ын гадаад



бодлого, тэдгээрийн дотоодын нийгэм, улс төрийн амьдрал, хоорондын харилцаа, хамтын ажиллагаатай шууд холбоотой байдаг.

Манай гадаад орчныг үндэсний аюулгүй байдлаа хангах зорилттой уялдуулж хоёр хөрш, бүс нутаг, дэлхийн хамтын нийгэмлэг гэсэн гурван төвшинд авч үзэж болно.

Монгол Улс газар нутаг байршлын хувьд уламжлалт ёсоор Төв Азид хамаарах боловч улс төр, эдийн засаг, ардчиллын хүчин зүйлээс улбаалан Ази Номхон далайн бүс нутаг, Зүүн Хойд Азийн хоёр талын болон олон талт хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох бодлого баримталж байна.

Энэ бүс нутаг нь Монгол орны хувьд дэлхийн хөгжлийг тодорхойлох гол бүс болох; Ази-Европыг холбосон газар зүйн таатай байршилтай; уг бүс нутгийн хамтын ажиллагаанд оролцох замаар манай улс төр, эдийн засаг, цэргийн аюулгүй байдлыг хангах боломжтой, эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөрт оролцсоноор гадаад хөрөнгө оруулалтыг татах, олон улсын мэдээллийн системтэй холбогдох зэрэг нөхцлүүдээр ихээхэн ач холбогдолтой.

Олон улсын харилцааны өнөөгийн байдал, хөгжлийн хандлага Монгол Улсыг даяаршил, харилцан хамааралд өөрийн эрхгүй хамруулж байна.

Ийм нөхцөлд улс орны аюулгүй байдлыг хангах бодлого маань улс төрийн хувьд “гуравдагч хөрштэй болох” чиглэлээр тодорхойлогдож, түүний гол зорилт нь ардчилал, эдийн засгийн хөгжилт болоод байна.

Энэ нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалуудад Ази, Номхон далайн бүс нутаг, ялангуяа Зүүн хойд болон төв Азид стратегийн тогтвортой байдлыг хангах, энх тайвныг бэхжүүлэх, аюулгүй байдлын найдвартай тогтолцоог бий болгох бодлого явуулах; Төв Азийг цөмийн зэвсэггүй болгох чиг баримтлах; Цэргийн салбарт итгэлцлийг бэхжүүлэх, бүс нутгийн аюулгүй байдлын хамтын механизм буй болгох хүчин чармайлт, хамтын ажиллагаанд бололцооныхоо хэрээр оролцох; ОХУ, БНХАУ-тай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж,

сайн хөршийн ёсоор хамтын ажиллагааг хөгжүүлэх; АНУ, Япон, БНСУ, Энэтхэгийн эдийн засгийн болон бусад бодит сонирхлыг Монголд бий болгон зохистой төвшинд хүргэх гэсэн зорилт үйл ажиллагаагаар тодорхойлогдож, улс орныхоо улс төр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхээр ажиллаж байна.

Харин аюулгүйн орон зай, цэргийн ажиллагааны театр гэдэг талаасаа бол монгол нь гадаадын улс орнуудын цэрэг-улс төрийн санаархалд амархан өртөж болох, стратегийн өргөн багтаамжтай, чухал байрлал бүхий улс юм.

### Монгол Улсын аюулгүй байдлын орчин



Монгол Улсыг хүрээлсэн цэрэг-улс төрийн орчин нь нэг талаас шууд утгаар ОХУ, БНХАУ-ын стратегийн түншлэл, нөгөө талаас Зүүн Хойд Ази, тэрчлэн Төв Ази дахь улс гүрнүүдийн цэрэг-улс төрийн харилцааны байдлаар тодорхойлогддог.

Монгол Улсаас аюулгүй байдлаа хангах зорилгоор явуулж буй олон талт үйл ажиллагааны нэг чухал хэсэг нь юуны өмнө өөрийн улсын хилийн эргэн тойронд найрсаг харилцаа, хамтын ажиллагаа, харилцан итгэлцлийн орчинг буй болгож, улс төр дипломатын аргаар аюулгүй байдлаа

баталгаажуулах явдал гэж үздэг.

Эдүгээ манай улсын аюулгүй байдлын гадаад орчинд эерэгээр болон сөргөөр нөлөөлөх хүчин зүйлийн хэлбэр хэмжээ шинж чанарт өөрчлөлт гарснаар “хүйтэн дайны” үеийнхтэй харьцуулбал аливаа эрсдэлт багасч, гадны цэргийн аюул занал, түрэмгийллийн талаарх төсөөлөл бүдгэрч, харин эдийн засгийн хямралт байдал, дэд бүтцийн сул хөгжилт, байгалийн гамшиг осол, нийгмийн ядуурал, ажилгүйдэл, гэмт хэрэг зэрэг гео-эдийн засгийн асуудал зүй ёсоор анхаарал татсан асуудал болоод байна.

**ОХУ-ын тухайд:** Гадаадын зарим судлаачид “хүйтэн дайнаас” хойш Оросыг их гүрэн байхаа больсон гэдэг. Манай улсын хувьд огтхон ч тийм биш юм. ОХУ-ын тогтвортой байдлаас манай улсын үндэсний аюулгүй байдал хамааралтай билээ. Манай улс ОХУ-тай 1990-ээд оноос өнөөг хүртэл цоо шинэ нөхцөл байдалд хамтын ажиллагааны тухай гэрээ хэлэлцээр байгуулж, дэлхийн хөгжлийн шинэ хандлагад нийцүүлэн шинэ зарчмаар харилцаагаа хөгжүүлж байна. Хоёр улсын харилцааны хувьд 1990-ээд оноос эхлэн хэсэг хугацаанд үргэлжилсэн харьцангуй зогсонги байдал эцэс болж, 1993 оны “Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ”, 2000 оны “Улаанбаатарын тунхаглал”-ын хүрээнд нийгмийн бүхий л салбарт харилцаа шинэ шатанд гарч, ОХУ-тай хил залгаа бүс нутаг Буриад, Тува улс, Эрхүү, Кемеров мужтай тогтоосон харилцаа идэвхжиж байна.

Эдүгээ хоёр орны харилцаанд орон нутгийн хил орчмын үйл ажиллагааны үүрэг өсч, хоёр улсын хувьд хөгжлийг бүсчлэх шинэлэг хандлага давамгайлах болоод байна. Одоо ОХУ дотооддоо эмх замбараагүй байдал, үндэсний цөөнхийн салан тусгаарлах байдлаас үүссэн алан хядах үйл ажиллагаа, эдийн засаг нийгмийн зөрчлүүдтэй байна.

ОХУ цөмийн зэвсгийн чадавхидаа түшиглэн батлан хамгаалах зорилтоо шийдвэрлэхээ “ОХУ-ын цэргийн номлол”-доо (2000.04.21) зарласан нь цөмийн эрсдлийг бий болгож байна.

ОХУ нь хэдийгээр эдийн засгийн гүн хямралд орсон ч цэргийн болон цөмийн хүчирхэг гүрэн хэвээр байна.

Эдийн засгийн хувьд дээрх байдлаасаа гарч төлөвшин, хүчирхэг, эдийн засагтай орон болоход наад зах нь 10-20 жил хэрэгтэй байх болно. Энэ бол Орос орон гадаад тал руугаа гэхээс илүү дотоод асуудлаа шийдэх, өөртэйгөө илүү ажиллах бодлого явуулах болж, энэ нь манай орны хувьд хэвийн найрсаг бодлого явуулах таатай он жилүүд байх болно.

**БНХАУ-ын тухайд:** Хятад улс өнөөдөр эдийн засгаа давшингуй хөгжүүлж, XXI зуунд амьдрах орон зайгаа тэлэх өөрийн нөлөөг дэлхийн болон бүс нутгийн хүрээнд бэхжүүлэн, их гүрний хэмжээнд бүхий л талаар гарах үйл ажиллагаа, явуулж буй бодлогоос нь харагдаж байна.

Эдүгээ хоёр орны янз бүрийн салбарын хамтын ажиллагааны асуудлыг зохицуулсан 40 гаруй гэрээ хэлэлцээр байгуулан тэр нь амжилттай хэрэгжиж байгаа билээ. Хятадын талаас Монголд үзүүлэх тусламж, хөрөнгө оруулалт, худалдаа эдийн засгийн асуудал улам өргөжиж байна.

Хятадын эдийн засаг дэлхийн 4 дэх том эдийн засаг болж хүчирхэгжихийн зэрэгцээ ХАЧА-ийн нүсэр бүтцийг цомхотгож, сайтар зэвсэглэсэн орчин үеийн арми байгуулах бодлого явагдаж байна.

Эл зорилтоо хэрэгжүүлэх гол нөхцлийн нэг бол олон улсын тогтвортой байдал, Хятадыг хүрээлсэн аюулгүй байдлын таатай орчин юм.

Иймд хоёр хөршийн байдал улс орноо дотоодод тогтворжуулах гадаадад бэхжүүлэх гэсэн улс төрийн бодлого явуулж, энэ нь манай улсын аюулгүй байдлын орчинд таатай нөхцлийг буй болгож байна.

Гэвч нөгөө талаас тус улсын хүчин чадавхи хурдацтай бэхжиж буй нь даяаршлын нөхцөлд БНХАУ-ын эдийн засгаас улам бүр хараат болсоор байгаа Монгол Улсын хувьд аюулгүй байдлын бас нэгэн сорилт болж байна.

**Бүс нутгийн тухайд:** Бүс нутагт нэг талаас АНУ, Японы аюулгүй байдлын гэрээнд тулгуурласан холбоотны харилцаа (Өмнөд Солонгос, Тайваныг оролцуулан), нөгөө талаас ОХУ-БНХАУ-ын стратегийн түншлэл гэсэн тэнхлэг оршоор байна.

Эдгээр тэнхлэгүүд мөн чанараараа хуучин тогтолцооны үеийнх шиг бие биеийн эсрэг хандсан ч, тэдгээрийн хооронд хурц сөргөлдөөн байхгүй байна.

Бүс нутгийн аюулгүй, тогтвортой байдалд нөлөөлж буй гол хүчин зүйлийг дараахь гурван хэсэгт хувааж болох юм. Үүнд:

- Бүс нутагт орших их гүрнүүдийн харилцаа,
- Солонгосын хойгийн байдал,
- Хүч нөлөө нь улам нэмэгдэж буй Хятадын байр суурь.

Хятад, Солонгос хоёр улс хуваагдмал хэвээр байна. Зэвсэглэлээр хөөцөлдөх үйл явц хэрэг дээрээ үргэлжилж, зарим чиглэлээр даамжрах төлөвтэй байна. Ямар ч атугай бүс нутгийн олонх оронд цэрэг зэвсэглэлээ шинэчлэх үйл явц тасралтгүй өрнөж байна.

Бүс нутаг дахь гүрнүүдийн ашиг сонирхлын тэнцвэр төдийлөн тогтоогүй байна. Хөгжилтэй болон буурай хөгжилтэй улс орны хоорондын түгээмэл шинжтэй зөрчил, Хойд Солонгосын цөмийн зэвсгийн асуудал зэрэг зөрчил энд мөн байсаар байна. Гэхдээ орчин үеийн нааштай харилцаа, хамтын ажиллагаануудтай уялдан энэ бүхэн товойж гарч ирэхгүй байх гэж хэлж болох ба ерөнхийдөө тогтвортой урьдчилан таамаглаж болохуйц гэж үзэж байна.

АНУ-д 9-р сарын 11-нд болсон хэрэг явдал бүс нутгийн улс орнуудын харилцаа, хамтын ажиллагаанд, дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө тулгарч байгаа аюул занал бол аль нэгэн улс орон, бүлэг улс биш харин хил хязгаар, орон зай, зэвсэгт тэмцлийн уламжлалт арга хэлбэрийг үл ойшоох алан хядах үйл ажиллагаа юм, түүнтэй хамтран тэмцэх шаардлагатай гэдгийг хатуу ойлгуулж сургамж өглөө.

**Дэлхийн хамтын нийгэмлэгийн тухайд:** Олон туйлт ертөнцийг төлөвшүүлэх гэсэн хандлага, АНУ тэргүүтэй өндөр хөгжилтэй орнууд давамгайлсан нэг туйлт ертөнц гэж хэлж болохоор дэг ёсыг төлөвшүүлэх гэсэн бас нэг хандлага байна. Энэ бүхний цаана глобальчлал буюу даяарших жам ёсны үйл явц эрч хүчээ авч байна. Энэ бүхнээс үзэхэд дэлхийн хэмжээний сөргөлдөөн үүсэх боломжгүй юм. Дэлхий нэгдмэл болохын хэрээр аюул занал ч нийтлэг, хамтын ажиллагаа шаардсан шинжтэй болж байна.

Олон улсын харилцаанд гарч байгаа огцом өөрчлөлт, дэлхийд хөгжлөөрөө тэргүүлэх орны удирдагчдын эрс шийдэмгий мэдэгдлүүд, АНУ, Иракийн хоорондын харилцаа, үйл ажиллагаа нь улс орнуудын улс төр, цэргийн байгуулалт, зэвсэгт хүчний үүрэг зориулалтад зарчмын хувьсал өөрчлөлт хийхэд хүргэж магадгүй байна.

Гэсэн хэдий ч олон улсын харилцаан дахь зөрчилтэй асуудлуудыг дэлхийн нэр хүнд бүхий олон улсын байгууллагуудын оролцоо дэмжлэгтэйгээр энхийн замаар, улс төр-дипломатын арга хэрэгслээр шийдвэрлэх үзэл санаа давамгайлж байгаа нь ихээхэн нааштай уур амьсгал, итгэл найдварыг төрүүлж байна.

Олон улсын харилцаанд НҮБ, Европын холбоо зэрэг олон улсын байгууллагуудын үйл ажиллагаа, нэр хүнд нэлээд өсөх хандлагатай байна. Энэ нь дэлхийн улсууд ардчилал, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж энх тайвныг шударга байдлаар тогтоохыг эрмэлзэж байгаагийн нэг тод жишээ болж байна.

Монгол Улсын аюулгүй байдлын гадаад орчин, төрөөс аюулгүй байдлаа хангах чиглэлээр явуулж байгаа бодлого, үйл ажиллагаа нь дэлхийн хамтын нийгэмлэгийн энх тайван, аюулгүй байдлын эрх ашиг, стратегид ямар нэгэн байдлаар тусгалаа олж, наад зах нь бүс нутгийн аюулгүй байдлын асуудал болж байна.

#### **Гурав. Дотоод орчин, иргэдийн аюулгүй байдал**

Монгол Улсын төр засаг эдүгээ дотоодынхоо нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд юуны

өмнө түлхүү анхаарч байна. Ийм боломжийг олон улсын харилцааны хөгжлийн ерөнхий чиг хандлага, аюулгүй байдлын гадаад орчны таатай байдал олгож байна.

Өнөөгийн нөхцөлд геополитикийн бус гео-эдийн засгийн шинжтэй, тэр тусмаа цэвэр эдийн засгийн чанартай бодит эрсдэлт, сорилт ихээхэн анхаарал татаж байгаа. Манай судлаачид жижиг улсын оршин тогтнохын үндэс нь газар зүйн байршлаас эдийн засгийн хараат байдлыг багасгах шинэ гео-эдийн засаг юм гэж үздэг. Манай улс орны ардчилсан шилжилт нийгмийн хөгжлийн өнөөгийн байдал нь дотоод байдлыг бүхэлд нь буюу эсвэл тодорхой орон нутагт асуудлыг ямар нэгэн байдлаар тодорхойгүй болгож аюулгүй байдалд хохирол үзүүлж болзошгүй дотоодын тийм эрсдэлт заналаас урьдчилан сэргийлэх, шинжилгээ үнэлэлт хийх, зохих арга хэмжээ авч байхыг төр засгийн бүх шатны байгууллагаас шаардаж байгаа. Энэ нь мэдээж цэргийн аюулгүй байдал, үндэстэн хоорондын зөрчил мөргөлдөөнтэй холбоогүй хүчин зүйл байдаг. Цэргийн аюулгүй байдлын тухай албан ёсны төвшин дэх үзэл үнэлгээ нь эдүгээ ба ойрын ирээдүйд гадны болзошгүй дайсангүй, бодитой заналхийлэл учрах магадлалгүй гэдгийг энэ ялдамд хэлэхийг хүсч байна.

Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг бүрт сөрөг нөлөөлж болох дотоод, гадаад хүчин зүйл болон аюулгүй байдлыг хангах арга замыг үзэл баримтлалд тусгасан байдаг.

Аюулгүй байдал алдагдах шалтгаан эрсдэлт нь буурай хөгжил, түүний дотор ажилгүйдэл, ядуурал өсөх хандлага, үндэсний үйлдвэрлэлийн уналт, эдийн засгийн хөгжлийн сааралт, төсвийн хөрөнгийн хомсдол, бүтээгдэхүүн товарын өрсөлдөх чадвар сул, нийгмийн эрсдэлт (ажилгүйдэл, гэмт хэрэг, хар тамхи, ДОХ, амьжиргааны чанар төвшингийн дорой доогуур болон ялгарал ихэсч буй байдал), тэрчлэн экологийн (байгалийн гамшиг, сүйрэл, цас зуд, ган гачиг, гал, усны аюул болон цаг уурын өөрчлөлт, агаарын бохирдолт) болон хүнсний аюулгүй байдал, эдийн засгийн зарим салбарт хараат хамааралт байдал зэрэгтэй холбоотой гэж үздэг.

Одоо Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөө үзүүлж буй дотоод хүчин зүйлийн талаар авч үзье.

### **1. Нийгэм-төрийн байгууллын аюулгүй байдал**

Нийгэм-төрийн байгууллын аюулгүй байдал гэж Монгол Улсын Үндсэн хуулиар бататгасан төр, нийгэм-эдийн засгийн тогтолцоо, төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмууд, түүнчлэн хүний эрх, эрх чөлөө баталгаажсан байдлыг хэлнэ. Нийгэм-төрийн байгууллын аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөөлж болох дотоод хүчин зүйлүүдээс заримыг нь үнэлж дүгнэхэд дараахь байдалтай байна.

#### ***Өмчийн хэлбэрүүдийн тэгш байдал алдагдаж, өмчлөгчдийн эрх зөрчигдөх байдлаар:***

Монгол Улсын иргэн үл хөдлөх хөрөнгөтэй байх, хувийн аж ахуй эрхлэх эрхээ баталгаатай эдлэх нь газар өмчлөх, эзэмших явдлаас ихээхэн хамааралтай байна. Үндсэн хуулийн зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно” [4.2] гэж заасан нь иргэд хамгийн найдвартай, үнэ цэнэтэй үл хөдлөх хөрөнгөтэй болж, аж ахуй эрхлэх үндэс боломж олгож байгаа хэрэг мөн боловч одоо хүртэл газар хувьчлах асуудлыг шийдвэрлэж чадаагүй маргаантай асуудлын нэг болсоор байна. Хэдий тийм боловч иргэд ашигтай байрлал бүхий газрыг эзэмших эрх олж аваад өөрийн өмч мэтээр тухайн газраа өндөр үнэ хүргэж бусдад худалдах явдал нэлээд газар авчээ. Сонин, хэвлэл, радиогоор зөвшөөрөлтэй газар худалдах тухай зарлах нь жирийн үзэгдэл болсон байна.

Иргэд, аж ахуйн нэгжийн газар эзэмших асуудал Нийслэлийн хэмжээнд маш хүндрэлтэй байна. Газрын тухай хуулийн 22, 23 дугаар зүйлд зааснаар Нийслэлийн Засаг дарга нь дүүргийн Засаг даргын саналыг харгалзан Нийслэлийн хөгжилд “чухал ажил үйлдвэрлэл эрхлэх иргэн, аж ахуйн нэгж байгууллагад” газар ашиглуулах талаар шийдвэр гаргах, мөн дүүргийн Засаг дарга нь аж ахуйн нэгж байгууллагад газар эзэмшүүлэх, ашиглуулах тухай шийдвэр



гаргах эрхтэй. Ийнхүү хуулийн заалт хоёрдмол утгатай байгаагаас гадна төрийн өмчийн газрын эзэмшлийг улс, нийслэл, дүүрэг, аймаг, сумаар зааглан зохион байгуулаагүйгээс газар эзэмшүүлэх шийдвэр гаргах талаар “өрсөлдөөн” гарч, шат дамжлага хүнд суртлын саад тотгор их болжээ.

Нийслэлийн хэмжээнд тогтоосон журмаар бол Улаанбаатарт газар эзэмшихийн тулд асуудлыг бүрэн шийдвэрлүүлэхэд 8 шат дамжлага дамжиж, наад зах нь 6 сараас доошгүй хугацаа зарцуулагддаг байна. Газар эзэмших, ашиглах зөвшөөрөл олгох ажиллагааны олон шат дамжлага аймаг, орон нутагт ч мөн адил байна. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хот байгуулалт, газрын харилцааны газар нь 1998-2000 онд иргэд, аж ахуйн нэгжээс газар эзэмшлийн холбогдолтой 11670 өргөдөл хүлээн авч 660 өргөдөл буюу 7 хувийг нь шийдвэрлэж, бусдыг хэрхсэн нь тодорхой бүртгэлгүй байсан ба тэдгээр өргөдөл, хүсэлтийг 60-354 хоногийн хугацаанд шийдвэрлэж хуулийн хугацааг ихээр хэтрүүлж байжээ [5.1233].

Төрийн захиргааны байгууллага олон шат дамжлагыг дамжуулан түргэн үйлчилгээний цэг (ТҮЦ) ажиллуулах зөвшөөрлийг олгосон атлаа сүүлийн үед Дүүргийн Засаг дарга шийдвэр гаргаж, жижиг бизнес эрхлэгчдийн ТҮЦ-ийг албадан буулгах компани дэгдээсэн нь нэг талаас хувийн өмчийн эрхийг илт зөрчиж, нөгөө талаас төр зайлшгүй шаардлагаар иргэний өмчийг шилжүүлэхэд хүрсэн бол холбогдох зардлыг нөхөн олгох Үндсэн хуулийн заалтыг үл хайхарсан ажиллагаа болжээ гэж үзэх үндэстэй.

Гааль, Үндэсний татварын газар зэрэг захиргааны хяналтын байгууллага зөрчил илрүүлж торгууль төлбөр тавьсан орлогынхоо зохих хувийг өөртөө үлдээх журам тогтоосон нь хууль биелүүлэх хөшүүрэг болохоосоо хүний эрхэд халдахад түлхсэн хөшүүрэг болж байна.

Иргэний хуулийн 134 дүгээр зүйлийн “эрх зүйн зөрчил гаргасан этгээдийн эд хөрөнгийг хураана” гэсэн заалт нь хэт ерөнхий, агуулгын хувьд дэндүү хавтгайруулсан шинжтэй байна.

Үл хөдлөх эд хөрөнгийг улсын бүртгэлд бүртгэх нь өмчийн эрхийг хамгаалах нэг үндэс мөн. Татвар өндөр байгаагаас шалтгаалан иргэд үл хөдлөх хөрөнгөө худалдахдаа ихэвчлэн бэлэглэлийн гэрээгээр халхавчилдаг байна. Сүүлийн 5 жилд бэлэглэх гэрээ 15689, худалдах гэрээ 13860 бүртгэгджээ. Үүнээс үндэслэн үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой татвар хураамж олон, хэмжээ нь ч багагүй байна гэсэн дүгнэлт хийж болохоор байна.

***Төрийн байгууллага шашны, сүм хийд төрийн хэрэгт үл оролцох зарчим алдагдах гэсэн асуудлаар:***

Өнөөгийн байдлаар Монгол Улсад Будда, Христос, Ислам, Бахай, Бөө, Язу тарнийн 270-аад сүм хийд байгаагаас 186 нь Хууль зүй, дотоод хэргийн яаманд албан ёсоор бүртгүүлж, үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс уламжлалт гэгдэх Буддын шашин 112 хийд дацан /нийслэлд 28/, Исламын шашны 2 /нийслэлд 1/, Бөөгийн 1 /нийслэлд/, “уламжлалт бус” гэгддэг Христос шашны 65 /нийслэлд 39/, Бахай шашны 5 /нийслэлд 1/, Язу тарнийн 1 сүм байна [5.1224].

Сүм хийдийг бүртгэхэд үндэслэлгүйгээр татгалзах, хаах, боох хандлага байна. 1996 оноос хойш аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал (ИТХ) шашны байгууллагад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгохдоо хугацааг нэг жилээр тогтоон, улмаар уг хугацааг дуусах үед жил, жилээр сунгадаг журам тогтсон байна. Гэвч тухайн үед зөвшөөрөл олгосон ИТХ-ын бүрэн эрхийн хугацаа дууссаны дараа шинээр сонгогдсон ИТХ шашны байгууллагад зөвшөөрөл олгох, хугацаа сунгахдаа хойрго ханддаг, түүнээс зайлсхийдэг хандлага гардаг ажээ. Шашны үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгохгүй, олгосон ч богино хугацаатай байх нь нэг талаас шүтэн бишрэх эрхээ чөлөөтэй эдлэх боломжийг хязгаарлах, мөн бусдын зүгээс гадуурхах шалтгаан болдог байна.

***Хээл хахууль газар авч, гэмт хэрэг зохион байгуулалтын шинжтэй болох гэсэн асуудлаар:***

Монгол Улсад авилгал бодитойгоор оршиж төрд итгэх олон түмний итгэлийг алдагдуулан улс төр, эдийн засгийн

шинэтгэлд бэрхшээл учруулж, улмаар үндэсний аюулгүй байдалд заналхийлэхэд хүргэж болзошгүй байна. Монгол дахь авилгалын талаархи олон нийтийн санаа бодол, байр суурийн асуудлаар Улаанбаатар хот, 9 аймагт 1999 оны 6-7 сард явуулсан судалгааны дүнгээс үзэхэд өнөөгийн нийгэмд авилгал түгээмэл байна гэж судалгаанд оролцогчдын 73.0 хувь нь үзжээ [6 .933].

Олон улсын хэмжээнд авилгад идэгдсэн байдлаар нь 90 орныг дүгнэхэд Монгол Улс дөрвөн оноогоор 43 дугаар байр эзэлжээ. “Авилгалын талаархи олон нийтийн санаа бодол, байр суурь-2002” социологийн судалгаанд оролцогчид “Монголд авилгалтай тэмцэл хийх, олон түмний итгэл даах нэг ч институт алга” гэсэн үнэлэмжийг нэгэн дуугаар илэрхийлсэн байна [7.3].

Улсын мөрдөн байцаах газрын 4 дүгээр хэлтэс буюу авилгал, эдийн засгийн хэргийг мөрдөх хэлтэст он гарсаар авилгал, албан тушаалын 26 хэргийг шалгаж байна. Мөн иргэдээс ийм төрлийн гэмт хэрэгтэй холбогдсон 45 өргөдөл ирүүлжээ. Үүний цаана харъяаллын дагуу аймаг, дүүргийн цагдаагийн газар, хэлтэс болон тагнуулын байгууллагын шугамаар энэ төрлийн хэргүүдийг шалгаж байгаа. Ингээд үзвэл сард дунджаар авилгал, албан тушаалтай холбоотой 40-өөд хэрэг гарч байна [13.3].

2002 онд 22555 гэмт хэрэг гарсны 47.5 хувь нь нийслэлд үйлдэгдсэн байгаа юм. Говь-Алтай, Өмнөговь, Сүхбаатар, Увс, Ховд, Хөвсгөл аймагт гэмт хэрэг 2.7-28.7 хувиар өсч, бусад аймагт буурлаа. Бүртгэгдсэн хэргийн илрүүлэлт 85.5 хувьтай байна. Хүнийг санаатай алах, хүчиндэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, булаалт, дээрэм гэх мэт төрлийн гэмт хэрэг 6.7-26.8, зохион байгуулалттай гэмт хэрэг 4.1 хувиар өсчээ. Улс нийгэм, ард иргэдэд 23.9 тэрбум төгрөгийн хохирол учирснаас 11.3 хувийг нь нөхөн төлүүлсэн ажээ [14. 3].

Зөвхөн сүүлийн гурван жилд нийт 70 орчим мянган гэмт хэрэг гарч, энэ нь тогтвортой буурахгүй байна. Сүүлийн гурван жилийн дунджаар авч үзэхэд гурван хэрэг тутмын нэг

нь онц хүнд, хүнд гэмт хэрэгт хамаарч, таван хэрэг тутмын нэгийг согтуугаар, зургаан хэрэг тутмын нэгийг бүлэглэн үйлджээ. Үйлдсэн этгээдийг нь тогтоогоогүй гэмт хэрэг өсөх хандлагатай байгаагийн зэрэгцээ дээрэм, танхай, хүчин, бусдын өмчийн хулгай, түүний дотроос иргэдийн өмчийн хулгайн гэмт хэргийг үйлдсэн этгээд тэр бүр тогтоогдохгүй байна. Зөвхөн 2002 онд 3261 гэмт хэргийг хэн үйлдсэн нь илрээгүй байна [15.3].

***Стратегийн болон улсын нөөц шавхагдах, өлсгөлөн, байгалийн ноцтой гамшигт нэрвэгдэх, хүн амыг олноор хөнөөх өвчин гарах гэсэн асуудлаар:***

Бэлчээрийн мал аж ахуй нь олон зууны туршид монголчуудын нүүдлийн амьдралын гол хэв маяг, эдийн засгийн үндсэн салбар байсаар ирсэн бөгөөд байгалийн гамшигт өртөх магадлал ихтэй байдаг онцлогтой. Монгол орны бэлчээрт одоогоор тогтоогдоод буй 2600 гаруй ургамлаас 600 гаруй нь малын тэжээлийн үндсэн хэрэгцээг хангадаг. Хангайн өндөр уулын бэлчээрийн ургац зуншлага сайтай жилүүдэд олон жилийн дундаж ургацаас 26-38 хувиар ихсэж, гантай жилүүдэд 12-48 хувиар багасч байхад цөлөрхөг хээрийн бэлчээрийн ургац зуншлага, ургац сайтай жил 23.1-58.3 хувиар нэмэгдэж, гантай жилүүдэд 28-60.3 хувиар багасдаг байна.

Бэлчээрийн ургамлын шимт чанар өвөл, хаврын улиралд зуныхаас 2-3 дахин, шингэх протеин 3-4 дахин буурдаг байна. Өвөл, хаварт мал хоногт шаардагдах тэжээлийнхээ дөнгөж 40-50 хувийг бэлчээрээс авдаг. Ган, зудтай жилүүдэд бэлчээрийн даац хэвийн жилийнхээс 23-39 хувиар буурч, мал аж ахуйн үйлдвэрлэлд багагүй хохирол үзүүлсээр ирсэн юм.

Байгалийн гамшиг дотроос хамгийн их хохирол учруулдаг нь ган, зуд юм. Сүүлийн 60 жилийн судалгаанаас үзэхэд манай оронд ган, зудын давтамж богиносх хандлагатай болж, үлэмж хэмжээний хохирол учруулж байна. 1940-1990 оны хоорондох 50 жилд 17 сая мал буюу 10 жил тутам 3.4 сая мал хорогдсон байхад зөвхөн 1990-2000 онд 5.2 сая мал хорогджээ [16.465-470].

Цаг агаар хуурайшнаас түймэр гарах нь олширч, зөвхөн 1998 онд 132 удаа түймэр гарсны уршгаар байгаль орчин, дэд бүтцэд хохирол учирч 3 гаруй тэрбум төгрөгөөр үнэлэгдэх ой мод, мал сүрэг түймрийн галд шатжээ. Гал түймрийн ихэнх нь хүмүүсийн үйл ажиллагаанаас үүдэн гарч байна [17.42].

Манай улсад сүүлийн 5 жилд буюу 1997-2001 онд халдварт өвчний 165700 тохиолдол бүртгэгдсэн нь 10000 хүн амд 140.6 өвчлөл ногдож, халдварт өвчний улмаас 772 хүн нас баржээ. Сүрьегийн өвчлөл 100000 хүн амд 127.0 байгаа нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Номхон далайн баруун бүсийн орнуудын өвчлөлийн дунджаас даруй 2.5 дахин их байна. Мөн хугацаанд гэдэсний халдварт өвчин ихсэх хандлагатай болсны дотор цусан суулга өвчин 2 дахин нэмэгдэж, А вируст гепатитийн өвчлөл сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд гарах нь ихсэж байна. 1992-2001 онд 59 голомтод 85 хүн тарваган тахлаар өвчилсний 37 нь нас барж, өвчлөл өмнөх 10 жилийнхээс 22-оор өсч, нас баралтын хувь 43.5 хувь болжээ. Манай орны ойт хээр, хээрийн бүсэд орших 15 аймгийн 70 шахам сум боом өвчний байгалийн нутагшмал голомттойгоос жилд дунджаар 40 орчим хувь нь идэвхжиж мал, хүний өвчлөл ихсэж байна. 1999-2001 онд галзуу, боомоор өвчилсөн малын тоо 2.5 дахин өссөн нь хүний өвчлөлд шууд нөлөөлж байна [18.1048-1049].

## **2. Иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал**

Иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал гэж бие хүн өөрийн хийгээд эх орон, ард түмнийхээ ашиг сонирхлын төлөө биеийн болон оюуны хүч чадавхиа бүрэн зориулах, олон улсын гэрээний дагуу хүний эрхийн асуудлаар Монгол Улсын хүлээсэн үүрэг хэрэгжих нөхцөл бүрдсэн байдлыг хэлнэ. Иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөөлж болох дотоод хүчин зүйлүүдийн заримыг үнэлж дүгнэхэд дараахь байдалтай байна.

***Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжоор олгогдсон Монгол Улсын иргэдийн эрх, эрх чөлөөг хангахуйц улс төр, эдийн засаг, нийгмийн***

**болон бусад бодит баталгаа эс бүрдэх буюу алдагдах асуудлаар:**

Мэргэжлээс шалтгаалсан өвчлөлд өртөж, хөдөлмөрийн чадвараа алдсан эрүүл мэндээр хохирсон хүний тоо буураагүй байна. Жил бүр дунджаар (1997-2000) 5692 хүн мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуу болж, хөдөлмөрийн чадвараа алдаж байна. Үүнд тоосны гаралтай цагаан мөгөөрсөн хоолойн архаг үрэвсэл 55.7 хувь, уушиг тоосжих өвчин 16.2 хувь, мэдрэлийн өвчин 8.3 хувь, хурц хордлого 8.4 хувь, мэс засал, яс булчингийн өвчин 7.0 хувийг тус тус эзэлж байгаа бөгөөд эдгээр өвчлөл нь түлш, эрчим хүч, геологи, уул уурхай, барилгын салбарт илүү гарсан байна [19.894-897].

**Хүнсний аюулгүй байдлын асуудлаар:** Хүнс, хоолоор дамжин халдварладаг, хордлого үүсгэдэг 60 гаруй өвчний 30 шахам нь манай орны мал, амьтанд оношлогдсон бөгөөд мах, сүү, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийг хүнсэнд зориулж бэлтгэх, нийтийн худалдаанд гаргахад мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн шаардлага зөрчигдөх явдал гарсаар байна. Сүүлийн жилүүдэд хүнсний бүтээгдэхүүний нян, хөгц, мөөгөнцөрийн бохирдолт 22.7, химийн-14.1, металлын-6 хувьд хүрч, шаардлага хангахгүй байгаа нийт сорьцын 35.5 хувийг хүнсний бүтээгдэхүүн эзэлж байна.

1995-2000 онд хорт хавдрын өвчлөл нэмэгдэж, ялангуяа элэгний хорт хавдар тэргүүлэх болсон байна. Эрүүл мэндийн тайлангийн дүнгээр нийт халдварт өвчний 30 гаруй хувийг хоол хүнс, орчны бохирдолт, ариун цэврийн шаардлага хангаагүйтэй холбоотой гэдэсний халдварт өвчин, хорт хавдар эзэлж байна.

**Хоол тэжээл-эрүүл мэндийн асуудлаар:** Амьжиргааны баталгаат төвшингээс дээгүүр орлоготой өрхийн нэг гишүүн хоол тэжээлээр хэрэгцээт хэмжээнээс илүү илчлэг 134-135 хувь авч байхад амьжиргааны баталгаат төвшингээс доогуур орлоготой өрхийн нэг гишүүний хоногийн хэрэгцээт илчлэгийн хангамж 58.1-68.5 хувь байна.

Хүн амын эмзэг бүлэг, эх, хүүхдийн дунд хоол, тэжээлтэй холбоотой архаг өвчлөл-зүрх судасны өвчин, таргалалт, чихрийн шижин, хоол боловсруулах болон бусад эрхтний хорт хавдар нэмэгдсээр байна.

**Боловсролын байдлаар:** Хүн ам, өрхийн 1998 оны тооллогоор 8-15 насны хүүхдүүдийн 1.5 хувь бичиг үсэггүй байсан бол 2000 онд энэ үзүүлэлт 4.9 хувь болж өсчээ. Нийт хүн амын 90-95 хувь бичиг үсэгт тайлагдсан байв.

**Нөхөн үржихүйн эрүүл мэндийн байдлаар:** Эхийн эндэгдэл сүүлийн 3 жилд 100000 амьд төрөлтөд дунджаар 163 байгаа нь зорьсон төвшнээс өндөр байна. Жирэмсэлж, төрж байгаа эхчүүдийн 29 хувийг малчид эзэлж байхад эндсэн эхчүүдийн 49.3 хувь нь малчид, 43.3 хувь багт, 36.9 хувь нь сумын төвд амьдардаг эхчүүд байна. Сүүлийн 3 жилд нас барсан эхчүүдийн 40.5 хувь нь сум, багийн эмнэлэгт энджээ. Энэ нь сум, багийн төвшинд эсэн мэнд амаржихуйн тусламжийн чанар, хүртээмж нэн хангалтгүй байгааг харуулж байна. 1000 амьд төрөлтөд 230 үр хөндөлт ногдож байна. Архидалт, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүд нь хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлтийн өсөлтөд шууд нөлөөлж байна. Үр хөндүүлсэн эмэгтэйчүүд хотод хөдөөгийнхөөс 2.3 дахин илүү байна. Хүн амын 36 хувь нь ядуу, нэн ядуу амьдарч байгаагаас хүүхэд төрүүлсний тэтгэмж авахын тулд амьжиргааны төвшин доогуур болон ахимаг настай зэрэг өндөр эрсдэлтэй эмэгтэйчүүд жирэмсэлж, төрөх нь нэмэгдсэнээр эх, нялхсын эндэгдэлд эмзэг бүлгийнхэн илүүтэй өртөж байна [20.480-481].

### **3. Эдийн засгийн аюулгүй байдал**

Эдийн засгийн аюулгүй байдал гэж дотоод нөөц бололцоогоо ашиглан нөхөн үйлдвэрлэл явуулах, ард түмнийхээ хэрэгцээг хангах, тусгаар тогтносон байдлаа бэхжүүлэх эдийн засгийн чадавхитай байх, шаардлагатай нөхцөлд улс орноо тодорхой хугацаагаар тэтгэж чадах эдийн засгийн бүтэц бүрдсэн байдлыг хэлнэ. Эдийн засгийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж болох дотоод хүчин зүйлүүдийн заримыг үнэлж дүгнэхэд дараахь байдалтай байна.

***Экологийн бодлого алдагдаж ус, ой мод, хөдөө аж ахуйн эдэлбэр газрын хэмжээ багасах асуудлаар:***

Монгол Улс нь газар нутгийнхаа хэмжээгээр дэлхийд 17-д ордог хэдий ч, дийлэнх хэсэг нь үржил шим багатайд тооцогддог. Үүний улмаас үржил шим сайтай газрыг хэт их ачаалалтай ашиглаж байгаа нь хөрсний ноцтой элэгдлийг буй болгож байна. Бэлчээрийн 70 орчим хувь нь ямар нэг хэмжээгээр талхлагдсанаас бэлчээрийн талбай байнга хумигдсаар байна.

Тариалангийн ихэнх талбай хөрсний элэгдэлд оржээ. 1.3 сая га тариалангийн талбайн бараг тэн хагас нь атаржсан бөгөөд өнгөрсөн 20 жилд улаан буудайн дундаж ургац тал хувиар буурчээ.

Уул уурхайн, нэн ялангуяа алт олборлолтын эрчимтэй үйл ажиллагаа газрын доройтолд бас нөлөөлсөн байна. Эрэл хайгуулыг 600 орчим цэгт хийж 200 цэгт олборлолт явуулж байгаа нь нэг талаар эдийн засгийн өсөлтөд сайнаар нөлөөлж байгаа ч нөгөөтэйгүүр олон сая га газрыг элэгдэлд оруулж байна. Уурхайн олборлолт хийж буй компаниуд хөрсийг нь сэргээхгүй орхиж байна. Олборлосон газраа ийнхүү сэргээлгүй орхисны төлөө торгууль ногдуулах нь туйлын ховор бөгөөд нөгөөтэйгүүр, компаниудын хувьд торгуулийн төлбөр нь олборлосон газраа сэргээхэд зарцуулах хөрөнгөнөөс хавьгүй бага учир торгууль төлчихөөд явах нь тэдэнд ашигтай байдаг байна.

Газрын хөрс элэгдэн доройтож байгаагийн хамгийн ноцтой хэлбэр нь цөлжилт юм. 1998 оны тооцоогоор газар нутгийн 21% нь цөлжилтөд дунд зэрэг өртөж, харин 4% нь ихээр нэрвэгджээ [17.39].

***Гаалийн бодлого алдагдаж, Монгол Улс, ард түмний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй эд зүйлс орж ирэх, төсвийн орлогын эх үүсвэр багасах, үндэсний үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлөх асуудлаар:***

Үндэсний үйлдвэрлэлийн зогсонги байдал, түүний дотор аж үйлдвэрийн боловсруулах салбар уналтад орж,



түүхий эд экспортлогч хавсарга орон болсон. Манай эдийн засгийн гол салбар болсон мал аж ахуйн бүтээгдэхүүн - малын арьс, шир, ноосны 70 орчим хувь, стратегийн чухал түүхий эд болох ямааны ноолуурын 50 гаруй хувийг аж үйлдвэрийн ямар нэг боловсруулалт хийлгүйгээр гадагш гаргаж байна.

***Улсын урсгал төсвийн алдагдал өсөх, Монгол Улсын мөнгөн тэмдэгт-төгрөгийг хамгаалах төрийн бодлого алдагдах асуудлаар:***

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) болон зарим чухал салбарын уналтыг зогсоож, өсөлт дэвшил буй болгож чадахгүй хэвээр байна (1995 онд ДНБ-ний бодит өсөлт 6.3% байсан бол 2001 онд 1.1% болж буурсан, ДНБ-ний 30-40%-ийг эзэлдэг хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбарын өсөлт байнга буурч байна [21.41].

Экспорт, импортын үр ашиг багатай, алдагдал, эрсдэл ихтэй бүтэцтэй. Гадаад худалдааны балансын алдагдал 2000 онд -148.4 сая ам.доллар, 2001 онд -169.6 сая ам.доллар болсон [22.173]. Экспортын гол орлогыг зэс, алт, ноолуурын экспорт бүрдүүлж байгаа бөгөөд эдгээр түүхий эдийн дэлхийн зах зээл дээрх үнийн хэлбэлзлээс шалтгаалж экспортын орлогыг маш их эрсдэлд оруулж байна. Зэс, алт, ноолуурын экспорт 1997 онд нийт экспортын 63.2 хувийг эзэлж байсан бол дэлхийн зах зээлийн түүхий эдийн үнийн бууралттай холбоотойгоор 1998 онд 58.8%, 1999 онд 57.5%, 2000 онд 51.3%, 2001 онд 56.0% болсон, Экспортлосон зэсийн баяжмал 2001 онд өмнөх оныхтой харьцуулахад биет хэмжээгээр 44.9 мянган тонноор өссөн боловч, дундаж нэгж үнэ нь 323.0 ам.доллараас 273.4 ам.доллараар буурч, нийт үнэ нь 12.4 сая ам.доллараар буурсан байна [23.6].

***Инфляци үсрэнгүй нэмэгдэн төгрөгийн ханш унаж, амьжиргааны доод төвшингөөс доогуур орлоготой айл өрхийн тоо олшрох асуудлаар:***

Төгрөгийн доллартай харьцах ханш байнга унаж байна. 1 америкийн доллар 1995 онд 474 төгрөг, 1997 онд 813 төгрөг, 1999 онд 1072 төгрөг, 2002 онд 1125 төгрөг болсон

[24.39]. Хүн амын амьжиргааны төвшин эрс ялгаатай хэвээр байна (хүн амын орлого багатай хэсгийн орлогыг их орлоготой хэсгийнхэнтэй харьцуулбал 15 дахин доогуур байгаа юм). Үүний зэрэгцээ нийт хүн амд амьжиргааны баталгаажих доод төвшингээс бага орлоготой хүн ам томоохон хувийг эзэлдэг аж. Дэлхийн дунджаас үзэхэд ядуурлын төвшинд хүн амын 10-аас илүүгүй хувь байж болох юм гэж тооцдог бол Монголын хүн амын 36 хувь нь ядуурлын төвшинд амьдарч байна.

Үндэсний статистикийн газраас явуулсан хүн амын амьжиргааны төвшний түүвэр судалгааны дүнгээс үзэхэд нийт хүн амын дунд нэн ядуу 19.7%, ядуу 15.9%, бага орлоготой 27%, боломжийн буюу дунд зэргийн орлоготой, чинээлэг хүмүүс 37.4%-ийг тус тус эзэлж байна [25]. Батлан хамгаалах салбарт ажиллагсдын амьжиргааны төвшинг улсын дундажтай харьцуулахад бүр тааруухан дүр зураг харагдаж байна. Уг салбарт дээрх үзүүлэлт 7.2%, 39.8%, 30.1%, 22.9% байгаагаас үзэхэд тус салбарт ажиллагсдаас “ядуу” гэсэн үзүүлэлтэд хамрагдагсад нь улсын дунджаас 23.9 хувиар их байгаагийн зэрэгцээ ядуу болон нэн ядуу төвшинд хамрагдагсдын нийт дүн 47 хувь хүрч буй нь анхаарал татаж байна [26.19].

Үндэсний статистикийн газраас олон улсын аргачлалаар хүн амыг нийгмийн халамж, дэмжлэг шаардагдах байдлаар нь “өөрийгөө хөгжүүлэх чадвартай, нийгмийн халамж, дэмжлэг үл шаардах”, “өөрийгөө авч явах чадвартай, нийгмээс хүчтэй дэмжлэг шаардахгүй”, “нийгмийн халамж, дэмжлэг хүчтэй шаардаж байгаа” хэмээн ангилдаг байхад судалгааны дүнгээс үзэхэд батлан хамгаалах салбарт ажиллагсдын 60 орчим хувь нь “өөрийгөө авч явах чадвартай, нийгмээс хүчтэй дэмжлэг шаардахгүй”, харин 40 гаруй хувь нь “нийгмийн халамж, дэмжлэг хүчтэй шаардаж байгаа” бүлэгт тус тус хамрагдаж байгаа тухай судалгааны дүнгээс гарч байна.

Түүнчлэн хөдөлмөр эрхэлж байгаа ядуучууд цөөнгүй байна. Дээрх судалгаанаас үзэхэд хотод нэн ядуучуудын 37.6%, ядуучуудын 48.3%, ядуу бус бага орлоготой хүмүүсийн 49.2%, хөдөөд нэн ядуучуудын 58.4%, ядуучуудын 79.6%,

ядуу бус бага орлоготой хүмүүсийн 83.3% нь тус тус хөдөлмөр эрхэлж байна. Үүнээс үзэхэд Монголд хөдөлмөр эрхлэх боломж хомс, орлогын төвшин доогуур байгаагаас орлогын ядуурал зонхилж байна.

Хүн амын амьжиргааны эх үүсвэр харилцан адилгүй байна. Улсын дунджаар хүн амын орлогын гуравны нэг нь цалин, тэтгэвэр, тэтгэмж, шагнал урамшуулал, 20 гаруй хувь нь хөдөө аж ахуйн болон хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэлийн орлогоос, 30 хувь нь өрхийн хувийн аж ахуйгаас, 10 хувь нь бусдаас үнэгүй авсан хэрэглээнээс бүрдэж байгаа ч өрхийн байршлаас хамааран хот, суурин газрын хүн амын орлогын 40-60 хувийг цалин, тэтгэвэр, тэтгэмж эзэлж байхад хөдөөгийн хүн амын орлогын дөнгөж 7 хувийг цалин, тэтгэвэр, тэтгэмж, 60-аад хувь нь өрхийн аж ахуйн орлогод ногддог аж.

Хүн амын амьжиргааны төвшин эрс ялгаатай, тухайлбал, хүн амын ядуу хэсгийн орлогыг чинээлэг хэсгийнхэнтэй харьцуулбал 15 дахин доогуур байгаа юм. Амьжиргааны төвшин, өрхийн байршил нь хүн амын нийгмийн үйлчилгээнд тэгш бус байдлыг бий болгож байна.

Чинээлэг өрхүүдтэй харьцуулахад эрүүл мэндийн салбарын үйлчилгээг ядуу өрхүүд бага хүртэж байна. Эрүүл мэндийн үйлчилгээний сарын дундаж зардлыг хэрэглээний төвшингээр авч үзвэл нэн ядуу бүлгийн нэг хүнд ногдох эрүүл мэндийн үйлчилгээний зардал хамгийн өндөр орлоготой хэсгийнхний зардлаас 9 дахин бага байгаагаас гадна ядуу хүний эмнэлэгт хандах давтамж буурсан байна.

Амьжиргааны доод төвшингээс доогуур орлоготой өрхийн иргэд хоол хүнсний байнгын хомсдолд орж, өлмөн зэлмэн байдалд аж төрж байна. Монгол хүний өдөрт хэрэглэх хоол тэжээлийн илчлэгийн зохистой нормыг 2900 калори гэж тогтоосон байхад ядуу өрхийн гишүүд өдөрт дунджаар 1784 калори авч байна. Эмзэг бүлгийн өрхийн амьжиргааны өнөөгийн байдал нь “ядуурал-өлсгөлөн-өвчин” гэсэн гинжин холбоог үүсгэж байна.

Ядуу амьдралтай өрхийн хүүхдэд боловсрол олгох, мэргэжил эзэмшүүлэхэд ихээхэн бэрхшээл учирч байна.

Судалгаанаас үзэхэд эдгээр өрхийн 8-15 насны хүүхдийн сургуульд хамрагдалтын төвшин 87.3 хувь, сургууль завсардалт 9.3 хувь байна. Сургууль завсардалт хөдөөд илүү байгаа бөгөөд сургууль завсардсан хүүхдүүдийн 43.8 хувь нь амьдралын гачигдал, ажил эрхлэх шаардлагын улмаас сургуульд хамрагдаагүй гэжээ.

Түүвэр судалгааны дүнгээс үзэхэд өрхийн орлогоос боловсролд зарцуулж байгаа зардал нь 1998 онд 1995 оныхоос 4-5 дахин нэмэгдсэн байна. Чинээлэг өрх сургуулийн хүүхдийн зардалд ядуу өрхөөс 6 дахин их зардал гаргаж байна.

***Бусад улс буюу олон улсын байгууллагад өртэй болж дарамт шахалт, хараат байдалд орох асуудлаар:***

Эдийн засгийн аюулгүй байдалд нөлөөлөх ноцтой хүчин зүйл нь гадаад өр, төлбөрийн асуудал юм. Монгол Улс олон жилийн турш бусад улс орны зээл тусламжаар тэжээгдэж ирсэн, одоо ч тэжээгдсээр байгаа нь эдийн засгийн аюулгүй байдлын тулгамдсан нэн эмзэг асуудлын нэг хэвээр байна.

***Ажилгүйчүүд, түүний дотор хөдөлмөрийн насны хөдөлмөрлөх чадваргүй хүн амын тоо хэт өсөх асуудлаар:***

Хүн амын амьжиргааны төвшинд хөдөлмөр эрхлэлтийн байдал зонхилох нөлөөтэй байдаг ба манай улсад ажилгүйдэл, эдийн засгийн идэвхтэй хүн амд ажилгүйчүүдийн эзлэх хувь өндөр байгаа юм. Эдийн засаг нь хөгжилтэй, тогтвортой улс орнуудад ажилгүйдэл эдийн засгийн идэвхтэй хүн амын 6 хувь байхыг зөвшөөрдөг ба харин 8-10 хувьд хүрвэл аюултай гэж үздэг. Гэтэл манай улсын дунджаар хөдөлмөрийн насны хүн амын 65 хувь нь ажил эрхэлж, 15.4 хувь нь хөдөлмөр эрхлээгүй гэсэн албан ёсны тоо баримт байдаг ч Монгол Улсын далд ажилгүйдлийг тооцвол уул үзүүлэлт 24 хувьд хүрээд байна. 2001 онд Зэвсэгт хүчний 12 анги, салбар, БХЯ-ны харъяа 5 байгууллага, аж ахуйн нэгжүүд болон тус салбарт ажиллагсдын 2678 өрх, түүний

6961 гишүүнийг хамруулан хийсэн судалгааны дүнгээс үзэхэд өрхийн нийт гишүүдийн 21.3 хувийг ажилгүйчүүд, 31.5 хувийг суралцагсад, 13.3 хувийг бага насны хүүхэд, 0.5 хувийг хөдөлмөрийн чадваргүй иргэд эзэлж байна.

*Хүснэгт 1*

Эдийн засгийн аюулгүй байдлыг тодорхойлох  
үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	2001 оны төвшин	Боломжит төвшин
Бүтцийн		
Экспортод түүхий эд болон эцсийн бүтээгдэхүүний эзлэх хувь	Түүхий эд 88% Эцсийн бүтээгдэхүүн 12%	50%
Үндэсний үйлдвэрлэгчдийн дотоод зах зээлд өрсөлдөх чадвар: ДНБ-д импортын эзлэх хувь	53,2 %	<50%
Импортын бүтэц: Орноор, нэг орны эзлэх хувь	36,4 %-ОХУ	<30%
Экспортын бүтэц: Орноор, нэг орны эзлэх хувь	53,7 %-Хятад	<40 %
ДНБ-д боловсруулах үйлдвэрийн эзлэх хувь	8,9 %	<30%
Технологийн		
Шинжлэх ухаан, технологийн судалгаанд зарцуулж буй хөрөнгө ба ДНБ-ийг харьцуулсан хувилбар	1 хүрэхгүй хувь	2-3 %
Санхүүгийн		
ДНБ-ний жилийн өсөлт	1,1%	>5%
Инфляцийн төвшин жилийн эцэст	11,2	1 оронтой тоонд
ДНБ-д төсвийн алдагдлын эзлэх харьцуулсан хувь	4%	>3%
Ядуурлын төвшин	36%	<7%
Гадаад валютын нөөц (сая ам.дол)	162.1 (импорт 655.4)	1 жилийн импорт
Нэг хүнд ногдох ДНБ, оны үнээр (ам.доллар)	430	>1000
Хүний хөгжлийн		
Хүн амын дундаж наслалт	64.2	70 нас
Хүн амын өсөлт	1,5%	2-3 хувь
Хүн амын бичиг боловсролын төвшин: Бичиг үсэг тайлагдагсдын хувь	96,5%	100%
Ажилгүйдлийн төвшин	Бүртгэгдсэнээр 4,7% Далд ажилгүйдэл 24%	<6%

Эдийн засгийн аюулгүй байдлыг тодорхойлсон үзүүлэлтүүдийг дэлхийн дундажтай харьцуулсан судалгаанаас үзэхэд (1 дүгээр хүснэгт) манай эдийн засагт оршиж буй бэрхшээл, сул талууд Монгол Улсын “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д заасан гол хүчин зүйлүүдийг хангаж чадахгүй байгаа бөгөөд эдийн засгийн аюулгүй байдал алдагдаж байна гэсэн дүгнэлтэнд хүргэж байна [27.8].

#### **4. Шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал**

Шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал гэж өөрийн орны экологийн өвөрмөц нөхцөлд технологи болон мэдээлэл судалгааг улс орныхоо хөгжилд ашиглах, шинжлэх ухааны үндэсний чадамжийг дээшлүүлэх, оюуны үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг хангасан нөхцөл байдлыг хэлнэ. Шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөөлж болох дотоод хүчин зүйлсд үнэлэлт дүгнэлт өгвөл:

***Үндэсний оюуны чадавхи, мэргэжилтэй боловсон хүчнийг улс орондоо бүрэн ашиглаж чадахгүй байх асуудлаар:***

1998 оны байдлаар манай оронд нийт бэлтгэгдсэн эрдэмтдийн дотор шинжлэх ухааны доктор 12,4 хувь, дэд доктор 87,6 хувь байгаа бөгөөд эрдэмтдийн 46.4 хувь буюу 890 нь эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуульд ажиллаж байна. Гэвч манай улсад эрдэм шинжилгээний ажилтны тоо сүүлийн 10 жилд 1.5 дахин буурч, дундаж нас 40 гарч, 30 хүртэлх насны залуу ажилтны эзлэх хувийн жин 20 хувьд хүрчээ.

Мөн оны судалгаанаас үзэхэд манай эрдэм шинжилгээний байгууллагуудад лабораторийн шинжилгээ, туршилт-үйлдвэрлэлийн зориулалттай 1.1 тэрбум төгрөгийн өртөг бүхий 2000-аад нэр төрлийн 3000 орчим тоног төхөөрөмж суурилагдсан боловч эдгээрийн 50-иад хувь нь 1950-1980 онд, 30 гаруй хувь нь 1981-1990 онд, 18 хувь нь 1991 оноос хойшхи хугацаанд тус тус ашиглалтад оржээ [28.200-208].

## **5. Хүн ам, удмын сангийн аюулгүй байдал**

Хүн ам, удмын сангийн аюулгүй байдал гэж Монгол Улсын хүн амын эрүүл мэнд, удмын сан, тогтвортой өсөлт хадгалагдаж, хамгаалагдсан нөхцөл байдлыг хэлнэ. Хүн ам, удмын сангийн аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөөлж болох дотоод хүчин зүйлүүдэд үнэлэлт дүгнэлт өгвөл:

***Архидан согтуурах явдал газар авч хүн амын эрүүл мэнд, удмын санд сөрөг нөлөө үзүүлэх асуудлаар:***

Манай улсын хүн амын 51.2 хувь нь архийг байнга хэтрүүлэн хэрэглэдгээс найман хувийг нь эмэгтэйчүүд эзэлж байна. Одоогоор улсын хэмжээнд архинд донтох өвчтэй 12 мянган хүн байдаг ажээ. Сүүлийн 10 жилд архинд донтох өвчтөний тоо хоёр дахин өссөн байна. 2002 оны эхний 11 сард гарсан гэмт хэргийн 19.3 хувийг согтуугаар үйлджээ. Эрүүлжүүлэгдсэн иргэдийн тоо ч өмнөх оныхоос 11 хувиар өссөн байна [29.3].

Гэмт хэрэг үйлдэх нэг гол шалтгаан нь архидан согтуурах хорт зуршил ихээхэн газар авсантай шууд холбоотой. Насанд хүрсэн хүн амын бараг 10 шахам хувьтай тэнцэх тооны иргэд 1997 онд эрүүлжүүлэгдэж, гэр орноо орхин тэнүүчлэх болсон хүүхдүүдийн 80 гаруй хувьд нь архидалттай холбоотой таагүй нөхцөл нөлөөлсөн байна [30.14].

Гэмт хэрэг, архидалт, хээл хахууль болон хүний амьдрах орчинг муутгаж байгаа нийгмийн бусад үзэгдлийн язгуур шалтгааныг ажилгүйдэл, ядуурал нэмэгдэж, хүн амын амьжиргааны төвшин доройтож байгаатай холбон үзэж байгаа нь үндэслэлтэй юм.

***Хүн амын дунд өлсгөлөн, тураал газар авах, ундны болон цэвэр усны хангамж хомсдох, бохирдох асуудлаар:***

Сүүлийн таван жилд хөрсний усны төвшин доошлохын хамт нэлээд гол, горхи ширгэж хатав. Жилдээ усны нөөцийн дөрөвний нэг орчмыг айл өрх, үлдсэнийг нь мал аж ахуй, үйлдвэрийн газрууд хэрэглэдэг. Гэхдээ гэр хорооллынхон

болон орон сууцанд амьдрагсдын усны хэрэглээ хоорондоо маш их ялгаатай байна. Гэр хороололд нэг хүн өдөрт 8 литр ус хэрэглэдэг байхад орон сууцанд амьдарч буй хүнд 200 буюу түүнээс дээш литр ногдож байна.

Бохир усны байгууламжийн гуравны нэг нь ажиллагаагүй, мөн гуравны нэг нь хагас дутуу ажиллаж, олон сая шоо метр бохир усыг цэвэршүүлж чадалгүй гадагшлуулан орхиж байна. Үүний уршгаар хүн ам, үйлдвэр ихээхэн төвлөрсөн Туул, Ерөө, Орхон зэрэг томоохон голын сав газарт ус үлэмж хэмжээгээр бохирдож эхлээд байна.

Говийн ихэнх нутагт болон дорнодын тал газарт хөрсний усан дахь эрдэс бодис (фтор, кальци, магни)-ын хэмжээ хэт өндөр байгаа нь эдгээр нутагт оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна [17.40].

## **6. Экологийн аюулгүй байдал**

Экологийн аюулгүй байдал гэж байгаль, цаг уурын өөрчлөлт болон байгалийн нөөцийг зохистой ашиглах, хамгаалах бодлогын харьцаа алдагдсанаас хүний амьдрах орчин, эдийн засагт үүсэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх нөхцөл хангагдсан байдлыг хэлнэ. Экологийн аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөөлж болох дотоод хүчин зүйлүүд:

***Ургамлын нөмрөг ядуурч ойн нөөц хомсдон мөрөн, гол, нуур, газрын доорхи ус татарч ширгэх, нутаг бэлчээр гандан хуурайших байдлаар:***

Манай орны ой нь Төв Азийн хээр цөл, зүүн Сибирийн их тайгын зааг дээр дэлхийн усны гурван том ай савын хагалбарыг дагаж ургасан бөгөөд гол мөрний усыг зохицуулах, цуглуулах, хөрсийг элэгдэл, эвдрэлээс хамгаалах, уур амьсгалыг зөөлрүүлэх, хүлэмжийн хийг шингээх, амьтан, ургамлын амьдрах орчныг бүрдүүлэх, мөнх цэвдгийг тогтоон барих зэрэг байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах хамгаалалтын өндөр ач холбогдолтой эмзэг тогтоцтой систем юм.



2000 оны байдлаар манай улсын ойн сангийн талбай нь 18.3 сая га, үүнээс ой модоор бүрхэгдсэн талбай нь 12.9 сая га буюу нийт нутаг дэвсгэрийн 8.2 хувь бөгөөд заган ой, сөөг, торлогийг оруулахгүйгээр шилмүүст, навчит ойн талбай нь 10.5 сая га буюу 6.7 хувь байгаа нь НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас гаргасан жишгээр ойн нөөцөөр хомс орны тоонд хамрагдаж байна. Манай ойн нөөцийн хэмжээ 1.4 тэрбум гаруй шоометр бөгөөд ойн нөөцийн 58 хувь нь онцгой болон хамгаалалтын бүсийн ойд хамрагдаж байна.

Судалгаанаас үзэхэд 1940-2000 онд 43.8 сая шоометр модыг 320 гаруй мянган га газраас огтолж ашигласнаас гадна 1980 оноос хойш жилд дунджаар түймэрт 392.5 мянган га, хөнөөлт шавьж, өвчинд 101.1 мянган га талбайн ой тус тус өртсөн байна. Зөвхөн 1996-1997 онд 5.0 сая га талбайн ой түймэрт өртсөний дотор 500 гаруй мянган га талбайн ой түймэрт хүчтэй шатаж сэргэн ургах чадваргүй болжээ. Үүнээс үндэслэн ойтой талбайн дөрөвний нэг нь мод бэлтгэл, түймэр, хөнөөлт шавьж, өвчин зэрэг гадны хүчин зүйлийн нөлөөнд өртсөн тооцоо гарч байгаа юм [31.1193].

1971 оноос ойг нөхөн сэргээх ажлыг төвлөрсөн төлөвлөгөөгөөр зохицуулж ирсэн бөгөөд өнгөрсөн хугацаанд 88.7 мянган га талбайг ойжуулсан нь мод бэлтгэсэн талбайн 30 хүрэхгүй хувьтай тэнцэж байна. 1980-2000 онд жилд дунджаар 3.9 мянган га, 1996-1999 онд 4.6 мянган га, 2000 онд 9.0 мянган га талбайд ойг нөхөн сэргээх, ойжуулалтын ажил хийсэн байна. Гэвч хөрөнгийн эх үүсвэргүйгээс тарьц, суулгац ургуулах, цөлжилт, хөрсний элэгдэлтэй тэмцэх арга хэмжээ үлэмж хоцрогдож байна.

Ой мод устаж алга болсноор газар хөрсний эвдрэл даамжирч, чийгийн ууршилт нэмэгдэн, цас хунгарлалт багасч, газар нутаг цөлжилтөд автагдахад хүрдэг. Үүний зэрэгцээ хөрсний болон газар доорхи усны төвшинг бууруулж, газар тариалангийн үржил шимийг муутгадаг юм. Ой мод нь ядуурлыг бууруулах, ажлын байр болон орлого нэмэгдүүлэх, эрчим хүчээр хангах, гадаад валютын нөөц бий болгох зэрэг хөгжлийн асуудлууд болон ус, газрын хөрс, биологийн төрөл зүйлийг хамгаалах, хүлэмжийн хийг багасгах, цаг уурын өөрчлөлт зэрэг байгаль орчны хамгааллын асуудлуудтай

харилцан шүтэлцээтэй юм.

***Хаягдал ихтэй техник, технологи хуримтлагдах, хорттой хог хаягдал гаргадаг үйлдвэрлэл бөөгнөрөх, гадаад орны хорттой хог хаягдал булшлах газар болох асуудлаар:***

Хот суурин газрын хог хаягдал газрын хөрсийг бохирдуулж 1998 онд улсын хэмжээнд хог хаях газар 30 гаруй мянган хавтгай дөрвөлжин километр талбайг эзэлж байв [17. 39].

Даяаршил, харилцан хамаарлын эрин үед бүс нутгийн болон дэлхий нийтийн чанартай эрсдэлт сорилт, аюул занал шууд буюу шууд бусаар нөлөөлж байна. Ер нь даяаршлын үйл явцад тодорхой хэмжээгээр татагдан ороод байгаагаа мэдэрч байгаагийн хувьд төр засаг алсын хараатай бодлого боловсруулж хэрэгжүүлэх, хүн амаа бэлтгэх, даяаршлын “гол тоглогч” орнууд, “гол явцаас” хөндийрөхгүй байж сайн, ашигтай талуудыг нь үндэсний онцлог, ашиг сонирхолд нийцүүлснээр зөвхөн “тэсвэрлэн” үлдэх төдийгүй үр шимийг нь хүртэж улс орноо хөгжүүлэх, үүний хамт ялангуяа аюулгүй байдлын салбарт үзүүлэх сөрөг нөлөөлөл, үр дагаврыг багасгах нь тулгамдсан асуудал болж байна.

Иймээс дээрх асуудал нь Монгол Улсын төр, засгийн анхаарлын төвд байдаг. Тухайлбал, одоо төр барьж буй засгийн газар үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой дараахь асуудлыг өөрийн үйл ажиллагааныхаа тэргүүлэх чиглэл болгосон байна. Үүнд:

- Үндэсний үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэх, экспортод чиглэсэн үйлдвэрлэлийг дэмжих замаар эдийн засгийн өсөлтийг хангах;
- Хүний хөгжлийг хангах тэгш орчин бүрдүүлж, бүх шатны боловсролын чанар, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх;
- Ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, ард иргэдийн амьжиргааны төвшинг дээшлүүлэх;
- Тогтвортой хөгжил, экологийн тэнцвэрт байдлыг хангах байгаль орчны бодлогыг бүс нутгийн нийгэм-

эдийн засгийн хөгжлийн чиглэлтэй уялдуулан хэрэгжүүлэх;

- Томоохон хот, суурин газруудын агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулж, хог хаягдлыг дахин боловсруулах замаар иргэдийн амьдрах орчныг сайжруулах;

- Засаглалын хямралыг арилгаж, хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглалыг бүрдүүлэх;

- Шүүх засаглалын хараат бус бие даасан байдал, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангах замаар иргэн бүрийн үндсэн эрх, эрх чөлөө, ардчиллын тулгуур зарчмыг баталгаатай хамгаалсан өндөр ёс суртахуун бүхий иргэний ардчилсан нийгмийг төлөвшүүлэх [32. 851].

#### **Дөрөв. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл**

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуулийг Улсын Их Хурал 1992 оны 5 дугаар сард батлан гаргасан билээ [33. 45].

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл (ҮАБЗ) нь үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн нэгдмэл бодлого боловсруулах үйл ажиллагаа болон түүнийг хэрэгжүүлэх явдлыг уялдуулан зохицуулах, энэхүү зохицуулалт нь хэрхэн хангагдаж байгаад хяналт тавих төрийн зөвлөлдөх байгууллага юм.

Зөвлөл үйл ажиллагаандаа хууль дээдлэх, улс үндэснийхээ язгуур эрх ашгийг эрхэмлэн хамгаалах, эрх хэмжээнийхээ асуудлыг хамтран хэлэлцэж санал нэгтгэйгээр шийдвэрлэх зарчмыг баримтална. ҮАБЗ нь Улсын Их Хурал (УИХ)-аас баталсан Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тулгуурлан ажлаа явуулна.

Ингэхдээ ҮАБЗ нь тухайн үеийн байдлыг харгалзан үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг хэрэгжүүлэх стратеги, тактикийг уялдуулан зохицуулах үүргийг хүлээх бөгөөд үндэсний аюулгүй байдал хэрхэн хангагдаж байгаад хяналт тавьж, УИХ-д жил бүр мэдээлж байх үүрэгтэй байдаг.

Зөвлөл нь энгийн бүтэцтэй байх ба түүнд Зөвлөлийн гишүүд, нарийн бичгийн дарга, зөвлөх, илтгэгч, шинжээчийн хэсэг хамаарна.

Зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нар ордог.

ҮАБЗ-ийн нарийн бичгийн дарга нь Зөвлөлийн үндсэн чиг үүрэгт хамаарах асуудлаар судалгаа хийх, үнэлэлт, дүгнэлт гаргах, шийдвэрийн үндэслэлийг боловсруулах, биелэлтэд хяналт тавих ажлыг зохион байгуулж, Зөвлөлийн гишүүд бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь тусалж, тэднийг үндэсний аюулгүй байдлын талаарх судалгаа, мэдээллээр хангах дотоод ажлыг эрхэлнэ. Зөвлөлийн нарийн бичгийн даргыг Монгол Улсын Ерөнхийлөгч томилдог.

УИХ-ын дэд дарга, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, УИХ дахь нам, эвслийн бүлгийн ахлагч нар зөвлөлийн хуралдаанд зөвлөх эрхтэй оролцдог.

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, тусгай газар, ЗХЖШ-ын дарга нар Зөвлөлийн илтгэгч байх бөгөөд тэдгээр нь тус тусын хариуцсан салбар, хүрээнд үндэсний язгуур ашиг сонирхол, аюулгүй байдлыг хангахтай холбоотой асуудлыг судалж зохих илтгэл, санал, шийдвэрийн төслийг боловсруулан Зөвлөлд оруулж, гарсан шийдвэрийг эрхэлсэн салбар, хүрээндээ хэрэгжүүлэх ажлыг хариуцна.

Зөвлөлийн шинжээчээр өндөр мэргэшлийн эрдэмтэн, мэргэжилтнийг орон тооны ба орон тооны бус журмаар томилон ажиллуулна. Тэдгээр нь үндэсний аюулгүй байдлыг хангах тодорхой асуудлаар болон Зөвлөлийн шийдвэрийн төслийн талаар шинжилгээ, судалгаа хийж, мэргэжлийн дүгнэлт гаргаж, түүний үндэслэлийг хариуцна. Зөвлөлийн шинжээчийг Монгол Улсын Ерөнхийлөгч томилдог.

Зөвлөл нь үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд онцгой ач холбогдол бүхий чиглэл, дотоодын болон олон улсын үйл явдал зэрэг шаардлагатай гэж үзсэн асуудлаар ажлын хэсэг байгуулах, судалгаа явуулах эрдэм шинжилгээний бие даасан нэгжтэй байж болно.

ҮАБЗ-ийн тэргүүн нь Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Монгол Улсын Ерөнхийлөгч байдаг. Хууль тогтоомжид заасан үндэслэлээр ҮАБЗ-ийн бүрэлдэхүүнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болгосноор УИХ зохих өөрчлөлт оруулж болдог.

ҮАБЗ-ийн тэргүүн нь Зөвлөлийн ажлыг бүхэлд нь удирдаж, дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ Зөвлөлийн хуралдаанд хэлэлцэх асуудлыг тодорхойлж, хуралдааныг товлох, даргалах;

2/ Зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэмэгдүүлэх саналыг Улсын Их Хуралд оруулах;

3/ төрийн гадаад, дотоод бодлогыг хэрэгжүүлэхэд Зөвлөлийг төлөөлөх;

4/ Зөвлөлийн ажлын хэсэг байгуулж ажиллуулах.

ҮАБЗ ажлаа УИХ-ын өмнө хариуцдаг. Зөвлөл нь дараахь асуудлаар үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн нэгдмэл бодлого боловсруулах үйл ажиллагааг болон түүнийг хэрэгжүүлэх явдлыг уялдуулан зохицуулах, энэхүү зохицуулалтад хяналт тавих чиг үүрэгтэй:

1/ өөрийн орны улс төр, нийгмийн амьдралд дүн шинжилгээ хийж, Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдлыг бэхжүүлэх, Үндсэн хуулиар тодорхойлсон төр, нийгмийн байгууллыг бататгах, үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах, хүн ам, удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах;

2/ Монгол Улсын үндэсний баялгийг зүй зохистой ашиглах, үндэсний технологийг хамгаалж орчин үеийн ололтоор баяжуулан хөгжүүлэх, дэлхийн аж ахуйн хэлхээ холбоонд идэвхтэй, уян хатан оролцох зэргээр эдийн засгаа дотоод нөөц бололцоондоо тулгуурлан бие даан хөгжих чадавхийг нэмэгдүүлэх;

3/ үндэсний соёл иргэншил, оюуны өв уламжлал, чадавхийг хамгаалан хөгжүүлэх;

4/ Монгол Улсын байгалийн баялгаа эзэмших бүрэн эрх, экологийн аюулгүй байдлыг хангах;

5/ гадаад орон, олон улсын байгууллагатай төр, засгийн дээд хэмжээний хэлэлцээрийн үед баримтлах чиглэл, гадаад орон, олон улсын байгууллагад тодорхой асуудлаар төр, засгийн дээд хэмжээний байр сууриа илэрхийлэхдээ төрийн гадаад бодлогод нийцүүлж зөвлөлдөн тогтох;

6/ төрийн батлан хамгаалах бодлогыг тодорхойлж, зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгон бэхжүүлэх, улс төрийн гадаад нөхцөл байдлыг харгалзан төрийн цэргийн бодлогын үндсийн талаарх саналыг бэлтгэж, Монгол Улсын Ерөнхийлөгчөөр уламжлан УИХ-д өргөн мэдүүлэх;

7/ Монгол Улсын үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдлын эрх ашгийн үүднээс олон улсын нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, технологи, цэрэг, улс төрийн байдалд дүн шинжилгээ хийж, шаардлагатай арга хэмжээг тодорхойлох.

Зэвсэгт хүчний тухай хуульд заасны дагуу цэргийн дээд албан тушаалтан буюу Зэвсэгт хүчний Жанжин Штабын даргыг Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч нь УИХ-тай зөвшилцсөний үндсэн дээр томилдог.

Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу зөвхөн Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдэлдэг. Иргэд, бусад байгууллага хуулийн төслийн тухай саналаа хууль санаачлагчид уламжилна. Иймээс дээр дурдсан гурван субъектаас бусад аливаа субъект, түүний дотор Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, хууль санаачлах эрхгүй байдаг.

ҮАБЗ нь төрийн батлан хамгаалах бодлогыг тодорхойлж, Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгон бэхжүүлэх, улс төрийн гадаад нөхцөл байдлыг харгалзан төрийн цэргийн бодлогын үндсийн талаарх саналыг бэлтгэж, Монгол Улсын Ерөнхийлөгчөөр уламжлан УИХ-д өргөн мэдүүлэх үүрэгтэй. Түүнчлэн ҮАБЗ үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн дотоод, гадаад батлан хамгаалах бодлогын үндсийг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон онц чухал асуудлыг

шийдвэрлэхэд чиглэл өгөх эрхтэй байдаг.

ҮАБЗ энэхүү эрх, үүргийнхээ дагуу үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болох батлан хамгаалах бодлогыг тодорхойлсон “Монгол Улсын Төрийн цэргийн бодлогын үндэс” хэмээх тулгуур баримт бичгийг Монгол Улсын Их Хурлын 1998 оны 5 дугаар сард 56 тоот тогтоолоор батлуулан, мөрдүүлж байна.

Төрийн цэргийн бодлогын үндэс нь аливаа зэвсэгт түрэмгийлэлд төрөөс хандах хандлагыг тодорхойлох, дайн, зэвсэгт мөргөлдөөний аюулаас сэрэмжлэх, улс орноо гаднын зэвсэгт түрэмгийллээс хамгаалах, цэргийн байгуулалт, зэвсэгт тэмцэл явуулах талаар төрөөс баримтлах албан ёсны үзэл баримтлал бөгөөд өөрийгөө хамгаалах тухай Монгол Улсын Үндсэн хуулийн зарчимд тулгуурлана.

БХЯ болон аюулгүйн салбарын бусад байгууллагын төсөвт нэмэлт оруулах саналыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл бус батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Монгол Улсын Засгийн газар гаргах эрхтэй байдаг.

Зөвлөл нь хэлэлцэн зөвшилцөлд хүрсэн асуудлаар шийдвэр гаргах бөгөөд тэр нь зөвлөмжийн шинж чанартай байна. Зөвлөлийн шийдвэрийг үндэслэн түүний хүрээнд төрийн дээд, төв байгууллага, албан тушаалтан өөрийн чиг үүрэг, бүрэн эрхийнхээ дагуу холбогдох шийдвэр боловсруулан гаргаж зохих журмаар хэрэгжүүлнэ.

Монгол Улсын Ерөнхийлөгч нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүний хувьд ҮАБЗ-өөр хэлэлцэж гаргасан шийдвэрийг үндэслэн өөрийн бүрэн эрхийнхээ хүрээнд зарлиг гаргаж, үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон асуудлаар тодорхой арга хэмжээ авах талаар Засгийн газарт чиглэл өгөх эрхтэй байдаг.

ҮАБЗ-ийн зөвлөмжийн дагуу үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэхтэй холбогдсон олон арван хууль, үзэл баримтлал, үндэсний хөтөлбөрийг Монгол Улсын УИХ, Засгийн газар батлан гаргаж, тэдгээрийг

хэрэгжүүлэх арга хэмжээ авч байгаа юм.

Эдгээрээс Сүүлийн үеийн томоохон амжилт бол Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үндсэн зарчим, үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааг уялдуулан зохицуулахтай холбогдсон харилцааг зохицуулах асуудлыг хуульчлан тогтоосон “Үндэсний аюулгүй байдлын тухай” хуулийг УИХ 2001 оны 12 дугаар сард баталсан явдал билээ [34.58].

Энэ хуулийн ач холбогдол, шинэлэг зүйлийг дараахь байдлаар тайлбарлаж болох юм:

1. Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үндсэн зарчмыг тодорхойлсон:

- 1/ улс, үндэснийхээ язгуур ашиг сонирхлыг эрхэмлэх;
- 2/ хүний эрх, эрх чөлөөг хамгаалах;
- 3/ хууль дээдлэх;
- 4/ нэгдмэл, харилцан уялдуулан зохицуулагдсан байх;
- 5/ шуурхай, тасралтгүй байх;
- 6/ бодит мэдээлэлд үндэслэх;
- 7/ төрийн байгууллага, иргэд харилцан хариуцлага хүлээх;
- 8/ үндэсний эв нэгдлийг эрхэмлэх;
- 9/ нээлттэй байх.

2. Улс төрийн нам, эвсэл, төрийн бус байгууллага, Монгол Улсын иргэн үндэсний аюулгүй байдлыг хангах талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд идэвхитэй оролцохыг хуульчилсан.

3. Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудыг тодорхойлсон:

- 1/ Байгаль орчныг хамгаалах алба;
- 2/ Гаалийн алба;
- 3/ Дипломат алба;
- 4/ Иргэний хамгаалалтын алба;
- 5/ Мэргэжлийн хяналтын алба;



- 6/ Зэвсэгт хүчин, бусад цэрэг;
- 7/ Татварын алба;
- 8/ Тусгай алба.

4. Үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавихад төрийн дээд болон төв байгууллага, албан тушаалтан, нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэний оролцоог тодорхойлсон.

5. Үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон мэдээлэл харилцан солилцох, зөвлөлөөс гарах шийдвэрийн төсөл боловсруулахад туслах болон гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх асуудлаар зөвлөлдөх төрийн байгууллага хоорондын орон тооны бус байнгын ажлын хэсгийг ҮАБЗ-ийн дэргэд байгуулахыг заасан. Үүнд:

- 1/ Гадаад бодлогын;
- 2/ Мэдээллийн аюулгүй байдлын;
- 3/ Мэргэжлийн хяналтын;
- 4/ Тусгай албадын;
- 5/ Цэргийн бодлогын;
- 6/ Шашны асуудлын;
- 7/ Эдийн засгийн бодлогын;
- 8/ Экологийн бодлогын.

Монгол Улсын ҮАБЗ-ийн талаар Үндсэн хууль болон бусад хууль, тогтоомжид орсон заалтуудыг тусгайлан түүвэрлэсэн эмхтгэл ч байдаг.

#### **Тав. Хүн хүчний бүрдүүлэлт: Аюулгүйн салбарт ажиллах хүн хүч**

Монголын Зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд монголын нийгмийн бүх давхаргын төлөөлөгчид ордог. Монголын цэрэг иргэн хоёр түүхийн урт удаан хугацаанд гүн бат холбоотой байж эх орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнолыг хамтын хүчээр хамгаалж ирсэн цэрэг-иргэний энэ холбоо нь Зэвсэгт хүчний чадвар, бэлэн байдлыг нэмэгдүүлж, бэхжүүлэх гол үндэс нь болж байгаа юм.

Зэвсэгт хүчний хөгжил нь эдийн засаг, тогтвортой хөгжил, эрүүл саруул өрсөлдөөн, төр засаг, ард иргэдийн оролцоо, дэмжлэг, харилцан үүрэг хүлээсэн эрх зүйн бат бэх суурь дээр тулгуурладаг.

Зэвсэгт хүчин төрийн онцгой чухал институт учраас бүх үйл ажиллагаа нь төрийн хяналт, зөвхөн хуулийн хүрээнд явагдах ёстой гэж үздэг.

Цэргийн алба нь цэргийн жинхэнэ болон бэлтгэл албанаас бүрддэг.

Монгол Улсын иргэн зэвсэгт хүчинд цэргийн үүрэг гүйцэтгэхийг цэргийн жинхэнэ алба, цэргийн жинхэнэ алба хааж байгаа иргэнийг хуулиар цэргийн албан хаагч гэж үздэг.

Цэргийн жинхэнэ алба нь байлдагч, түрүүчийн алба, ахлагчийн, офицерын албанаас бүрэлдэж байна.

Офицер, ахлагчийн цэргийн алба хаах журмыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтоож өгдөг.

Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний 64,4 хувь нь хугацаатай алба хааж буй байлдагч, түрүүч нар, 3,5 хувь нь цэргийн сургуулийн сонсогчид, 32,1 хувь нь байнгын бүрэлдэхүүн болох офицер, ахлагч, гэрээт цэргүүд юм.

Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний гуравны хоёрыг бүрдүүлж байгаа ахлагч нарын мэргэжлийн ур чадвар, бэлтгэлд онцгой анхаарч тэдний тоог нэмэгдүүлэх чиглэл баримталж байна.

Байлдагч түрүүчийн алба нь хугацаат цэргийн алба, гэрээт цэргийн албанаас бүрддэг. Монгол Улсын иргэн нь Зэвсэгт хүчний ангиудад сайн дурын үндсэн дээр байлдагч түрүүчийн албыг гэрээгээр хааж болдог.

Гэрээгээр алба хаах хугацаа 24 сар, байлдагч түрүүчийн хугацаат цэргийн алба хаах хугацаа 12 сар байдаг.

Цэргийн сургуулийн сонсогчдын цэргийн сургуульд суралцсан хугацааг цэргийн жинхэнэ алба хаасанд тооцдог.

Цэргийн албан хаагч эх орон, ард түмэндээ үнэнч байхаа баталж, цэргийн тангараг өргөдөг. Цэргийн албанд татах хүчний тоог Засгийн газар жил бүр Монгол Улсын Ерөнхийлөгчтэй зөвшилцөн тогтооно.

Байлдагч түрүүчийн жинхэнэ албанд 18-25 насны иргэнийг татах бөгөөд 27 нас хүртэл алба хааж болно.

Ахлагчийн албыг 45 нас хүртэл хаана. Офицерын албыг дунд офицер 45 нас, ахлах офицер 50 нас, дээд офицер 55 нас хүртэл хааж болно.

Цэргийн сургуульд 17 нас хүрсэн иргэн сонсогчоор элсэнэ.

Иргэний цэргийн үүрэг, цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулиар эмэгтэйчүүд сайн дурын үндсэн дээр офицер, ахлагчийн албыг 45 нас хүртэл хааж болдог. Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний арван офицерын нэг нь эмэгтэй албан хаагч байна.

Байлдагч, түрүүчийн алба хаасан эрэгтэйчүүд 45 нас хүртэл, цэргийн бэлтгэл албанд байгаа дээд офицер 60 нас, бусад офицер, ахлагч нар 55 нас хүртэл, цэрэгт бүртгэлтэй мэргэжил бүхий эмэгтэйчүүд цэргийн тоо бүртгэлд байж дайчилгааны сургууль цугларалтаар болон хуульд заасан бусад үүрэг гүйцэтгэхийг цэргийн бэлтгэл алба гэнэ.

Цэргийн бэлтгэл алба нь нэг, хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтний албанаас бүрддэг. Цэргийн жинхэнэ алба хаасан иргэнийг нэгдүгээр зэргийн цэргийн бэлтгэл үүрэгтэн, бэлтгэлд байгаа цэргийн албанд байсан эрэгтэйчүүд, мөн цэрэгт бүртгэлтэй мэргэжил бүхий эмэгтэйчүүдийг хоёрдугаар зэргийн цэргийн бэлтгэл үүрэгтэн гэнэ. Бэлтгэл үүрэгтний цэргийн бэлтгэлийг дээшлүүлэх зорилгоор тэднийг дайчилгааны сургууль, цугларалтад татан оролцуулдаг.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн шийдвэрээр цэргийн

бэлтгэл үүрэгтнийг цэргийн албанд татаж гурван сар хүртэл хугацаагаар үүрэг гүйцэтгүүлдэг.

Хүний эрх, эрх чөлөө, шашин шүтлэг, ёс зүйн шалтгаанаар цэргийн насны болон цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэг бүхий иргэн өөрийнхөө хүсэлтээр иргэний хамгаалалтын мэргэжлийн анги, байгалийн гамшигтай тэмцэх салбар, хилийн цэрэгт туслах хүчин болон хүмүүнлэгийн бусад байгууллагад цэргийн албыг хуулийн дагуу дүйцүүлэн хааж болдог.

Уг албыг хаах хугацаа 24 сар байна. Алба хаах хугацааг Засгийн газар гурав хүртэл сараар сунгаж болно.

Байлдагч, түрүүчийн алба хаагаагүй иргэн хуулиар тогтоосон хугацаат цэргийн албыг биеэр хаагаагүйн төлөө мөнгөн төлбөрийн хэлбэрээр цэргийн дүйцүүлэх албыг орлуулан хааж болдог. Уг албыг иргэн мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзлыг Улсын Их хурал баталж, мөнгөн төлбөрийн хэмжээг Засгийн газар жил бүр шинэчлэн тогтоож байна.

Цэргийн албан хаагч нь иргэдийн нэгэн адил Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу хүний эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлж, эрх зүйн этгээд байдаг.

Зэвсэгт хүчний зориулалт, цэргийн албаны онцлогтой холбогдуулан тэдэнд эрх зүйн байдлын зарим хязгаарлалт, хөнгөлөлт давуу байдлыг хуулиар тогтоож өгсөн байдаг.

Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдалд: Монгол Улсын Зэвсэгт хүчний албан хаагчид, дайчилгааны сургууль, цугларалтад оролцож байгаа цэргийн үүрэгтнүүд хамаардаг.

Төрийн цэргийн бодлогоор тайван цагт зэвсэгт хүчин олон талт чиг үүрэг гүйцэтгэх болж, эдгээр чиг үүрэгт цэргийн бус шинжтэй чиг үүрэг давамгайлах болов.

Зэвсэгт хүчнийг мэргэжлийн чиг баримжаатай болгон чадваржуулах нь тулгамдсан зорилт бөгөөд мэдээллийн эринд цэргийн албан хаагчдын мэдлэг, боловсролд тавигдах

шаардлага нэмэгдэж, цэргийн сургалтанд эдгээр хүчин зүйлийг харгалзан үзэж байна.

**Цэргийн албан хаагч дараахь үйл ажиллагааг явуулахыг хуулиар хориглоно:**

- Цэргийн албан хаагч улс төрийн зорилгоор эвлэлдэн нэгдэх, улс төрийн үйл ажиллагаа явуулдаг эвсэл, холбооны гишүүн байх;
- Төрийн бодлого, цэргийн удирдлагын шийдвэр, захирагч даргын тушаалыг эсэргүүцэх;
- Захирагч, даргын зөвшөөрөлгүйгээр цэргийн дүрэмд зааснаас бусад жагсаал, цуглаан зохион байгуулах, түүнд оролцох;
- Байлдагч, түрүүч нь цэргийн жинхэнэ алба хаах хугацаандаа цэргийн анги, байгууллагын зохион байгуулснаас бусад сургууль, дамжаанд суралцах;

Эдүгээ цэргийн сургалтанд байнгын бүрэлдэхүүний сургалтыг чухалчлан анхаарч болно.

Батлан хамгаалах салбарын дээд, тусгай мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх болон эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг Батлан Хамгаалахын Их Сургууль (БХИС)-д төвлөрүүлж байна.

БХИС нь Батлан хамгаалах удирдлагын Академи, Цэргийн дээд сургууль, Иргэний боловсролын дээд сургууль, Ахлагч бэлтгэх коллеж, Цэргийн хөгжмийн коллеж, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн зэргээс бүрдэж байна.

Батлан хамгаалах удирдлагын Академид ерөнхий цэргийн стратеги, тактик, цэргийн удирдлагын мэргэжлээр цэргийн дээд боловсролтой, цэргийн шинжлэх ухааны магистр зэрэгтэй офицер; Цэргийн дээд сургуульд төрийн захиргааны удирдлага, радио цахилгаан, радио электроник, автын ашиглалт, зам гүүр, барилгын машин механизмын инженер зэрэг ес гаруй мэргэжлээр мөн цэргийн 10 гаруй мэргэжлээр дипломын дээд боловсролын сургалт явуулж,

энгийн цэргийн хосолсон дээд боловсролтой төрлийн цэргийн офицер; Иргэний боловсролын дээд сургуульд эдийн засаг, хууль эрх зүйч, төрийн захиргаа зэрэг мэргэжлээр; Ахлагч бэлтгэх төвд цэргийн бага мэргэжилтнийг 30 орчим мэргэжлээр, Цэргийн хөгжмийн дээд сургуульд цэргийн хөгжмийн удирдаач, хөгжимчин мэргэжлээр тус тус бэлтгэж байна.

Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн нь батлан хамгаалах бодлого судлал, цэрэг, иргэний харилцаа, цэргийн онол-урлаг, цэргийн зэвсэг техник-туршилт зохион бүтээх, цэргийн түүх судлалын чиглэлүүдээр судалгаа явуулдаг.

Зэвсэг хүчинд алба хааж буй байлдагч, түрүүч нар тус бүр 5,5 сарын хугацаатай хоёр үе шаттай сургалтанд хамрагддаг. Эхний шатанд байлдагч, түрүүч нартай бага мэргэжилтний сургалт явуулж, цэргийн мэргэжил эзэмшүүлээд дараагийн шатанд салбарын байлдааны жигдрэлтийн сургалтанд хамруулан тоот, экипажид байлдааны үүрэг гүйцэтгэх чадвартай болгож, нэгдүгээр зэргийн цэргийн бэлтгэл үүрэгтнээр жинхэнэ албанаас хална.

Цэрэг, иргэний харилцаанд гол нөлөө үзүүлдэг нэг хүчин зүйл бол цэргийн салбарт ажилладаг энгийн ажилчин албан хаагчид байдаг.

Цэргийн салбарт ажилладаг энгийн ажилчин албан хаагчид Зэвсэгт хүчний үйл ажиллагаа, бодит байдлыг ард түмэнд түгээн сурталчлагчид байдаг.

Зэвсэгт хүчинд ажилладаг энгийн ажилчин албан хаагчид нь цэргийн албаны онцлогоос шалтгаалан илүү цагаар ажиллахын зэрэгцээ, ажлын шаардлагаар байнгын бүрэлдэхүүний хамт олон хоног, сараар, цаг агаарын болон сэтгэл зүйн хүнд нөхцөл байдалд хээрийн дадлага, сургуульд ч тогтмол оролцдог.

Түүнчлэн тэд цэргийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулахад чиглэсэн, хангалт,

үйлчилгээний нийтлэг ажил, албанаас гадна Зэвсэгт хүчинд шаардлагатай зарим албыг гэрээгээр хашиж, цэргийн нууц материалтай тодорхой хязгаарлалттайгаар харьцах ба зарим хэсэг нь байлдааны зэвсэг, техник галт хэрэгсэлтэй харьцаж, тэдгээрийг хадгалах, хамгаалах, засварлах зэрэг хүнд бөгөөд аюултай орчинд ажилладаг.

Монгол Улсын аюулгүй байдлын орчин харьцангуй тогтвортой болж, учирч болох цэргийн аюулын төсөөлөл бүдгэрч, хөрш орнуудтайгаа найрсаг, хамтын ажиллагаа явуулж байгаа нь Зэвсэгт хүчний байгуулалтыг өөрөөр авч үзэхэд хүргэсэн юм.

Өнөөдөр Монголын төрөөс аюулгүй байдал, батлан хамгаалах салбарт энгийн ажилчин албан хаагчдыг түлхүү ажиллуулах, цэрэг-армийг иргэншүүлэх бодлого явуулж байгаа үед улс орныг батлан хамгаалахад тэдний оруулах хувь нэмэр, үүрэг оролцоо нэмэгдэж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 34 дүгээр зарлигаар батлагдсан “Цэргийн байгуулалтыг 2005 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-т офицерүүдийн зарим албан тушаалын орон тоог ахлагчийн болон энгийн орон тоонд шилжүүлэх, цэргийн мэргэжил зайлшгүй шаардахгүй албан тушаалуудад энгийн иргэдийг ажиллуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх арга хэмжээнүүд авч хэрэгжүүлэхийг тус тус заасны дагуу офицерийн зарим албан тушаал, тухайлбал цэргийн анги, байгууллагын санхүүгийн дарга нар, зарим мэргэжлийн эмч, багш, мэдээллийн техникийн ажилтнууд зэрэгт иргэний их, дээд сургууль төгссөн энгийн албан хаагчдыг авч ажиллуулах арга хэмжээг авч эхлээд байна.

Зэвсэгт хүчний өөрчлөлтийн хүрээнд хийгдэж байгаа эдгээр арга хэмжээний дүнд түүнд ажиллах энгийн ажилчин, албан хаагчдын тоо улам өсөх төлөвтэй байна.

Иймд БХЯ-аас “Зэвсэгт хүчинд ажиллаж байгаа энгийн албан хаагчдын эрх зүйн байдлын тухай хууль” боловсруулж гаргахаар ажиллаж байна.

Энэ хуулийн төсөл нь цэргийн байгууллагад ажиллаж буй энгийн ажилчин, албан хаагчийн зарим эрхийг цэргийн

албаны онцлогтой уялдуулан хязгаарлах, үүнээс үүсэх хөдөлмөрийн харилцааг зохицуулахад оршиж байгаа юм.

Аюулгүй байдлын салбарт ажилладаг энгийн албан хаагчдыг элсүүлэх, сонгох, дэвшүүлэх, халах үйл ажиллагааг Монгол Улсын хөдөлмөрийн болон төрийн албаны хуулиудаар зохицуулдаг.

Монгол Улсын Үндсэн хуулиар Монгол Улсын иргэн нь сурч боловсрох, ажиллах эрхтэйгээс гадна ажлын байраа өөрөө сонгох эрхтэй байдаг.

Аюулгүйн салбарт ажиллагсдыг төрийн улс төрийн албан хаагч, төрийн захиргааны албан хаагч, төрийн тусгай албан хаагч, төрийн үйлчилгээний албан хаагч гэсэн зэрэглэлүүдэд хуваан авч үздэг бөгөөд тэдгээрийн цалин хангамжийг Монгол Улсын Засгийн газраас тусгайлсан сүлжээгээр ажлын туршлага, албан тушаал, ажилласан хугацаа зэргийг харгалзан тогтоож өгдөг.

Цэргийн албан хаагчдыг төрийн тусгай албан хаагчид, энгийн ажилчдыг төрийн үйлчилгээний албан хаагчид гэсэн зэрэглэлд багтааж үздэг.

Батлан хамгаалах салбарт ажилладаг энгийн албан хаагчид нь сурч боловсрох, курс дамжаанд явах, бакалавр, магистр, докторын сургалтанд хамрагдах өргөн боломжтойгоос гадна, шаардлагатай тохиолдолд тэдний сургалтын зардлыг ажиллаж байгаа байгууллагаас нь хөнгөвчилдөг.

Энгийн ажилчин, албан хаагчдын өөрсдийнх нь хүсэл сонирхлыг харгалзан үзэж дээд боловсролтой тэргүүний хүмүүсийг ахлагч, офицерийн дамжаанд сургаж бэлтгэн, мэргэжлийн офицер, ахлагч болгодог.

Цэргийн байгууллагад ажиллагсад нь үнэ төлбөргүй эмчлүүлэх эрхтэйгээс гадна, тэдний нэг хүүхдийн сургалтын төлбөрийг төр хариуцдаг.

Ажиллагсад нь тусгай техник, хортой хүнд нөхцөл байдлаасаа хамаарч онцгой нөхцлийн нэмэгдлийг авдаг.



Энгийн ажилчин албан хаагчид нь ахлагч, офицер нарын нэгэн адил жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамрагддаг.

Батлан хамгаалах салбарын төв аппаратын бие бүрэлдэхүүний 60-70 орчим хувь нь өнөөдөр албан тасалгааныхаа дотоод сүлжээгээр дамжин интернетэд холбогдох боломжоор хангагдсан байна.

Батлан хамгаалахын сайд, ЗХЖШ-ын дарга нар батлан хамгаалах болон цэргийн байгуулалтын бодлого, үйл ажиллагааны хэрэгжилтийн асуудлаар Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн хувьд Монгол Улсын Ерөнхийлөгчид илтгэл, мэдээлэл хийх зэрэг хэлбэрээр харилцдаг.

Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь өөрийн эрхлэх чиг, үүргийн хүрээнд Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газартай байнга холбоотой ажилладаг.

Батлан хамгаалахын сайд УИХ-д тус салбарын үйл ажиллагааны талаар жилд хоёроос доошгүй удаа мэдээлэл хийдэг.

Монгол Улсын Ерөнхийлөгч Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн санаачлагаар гурван жил тутамд “Зэвсэгт хүчний удирдах ажилтны зөвлөлгөөн”-ийг зохион байгуулж хийдэг бөгөөд хүчний байгууллагуудын үйл ажиллагаанд дүгнэлт өгч цаашдын зорилтыг тодорхойлдог.

Улсын Их Хурал, аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хорооны гишүүд батлан хамгаалах салбарын хууль тогтоомжийн биелэлт, цэргийн анги, байгууллагын үйл ажиллагаатай тусгай төлөвлөгөөний дагуу танилцдаг.

УИХ-ын хувьд үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалахтай холбоотой засгийн газраас оруулсан хууль тогтоомжийн төслийг УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хуралдаанаараа авч хэлэлцдэг журамтай. Хэрвээ тус байнгын хороо сайшаавал УИХ-ын чуулганы хуралдаанд оруулж хэлэлцүүлдэг.

Батлан хамгаалах салбарын боловсон хүчнийг бэлтгэх, тэдний мэдлэг, боловсролыг дээшлүүлэх бодлогын хүрээнд ажилтнуудыг дотоод, гадаадын төрөл бүрийн сургалт, семинарт боломжийн хэрээр оролцуулдаг. Хоёр талын гэрээ, хэлэлцээрийн дагуу зардлыг нь нөгөө тал хариуцаж буй гадаадын өндөр хөгжилтэй орнуудын сургалт, семинарт ажилтнуудыг ихэвчлэн хамруулдаг. Тухайлбал, ОХУ, БНХАУ, АНУ, ХБНГУ, Япон, Турк, Энэтхэг, Швейцар зэрэг 10-аад оронд хэлний дамжаанаас эхлээд Жанжин Штабын Академийн хүртэл төвшингийн сургууль, дамжаанд сүүлийн 3 жилийн байдлаар жил бүр дунджаар 70 офицер, албан хаагч хамрагдсан байна. Мөн төрөл бүрийн бага хурал, симпозиум, семинарт сүүлийн жилүүдэд АНУ-д 300 гаруй хүн ямар нэг шатны сургалт, дамжаанд хамрагдсан.

БХЯ-ны ажилтнууд нь харъяа агентлаг, байгууллага, аж ахуйн нэгж, ЗХЖШ, ЗХ-ний анги, салбарт албан үнэмлэхээ үзүүлэн чөлөөтэй нэвтрэх эрхтэй байдаг. Хэрвээ БХЯ-наас томилогдсон ажлын хэсэг, комисс нь шалгах, зөвлөх зорилготой бол ажлын тодорхой удирдамжтай байна.

Монголын нийгмийн улс төрийн тогтолцоо, төрийн байгууллагуудын хоорондын харилцаа, хамаарал, Зэвсэгт хүчний нийгэмд эзэлж буй байр суурь, олон нийтийн санал бодлын үнэлэмж зэргээс харахад цэрэг, иргэний харилцаа нь төлөвшин бүрдэх үндэс тавигдсан байна гэж дүгнэж болохоор байна.

Өрнөдийн төлөвшиж тогтсон нийгмийн байгуулал дахь цэрэг-иргэний харилцааны систем нь манай улсад монгол үндэсний онцлог байдалтай уялдан хөгжиж байна.

## **АШИГЛАСАН НОМ, БҮТЭЭЛ, СУРВАЛЖ, СУДАЛГААНЫ МАТЕРИАЛ**

1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, УИХ-ын 1994 оны 56 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт. “Ардын эрх” сонин, 1994.07.26. № 145.
2. Л.Моломжамц. Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, болзошгүй аюул заналын тухай. БХЯ-ны удирдах офицеруудад уншсан лекц, 2002 он.
3. Л.Моломжамц. “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын шинжлэх ухааны үндэслэл” сэдэвт эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэл. Эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. “Өнгөт хэвлэл”, Улаанбаатар, 2001 он.
4. Монгол Улсын Үндсэн хууль, “Төрийн мэдээлэл” сэтгүүл, 1992 он, № 1 (7).
5. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын тухай илтгэл 2002 он. “Төрийн мэдээлэл” сэтгүүл. 2002 он. №38 (275).
6. “Авилгалтай тэмцэх үндэсний хөтөлбөр”. “Төрийн мэдээлэл” сэтгүүл. 2002 он. № 28 (265)
7. “Зууны мэдээ” сонин. 2003.01.28. № 23 (1221).
8. Д.Мягмар. “Монголын ардчилал ба цэрэг армийн тухай бодол эргэцүүлэл”. 1997 он. УБ
9. Д.Мягмар “Монголын нийгмийн шинэчлэлт ба аюулгүй байдал, цэрэг армийн тухай бодол эргэцүүлэл”. 2001 он. УБ
10. Д.Мягмар “Батлан хамгаалах салбар, зэвсэгт хүчний шинэчлэлийн тухай бодол эргэцүүлэл” 2002 он. УБ
11. Л.Моломжамц “Иргэний хяналтын монгол хувилбарын тухайд” ССХ. 1994 он №1. УБ
12. Д.Доржготов “Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналт” БХУА-ийн лекц. 1999. УБ
13. “Зууны мэдээ” сонин. 2003.02.18. № 40 (1238).
14. “Зууны мэдээ” сонин. 2003.01.18. № 15 (1213).
15. “Зууны мэдээ” сонин. 2003.03.05. № 53 (1251).
16. “Мал сүргийг ган, зудаас хамгаалахад туслах үндэсний хөтөлбөр”. “Төрийн мэдээлэл” сэтгүүл. 2001 он. № 17 (204).
17. Монголын хүний хөгжлийн илтгэл 2000 он.
18. “Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”.

“Төрийн мэдээлэл” сэтгүүл. 2002 он. № 33 (270).

19. “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах үндэсний хөтөлбөр”. “Төрийн мэдээлэл” сэтгүүл. 2001 он. № 36 (223).

20. “Нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр”. “Төрийн мэдээлэл” сэтгүүл. 2002 он. № 9 (246).

21. Монгол Улсын эдийн засаг нийгмийн хөгжил 2001 онд, Санхүү Эдийн засгийн Яам, 2002 он, УБ.

22. Монгол Улсын статистикийн эмхтгэл 2000, 2001 он, УБ.

23. Гадаад худалдааны гаалийн статистикийн мэдээлэл, 2002 он, УБ.

24. Монгол Улсын Засгийн Газраас олон улсын банк санхүүгийн байгууллагуудтай тохиролцсон бодлогын баримт бичиг, Санхүү Эдийн засгийн Яам, 2001 он, УБ.

25. “Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих” үндэсний хөтөлбөр. “Төрийн мэдээлэл” сэтгүүл. 2001 он. №29 (216).

26. Ц.Тогоо. “Цэргийн албан хаагчдын нийгмийн хамгааллын байдалд хийсэн дүн шинжилгээ, зангилгаа асуудлууд”, “Цэргийн албан хаагчдын нийгмийн хамгааллын тулгамдсан асуудлууд” сэдэвт онол, практикийн бага хуралд тавьсан илтгэл. “Т&У” ХХК, Улаанбаатар хот. 2002 он.

27. Д.Азжаргал. “Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдалд гадаадын зээл нөлөөлөх нь” магистрын зэрэг горилсон дипломын ажил. МУИС-ийн Олон улсын харилцааны сургууль. 2003 он.

28. “Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийг 2010 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”. “Төрийн мэдээлэл” сэтгүүл. 2001 он. № 8 (195). 200-208.

29. “Зууны мэдээ” сонин. 2002.11.30. № 288 (1174).

30. Н.Багабанди. Үндэсний аюулгүй байдал олон талтай. “Т&У” хэвлэх үйлдвэр, Улаанбаатар хот. 2001 он.

31. Ойн тухай үндэсний хөтөлбөр. “Төрийн мэдээлэл” сэтгүүл, 2001 № 50 (237).

32. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, “Төрийн мэдээлэл” сэтгүүл. 2000 он. № 49 (186).

33. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Улаанбаатар хот, “Т&У” Хэвлэх үйлдвэр, 2002 он.

34. Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, “Төрийн мэдээлэл” сэтгүүл. 2002 он. № 3 (240). Улаанбаатар хот.

1 дүгээр хавсралт  
Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль,  
тогтоомжид үндэсний аюулгүй байдлын үзэл  
баримтлалыг хэрэгжүүлэхтэй холбогдсон заалтууд

## **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ**

### **Тавдугаар зүйл.**

4. Төр үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.

### **Зургадугаар зүйл.**

4. Төр газрын эзэнд газартай нь холбогдсон үүрэг хүлээлгэх, ... уг газрыг ... үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашиглавал хураан авч болно.

### **Арван нэгдүгээр зүйл.**

1. Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн.

### **Арван зургаадугаар зүйл.**

Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:

2/ эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй;

10/ ... нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ ...

17/ ... улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал ... хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;

18/ ... гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, ... хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно.

### **Арван наймдугаар зүйл.**

5. Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд заасан Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харъяалалгүй хүнд эдлүүлэхдээ ... үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд хуулиар зохих хязгаарлал тогтоож болно.

**Арван есдүгээр зүйл.**

3. Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй.

**Гучин наймдугаар зүйл.**

2. Засгийн газар ... дараахь үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

б/ ... үндэсний аюулгүй байдлыг хангах.

***МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУХАЙ ХУУЛЬ***

**13 дугаар зүйл.**

Үндэсний аюулгүй байдлыг хангах, улсыг батлан хамгаалах талаарх Ерөнхийлөгчийн бүрэн эрх:

13.3. Үндэсний аюулгүй байдлыг хангах эрх ашгийн үүднээс шаардлагатай гэж үзвэл улсын аюулгүй байдлыг хангах байгууллагын тодорхой үйл ажиллагаатай танилцаж, мэдээлэл авна.

13.4. Батлан хамгаалах, улсын болон эдийн засаг, экологийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий байгууллагын эрх баригчдын илтгэл, мэдээллийг сонсоно.

13.5. Цэргийн номлол, зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалтыг Засгийн газартай тохиролцон тодорхойлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

13.6. Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болбол Улсын Их Хурлын чөлөө цагт, хойшлуулшгүй тохиолдолд, улсын нийт нутаг

дэвсгэрт буюу зарим хэсэгт нь онц болон дайны байдал зарлах, түүнчлэн цэрэг хөдөлгөх захирамж өгнө...

### **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬ**

#### **17 дугаар зүйл.**

2. Байнгын хороо дараахь эрхлэх асуудлын хүрээнд бүрэн эрхээ хэрэгжүүлнэ:

- 1/ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо:
  - Монгол Улсын үндэсний аюулгүй байдал;
  - Монгол Улсын аюулгүй байдлыг хангах бодлого;
  - Монгол Улсын батлан хамгаалах, зэвсэгт хүчин;
  - Төрийн нууцын хадгалалт, хамгаалалт;
  - Монгол Улсын хил, түүний хамгаалалт;
  - Гадаад бодлого;
  - Гадаадад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох асуудал;
  - Монгол Улсын олон улсын гэрээ, Монгол Улсын олон улсын байгууллагад элсэх тухай асуудал.

#### **19 дүгээр зүйл.**

1. Улсын Их хурал зохих байнгын хороонд харъяалагдах дор дурдсан дэд хороотой байна:

- 1/ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд:
  - Тусгай хяналтын.
4. Дэд хороод дараахь асуудлыг эрхэлнэ:
  - 1/ Тусгай хяналтын дэд хороо:
    - Монгол Улсын аюулгүй байдал;
    - төрийн нууцын хадгалалт, хамгаалалт;
    - тагнуул болон гүйцэтгэх ажлын талаарх хууль тогтоомжийн биелэлт;
    - улсын хил хамгаалалт;
    - төрийн тусгай хамгаалалт.

### **ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬ**

#### **8 дугаар зүйл.**

Эдийн засгийн хөгжил, шинжлэх ухаан, технологийн

нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх талаарх засгийн газрын бүрэн эрх:

8.5. Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

**11 дүгээр зүйл.**

Хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах талаарх Засгийн газрын бүрэн эрх:

11.2. ... экологийн аюулгүй байдлыг хангах ...

**13 дугаар зүйл.**

Улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангах талаарх Засгийн газрын бүрэн эрх:

13.1. Улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангах болон цэргийн бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

13.2. Зэвсэгт хүчнийг бэхжүүлэх арга хэмжээ авна.

13.3. Улсын хилийг хамгаалах ажлыг чиглүүлэн хэрэгжүүлнэ.

13.4. Үндэсний аюулгүй байдлыг хангах арга боловсруулж хэрэгжүүлнэ.

13.5. Улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангахад зайлшгүй шаардагдах материаллаг нөөцийн санг бүрдүүлэх, нөхөн сэлбэх арга хэмжээ авна.

13.6. Төрийн нууцыг хамгаалах ажлыг чиглүүлэн удирдана.

13.7. Хүн амыг байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, түүний хор уршгийг арилгах арга хэмжээ авч, иргэний хамгаалалтын ажлыг удирдан зохион байгуулна.



## **БАТЛАН ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ**

### **3 дугаар зүйл.**

1. Батлан хамгаалах нь улс орны үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг мөн.

2. Батлан хамгаалах нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг гаднын зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалахад улс орны бэлэн байдлыг хангах, хамгаалах зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн цогцолбор арга хэмжээ мөн.

### **4 дүгээр зүйл.**

1. Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдлыг хангах нь төрийн үүрэг мөн. Төр нь улс орны батлан хамгаалах нэгдмэл, уян хатан тогтолцоог бүрдүүлж бэхжүүлнэ.

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭР, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬ**

### **15 дугаар зүйл.**

Аймаг, нийслэлийн засаг дарга дараахь бүрэн эрхийг эдэлнэ:

5/ нутаг дэвсгэртээ цэрэг, иргэний хамгаалалтын болон нийгмийн хэв журам хамгаалах ажлыг удирдах, цэргийн анги, салбар, улсын аюулгүй байдлыг хангах хийгээд хууль хамгаалах бусад байгууллагатай харилцан ажиллах.

## **ПАТЕНТЫН ТУХАЙ ХУУЛЬ**

### **20 дугаар зүйл.**

1. Патент бүхий шинэ бүтээлд сонирхогч этгээдийн хүсэлтийн дагуу оюуны өмчийн газрын шийдвэрээр дараахь тохиолдолд лиценз албадан хэрэглэж болно:

1/ шинэ бүтээлийг үндэсний аюулгүй байдал, хүн амын хүнсний хангамж, эрүүлийг хамгаалах зэрэг нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн заавал ашиглавал зохих.

## **МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ**

### **10 дугаар зүйл.**

Улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа болон мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх журмыг тогтоох, өөрчлөхдөө дараахь зарчим баримтална:

1/ Үндэсний аюулгүй байдлыг хангах.

### **30 дугаар зүйл.**

1. Улсын хил хамгаалалт нь үндэсний аюулгүй байдал, улсын батлан хамгаалах арга хэмжээний салшгүй хэсэг мөн. Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, хилийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хилийн зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор улсын хилийн бүс, зурваст Улсын хил хамгаалах байгууллагаас улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, цэргийн инженер-техникийн зэрэг арга хэмжээг хослуулан явуулж байгаа үйл ажиллагааг улсын хил хамгаалалт гэнэ.

## **ТӨР, СҮМ ХИЙДИЙН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ ХУУЛЬ**

### **3 дугаар зүйл.**

3.4. Иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг гагцхүү бусад иргэний мөнхүү эрх чөлөө, эрүүл мэнд, ёс суртахуун болон үндэсний аюулгүй байдал нийгмийн дэг журмыг тогтоон зохицуулж байгаа Монгол Улсын хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээр зохицуулан хэрэгжүүлнэ.

### **4 дүгээр зүйл.**

4.4. Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд хохирол учирч болох нөхцөлд төрөөс сүм хийдийн тухайн үйл ажиллагааг зөвлөн зохицуулах, шаардлагатай бол зогсоох эрхтэй.

### **5 дугаар зүйл.**

5.2. Ард түмний эв нэгдэл, үндэсний аюулгүй байдлын эрх ашигт нийцүүлэн төр, сүм хийдийн болон шашин

хоорондын харилцааг Монгол Улсын Ерөнхийлөгч зохицуулна.

### ***ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ***

#### **19 дүгээр зүйл.**

Гадаадын иргэнийг дараахь үндэслэл байвал Монгол Улсад орохыг үл зөвшөөрнө:

4/ Монгол Улсын үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахад харшилж байвал.

#### **20 дугаар зүйл.**

2. Гадаадын иргэнийг дараахь үндэслэл байвал дор дурдсан хугацаанд Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлнэ:

4/ Монгол Улсын үндэсний болон хүн амын аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах ашиг сонирхолд харшилж байвал.

### ***ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬ***

#### **10 дугаар зүйл.**

Заавал соёрхон батлах гэрээнд дараахь олон улсын гэрээ багтана:

1/ Монгол Улсын бүрэн эрхт байдал, аюулгүй байдал, нутаг дэвсгэр, улсын хил болон хүний салшгүй эрхтэй холбогдсон олон улсын гэрээ.

### ***ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬ***

#### **8 дугаар зүйл.**

8.1. Дараахь зорилгоор жагсаал, цуглаан хийхийг хориглоно:

8.1.1. дайн сурталчлах, үндэстэн ястны хооронд хагарал гаргах буюу үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс,

нийгмийн гарал, байдал, шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхах, аллага хядлага, хорлон сүйтгэх ажиллагаа явуулах, төрийн эрх мэдлийг хууль бус аргаар авахыг уриалах;

8.1.2. үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журамд хохирол учруулж эмх замбараагүй байдал бий болгох.

### **ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬ**

#### **4 дүгээр зүйл.**

Газрын талаар төрөөс дараахь зарчмыг баримтална:

5. Хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдалд харшлах, байгаль орчны тэнцвэрт байдлыг алдагдуулах аливаа үйл ажиллагааг явуулахгүй байх.

#### **18 дугаар зүйл.**

1. Улсын тусгай хэрэгцээний газарт дараахь газар хамаарна:

2/ хилийн зурвас газар;

3/ улсын батлан хамгаалах болон үндэсний аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар.

### **ТӨРИЙН НУУЦЫН ТУХАЙ ХУУЛЬ**

#### **5 дугаар зүйл.**

Төрийн нууцад хамааруулах нууцын хүрээ:

5.1. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын хүрээнд:

5.1.1. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон мэдээ, баримт бичиг, бусад зүйлийн нууцалбал зохих хэсэг;

5.1.2. Монгол Улсын гадаад бодлого, байр суурьтай холбоотой онц чухал мэдээлэл, түүнчлэн Монгол улсаас гадаад орнуудтай байгуулсан нууцалбал зохих гэрээ, хэлэлцээр, тэдгээрийн төсөл.

5.3. Эдийн засаг, шинжлэх ухаан, техник-технологийн хүрээнд:

5.3.1. Үндэсний аюулгүй байдал, эдийн засаг, батлан хамгаалахад онцгой ач холбогдол бүхий эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл, туршилт, нээлт, зураг төсөл, үндэсний болон дэвшилтэт технологи;

5.3.3. батлан хамгаалах болон эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад ач холбогдол бүхий стратегийн түүхий эд, материалын нөөц, олборлолт, нийлүүлэлтийн хэмжээ.

## **ТӨРИЙН НУУЦЫН ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ ХУУЛЬ**

### **1 дүгээр зүйл.**

Дор дурдсан мэдээ, баримт бичиг, биет зүйлийг Монгол Улсын төрийн нууцад хамааруулна:

Нэг. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын хүрээнд:

1. Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын үзэл баримтлал, номлол, улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалтай холбоотой, хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээлэл агуулсан бөгөөд төлөөлүүлсэн нэр шифр, дугаар хэрэглэж нууцалсан мэдээ, баримт бичиг, биет зүйл.

Нууцын зэрэглэл:

нууцалсан зэргээр

Нууцлах хугацаа (жилээр): байнга.

### **20 дугаар зүйл.**

20.1. Төрийн нууцыг дараахь үндэслэлээр шилжүүлж болно:

20.1.1. Монгол Улсын аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан төрийн нууцыг бусад байгууллагатай хамтран ашиглаж тодорхой зорилго биелүүлэх.

### **21 дүгээр зүйл.**

21.4. Монгол Улсын аюулгүй байдлын эрх ашгийн үүднээс төрийн нууцыг яаралтай ил болгох шаардлага гарсан онцгой тохиолдолд Тагнуулын төв газрын даргын саналыг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгч уул асуудлыг шийдвэрлэнэ.

## **БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ**

### **13 дугаар зүйл.**

Улсын Их Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

2. Засгийн газрын өргөн мэдүүлснээр байгаль орчныг хамгаалах, экологийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр батлах.

### **14 дүгээр зүйл.**

Засгийн газар байгаль орчныг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1. байгаль орчныг хамгаалах, экологийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

### **19 дүгээр зүйл.**

19.1. Монгол Улс санхүүгийн баталгаа бүхий байгаль орчныг хамгаалах, экологийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөртэй байна.

## **ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬ**

### **12 дугаар зүйл.**

12.2. Үндэсний аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах зориулалттай бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн талаар уул асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх хэмжээг тусгайлан тогтоож болно.

### **56 дугаар зүйл.**

56.4. Үндэсний аюулгүй байдал, стратегийн ач холбогдолтой, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд ногдох хувьцааг худалдах талаар Засгийн газар тусгайлан журам тогтоож болно.

## **СОЁЛЫН ТУХАЙ ХУУЛЬ**

### **19 дүгээр зүйл.**

3. Дайн түрэмгийлэл, хүчирхийлэл, садар самууныг сурталчлах, Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, соёлд хор хохирол учруулах соёлын үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

## **ХАРЪЯАТЫН ТУХАЙ ХУУЛЬ**

### **10 дугаар зүйл.**

1. Дор дурдсан үндэслэлээр гадаадын иргэн, харъяалалгүй хүнийг Монгол Улсын иргэн болгохоос татгалзана:

2/ Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, язгуур эрх ашгийн эсрэг үйл ажиллагаа явуулж байсан буюу явуулж байгаа бол.

### **12 дугаар зүйл.**

Дор дурдсан үндэслэлээр Монгол Улсын харъяатаас гаргахыг татгалзаж болно:

3/ харъяатаас гарах нь Монгол Улсын үндэсний болон нийгмийн аюулгүй байдалд хохирол учруулахаар бол.

## **ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ**

### **7 дугаар зүйл.**

1. Төрийн хянан шалгах хороо чиг үүргийнхээ дагуу дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1. Дор дурдсан байгууллага, аж ахуйн нэгжид хяналт шалгалт явуулах:

2/ ... Тагнуулын байгууллага, зэвсэгт хүчин, бусад цэрэг, түүнчлэн цагдаагийн гүйцэтгэх албанд зориулсан төсвийн хөрөнгийн зарцуулалтыг Төрийн хянан шалгах хорооны дарга болон Улсын Их Хурлаас итгэмжлэгдсэн албан тушаалтан хянан шалгана.

Ийнхүү шалгасан тухай асуудлыг Төрийн хянан шалгах хорооны хуралдаанаар хэлэлцэхгүй.

## **ХЭМЖЛИЙН НЭГДМЭЛ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬ**

### **7 дугаар зүйл.**

2. Дараахь үйл ажиллагаанд хэрэглэх хэмжих хэрэгсэл, хэмжих аргачлалыг хэмжил зүйн төрийн хяналт шалгалтад хамруулна:

6/ Улсыг батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангахтай холбогдсон үйл ажиллагаа.

## **ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ**

### **7 дугаар зүйл.**

1. Улсын Их Хурлын чуулган болон Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаан, олон улсын дээд хэмжээний уулзалт, хэлэлцээ, хурал, зөвлөлгөөн төрийн тусгай хамгаалалтад байна.

## **ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ**

### **6 дугаар зүйл.**

10. Төмөр замаар тээвэрлэх нууц болон хүн ам, байгаль орчинд хохирол учруулж болзошгүй тэсэрч дэлбэрэх, цацраг идэвхт, хортой бодисыг ачиж буулгах, тээвэрлэх, хадгалах журмыг төмөр замын захиргааны төв байгууллагатай хамтран батална.

11. Монгол Улсын төрийн тэргүүн, гадаад улсын төрийн тэргүүн зэрэг өндөр албан тушаалын хүн зорчих тусгай галт тэрэгний аялах журмыг төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын аюулгүй байдлыг хангах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, цагдаагийн төв байгууллагатай зөвшилцөн батална.

## **АРХИВЫН ТУХАЙ ХУУЛЬ**

### **20 дугаар зүйл.**

6. Шүүх, прокурор, гадаад харилцаа, батлан хамгаалах, улсын аюулгүй байдлыг хангах болон цагдаагийн



төв байгууллага нь шүүн таслах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдалд холбогдох баримт бичиг, гэрээ хэлэлцээрийн эхийг төвлөрүүлж хадгалах зорилгоор төрөлжсөн архивтай байж болно.

### ***ГАДААДЫН ЦЭРГИЙН ХҮЧНИЙГ БАЙРЛУУЛАХ, ДАМЖИН ӨНГӨРҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ***

#### **4 дүгээр зүйл.**

4.1. Гадаадын цэргийн хүчнийг байрлуулах, дамжин өнгөрүүлэхдээ дараахь зүйлийг үндэслэл болгоно:

4.1.4. гадаад улсын Засгийн газраас өөрийн цэргийн хүчнээ Монгол Улсын нутаг дэвсгэр, агаарын зайгаар дамжин өнгөрүүлэх тухай тавьсан хүсэлтийг Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд харшлаагүй гэж үзэж гаргасан Засгийн газрын шийдвэр.

### ***ЭМИЙН ТУХАЙ ХУУЛЬ***

#### **4 дүгээр зүйл.**

4.1. Эмийн үндэсний бодлого нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах нэгдмэл бодлогын салшгүй хэсэг мөн.

### ***ТАГНУУЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬ***

#### **10 дугаар зүйл.**

10.1. Тагнуулын ерөнхий газар нь тагнуулын байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, үндэсний аюулгүй байдлыг тагнуулын аргаар хангах бодлого боловсруулж, хэрэгжүүлэх зорилго бүхий төрийн захиргааны төв байгууллага мөн.

#### **11 дүгээр зүйл.**

11.1. Тагнуулын ерөнхий газар дараахь үүрэг гүйцэтгэнэ:

11.1.1. Монгол Улсын ашиг сонирхлыг хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн асуудлаар

тагнуулын мэдээ олох, цуглуулах, задлан шинжилгээ хийж, дүгнэлт гарган энэ хуульд заасан эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлэх;

11.1.3. Улсын эдийн засгийн аюулгүй байдалд ноцтой хохирол учруулж болзошгүй ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, түүнийг илрүүлэх, таслан зогсоох;

11.1.5. Монгол Улсын хил, зэвсэгт хүчин бусад цэргийн аюулгүй байдлыг эрх хэмжээнийхээ хүрээнд гүйцэтгэх ажлын шугамаар хамгаалах;

11.1.6. Төрийн мэдээлэл, холбоо харилцааны аюулгүй байдлыг хангах.

#### **15 дугаар зүйл.**

Тагнуулын ерөнхий газрын даргын бүрэн эрх:

15.1.6. Үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон асуудлаар Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг мэдээллээр хангах, энэ талаар зохих санал тавих;

### ***ХҮНСНИЙ ТУХАЙ ХУУЛЬ***

#### **3 дугаар зүйл.**

3.1.2. “Хүнсний аюулгүй байдал” гэж хүнсэнд чанар, эрүүл ахуйн зохистой хэм хэмжээ хангагдсан байхыг хэлнэ.

#### **4 дүгээр зүйл.**

4.1. Улсын Их Хурал хүнсний асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.1.1. Хүн амын хүнсний хангамж, аюулгүй байдлын талаар төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох, хэрэгжилтэд нь хяналт тавих.

#### **5 дугаар зүйл.**

5.1. Засгийн газар хүнсний асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.3. Хүнсний аюулгүй байдлын үзүүлэлтийг тодорхойлох, хүнсийг улсын хилээр нэвтрүүлэхэд тавих хяналтын журам тогтоох.

#### **6 дугаар зүйл.**

6.1. Хүнсний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1. Хүнсний хангамж, аюулгүй байдлыг харгалзан тухайн жилд импортлох, экспортлох мал, стратегийн хүнсний нэр төрөл, хэмжээний талаар олон нийтэд мэдээлэх.

#### **7 дугаар зүйл.**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын бүрэн эрх:

7.2. Нутаг дэвсгэрийнхээ хүн амын хүнсний аюулгүй байдлын талаарх бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, хүн амын хэрэглээний бодит гүйцэтгэлийг жил бүр тухайн шатны иргэдийн төлөөлөгчдийн хуралд танилцуулах, холбогдох асуудлыг зохих байгууллагад уламжлах;

#### **11 дүгээр зүйл.**

11.1. Хүнсний аюулгүй байдалд тавих хяналтыг хүнс бэлтгэх, боловсруулах, үйлдвэрлэх, савлах, тээвэрлэх, борлуулах болон хаягдал ашиглах шатанд хүнсний аюулгүй байдлын шаардлага хангахад чиглүүлнэ.

#### **12 дугаар зүйл.**

12.1. Хүнсний аюулгүй байдалд тавих хяналтыг улсын хэмжээнд мэргэжлийн хяналтын байгууллага, орон нутагт хяналтын албад эрхлэн зохион байгуулна.

#### **13 дугаар зүйл.**

13.1. Хүнсний аюулгүй байдлын хяналтыг хүнсний үйлдвэрлэлийн техник, технологи, эрүүл ахуй, үр ургамал, хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн мэргэшсэн улсын байцаагч ... хэрэгжүүлнэ.

#### **14 дүгээр зүйл.**

14.3. Хүнсний аюулгүй байдалд магадлан шинжилгээ

хийх лабораторид стандартчилал, хэмжил зүйн төв байгууллага зохих журмын дагуу итгэмжлэл олгоно.

**15 дугаар зүйл.**

15.1. Лабораторийн итгэмжлэл авсан хуулийн этгээд хүнсний эрүүл ахуй, чанар, аюулгүй байдалд хөндлөнгийн хяналт тавьж болно.

**16 дугаар зүйл.**

16.2. Иргэн, төрийн бус байгууллага хүнсний аюулгүй байдалд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг төрийн захиргааны болон хяналтын эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтийг сэрэмжлүүлнэ.

***ЦӨМИЙН ЗЭВСГЭЭС АНГИД БАЙХ ТУХАЙ ХУУЛЬ***

**1 дүгээр зүйл.**

1.1. ... Монгол Улсын аюулгүй байдлыг хангахад чухал хүчин зүйл болох Монгол Улсын нутаг дэвсгэрийг бүхэлд нь, түүний дотор агаар мандал, газар, ус, газрын хэвлийг цөмийн зэвсгээс ангид байлгах ...

***ЦАЦРАГИЙН ХАМГААЛАЛТ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ***

**3 дугаар зүйл.**

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.4. “Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдал” гэж хүн ам, байгаль орчныг цацраг идэвхт бодис болон ионжуулагч цацрагийн бусад үүсгүүрийн нөлөөллөөс хамгаалах, цацрагийн үүсгүүрийн аюулгүй байдлыг хангасныг.

***ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛЬ***

**20 дугаар зүйл.**

20.1. Монгол Улсын батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах, иргэний хамгаалалт, гэмт хэрэгтэй тэмцэх,

нийгмийн хэв журам сахиулах, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын хэрэгцээнд зориулан тусгай хэрэглээний холбооны сүлжээг байгуулан ажиллуулж болно.

## **ЭРҮҮГИЙН ТУХАЙ ХУУЛЬ**

### **1 дүгээр зүйл.**

1.1. Монгол Улсын Эрүүгийн хуулийн зорилт нь Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон хувийн өмч, үндэсний баялаг, байгаль орчин, эрх зүйн журам, энх тайван, хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалахад оршино.

### **79 дүгээр зүйл.**

79.1. Монгол Улсын иргэн тус улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах хүчин чадалд хохирол учруулах зорилгоор гадаад улсын тагнуулын албанд элссэн, төрийн нууцыг гадаад улс, түүний тагнуулын албанд шилжүүлэн өгсөн, Монгол Улсын эсрэг дайсагнасан үйл ажиллагаа явуулдаг гадаад улсын байгууллагатай хамтран ажилласан, дайны байдалд буюу дайн бүхий байдал зарласан үед дайсны талд шилжин орсон бол арван зургаагаас хорин таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

### **80 дугаар зүйл.**

80.1. Гадаад улсын иргэн буюу харъяалалгүй хүн Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах хүчин чадалд хохирол учруулах зорилгоор төрийн нууц, түүнд хамаарах мэдээ, баримт, бусад зүйлсийг хулгайлсан, цуглуулсан, тэдгээрийг гадаад улс, түүний тагнуулын албанд шилжүүлэн өгсөн бол арван зургаагаас хорин таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

### **84 дүгээр зүйл.**

84.1. Монгол Улсын эдийн засгийн хүчин чадлыг сулруулан доройтуулах зорилгоор үйлдвэр, байгууламж, зам харилцаа, холбооны хэрэгсэл, бусад эд хөрөнгийг тэслэх, дэлбэлэх, галдан шатаах болон бусад аргаар хорлон сүйтгэх ажиллагаа явуулсан, хүн, мал, ургамлын гоц халдварт өвчин

тараасан, олон хүнийг хордуулсан, түүнчлэн хүн, мал, амьтныг үй олноор нь устгасан бол арван зургаагаас хорин таван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл цаазаар авах ял шийтгэнэ.

#### **87 дугаар зүйл**

87.1. Төрийн нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагааг итгэмжлэгдэн хариуцсан буюу албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн этгээд задруулсан нь эх орноосоо урвах, тагнуул хийх гэмт хэргийн шинжтэй бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

#### **88 дугаар зүйл.**

88.1. Төрийн нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйлийг итгэмжлэгдэн хариуцсан буюу албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн этгээд тэдгээртэй харьцах талаар тогтоосон журам зөрчсөний улмаас үрэгдүүлсэн бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

### **МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ЦЭРГИЙН БОДЛОГЫН ҮНДЭС**

#### **II. Зэвсэгт түрэмгийллийн аюулаас сэрэмжлэх төрийн бодлогын үндсэн чиглэл**

Монгол Улс өөрийгөө хамгаалах зорилтоо хэрэгжүүлэхдээ үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалыг үндэс болгон улс төр-дипломатын аргыг урьдал болгоно.

Олон улсын хэмжээнд болон Ази, Номхон далайн бүс нутагт албан ёсны түвшинд аюулгүй байдлын олон талт яриа хэлцээ явуулах, аливаа дайн, зэвсэгт мөргөлдөөнийг сэрэмжлэн зайлуулах, цэргийн хоёр талын болон олон талт итгэлцлийг бэхжүүлэхэд идэвхтэй оролцох, олон түнштэй байх, үндэснийхээ язгуур ашиг сонирхлыг дээдэлж аюулгүй байдлаа улс төрийн аргаар хангах гадаад бодлогыг тууштай явуулах нь Монгол Улсын төрийн эрхэм зорилт байна.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ.  
**БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН ГАДААД  
ХАРИЛЦАА, ЭНХИЙГ САХИУЛАХ АЖИЛЛАГАА**

*Ph.D. С.Ганболд*  
/БХЭШХ-ийн эрдэм  
шинжилгээний ахлах ажилтан/  
*Ph.D. Г.Рагчаа*  
/ЗХЖШ-ын орлогч, Энхийг  
сахиулах ажиллагааны газрын  
дарга/

Монгол оронд 1980-аад оны сүүлч 1990-ээд оны эхнээс өрнөсөн ардчилсан хувьсгалын үр дүнд улс орон нийгмийн шинэ тогтолцоонд шилжсэнээр гадаад бодлогод өөрчлөлт орж олон тулгуурт гадаад бодлогыг тууштай баримтлах болсон юм. Нийгмийн амьдралын бүх л салбарыг хамарсан өөрчлөлт шинэчлэлт батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчинд ч нөлөөлөв.

Монгол Улс дэлхийн олон улс оронтой эрх тэгш харилцах болсон нь улс төр, эдийн засаг төдийгүй цэргийн гадаад харилцааг ч хамрах болсон юм. Монгол Улс 1990-ээд оноос өмнө зөвхөн Зөвлөлт Холбоот Улс (ЗХУ) болон социалист системийн орнуудтай л цэргийн гадаад харилцаатай байсан бөгөөд энэ нь улс төр, үзэл суртлын шинжийг илүүтэй агуулсан байв. Тус улсын хувьд батлан хамгаалах салбарын гол түнш нь ЗХУ байсан бөгөөд эл харилцаа нь олон арван жилийн уламжлалтай хэдий ч хэт өрөөсгөл байдалтай явж иржээ.

Дэлхий нийтийг хамарсан өөрчлөлт шинэчлэлтийн нөлөөгөөр социалист систем задран унаж, түүний дээр зөвлөлтийн цэрэг Монголоос бүрмөсөн гарснаар Монгол Улсын батлан хамгаалах салбарын гадаад харилцаа зогсонги байдалд орсон юм. Үүний зэрэгцээ Монгол Улс батлан хамгаалах бодлогодоо зарчмын өөрчлөлт оруулж түүнийгээ баталгаажуулсан хэд хэдэн хууль тогтоомж, баримт бичиг гаргав.

Дээрхи бодлогын хүрээнд Монголын Зэвсэгт хүчнийг

шинэчлэн өөрчлөх зайлшгүй шаардлага тулгарч эл зорилтыг төрийн бодлогын төвшинд авч үзэх болсон юм. Цэргийн шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлэх нэг чухал хүчин зүйл нь төрийн гадаад бодлоготой уялдсан батлан хамгаалах салбарын гадаад харилцааг хөгжүүлэх явдал юм.

Монгол Улсын хувьд батлан хамгаалах салбарын гадаад харилцааг үндсэндээ цоо шинэ байдлаар шинэ нөхцөл, байдалтай уялдуулан дэлхийн улс орнуудтай хөгжүүлэхийн хамт уламжлалт харилцаат Оросын Холбооны Улс (ОХУ), Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ)-тай харилцаагаа сэргээн хөгжүүлэх шаардлага тулгарсан байна.

Монгол Улсын “Гадаад бодлогын үзэл баримтлал”-д “Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхлыг улс төр-дипломатын аргаар хангах, эдийн засаг, шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх гадаад таатай нөхцлийг бүрдүүлэх нь тус улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэл мөн” гэж тодорхойлохын хамт “ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад бодлогын эн тэргүүний зорилт мөн . . . чингэхдээ энэ хоёр оронтой харилцаж ирсэн уламжлал, эдийн засгийн хамтын ажиллагааны өвөрмөц онцлогийг харгалзана” гэж заасныг батлан хамгаалах салбарын гадаад харилцаанд баримталж буй юм.

Монгол Улсын Гадаад бодлогын болон Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Төрийн цэргийн бодлогын үндэс зэрэг эрх зүйн баримт бичгийн заалтыг үндэслэн Батлан хамгаалахын сайдын тушаалаар “Батлан хамгаалах салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааны үндсэн чиглэл”-ийг 1997 онд батлан мөрдөж байна. Энэхүү үндсэн чиглэлд ОХУ, БНХАУ, Америкийн Нэгдсэн Улс (АНУ), Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ) зэрэг орныг цэргийн гадаад харилцааны тэргүүлэх чиглэлд хамруулж, тэдэнтэй явуулах хамтын ажиллагаанд түлхүү анхаарах болов. Түүнчлэн Монгол оронтой улс төр, эдийн засгийн болон бусад салбарын харилцааг хөгжүүлж байгаа гадаад орнуудтай цэргийн итгэлцлийг бэхжүүлэх явдал чухал гэж үзэж тэдэнтэй харилцаагаа өргөжүүлэх чиглэлийг баримтлах болно гэж үзжээ.



Ингэснээр батлан хамгаалах салбарын гадаад харилцаа нь Монгол Улсын гадаад улс төрийн бодлогын хүрээнд улс орныхоо аюулгүй байдал, үндэснийхээ ашиг сонирхлыг улс төр, дипломатын аргаар хангах, батлан хамгаалах нэгдмэл тогтолцоог бэхжүүлэх, цэргийн байгуулалтаа олон улсын жишигт хүргэх, мэргэжлийн чиг баримжаатай, цомхон, чадварлаг зэвсэгт хүчинтэй болох зорилтуудыг хэрэгжүүлэхэд хоёр хөрш, Ази, Номхон далайн бүс нутгийн болон дэлхийн бусад орнуудтай тогтоосон цэргийн харилцаа, хамтын ажиллагааны нааштай үр дүнг зохистой ашиглах бодлогыг баримтлах болов.

Дээр дурдсан хүчин зүйл, нөхцөл байдлыг харгалзан Монгол Улсын батлан хамгаалах салбарын гадаад харилцаа 1990-ээд оноос шинэ нөхцөл байдалд хэлбэр, агуулгын хувьд шинэчлэгдэн хөгжиж байгаа юм. Энд юуны түрүүнд ОХУ болон БНХАУ-тай тогтоосон харилцааг онцлон дурдууштай.

Харин номын энэхүү бүлгийг төгсгөл хэсэгт Монгол Улсын Зэвсэгт хүчнээс Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Энхийг сахиулах үйл ажиллагаанд хэрхэн оролцож буй талаар тусгайлан өгүүлэх болно.

**Монгол Улс, Оросын Холбооны Улсын харилцаа.** 1990-ээд оны эхээр Монголоос зөвлөлтийн цэрэг гарах хугацаанд тус хоёр орны нийгэм, улс төрийн амьдралд гүн гүнзгий өөрчлөлт гарав. Монголд ардчилсан хөдөлгөөн өрнөж шинэ, ардчилсан төр үндэс сууриа тавьж, ЗХУ задарч түүний үр дүнд тусгаар тогтносон улсуудын хамтын нөхөрлөл үүссэн билээ.

Ингэснээр урьдын БНМАУ, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс (ЗСБНХУ)-ын оронд түүнийг залгамжилсан шинэ улс бий болсноор батлан хамгаалах салбарын харилцааны хуучин хэв загвар хоцрогдож, түүний оронд эрх тэгш, харилцан ашигтай хамтын ажиллагааны үе эхлэв. Нөгөө талаар тус хоёр орны харилцаа нь үзэл суртал, “ах дүүгийн ёс”, бусдын эсрэг улс төрийн талаар сөргөлдөх байдлаас ангижирч, өөр өөрсдийн ашиг сонирхолд хөтлөгдсөн харилцаанд шилжсэн гэж болно.

Монгол Улс ерээд оны эхэн үеэс нийгэм, улс төр, эдийн засгийн далайцтай өөрчлөлт хийж, энэ нь зарим талаар тодорхой саад бэрхшээлийг дагуулж байв. Энэ нь юуны өмнө батлан хамгаалах салбарт илүүтэй нөлөөлсөн бөгөөд олон арван жилийн турш ЗХУ-ын цэргийн холбоотон байж, түүний тусламж, дэмжлэгт дулдуйдаж ирсэн нь тус салбарын цаашдын хөгжил, цэргийн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд тодорхой бэрхшээл учруулж байсан юм. Монгол Улс батлан хамгаалах салбарынхаа үйл ажиллагааг хэвийн хэмжээнд явуулах, цэргийн шинэчлэл хийх зорилтыг хэрэгжүүлэхдээ олон арван жилийн уламжлалаа харгалзан ОХУ-аас тусламж дэмжлэг авах, улмаар харилцаагаа сэргээн хөгжүүлэхийг эрмэлзэж байлаа.

Энэ ч үүднээс Монгол Улс харилцаа тогтоох, хамтран ажиллах чиглэлээр харьцангуй илүүтэй анхаарал тавьж байсан юм. Үүний нэг илрэл нь 1991 онд Монгол Улсын Зэвсэгт Хүчний Ерөнхий Штаб (ЗХЕШ)-ын дарга, 1992 онд Монгол Улсын Батлан хамгаалахын сайдын ОХУ-д хийсэн ажлын айлчлал юм. Харамсалтай нь эдгээр ажлын айлчлал тэр бүр санасан үр дүнд хүрсэнгүй. Энэ нь Оросын талын нааштай хандлагын үед бус, цаг үеэ олоогүй, зарим талаар Орос, Монголын харилцаа зөрчилтэй байж болохуйц буюу Монголд зөвлөлтийн эсрэг, түүнийг буруушаах үзэл бодол дэгдээд байсан үед, зөвхөн Монголын талын санаачилга, хүсэлтээр болж байсан нь Оросын талын сонирхлыг хөндөж чадаагүй ажээ. Нөгөө талаар тухайн үед ЗСБНХУ задарч, ОХУ үүсэх үйл явцтай давхцаж, Орос оронд нийгэм, улс төр, цэрэг армийн хямрал болж байхтай зэрэгцсэн нь ч тодорхой нөлөөлсөн аж.

Монгол Улсын анхны Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч П.Очирбат ЗХУ задарсны дараа түүнийг залгамжлах болсон ОХУ-ын Ерөнхийлөгч Б.Н.Ельциний урилгаар 1993 оны 1 дүгээр сард төрийн дээд хэмжээний айлчлал хийв. Албан ёсны айлчлалын үр дүнд гарын үсэг зурсан “Монгол Улс, Оросын Холбооны Улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ”-нд батлан хамгаалах болон аюулгүй байдлын салбарт хамтран ажиллах тухай дурджээ. Гэрээний 2 дугаар зүйлд: “. . . талууд улс төр, эдийн засаг, соёл, урлаг, боловсрол, шинжлэх ухаан,

техник, эрүүлийг хамгаалах, батлан хамгаалах, аюулгүй байдал, экологи, зам тээвэр, харилцаа холбоо, мэдээлэл, хүмүүнлэгийн болон бусад салбарт эрх тэгш, харилцан ашигтай хамтын ажиллагааг тогтвортой, урт хугацааны үндсэн дээр хөгжүүлнэ . . .” хэмээн онцлон тэмдэглэсэн байна [1. 93-98].

Уг гэрээний заалтыг иш үндэс болгон, мөн Монголд түр хугацаагаар байрлаж байгаад гарсан зөвлөлтийн цэргийн асуудлаар Монгол Улс, ОХУ-ын Жанжин штабын дарга нар 1993.06.28-ны өдөр Улаанбаатарт хэлэлцээ хийжээ. Хэлэлцээний үр дүнд “Монгол Улсын Батлан Хамгаалах Яам (БХЯ), Оросын Холбооны Улсын БХЯ-ны хоорондын цэргийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-т гарын үсэг зурав.

Хэлэлцээр ёсоор талууд цэргийн хамтын ажиллагааг цэргийн, цэргийн шинжлэх ухааны; цэргийн эмнэлгийн; боловсон хүчнийг сурган бэлтгэх; арми, нийгмийн хоорондын харилцаа; соёлын харилцаа гэсэн чиглэлээр хөгжүүлэхээр тохиролцов. Үүний хамт цэргийн хамтын ажиллагааг Батлан хамгаалахын сайд болон бусад удирдагчдын албан ёсны айлчлал, Батлан хамгаалахын сайд болон талуудын бусад төлөөлөгчдийн уулзалт, зөвлөлдөх, туршлага солилцох, цэргийн албан хаагчдыг сургах, дадлагажуулах, давтан бэлтгэх, хээрийн сургууль, бага хурал, зөвлөлгөөн, семинарт урих, мэдээлэл, баримт бичиг солилцох, ахмад дайчдын уулзалт, түүхт газраар аялах, концерт, үзэсгэлэн, кино наадам зохион байгуулах зэрэг хэлбэрээр хэрэгжүүлэхээр тогтжээ [2. 253-255] .

Уг хэлэлцээрийг 4 жилийн хугацаатай байгуулсан боловч хоёр талын тохиролцсон зүйл бодит амьдрал дээр тэр бүр хэрэгжиж чадсангүй. Энэ нь хоёр орны дотоод улс төрийн байдал, санхүү, эдийн засгийн бэрхшээлээс үүдээд уг тохиролцоог хэрэгжүүлэх бодит нөхцөл бололцоо тэр бүр байсангүйтэй холбоотой байв.

Мөн 1993 оны 4 дүгээр сард цэргийн зарим техник, сэлбэг хэрэгслийг Монголд буцалтгүй тусламжаар олгох тухай ОХУ-ын БХЯ, холбогдох байгууллагуудтай Монгол Улсын БХЯ-ны шугамаар хэлэлцээ хийж 2.3 сая ам.долларын

техник, сэлбэг хэрэглэл нийлүүлэхээр гэрээ байгуулсан боловч өнөөг болтол хэрэгжиж чадаагүй нь дээр дурдсан байдалтай холбогдох юм.

Монгол Улсын Батлан хамгаалахын сайд Д.Дорлигжав тэргүүтэй цэргийн төлөөлөгчид цэргийн салбар дахь хамтын ажиллагааг өргөжүүлж гүнзгийрүүлэх ашиг сонирхлын үүднээс 1997 оны 2 дугаар сард ОХУ-д айлчлал хийжээ. Айлчлалын үр дүнд “Монгол Улсын Батлан хамгаалахын сайд Оросын Холбооны Улсад хийсэн албан ёсны айлчлалын протокол”-д Монгол Улсын Батлан хамгаалахын сайд Д.Дорлигжав, ОХУ-ын Батлан хамгаалахын сайд армийн генерал И.Родионов нар гарын үсэг зурав [З. 131]. Монгол Улсын Батлан хамгаалахын сайдын энэхүү айлчлал нь хөрш хоёр улсын хоорондын цэрэг, батлан хамгаалах салбарын зогсонги байдалд ороод байсан харилцаа, хамтын ажиллагаанд түлхэц өгч, энэ харилцааг шинэ шатанд гаргах алхам болсон байна.

Уг албан ёсны айлчлалын явцад дэлхий дахины болон бүс нутгийн цэрэг, улс төрийн асуудлаар талууд санал солилцож, хоёр орны цэрэг, цэрэг-техникийн хамтын ажиллагааны асуудлыг хэлэлцжээ. Протоколд талууд харилцан сонирхож байгаа бүс нутгийн цэрэг-улс төрийн болон цэргийн асуудлаар зохих төвшинд саналаа байнга солилцож байх, хоёр орны БХЯ-ны хооронд байгуулсан цэргийн хамтын ажиллагааны тухай хэлэлцээрийн заалтууд, хамтын ажиллагааны төлөвлөгөө, түүнчлэн дээд хэмжээний уулзалтын явцад тохиролцсон хэлэлцээг хэрэгжүүлэх бүрэн эрхт байгууллагуудыг томилох, Монгол Улсын Зэвсэгт хүчний Ерөнхий штабын газар, хэлтсүүд ОХУ-ын Өвөр Байгалийн болон Сибирийн цэргийн тойргийн зохих албадын хооронд хамтын ажиллагааны шууд харилцаа тогтооход тус дөхөм үзүүлнэ гэж заажээ.

Хоёр орны батлан хамгаалах салбарын харилцааны эрх зүйн үндэс болсон эдгээр гэрээ, протокол нь цаашдын хамтын ажиллагааг эрчимжүүлэх хүчин зүйл болов. Дээр дурдсан хамтын ажиллагааны чиглэлүүдээр хоёр орны харилцаа 1990-ээд оны дунд үеэс харьцангуй идэвхжсэн байна.

Монгол Улсын БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга хошууч генерал С.Баасанхүү 1999 онд ОХУ-д айлчилж Монголын зэвсэгт хүчний зэвсэглэл, техникийг шинэчлэн сайжруулахад тусламж үзүүлэх чиглэлээр хамтын ажиллагааг идэвхжүүлэх талаар хэлэлцэв. ОХУ-ын Зэвсэгт Хүчний Жанжин Штаб (ЗХЖШ)-ын дарга, БХЯ-ны 1 дүгээр орлогч сайд армийн генерал А.В.Квашнин тэргүүтэй төлөөлөгчдийн 2000 оны 10 сард хийсэн ажлын айлчлал, Монгол Улсын Батлан хамгаалахын сайд Ж.Гүррагчаа 2000 онд ОХУ-д албан ёсны айлчлал хийж ОХУ-ын Төрийн Думын байнгын хорооны гишүүд, Батлан хамгаалахын сайд, ЗХЖШ-ын дарга нартай уулзсан нь хоёр орны батлан хамгаалах салбарын уламжлалт харилцааг идэвхжүүлэхэд чухал алхам болов.

Тус хоёр орны харилцаа хүмүүнлэгийн буюу байгалийн гамшиг, осолтой тэмцэх салбарт идэвхжив. Монгол Улсын Иргэний хамгаалалтын газрын урилгаар 1993 оны 9 дүгээр сард ОХУ-ын ойн түймэр эсэргүүцэн хамгаалах агаарын харуулын үйлдвэрлэлийн нэгдлийн төлөөлөгчид айлчилж хамтран ажиллах, харилцан туслалцах тухай протоколд гарын үсэг зуржээ.

ОХУ-ын Иргэний хамгаалалт, онцгой байдал, байгалийн гамшгийн үр дагаврыг арилгах асуудал эрхэлсэн яамны дэд сайд В.А.Владимиров тэргүүтэй төлөөлөгчид 1995 оны 2 дугаар сард Монголд айлчлав. Төлөөлөгчид Монгол Улсын Иргэний хамгаалалтын газрын дарга хошууч генерал Г.Дамдинсүрэнтэй хэлэлцээ хийж дүнгийн тухай протоколд гарын үсэг зурсан байна. Мөн энэ үеэр Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын комиссын хамтарсан 3 дугаар хуралдаан болж “Үйлдвэрийн осол, байгалийн гамшигаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийн үр дагаврыг арилгах салбарт хамтран ажиллах тухай” Засгийн газар хоорондын хэлэлцээрт гарын үсэг зуржээ. Хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон протоколын дагуу иргэний хамгаалалтын салбарт хамтран ажиллах хоёр талын комисс байгуулагдаж, Монголын мэргэжилтнүүдийг ОХУ-д бэлтгэх талаар тохиролцжээ.

ОХУ-ын Онцгой байдлын яамны сайд С.Шойгу 1996 оны 10 дугаар сард Монгол Улсад албан ёсоор айлчилж Улсын Иргэний Хамгаалалтын Газар (УИХГ)-тай хэлэлцээр хийж, хэлэлцээрийн дүнгийн тухай протоколд гарын үсэг зурав. Уг хэлэлцээрээр хоёр орны иргэний хамгаалалтын удирдах газар, яамны хооронд “ВЧ” холбоо тогтоох, иргэний хамгаалалтын тулгамдсан асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны ажил хамтран явуулах, Монголын боловсон хүчнийг сургаж бэлтгэх, олон улсын үзэсгэлэнд Монгол Улсыг оролцуулах, мэдээллийн харилцан ажиллагаа зохион байгуулах, хамтарсан команд-штабын сургууль зохион байгуулах зэрэг өргөн хүрээтэй асуудлаар хамтран ажиллах болжээ.

Дээрх хэлэлцээрт Монгол Улсын иргэний хамгаалалтын байгууллага, ОХУ-ын Өвөр Байгаль, Дорнод Сибирийн бүс нутгийн холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааг илүүтэй хөгжүүлэхээр заасан бөгөөд үүний дагуу ОХУ-ын Буриад улсын Иргэний хамгаалалт, онцгой байдлын хэрэг эрхлэх хорооны төлөөлөгчид 1998 оны 4 дүгээр сард айлчлан хил орчмын нутагт байгалийн гамшигаас урьдчилан сэргийлэх, түүний үр дагаврыг арилгах талаар хамтран ажиллах, ажил хэргийн талаар холбоо тогтоох талаар хэлэлцэж протоколд гарын үсэг зуржээ.

Монгол, Оросын хамтын ажиллагаа хоёр орны Хилийн цэргийн хооронд ч өргөжив. Монгол Улсын Хилийн Цэргийг Удирдах Газар (ХЦУГ)-ын дарга хошууч генерал П.Сүндэв 1994 оны 11 дүгээр сард ОХУ-д айлчилж хоёр улсын Засгийн газар хооронд хилийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрт гарын үсэг зурав. Хэлэлцээрээр хоёр орны хилийн цэргийн хамтарсан үйл ажиллагааны чиглэл, төрлийг тодорхойлсон байна. Хоёр орны хилийн цэргийн хамтын ажиллагаанд ОХУ-ын төлөөлөгчдийн Монголд хийсэн айлчлал чухал ач холбогдолтой болов.

ОХУ-ын Хилийн албаны захирал А.И.Николаев 1995 оны 9 дүгээр сард Монголд айлчилсан бөгөөд Монгол Улсын ХЦУГ-ын дарга П.Сүндэвтэй хэлэлцээ хийж хоёр улсын хилийн цэргийн албан ёсны төлөөлөгчдийн үйл ажиллагааны тухай, Монгол Улсын хилийн цэргийн албан хаагчдыг ОХУ-д

сургах, холбоо зохион байгуулах журам, хамтарсан байнгын ажиллагаатай хилийн ажлын хэсэг байгуулах болон ажлын уулзалтын дүнгийн тухай зэрэг гэрээ, протоколд гарын үсэг зуржээ. Түүнчлэн 1999 онд ОХУ-ын Хилийн албаны захирал хурандаа генерал К.В.Троцкий, Өвөр Байгалийн бүс нутгийн хилийн албаны төлөөлөгчид Монголд айлчилж хоёр орны хил хамгаалалтын байгууллагуудын хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх, хилийн зөрчлийг багасгах зэрэг асуудлыг хэлэлцсэн байна.

Энэ хугацаанд хоёр орны хамтын ажиллагааны хүрээнд ОХУ-ын Өвөр Байгалийн цэргийн тойрогтой харилцаагаа өргөжүүлэв. Монгол Улсын БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга хошууч генерал Ц.Дашзэвэг тэргүүтэй төлөөлөгчид 1998 оны 4 дүгээр сард тус цэргийн тойрогт айлчилж хамтран ажиллах төлөвлөгөөнд гарын үсэг зурсан байна. Мөн 1997, 1998 онд Монголын зэвсэгт хүчний болон тус тойргийн цэргийн төлөөлөгчдийг команд штабын хээрийн сургуульд харилцан урьж оролцуулжээ.

Хоёр орны хамтын ажиллагааг зэвсэг техникийн чиглэлээр өргөжүүлэхэд талууд онцгой анхаарч буй бөгөөд 1997 онд ОХУ-ын цэрэг, аж үйлдвэрийн МАПО нэгдлийн төлөөлөгчид Монголд айлчилж нисэх онгоц, нисдэг тэрэгний асуудлаар санал солилцож байжээ.

Хоёр орны хамтын ажиллагаа бусад чиглэлээр ч өргөжих эхлэл тавигдаад байна. Түүхт үйл явдал, тэмдэглэлт ойгоор харилцан төлөөлөгчид солилцох болов. Тухайлбал, 1995 оны 5 дугаар сард Москвад болсон Аугаа Их Эх орны дайны ялалтын 50 жилийн ойн баяр ёслолд Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат болон ахмад дайчид оролцсон байна.

Монголын Зэвсэгт хүчний 75 жилийн ой болон Халхын голын дайны ялалтын 55 жилийн ойг тэмдэглэх үеэр ОХУ-ын Өвөр Байгалийн цэргийн тойргийн командлагч хурандаа генерал В.С.Третьяков тэргүүтэй төлөөлөгчид ирж оролцов. Мөн Халхын голын дайнд оролцсон Оросын ахмад дайчид, цэргийн дуу бүжгийн чуулгын жүжигчид ойн арга хэмжээнд оролцсон байна. Халхын голын дайны ялалтын 60 жилийн

ойг 1999 онд тэмдэглэх үеэр Сибирийн цэргийн тойргоос 35 хүний бүрэлдэхүүнтэй барилгачид ирж Халхын голын орчимд байгаа хөшөө дурсгалыг сэргээн засварласан бөгөөд уг баяр ёслолд ОХУ-ын Зэвсэгт хүчний Жанжин штабын орлогч, холбооны цэргийн дарга хурандаа генерал Ю.М.Залогин тэргүүтэй ОХУ-ын БХЯ-ны төлөөлөгчид, Сибирийн цэргийн тойргийн командлагчийн орлогч дэслэгч генерал А.И.Скородумов тэргүүтэй тус тойргийн төлөөлөгчид уригдан оролцжээ.

Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын хооронд хамтын ажиллагаа өргөжиж, Халхын голын ялалтын ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний бага хурлуудад ОХУ-ын эрдэмтэд тогтмол оролцож ирэв. Мөн хамтарсан бүтээл туурвих, судалгаа явуулах, төлөөлөгчид харилцан айлчлах зэргээр эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудын хамтын ажиллагааны хэлбэрүүд баяжиж байна.

Хоёр орны харилцааны уламжлалт хэлбэрийн нэг нь Монголын цэргийн боловсон хүчнийг сургаж бэлтгэх явдал юм. Монгол Улс 1990-ээд оныг хүртэл цэргийн боловсон хүчнээ зөвхөн хойт хөршдөө олон тоогоор бэлтгэж байсан бөгөөд эл үйл явц ерээд оноос тасалдаж зогсонги байдалд орсон билээ. Гэсэн ч Монголын Зэвсэгт хүчний өнөөгийн байдал, шаардлагыг харгалзан ОХУ-ын төрөл, мэргэжлийн цэргийн академи, дээд сургууль, урт богино хугацааны дамжаанд цөөн тоогоор хүнээ сургах бодлогыг баримталж байгаа юм. Зөвхөн 1999 оны байдлаар ОХУ-ын цэргийн академи, сургуулийг 5 хүн төгсөн гарсан бөгөөд 18 хүн суралцаж байв. Ийнхүү суралцагсдын тоо харьцангуй цөөн байгаа нь хөрөнгө санхүүтэй холбоотой юм. Энэ хугацаанд ОХУ-ын цэргийн академиудад шинжлэх ухааны докторын зэргийг цөөн тооны хүн хамгаалсан байна.

Ийнхүү Монгол, Оросын цэргийн харилцаа 1990-ээд оноос шинэ нөхцөл байдалд сэргэн хөгжиж байгаа бөгөөд эл харилцааны хандлага нь урьдын адил Монголоос Орос руу хандсан чиглэлтэй, зөвхөн боловсон хүчин, сургалт, айлчлал, хүн солилцох, хүмүүнлэгийн чиглэлээр явцуу хүрээгээр хязгаарлагдаж байгаа юм. Монгол, Оросын цэргийн харилцааг



бүхэлд нь авч үзвэл 1990-ээд оны эхэн үеийн зогсонги байдлаас аажмаар гарч байгаа хэдий ч хүсэн хүлээсэн үр дүнд хараахан хүрч чадаагүй гэж болно. Цаашид эл хамтын ажиллагааг улам өргөжүүлж хэлбэр, агуулгыг баяжуулах, ялангуяа зэсвэг, техникийн чиглэлээр гүнзгийрүүлэх шаардлага тулгарч байна.

**Монгол Улс, БНХАУ-ын харилцаа.** Өнгөрсөн ХХ зуунд Монгол, Хятадын цэргийн харилцаа нь харилцан сөргөлдөх, ойртон нийлж хамтран ажиллах байдал хосолсон өвөрмөц онцлогтой хөгжиж ирсэн юм. Зөвлөлт, Хятадын хооронд 1960-аад онд үүсч бий болсон зөрчил, сөргөлдөөнд Бүгд Найрамдах Монгол Ард Улс (БНМАУ) татагдан орж улмаар ЗХУ-ын талыг тууштай дэмжих болсноор Монгол, Хятадын харилцаа муудаж, дайсагнасан байдалд шилжсэн юм. Энэ нь тус хоёр орны цэргийн харилцаа тасрахад хүргэв.

Харин 1980-аад оны дунд үеэс ЗХУ-д өрнөсөн өөрчлөн байгуулалт, дэлхий дахинд бий болсон улс төрийн шинэ нөхцөл байдалтай уялдан Монголоос Зөвлөлтийн цэрэг гарах болсон, үүнээс улбаалан Зөвлөлт, Хятадын харилцаанд нааштай байдал бий болсноор Монгол, Хятадын харилцаа хэвийн болох нөхцөл бүрдсэн юм. Монгол оронд өрнөсөн ардчилсан өөрчлөлтийн дүнд улс төрийн шинэ тогтолцоо бүрэлдэн Монгол Улс үзэл сурталчсан гадаад бодлогоосоо татгалзсан, нээлттэй, аливаа үзэл суртлаас ангид, улс орнуудтай эрх тэгш хамтран ашигтай ажиллах гадаад бодлого явуулах болов.

Монгол Улс, БНХАУ-ын төр, засгийн хэмжээнд 1990 оноос эхлэн төлөөлөгчид харилцан айлчилж эхэлсэн нь харилцаа, хамтын ажиллагааг бүх чиглэлээр сэргээн хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой болсон юм. Энэ хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их хурал, Улсын Бага хурлын дарга, Ерөнхий сайд, Гадаад харилцааны сайд нар Хятадад, БНХАУ-ын дарга, Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд, түүний орлогч бөгөөд ГЯЯ-ны сайд зэрэг төлөөлөгчид Монголд айлчлав. Эдгээр айлчлалын үеэр хоёр орны бүхий л салбарын хамтын ажиллагааны асуудлыг зохицуулсан гэрээ, хэлэлцээрүүд байгуулж ирсэн байна.

БНХАУ-ын Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд 1994 онд Монгол Улсад айлчлах үеэр “Монгол, Хятадын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ” байгуулсан нь тус хоёр орны цаашдын хамтын ажиллагааны чиглэл, зорилтыг тодорхойлсон чухал баримт бичиг болсон юм. Гэрээнд “хэлэлцэн тохирогч талууд бие биеийн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг харилцан хүндэтгэх, харилцан үл довтолох, дотоод хэрэгт үл оролцох, эрх тэгш харилцан ашигтай байх, энх тайвнаар зэрэгцэн орших зарчмын үндсэн дээр хоёр улсын сайн хөршийн найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ” [3. 139] гэж хоёр орны харилцааны үндсэн зарчмыг тодорхойлжээ.

Энэ үеэс Монгол, Хятадын хамтын ажиллагаа хөгжлийнхөө шинэ шатанд гарсан юм. Тус хоёр орны улс төрийн харилцаа сайжирсантай уялдаж цэргийн салбарын харилцаа, хамтын ажиллагаа сэргэх нөхцөл бүрдсэн ажээ.

БНМАУ-ын Гадаад явдлын яамны сайд Ц.Гомбосүрэн 1989 оны 3 дугаар сард БНХАУ-д айлчлах үеэрээ хоёр орны цэргийн харилцааг сэргээх санал тавьсан юм. Үүнээс нэг жилийн дараа буюу 1990 оны 3 дугаар сард Монголын Гадаад Явдлын Яам (ГЯЯ)-аас БНХАУ-ын БХЯ-ны төлөөлөгчдийг Монголд айлчлахыг урьжээ. Үүний дагуу БНХАУ-ын БХЯ-ны гадаад харилцааны газрын дарга Фу Зянин тэргүүтэй төлөөлөгчид 1990 оны 10 дугаар сард Монголд айлчилснаар хоёр орны цэргийн салбарын харилцаа албан ёсоор сэргэсэн юм.

Энэ үеэс эхлэн хоёр орны цэргийн харилцаа идэвхжиж Монгол Улсын Батлан хамгаалахын сайд, ЗХЕШ-ын дарга, УИХГ-ын дарга, Ар талын газрын орлогч дарга тэргүүтэй цэргийн төлөөлөгчид Хятадад, БНХАУ-ын БХЯ-ны сайд, Хятадын Ардын Чөлөөлөх Арми (ХАЧА)-ийн Жанжин штабын дарга, Иргэний хамгаалалтын газрын орлогч дарга, Бээжингийн цэргийн тойргийн командлагчийн орлогч тэргүүтэй цэргийн төлөөлөгчид Монголд айлчилсан байна. Ийнхүү хоёр орны цэргийн дээд удирдлагын харилцан айлчлал нь цэргийн итгэлцэл, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чухал хувь нэмэр болсон юм. Түүнчлэн тус хоёр орны цэргийн хамтын ажиллагааг улам хөгжүүлэх зорилгоор цэргийн атташе

харилцан солилцож суулгах болов. БНМАУ-аас БНХАУ-д суугаа Элчин сайдын яамны дэргэдэх цэргийн атташе 1991 оны 4 дүгээр сард албан ажилдаа орсон байна.

Монгол Улсын Батлан хамгаалахын сайд Д.Дорлигжав тэргүүтэй Монголын цэргийн төлөөлөгчид 1997 оны 11 дүгээр сард Хятадад айлчилж “Монгол Улсын БХЯ, БНХАУ-ын БХЯ хоорондын хамтын ажиллагаа, солилцооны тухай протокол”-ыг байгуулсан нь тус хоёр орны батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх хууль эрхийн анхны баримт бичиг болсон юм. Протоколд “хоёр тал бие биеийн бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг харилцан хүндэтгэх, харилцан үл довтолох, дотоод хэрэгт үл оролцох, эрх тэгш харилцан ашигтай байх, энх тайвнаар зэрэгцэн орших зарчмын үндсэн дээр хоёр улсын батлан хамгаалах салбарын найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ. Хамтын ажиллагаа, солилцоо нь хоёр орны аюулгүй байдлыг сахин хамгаалах, харилцан ойлголцох, итгэлцлийг гүнзгийрүүлэх, найрамдлаа бэхжүүлж, тус бүс нутгийн энх тайван, аюулгүй байдалд дэмжлэг үзүүлэх зорилготой” [3. 142] хэмээн тодорхойлсон байна.

Хоёр орны цэргийн хамтын ажиллагаа эрдэм шинжилгээ, судалгаа, боловсрол, соёл урлаг, хэвлэл мэдээлэл, спортын салбарт ч эрчимтэй хөгжиж хүрээгээ тэлж эхлэв. Энэ хугацаанд Монгол Улсын БХЯ-ны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, Цэргийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал, дэд захирал, Стратегийн судалгааны төвийн нарийн бичгийн дарга зэрэг судалгааны байгууллагын төлөөлөгчид БНХАУ-д айлчилж холбогдох байгууллагуудын үйл ажиллагаатай танилцан, эрдэм шинжилгээ судалгааны ажлын туршлага солилцжээ.

Боловсролын салбарт ч хоёр орны харилцаа гүнзгийрэн хөгжих болов. Монголын цэргийн албан хаагчид Хятадын цэргийн сургууль, хэлний дамжаанд суралцах явдал өргөжсөн байна. Монголын цэргийн албан хаагчид 1995 оноос эхлэн БНХАУ-д суралцаж эхэлсэн нь тус улсын цэргийн сургуульд хүн сургах арга хэмжээний эхлэл болсон юм. БНХАУ-ын Батлан хамгаалахын академи болон цэргийн

дээд сургуулиудад 2001 оны байдлаар Монголын 17 цэргийн албан хаагч тэдний зардлаар суралцсан байна. Түүнчлэн Монгол Улсын Батлан Хамгаалахын Их Сургууль (БХИС)-ийн материаллаг баазыг бэхжүүлэх, ном сурах бичгээр хангахад БНХАУ туслалцаа үзүүлэх болсны дээр хятад хэлний иж бүрэн тоногдсон танхим байгуулж өгчээ.

Хоёр орны цэргийн хамтын ажиллагаа иргэний хамгаалалтын шугамаар хөгжиж эхлэхэд Монгол Улс болон БНХАУ-ын Иргэний хамгаалалтын газрын дарга, орлогч нарын 1992, 1993 онд хийсэн харилцан айлчлал чухал ач холбогдолтой болов. Эдгээр айлчлалын үр дүнд иргэний хамгаалалтын салбарт хамтран ажиллах эхлэл тавигдаж байна.

Дурдан буй хугацаанд хоёр орны Хилийн цэргийн харилцаа, хамтын ажиллагаа хэлбэр, агуулгын хувьд өргөжсөн байна. Монгол Улсын Хилийн цэргийг удирдах газрын дарга, орлогч нар тэргүүтэй төлөөлөгчид 1992, 1997 онд БНХАУ-д, Хятадын хилийн цэргийн төлөөлөгчид Монгол Улсад харилцан айлчлал хийсэн нь хамтын ажиллагааг өргөжүүлэхэд тодорхой хувь нэмэр болсон байна. Эдгээр айлчлалын үеэр хоёр тал хамтран ажиллах тухай хэлэлцээр байгуулж ажлын уулзалтын протоколд гарын үсэг зурсан ажээ.

Хоёр орны цэргийн хамтын ажиллагааны хүрээнд Хятадын талаас үзүүлэх хөрөнгө санхүү, эд материалын тусламж чухал байр эзэлж байна. Хятадын тал Монголын Зэвсэгт хүчинд тохиолдож буй эдийн засгийн хүндрэл бэрхшээлийг харгалзан 1993 онд 4,5 сая юанийн өртөг бүхий 1300 тонн дизелийн түлш, 600 тонн авто бензин, 100 мянган метр бөс бараа тусламжаар нийлүүлсэн бөгөөд 1996 онд ХАЧА-ийн Жанжин штабын даргын айлчлалаар Монголын Зэвсэгт хүчинд 3 сая юанийн тусламж үзүүлжээ. Түүнчлэн 1996 онд Монгол оронд гарсан ой хээрийн түймрийн хор уршгийг арилгахад зориулан 3 сая юань, 100 ширхэг гал унтраах төхөөрөмжийг хүлээлгэн өгчээ.

Мөн Хятадын БХЯ-наас 1999 онд Монгол Улсын БХЯ-нд 1 сая юанийн буцалтгүй тусламж, 4.2 сая юанийн өртөг

бүхий тоног төхөөрөмжийг Бүх цэргийн дуу бүжгийн чуулга болон Дуулга теле студид хүлээлгэн өгөв. Хятадын БХЯ-ны сайд 2000 онд Монгол Улсад айлчлахдаа батлан хамгаалах салбарт зориулан 8 сая юанийн буцалтгүй тусламж үзүүлжээ. Монгол Улсын Батлан хамгаалахын сайд 2001 оны 6 дугаар сард БНХАУ-д албан ёсны айлчлал хийх үеэр Хятадын тал дахин 8 сая юанийн буцалтгүй тусламжийг олгохоор тохиролцсон байна.

Ийнхүү хоёр орны батлан хамгаалах салбарын харилцаа 1990-ээд оноос эрчимтэй хөгжиж ирсэн нь Монгол Улсын Зэвсэгт хүчний хөгжил, бэхжилтэд багагүй хувь нэмэр оруулсан юм. Эл харилцааны үр дүнг хоёр орны төр, засгийн удирдлага ч өндөр үнэлж байдаг юм. Тухайлбал, Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди 1998 оны сүүлчээр БНХАУ-д төрийн дээд хэмжээний айлчлал хийх үеэрээ “манай хоёр орны сайн хөршийн найрсаг харилцаа чанарын шинэ төвшинд хүрч, бүх салбарт идэвхтэй хөгжиж байгаад сэтгэл хангалуун байна. Монгол Улс олон тулгуурт, нээлттэй гадаад бодлогынхоо хүрээнд БНХАУ-тай тогтоосон харилцаандаа эн тэргүүн зэргийн ач холбогдол өгдөг бөгөөд харилцааны улс төр, эрх зүйн орчин улам бүр баяжин бэхжиж байна” [4] гэж Монгол, Хятадын хамтын ажиллагааны өнөөгийн төвшинг өндөр үнэлсэн байна.

**Монгол Улс, АНУ-ын харилцаа.** Тус хоёр орны хооронд батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа 1990-ээд оноос өмнө бүрэлдэж тогтоогүй байсан гэж болно. Дэлхий дахины улс төрийн байдал, олон улсын харилцаанд 1980-аад оны дунд үеэс цоо шинэ уур амьсгал, хандлага бий болсон нь Монгол, Америкийн хооронд цэргийн харилцаа тогтоох нөхцөл байдлыг бий болгосон юм.

НҮБ дахь АНУ-ын байнгын төлөөлөгч В.Уолтерс 1986 оны 7 дугаар сард хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоох асуудлаар хэлэлцээ хийж эхлэхийг Монголын талд албан ёсоор санал болгосноор хоёр талын эрх бүхий байгууллага харилцан тохиролцож 1987.01.27-нд БНМАУ, АНУ-ын хооронд дипломат харилцаа тогтжээ. Ийнхүү дипломат харилцаа тогтсоноор хоёр орны харилцааны шинэ үе эхэлсэн юм.

Энэ харилцааны хүрээнд Монгол, Америкийн цэргийн харилцаа, хамтын ажиллагаа 1990 оноос эхэлсэн байна. Монгол Улсын Ерөнхий сайд Д.Бямбасүрэн 1990 онд АНУ-д айлчилсан бөгөөд төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд явсан Гадаад Харилцааны Яам (ГХЯ)-ны хэлтсийн дарга Л.Даваагив Пентагонд зочилж Монгол, Америкийн хооронд цэргийн харилцаа тогтоох тухай асуудлыг анх хөндөж тавьсан ажээ. Үүнээс хойш жил гаруйн дараа АНУ, Монгол Улс харилцан цэргийн атташе суулгахаар тохиролцон АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны дэргэд суух цэргийн атташегаар хурандаа Майкл Бернсийг 1991 оны 8 дугаар сард Бээжингээс хавсарган суулгах болов. Мөн Монгол Улсаас АНУ-д суугаа Элчин сайдын яамны дэргэдэх цэргийн атташегаар хурандаа Г.Рагчаа 1992 онд томилогдож 1994 оноос байнга суух болжээ.

Хоёр орны цэргийн харилцааг өргөжүүлэн хөгжүүлэхэд цэргийн дээд албан тушаалтнуудын харилцан айлчлал чухал ач холбогдолтой болсон юм. Монголын ардын армийн 70 жилийн ойг 1991 оны 3 дугаар сард тэмдэглэх арга хэмжээнд АНУ-ын БХЯ-ны сайдын туслах Р.Вольтиус ирж оролцсон нь Америкийн цэргийн албан ёсны анхны төлөөлөгч байв.

Үүнээс хойш 1992-2000 онд АНУ-ын Ази, Номхон далайн цэргийн ерөнхий командлагч адмирал Ч.Ларсен, Р.Маки, Д.Блэйр, АНУ-ын Ази, Номхон далайн цэргийн хуурай замын цэргийн командлагч хурандаа генерал Р.Орд зэрэг цэргийн өндөр албан тушаалтнууд Монгол Улсад айлчилжээ. АНУ-ын Ази, Номхон далайн цэргийн командлал байрладаг Хавайн аралд Монгол Улсын Батлан хамгаалахын сайд дэслэгч генерал Ш.Жадамбаа 1995 онд, Д.Дорлигжав 1997 онд, ЗХЕС-ын дарга хошууч генерал Р.Гаваа 1993, 1995 онд, Батлан хамгаалахын тэргүүн дэд сайд хошууч генерал Ц.Дашзэвэг 1996 онд тус тус айлчлав. Эдгээр айлчлалууд нь хоёр орны цэргийн харилцаа хамтын ажиллагааг өргөтгөн, өргөн агуулга хэлбэртэй болгоход хувь нэмэр болсон бөгөөд үүний үр дүнд цэргийн боловсон хүчин сургаж бэлтгэх, хүмүүнлэгийн болон байгалийн гамшигтай тэмцэх, буцалтгүй тусламж үзүүлэх зэрэг хэлбэрээр хамтын ажиллагаа өргөжин хөгжиж байна.

Хоёр орны цэргийн харилцааг өргөжүүлэн гүнзгийрүүлэхэд 1996.06.26-нд хоёр талын гарын үсэг зурсан “Цэргийн салбар дахь солилцоо айлчлалын тухай Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр” чухал ач холбогдолтой юм. Энэхүү хэлэлцээр нь хоёр орны батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааны эрх зүйн үндэс, гол баримт бичиг болж байна.

Монгол, Америкийн цэргийн хамтын ажиллагаанд АНУ-аас үзүүлж буй хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламж чухал байр эзэлдэг юм. АНУ-ын Конгресс 1991 оны 3 дугаар сард Монголд тусламж дэмжлэг үзүүлэх тухай тогтоол гаргасан нь Монгол Улс цэргийн тусламж авах эрх зүйн үндэс бүрдэхэд таатай нөлөө үзүүлэв.

АНУ дэлхийн хөгжиж байгаа орнуудад цэргийн 3 төрлийн тусламж үзүүлдэг бөгөөд түүний хоёр нь буцалтгүй тусламж ажээ. Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбатыг 1991 оны 1 дүгээр сард АНУ-д айлчилсны дараа Пентагоноос буурай хөгжилтэй оронд өгдөг тусламжийг Монгол руу тээвэрлэх ажил эхэлсэн байна. АНУ-ын цэргийн тусламжийн барааны анхны хэсгийг 1992 онд хүлээлгэн өгчээ. Дашрамд дурдахад АНУ цэргийн янз бүрийн буцалтгүй тусламжийг Израиль, Египет, Турк, Грек, Монгол зэрэг цөөн улсад олгодог ажээ. Энэ хугацаанд АНУ-ын БХЯ цэргийн илүүдэл техник хэрэгсэл, эд хогшлоос Монгол Улсад 9 удаагийн хүмүүнлэгийн тусламжаар 10 сая ам.долларын эм, эмнэлгийн хэрэглэл, хүнс, дулаан хувцас, уул уурхайн хүнд механизм бэлэглэжээ [6. 362].

Өнгөрсөн хугацаанд АНУ-ын Засгийн газраас манай улсад үзүүлж буй хүмүүнлэгийн тусламжийн хүрээнд “Бейкер Монгуз” төсөл хэрэгжиж дууссан юм. Уг төслийн хүрээнд Улаанбаатар хотын 11 дүгээр сургуулийн засвар тохижилтын ажлыг АНУ-ын Номхон далайн цэргийн инженерийн 23 дугаар салбарын албан хаагчид Монголын барилгын цэрэгтэй хамтран гүйцэтгэжээ. Энэ ажилд Америкийн талаас 50 мянган ам.долларын хөрөнгө зарцуулсан бөгөөд барилгыг 1995 оны 8 дугаар сард хүлээлгэн өгсөн байна. Мөн энэ төслийн хүрээнд АНУ-ын барилгын цэргийнхэн 1999 онд Улаанбаатарын “Энэрэл” төвийн засварын ажлыг гүйцэтгэжээ.

АНУ-аас үзүүлдэг буцалтгүй тусламжийн 2 дахь хэлбэр бол бусад орнуудын ялангуяа буурай хөгжилтэй буюу ардчилал, зах зээлийн замд тууштай шилжсэн улсуудын цэргийн боловсон хүчнийг бэлтгэх, давтан бэлтгэхэд чиглэсэн “олон улсын цэргийн сургалт боловсрол” хөтөлбөр юм. Эл хөтөлбөрт Монгол Улс 1992 онд хамрагдсанаас хойш АНУ манай цэргийн боловсон хүчнийг сургахад жил бүр 100 мянга орчим ам.доллар зарцуулж байгаа ажээ [5]. Монголын Зэвсэгт хүчний офицерууд англи хэл, ар тал, эмнэлэг, команд штаб, стратегийн судалгааны чиглэлээр АНУ-д суралцаж байгаа бөгөөд анхны монгол офицер 1992 онд очиж суралцсанаас хойш 2000 оны байдлаар 70 гаруй хүн АНУ-ын зардлаар урт богино хугацаагаар сурсан байна.

Монголын цэргийн боловсон хүчнийг бэлтгэхэд БХИС-д үзүүлж буй тусламж, дэмжлэг чухал байр суурь эзэлдэг юм. Анх 1990 онд АНУ-ын цэргийн дээд сургуулийн төгсөх ангийн оюутнууд манай оронд ирснээс хойш АНУ-ын Вест-Пойнтын цэргийн академи, Виржини мужийн цэргийн дээд сургууль, Монгол Улсын БХИС-ийн хооронд шууд харилцаа тогтоон хамтран ажиллаж байна. Энэ хугацаанд тус сургуульд АНУ-ын хөрөнгөөр англи хэлний тэнхимийг бүрэн тоноглож өгсний дээр 1995 оноос Сан-Антониогийн Батлан хамгаалахын хэлний төвийн багш нар уригдан ирж англи хэлний хичээл зааж байна.

АНУ-ын цэргийн сургуулиудтай тус сургуулийн тогтоосон холбоо улам өргөжиж Америкийн өндөр мэргэжил, дадлагатай багш нар ирж хичээл заах болсны дээр оюутан солилцоогоор БХИС-ийн сонсогч нараас АНУ-д сургах, багш нарын мэргэжлийг дээшлүүлэх, сургуулийн захирал тэргүүтэй төлөөлөгчид харилцан айлчилж хамтын ажиллагааныхаа үр дүн, хэтийн чиг хандлагаа тодорхойлох болов.

АНУ-аас үзүүлдэг цэргийн тусламжийн гурав дахь хэлбэр нь цэргийн техник, сэлбэг хэрэгслийг найрсаг харилцаатай орнуудад худалдах явдал байдаг. Мөн илүүдэл гэгдэх цэргийн техник, хэрэгслийг үйлчилгээнийх нь хамт тодорхой улс оронд хөнгөлөлттэй үнээр худалдахыг зөвшөөрдөг ажээ. Ийм улс орны тоонд Монгол Улсыг оруулах



тухай баримт бичигт АНУ-ын Ерөнхийлөгч 1995 оны 8 дугаар сард гарын үсэг зурсан нь манай орны хувьд маш чухал ач холбогдолтой зүйл болсон юм.

АНУ-ын БХЯ-ны санаачлагаар Монголын Зэвсэгт хүчний төлөөлөгчид Ази, Номхон далайн цэргийн ерөнхий командлалын төлөвлөгөөгөөр зохиогддог төрөл бүрийн хурал, семинар, цугларалтад тогтмол оролцох болов. Оператив, ар тал, нисэх хүчин, улсыг агаарын довтолгооноос хамгаалах, цэргийн хүн эмнэлгийн зэрэг чиглэлээр болдог арга хэмжээнүүдэд Монголын Зэвсэгт хүчний офицерууд оролцох болсон нь хамтын ажиллагааны нэгэн шинэ хэлбэр болсон төдийгүй Монгол дахь цэргийн шинэчлэлийг эрчимжүүлэхэд багагүй хувь нэмэр оруулж байгаа юм. Дээрх чиглэлээр 1992-2001 онд зохиогдсон 80 гаруй хурал, семинар, цугларалтад Монгол Улсын Зэвсэгт хүчний 200 орчим, иргэний байгууллагын 40 орчим хүн тэдний ивээн тэтгэлгээр оролцсон байна [6. 362].

Түүнчлэн хоёр тал хамтарсан семинар, хурал зохион байгуулах болсон нь Монголын цэргийн шинэчлэлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой юм. Тухайлбал, зөвхөн 1999 онд “Батлан хамгаалах салбарын төсвийн боловсруулалт, хуваарилалт”, “НҮБ-ын энхийг сахиулах ажиллагааны эрх зүйн үндэс”, “Цэрэг, иргэний харилцаа” сэдвээр хамтарсан семинарыг Улаанбаатарт зохион байгуулжээ. Мөн 2000 онд Ази, Номхон далайн орнуудын бүс нутгийн орнуудын цэргийн ар талын дарга нарын зохион байгуулах хуралдааныг Улаанбаатарт хийв.

Тус хоёр орны харилцаанд үр ашигтай хөгжиж байгаа нэг чиглэл бол байгалийн гамшиг, үйлдвэрийн томоохон ослоос урьдчилан сэргийлэх, авран хамгаалах талаар хамтран ажиллаж буй явдал юм. Үүний нэг жишээ нь Монгол Улсын Иргэний хамгаалалтын газар, АНУ-ын тусгай даалгаврын нэгтгэлийн хооронд 1996 онд байгуулсан хамтын ажиллагааны Меморандумын дагуу хэд хэдэн удаа зохион байгуулсан “Balanc magic” хамтарсан сургууль юм. Эл сургуулиар шүхэрчдийн хамтарсан буулт, осол гамшигт нэрвэгдэгсдэд үзүүлэх онол, дадлагын сургалт, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх, нисэх онгоцноос төрөл бүрийн ачааг шүхрээр буулгах зэрэг сэдвээр сургалт зохион

байгуулсан нь манай шүхэрчин, аврагчдын онол, дадлага туршлагыг гүнзгийрүүлэх, шинэ техник багаж хэрэгсэлтэй танилцах, эзэмшиж сурахад чухал үр дүнтэй сургалт болов.

Монгол Улсын Хилийн цэргийг удирдах газар хээрийн холбоог шинэчлэх талаар АНУ-тай хамтран ажиллаж байна. Мөн хоёр орны эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудын хооронд харилцан айлчлах, ажлын туршлага солилцох зэргээр хамтын ажиллагаа өргөжиж эхлэв.

Монгол Улс, АНУ батлан хамгаалах салбарынхаа хамтын ажиллагааны арга хэмжээнүүдийг жил бүрийн эхэнд тохиролцон явуулж байснаа 1995 оноос эхлэн хэтийн төлөвлөгөөтэй ажиллаж, 1999 оны 11 дүгээр сард 2000-2007 оны хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлон хэрэгжүүлж эхэлжээ.

Ийнхүү хоёр улсын хамтын ажиллагаа нь цэргийн төлөөлөгчид харилцан айлчилж мэдээлэл хийх, санал солилцох, цэргийн байгуулалт, нэгтгэл ангийн үйл ажиллагаатай танилцах, АНУ-ын цэргийн байгууллагын хүмүүнлэгийн тусламжийн хүрээнд иргэний хамгаалалт, цэргийн эмнэлэг, барилгын цэргийн хамтарсан сургалт явуулах, мэргэжилтний болон материал хөрөнгийн тусламж үзүүлэх, Монголын цэргийн албан хаагчдыг сургах, мэргэжил дээшлүүлэх, англи хэлний багшийг түр хугацаагаар монголд ажиллуулах, ингэхдээ зардлын дийлэнхийг АНУ-ын тал гаргах хэлбэрээр хөгжиж, цаашид улам гүнзгийрэх төлөв байдал бий болов.

Монгол, Америкийн харилцаанд 1998 онд онцлог үйл явдал болж АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Мадлен Олбрайт Монгол Улсад айлчилж, харилцааны үндсэн зарчмыг тусгасан хамтарсан мэдэгдэл гарган, АНУ-ын Парламент Монголын ардчилал, эдийн засгийн шинэчлэлийг дэмжсэн тогтоол, Монголын парламент АНУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх тогтоол тус тус батлав.

АНУ-ын Төрийн нарийн бичгийн даргын айлчлалын үеэр 1998 оны 5 дугаар сард гаргасан Монгол Улс, АНУ-ын

харилцааны тухай хамтарсан мэдэгдэлд “хоёр тал байлдааны бус сургалт явуулах, харилцаа холбоо, цэрэг-иргэний харилцааг хөгжүүлэх, гамшигтай тэмцэх бэлэн байдлыг хангах талаар АНУ, Монголын Зэвсэгт хүчний хооронд батлан хамгаалах салбарт хамтран ажиллаж байгаад сэтгэл ханамжтай байна” [7] гэж тус хоёр орны цэргийн харилцааг үнэлжээ.

Монгол, Америкийн цэргийн харилцааг цаашид бүх талаар гүнзгийрүүлэн хөгжүүлэх нь Ази, Номхон далайн бүс нутагт аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт Монгол Улсын оролцоог өргөтгөх, дэлхий дахинд Монгол Улсын нэр хүндийг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

**Монгол Улс, ХБНГУ-ын харилцаа.** Өнгөрсөн хугацаанд ХБНГУ-тай тогтоосон харилцаа, хамтын ажиллагаа идэвхтэй хөгжиж ирэв. Монгол Улс Бүгд ХБНГУ-тай 1993 онд цэргийн дипломат харилцаа тогтоож тус улсын цэргийн анхны атташегаар хурандаа Эберхард Мөшель Бээжингээс хавсран суух болсон бөгөөд 1994 оны 2 дугаар сард Монгол Улсын Батлан хамгаалахын сайдад албан бараалхалаа хийжээ. ХБНГУ-д суух Монгол Улсын цэргийн анхны атташегаар хурандаа О.Налжир томилогдож 1991 оны 5 дугаар сараас Москвагаас хавсран ажиллав. Харин 1998 оноос Бельгийн Вант Улсаас хавсрах болжээ.

Тус хоёр орны хооронд цэргийн харилцааны уламжлал бараг үгүй бөгөөд (хуучин Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улсыг эс тооцвол) 1990-ээд оноос шинээр харилцаа тогтоож эхэлсэн юм. Энэ хугацаанд хоёр орны цэргийн дээд албан тушаалтнууд харилцан айлчилж хамтын ажиллагааны хэлэлцээр, протокол байгуулжээ. Тухайлбал, ХБНГУ-ын Холбооны БХЯ-ны парламентын төрийн нарийн бичгийн дарга В.Вильц 1995 оны 10 дугаар сард Монгол Улсад айлчлан хэлэлцээр хийв.

Энэ айлчлалын үед болсон уулзалтаар хоёр орны хамтын ажиллагааны зорилгыг “олон улсын аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, Зэвсэгт хүчний материал, техникийн хангамжийн асуудал, цэргийн байгууламж, үйл ажиллагаатай холбогдуулан хүрээлэн

байгаа орчныг хамгаалах асуудал, цэргийн аж үйлдвэрийг өөрчлөн зохион байгуулах, цэргийн албан хаагчдыг сургалтын төрөл бүрийн төвшинд хамруулахад чиглэгдэнэ” хэмээн тодорхойлсон мэдэгдэл гаргажээ [6. 364]. Түүнчлэн цэргийн сургалтад тусламж үзүүлэх хөтөлбөрийн хүрээнд “Монгол Улсын цэргийн албан хаагчдыг Германы цэргийн сургуулиудад сургах тухай Монгол Улсын БХЯ, ХБНГУ-ын Холбооны БХЯ-ны хоорондын хэлэлцээр”-т гарын үсэг зурсан байна.

ХБНГУ-ын Холбооны БХЯ-ны урилгаар Монгол Улсын БХЯ-ны төрийн нарийн бичгийн дарга хошууч генерал Ц.Дашзэвэг тэргүүтэй төлөөлөгчид 1996 оны 5 дугаар сард ХБНГУ-д айлчилж цэргийн хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар санал солилцож “Ардчилсан нийгэмд зэвсэгт хүчний эзлэх байр суурь” сэдвээр хамтарсан сургалт явуулах протоколд гарын үсэг зуржээ. Үүний дагуу 1996, 2000, 2001 онд Улаанбаатар болон Подстам хотод хэд хэдэн хамтарсан семинарыг зохион байгуулав.

Хоёр орны батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны хүрээнд ХБНГУ-ын Холбооны БХЯ-аас хүмүүнлэгийн тусламжийн шугамаар 1994-1996 онд “Монгол – I, II, III, IV” төслүүдийг хэрэгжүүлэв. Тухайлбал, 1994 онд “Монгол – II” төслийн дагуу 450 мянган дойч маркийн холбоо, ар талын сэлбэг хэрэглэл, 1995 онд “Монгол III” төслийн дагуу 17 сая дойч маркийн хувцас хэрэглэл, 1996 онд “Монгол – IV” төслөөр 22 мянган дойч маркийн үнэ бүхий эмнэлгийн багаж хэрэглэл тус тус нийлүүлжээ. Дээрх төслүүдийг хэрэгжүүлсний үр дүнд нийт 18 сая 122 мянган дойч марк, 50 сая төгрөгийн үнэ бүхий техник хэрэглэл, хувцсыг Монгол Улсын БХЯ-нд нийлүүлжээ [6. 365].

Хоёр орны харилцаанд цэргийн удирдлагын дээд төвшинд харилцан айлчлал тогтмол болж хамтын ажиллагааны асуудлыг хэлэлцэх болсон байна. Монгол Улсын БХЯ-ны төрийн нарийн бичгийн дарга хошууч генерал С.Баасанхүү 1999 онд ХБНГУ-д айлчилсан бол 2000 онд ХБНГУ-ын Холбооны БХЯ-ны төлөвлөлтийн газрын дарга хурандаа генерал В.Шнайдерхан Монгол Улсад айлчилж хоёр орны цэргийн харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар

дээд хэмжээний зөвлөлдөх уулзалт хийсэн нь ач холбогдолтой болсон бөгөөд цаашид зөвлөлдөх уулзалтыг тогтмол зохион байгуулж байх тохиролцоонд хүрсэн байна.

Үүний дагуу 2001 оны 7 дугаар сард ХБНГУ-ын Холбооны БХЯ-ны төлөвлөлтийн газрын дарга В.Шнайдерхан, тус яамны Парламентын төрийн нарийн бичгийн дарга В.Кольбов тэргүүтэй төлөөлөгчид 9 дүгээр сард Монгол Улсад айлчилж хоёр орны гадаад бодлого, аюулгүй байдал, хамтын ажиллагааны чиглэл, дэлхийн болон бүс нутгийн асуудлаар мэдээлэл солилцох, цэргийн инженерийн салбарт хамтран ажиллаж худаг ухах, сэргээх, хөдөө орон нутагт зам харилцааг сайжруулах, шинээр тавих зэрэг чиглэлээр хамтран ажиллах боломж, нөхцлийг судлах зэрэг асуудлыг хөндөн ярилцжээ.

Хоёр орны хамтын ажиллагааны төлөвлөгөөний дагуу 2001 оны 9 дүгээр сард Карлштат хотод “Ар талын боловсон хүчний сургалт”, Бонн хотноо “Цэргийн хуулийн тогтолцоо”, Улаанбаатар хотод “Дайчилгаа, цэрэг-иргэний харилцаа”, 10 дугаар сард “Цэргийн сургалт, бэлтгэл” сэдвээр хамтарсан семинарыг амжилттай зохион байгуулсан байна.

Тус хоёр орны харилцаа цэргийн боловсон хүчнийг сургах чиглэлээр амжилттай хөгжиж буй бөгөөд энэ хугацаанд ХБНГУ-ын цэргийн удирдлагын академи, Бундесверийн их сургууль, хуурай замын цэргийн офицерын сургууль, герман хэлний багшийн их сургууль, батальон, рот, салааны захирагч, герман хэлний багшийн дамжаанд Монголын 60 гаруй цэргийн албан хаагч суралцжээ. Түүнчлэн хоёр орны цэргийн сургуулиудын хооронд харилцаа тогтож, энэ хүрээнд Монгол Улсын БХИС-д ХБНГУ-ын тусламжаар герман хэлний иж бүрэн кабинетыг тоноглон ашиглалтад оруулжээ. Үүний хамт БХИС-ийн багш нарын мэргэжлийг дээшлүүлэх, герман хэлний багш нарыг бэлтгэх талаар хамтран ажиллаж эхлээд байна.

Өгүүлэн буй хугацаанд Монгол Улсын батлан хамгаалах салбарын гадаад харилцаа **бусад улс орнуудтай** нэгэн адил өргөжиж хөгжиж байна.

**Японы** ГХЯ-ны урилгаар 1995 онд Монгол Улсын Батлан хамгаалахын сайд тус улсад айлчилсан бөгөөд уг айлчлалын дүнд Японы үндэсний батлан хамгаалахын их сургуульд Монголын цэргийн албан хаагчдаас сургаж эхлэх тухай тохиролцооноор тусламжийн журмаар сургах хамтын ажиллагааны эх үүсвэр тавигдсан юм. Үүний дагуу хоёр орны цэргийн сургуулиудын хооронд байгуулсан меморандумын дагуу 1998 оноос эхлэн Монгол Улсын БХИС-ийн сонсогч нар Японы Үндэсний батлан хамгаалахын академид тэдний зардлаар суралцах болов. 2001 оны байдлаар тус академид Монголоос нэг багш, 5 сонсогч суралцаж байна. Түүнчлэн Японы Үндэсний Батлан хамгаалах газраас эрхлэн жил бүр зохион байгуулдаг Ази, Номхон далайн аюулгүй байдлын семинарт монголын судлаачдыг 1995 оноос эхлэн өөрийн зардлаар оролцуулах болжээ.

Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ) 1996 онд Хятадад суугаа өөрийн цэргийн атташег Монгол Улсад хавсран суулгах тухай хүсэлт тавьснаар тус хоёр орны цэргийн харилцаа эхэлсэн юм. Монгол Улсын Батлан хамгаалахын сайд 1999 онд БНСУ-д айлчилж хоёр орны БХЯ-ны хоорондын хамтын ажиллагааны хэлэлцээрт гарын үсэг зурсан нь тус хоёр улсын батлан хамгаалах салбарын харилцааг хөгжүүлэхэд чухал алхам болжээ. Энэ хугацаанд БНСУ манай улсад шүхэр, хувцас, нэг бүрийн хэрэглэл зэрэг 8 мянган ам.долларын хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламжийг үзүүлсэн байна. БНСУ-д Монголын цэргийн албан хаагчид анх суралцах болсон бөгөөд 2002 оны байдлаар тус улсын цэргийн сургууль, коллежид Монголоос 8 цэргийн албан хаагч суралцаж байв.

Бүгд Найрамдах Энэтхэг Улс (БНЭУ) манай улстай 1973 онд цэргийн харилцаа тогтоосон юм. Энэ хугацаанд хоёр орны цэргийн харилцаа идэвхтэй төвшинд хөгжөөгүй байв. Харин Монгол Улсын Батлан хамгаалахын дэд сайд Ц.Тогоо 2000 оны 12 дугаар сард тус улсад ажлын айлчлал хийснээр хамтын ажиллагаа сэргэх хандлагатай болжээ. Монгол Улсын Ерөнхийлөгч 2001 оны 1 дүгээр сард БНЭУ-д айлчлах үеэрээ “Цэргийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, БНЭУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр” байгуулсан байна. БНЭУ-ын цэргийн сургуулиудад Монголын

цэргийн албан хаагчдыг сургахаар тохиролцсоны дагуу 2001 оны байдлаар зөвхөн англи хэлний сургалтад цөөн тооны хүн хамрагджээ. Хоёр талын судалгааны байгууллага бүс нутгийн аюулгүй байдлын судалгааны асуудлаар мэдээлэл солилцох хэмжээнд хамтран ажиллаж байна.

Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улс (БНТУ)-ын Засгийн газар хооронд “Цэргийн салбарт хамтран ажиллах тухай”, хоёр орны ЗХЖШ-ын хооронд “Цэргийн сургалтын салбарт хамтран ажиллах тухай” хэлэлцээрт 1999 онд гарын үсэг зурсан юм. Тус хоёр орны хоорондох харилцаа өргөжиж Монгол Улсын Батлан хамгаалахын сайд болон ЗХЖШ-ын 1 дүгээр орлогч дарга тэргүүтэй төлөөлөгчид Турк улсад айлчлав. Монголын цэргийн албан хаагчид 2000 оноос Турк улсад суралцах болсон бөгөөд тус улсын тусламжаар БХИС-д Турк хэлний тэнхим байгуулагдаж, мөн 150 дугаар ангид зориулж хүн нэг бүрийн хамгаалалтын хувцас, материал олгох болов.

Монгол Улс дээрх орнуудаас гадна **Канад, Израиль, Франц, Швейцар, Польш, Бельги, Их Британи, Итали, Казакстан** зэрэг оронтой батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, боловсон хүчин бэлтгэх, иргэний хамгаалалт, энхийг сахиулах хүчний чиглэлээр харилцааны эх үндсийг тавьж эхлээд байгаа юм.

Монгол Улсын батлан хамгаалах салбарын гадаад харилцаанд дэлхийн болон бүс нутгийн олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах явдал чухал байр суурь эзлэх болов. Үүнд АСЕАН-ы бүсийн чуулга (ARF)-ыг дурдаж болох юм. Тус бүсийн чуулганы шугамаар зохиогддог хурал, зөвлөгөөн, семинарт БХЯ, УИХГ-ын холбогдох албан тушаалтнууд оролцож ирсний дээр чуулганы гишүүн орнуудын Батлан хамгаалахын сургууль, коллеж, эрдэм шинжилгээний байгууллагын тэргүүн нарын чуулга уулзалтад БХИС-ийн төлөөлөгчид идэвхтэй оролцож, 1999 онд 3 дугаар чуулга уулзалтыг Улаанбаатарт амжилттай зохион байгуулав. Мөн хүмүүнлэгийн болон энхийг сахиулах чиглэлээр зохиож буй олон улсын арга хэмжээнд Монголын зэвсэгт хүчний төлөөлөгчид тогтмол оролцож байна.

**Монгол Улсын Зэвсэгт хүчин НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд.** Олон үндэстний цэргийн хүчээр зохион байгуулдаг Энхийг сахиулах ажиллагаа (ЭСА) нь НҮБ-аас олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа томоохон арга хэмжээний нэг юм. НҮБ-ын гишүүн улсууд олон үндэстний ЭСА-нд өөрсдийн боломжийн хэмжээнд оролцох нь тэдгээрийн нэр төрийн хэрэг төдийгүй НҮБ-ын гишүүн орноос олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахиулахад оруулж буй хувь нэмэр гэж үздэг байна. НҮБ-д өөрт нь байнгын цэрэг байдаггүй тул аливаа сөргөлдөөнийг зохицуулахаар ЭСА явуулахын тулд гишүүн орнуудаас нийлүүлсэн цэрэг, техник хэрэгсэлд тулгуурлан олон үндэстний цэргийн хүчнийг бүрдүүлэн ЭСА-г явуулдаг бөгөөд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлөөс нэгэнт шийдсэн тухайн ЭСА нь гишүүн орнуудаас төлсөн татварын үндсэн дээр санхүүжигддэг юм.

Монгол Улс НҮБ-д 1961 онд гишүүнээр элссэнээс хойшхи 40 гаруй жилийн хугацаанд хоёр туйлт сөргөлдөөнөөс шалтгаалан “НҮБ-ын бүх гишүүн олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахиулах үйл хэрэгт хувь нэмрээ оруулахын тулд Аюулгүйн зөвлөлийн шаардсанаар түүний мэдэлд тусгай нэг буюу багц хэлэлцээрүүдийн дагуу олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахиулахад шаардагдах зэвсэгт хүч гаргах, тусламж үзүүлэх” /НҮБ-ын Дүрмийн 43-1 дүгээр заалт/ үүргээ биелүүлэх нөхцөл боломж бүрдээгүй байсан юм.

Монгол Улсын Засгийн газар 1999 оны 7 дугаар сарын 28-ны өдөр “Энхийг сахиулах ажиллагаанд оролцох тухай” 115 тоот тогтоол гаргасан ба уг тогтоолоор 1/ Энхийг сахиулах ажиллагаанд Монгол Улсаас сайн дурын үндсэн дээр оролцох хүмүүсийг бүртгэж, сонголт хийх замаар НҮБ-тай байгуулсан хэлэлцээр, НҮБ-ын практик, холбогдох нөхцөлүүдийн дагуу тэднийг энхийг сахиулах ажиллагаанд оролцуулах арга хэмжээ авах; 2/ НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд манай талаас оролцох мэргэжилтнүүдийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах, олон улсын хамтын ажиллагаа, дотоод нөөц бололцоонд түшиглэн энхийг сахиулагчдын багийг бэлтгэх ажил зохион байгуулахыг ГХЯ, БХЯ-нд тус тус үүрэг болгосон байна. 1999 оны 9 дүгээр



сарын 27-ны өдөр “НҮБ-ын байнгын хүчний тогтолцоонд хувь нэмэр оруулах талаар Монгол Улсын Засгийн газар НҮБ-ын хооронд харилцан ойлголцсон тухай санамж бичиг”-т Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суугаа байнгын төлөөлөгч, энхийг сахиулах асуудал эрхэлсэн НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч нар АНУ-ын Нью-Йорк хотноо гарын үсэг зурсан нь Монгол Улс НҮБ-ын бүрэн эрхт гишүүний хувьд НҮБ-ын дүрмийн дээрхи заалтаар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх бэлтгэлээ хангах, бэлэн байх шаардлага бий болсон төдийгүй Монгол Улсын цэргийн албан хаагчдаас ЭСА-нд оролцох олон улсын эрх зүйн үндэс тавигдсан юм.

Энэхүү санамж бичгийн хавсралтаар Монгол Улсын Засгийн газраас НҮБ-ын ЭСА-нд зориулан тодорхой нөхцлөөр нийлүүлэх хүн хүч, эд материалын хэмжээг штабын ажилтан 1, цэргийн ажиглагч 2, эмч, эмнэлгийн ажилтан 5 хүн, нийт 8 хүн байхаар тогтоожээ. Үүний дагуу 2000 оны 3 дугаар сард зохих судалгаа хийсний үндсэн дээр Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн хуралдаанд “НҮБ-ын ЭСА-нд Монгол Улсын Зэвсэгт хүчнээс сайн дурын үндсэн дээр оролцох хүсэлт гаргасан зарим албан хаагчдын материалыг холбогдох газарт явуулах тухай” асуудлыг хэлэлцүүлж, мөн оны 4 дүгээр сард 8 офицерын анкетыг Монгол Улсаас НҮБ-д суугаа Байнгын төлөөлөгчийн газраар дамжуулан НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагааны газарт илгээв. НҮБ-ын ЭСА-д гишүүн улсуудаас цэргийн анги, салбарууд, цэргийн ажиглагч офицер, иргэний цагдаа илгээн үүрэг гүйцэтгүүлдэг бөгөөд манай улсын хувьд цөөн тооны бэлтгэгдсэн хүмүүстэй байсныг үндэслэн 1999 онд дээрх хүн хүчийг нийлүүлэхээр санамж бичиг байгуулжээ.

Монгол Улсын Засгийн газрын тогтоол, НҮБ-тай хийсэн хэлэлцээрийн дагуу ЭСА-нд Монгол Улсын Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнээс оролцох хүмүүсийг сургаж бэлтгэх, сонголт хийх, НҮБ-ын практик, холбогдох нөхцлүүдийн дагуу тэднийг ЭСА-нд оролцуулах, манай талаас оролцох мэргэжилтнийг бэлтгэх, бэлэн байдлыг хангах, олон улсын хамтын ажиллагааны дотоод нөөц боллоцоонд түшиглэн энхийг сахиулагчдын багийг бэлтгэх ажлыг зохион байгуулах талаар эхлэл ажлуудыг Монгол Улсын Зэвсэгт хүчин холбогдох байгууллагуудтай хамтран

хийж байна. Энхийг сахиулах олон улсын ажиллагаанд Зэвсэгт хүчнийг оролцуулах олон улсын эрх зүйн үндэс бүрдэж, үүнтэй уялдан төрийн бодлого тодорхойлогдон, Зэвсэгт хүчний зарим салбар энэ чиглэлээр үүрэг гүйцэтгэхээр бэлтгэгдэж байгаа нь цэргийн албан хаагчдыг энхийг сахиулах болон олон улсын ажиллагаанд оролцуулахтай холбогдсон харилцааг зохицуулах хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагыг бий болгосон юм.

Монгол Улсын Их Хурлаас 2002 онд батлагдсан “Зэвсэгт Хүчний тухай” Монгол Улсын хуульд Зэвсэгт хүчний тайван цагийн нэг үүрэг нь “Энхийг сахиулах олон улсын хамтын ажиллагаанд оролцох” [8] хэмээн тодорхойлов. Түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч санаачлан “Цэрэг, цагдаагийн албан хаагчийг НҮБ-ын Энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай” хуулийн төсөл боловсруулан УИХ-д өргөн барьсан нь 2002 оны хаврын чуулганаар батлагдсан юм [9. 89-93].

Энэхүү хуулиар НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын ажиллагаанд цэргийн албан хаагчид төдийгүй цагдаагийн албан хаагчид оролцох нөхцөл боломжийг бүрдүүлэн түүнтэй холбогдох харилцааг зохицуулах болов. Түүнчлэн энэхүү хуулиар ЭСА-наас гадна олон улсын бусад ажиллагаа гэсэн нэр томъёо оруулж, түүнийг олон улсын байгууллага, аливаа улсын санаачлагаар зохион байгуулж байгаа энхийг сахиулах төрөл бүрийн сургалт, дадлага, цэргийн хээрийн сургууль, гамшиг, ослын хор уршгийг арилгах, авран хамгаалах болон хүмүүнлэгийн олон улсын үйл ажиллагааг ойлгоно хэмээн тодорхойлсон ажээ. ЭСА-тай холбогдсон асуудал манай улсын хувьд шинэ тутам учраас үүнтэй холбогдсон нэр томъёонуудын талаар хуулинд зохих тайлбар хийж, ажиллагаанд оролцуулахтай холбогдон Монгол Улсын Засгийн газар, чиглэл хариуцсан сайдуудын эрх хэмжээг тус тус хуульчлан баталгаажуулав. Уг хуулийг дагалдан хэд хэдэн журам гаргахаар боловсруулж бэлэн болгоод байна.

Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн өгсөн чиглэлийн дагуу Монгол Улсын Зэвсэгт хүчний Ерөнхий

штабын бүтцэд Энхийг сахиулах хүчний алба 1999 онд байгуулагдан Зэвсэгт хүчний бүрэлдэхүүнийг олон улсын ЭСА-нд оролцуулах бэлтгэл ажлыг хариуцан ажиллах болсон ба энхийг сахиулах чиглэлээр сургаж бэлтгэхээр мотобуудлагын батальон нэгийг байгуулав. Энхийг сахиулах хүчний алба /3 орон тоотой/-ыг 2001 онд Энхийг сахиулах албаны хэлтэс /5 орон тоотой/, 2003 оны 2 дугаар сард Энхийг сахиулах ажиллагааны газар /15 орон тоо/ болгон өргөтгөн зохион байгуулжээ. Тус газар байгуулагдсан цагаасаа Монгол Улсын Зэвсэгт хүчний хэмжээнд НҮБ-ын ЭСА хариуцсан нэгж болон бүс нутгийн ижил төрлийн байгууллага, албан тушаалтнуудтай тогтмол харилцаа тогтоон, хамтран ажиллаж, өөрийн оронд ЭСА-тай холбогдсон сургууль, дадлага, хээрийн сургуулийг зохион байгуулж ирэв.

Тус газар 1999 оны 9 дүгээр сард НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагааны газрын сургалтын бүлэгтэй хамтран Улаанбаатар хотноо сургалт, семинар зохион байгуулсан бөгөөд Олон улсын улаан загалмайн нийгэмлэгийн Зүүн Хойт Азийн суурин төлөөлөгчийн газраас Монгол Улсын Зэвсэгт хүчинд зэвсэгт мөргөлдөөний хуулийн сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх, цэргийн албан хаагчдыг зэвсэгт мөргөлдөөний хуулийн сургалтад хамруулах арга хэмжээг хэрэгжүүлж эхлээд байна. Энэ чиглэлийн сургалт нь энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцох цэргийн албан хаагчдын эрх зүйн мэдлэг /тухайлбал хүч хэрэглэх дүрэм/-ийг дээшлүүлэхэд ихээхэн ач тустай юм. Түүнчлэн 2000 онд НҮБ-ын ЭСА-ны газрын ВЭБ хуудаст Монгол Улсыг бүртгүүлж, өөрийн мэдээллийг байрлуулах болов.

НҮБ-ын энхийн ажиллагаанд цэргийн ажиглагч оролцож эхэлснээс хойш 50 гаруй жил өнгөрчээ. Түүнээс хойш НҮБ-ын гишүүн 90 гаруй орон өөрсдийн цэргийн ажиглагч нараа энхийн ажиллагаанд илгээгээд байгаа юм. Өнөөгийн байдлаар НҮБ-ын 15 энхийн ажиллагаанд дэлхийн 61 орны 3000 орчим цэргийн ажиглагч үүрэг гүйцэтгэж байна. Сүүлийн жилүүдэд Монгол Улсаас НҮБ-ын энхийн ажиллагаанд оролцох нөхцөл, боломж бүрдсэнээр Монгол Улсын Зэвсэгт хүчнээс 5 офицер Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс болон Баруун Сахарт явагдаж байгаа НҮБ-ын ЭСА-нд НҮБ-ыг болон өөрийн улс үндэстнээ төлөөлөн

“Цэргийн ажиглагч” хэмээх эрхэм үүргийг гүйцэтгэх болов. Тэдгээрийн 2 нь Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улсад, 3 нь Баруун сахарт явагдаж байгаа НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцож байгаа бөгөөд үүргээ НҮБ-ын стандарт нөхцлийн дагуу нэр төртэй гүйцэтгэж байна.

ЭСА-нд цэргийн салбарын хэмжээнд оролцох асуудлыг 2000 оноос судалж Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн бие бүрэлдэхүүнтэй ЭСА-ны чиглэлээр хэд хэдэн удаа команд-штабын болон хээрийн сургууль зохион байгуулсан байна. Тус ангиас 2000 оны 9 дүгээр сард Казакстан Улсад зохион байгуулсан олон улсын хамтарсан хээрийн сургууль “Центразбат-2000”, 2002 оны 9 дүгээр сард Бангладеш Улсад зохион байгуулсан олон үндэстний салааны хээрийн сургуульд тус тус нэг салаа амжилттай оролцож, сургуулийн үед тавигдсан үүргийг амжилттай биелүүлэн НҮБ-ын дундын хянагч, шинжээчдийн зүгээс олон улсын ЭСА-нд оролцож үүрэг гүйцэтгэх бүрэн боломжтой гэсэн өндөр үнэлэлт авчээ.

Мөн Номхон далай дахь АНУ-ын цэргийн командлалаас зохион байгуулдаг бүс нутгийн ЭСА-ны команд-штабын болон хээрийн сургуульд тэдний санхүүгийн дэмжлэгтэйгээр манай цэргийн албан хаагчид оролцож байна. Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнээс ЭСА-ны олон улсын хээрийн сургуульд ажиглагчаар 2 удаа, оролцогчоор явган салаа 2 удаа, олон улсын команд штабын сургуульд ажиглагч, оролцогчоор тус бүр нэг удаа оролцож, өөрийн оронд хамтарсан сургалт, семинар 10 гаруй удаа, команд-штабын сургууль 3, тактикийн хээрийн сургууль 4-ийг тус тус зохион байгуулжээ. Энэтхэг Улсад 2003 оны 2 дугаар сард зохион байгуулсан олон үндэстний энхийг сахиулах ажиллагааны команд штабын сургуульд анх удаа оролцогчоор оролцсон нь ЭСА-ны үеийн удирдлага зохион байгуулалт, оператив, тактикийн төвшинд ажиллагааг хэрхэн зохион байгуулах, газар орон дээр НҮБ, бусад төрийн болон төрийн бус байгууллагатай хэрхэн хамтран ажиллах талаар туршлага бүхий улс орнуудын цэргийн албан хаагчдаас харилцан суралцах боломж олгосон юм.

Түүнчлэн хоёр талын хамтарсан хээрийн сургуулийг

2000 оноос эхлэн зохион байгуулсан бөгөөд 2002 онд АНУ-ын цэргийн албан хаагчидтай энхийг сахиулах ажиллагаа болон хүмүүнлэгийн тусламжийн чиглэлээр хамтарсан сургууль хийсэн нь хоёр орны цэргийнхэн харилцан суралцах, туршлага солилцох ихээхэн үр нөлөөтэй арга хэмжээ болсон юм. Мөн 2003 онд Бельгийн вант Улсын тусгай хүчнийхэнтэй энхийг сахиулах ажиллагааны хамтарсан сургууль, АНУ-ын тэнгисийн явган цэргийн хүчнийхэнтэй ЭСА-ны хамтарсан хээрийн сургууль тус тус хийхээр бэлтгэж байна.

АНУ-ын Олон улсын энхийг сахиулах хүчний чадавхийг дээшлүүлэх /EPIC/ хөтөлбөр, Олон улсын цэргийн боловсрол, сургалтын өргөтгөсөн E-IMET хөтөлбөрийн санхүүжилтээр олон улсын ЭСА-ны эрх зүйн болон сургалтын асуудлаар хамтарсан сургалт, семинар хийж, холбогдох албан тушаалтныг АНУ-д дамжаанд суралцуулах болов. Тухайлбал, 2000 оны 8 дугаар сар болон 2001 оны 9 дүгээр сард АНУ-ын Батлан хамгаалахын Олон улсын эрх зүйн хүрээлэнгийн мэргэжилтнүүдтэй хамтран ЭСА-ны эрх зүйн асуудлаар хамтарсан сургалт зохион байгуулж 2000 оны 10 дугаар сард АНУ-ын Хавай мужийн Хонолулу хотноо зохион байгуулсан “Сургагч нарыг бэлтгэх сургалт, семинар”-т ЗХЕШ-ын Энхийг сахиулах хүчний албаны бүрэлдэхүүн, Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн багш нар оролцсон байна. Мөн 2001 оны 8 дугаар сард “Энхийн ажиллагаа” сэдэвт сургалт зохион байгуулав.

Зүүн хойд Азийн энхийг сахиулах ажиллагааны дадлага-семинарыг 2002 онд өөрийн оронд анх удаагаа зохион байгуулсан нь энэ талаар туршлага бүхий улс орны төлөөлөгчид Монгол Улстай танилцах, харилцан туршлага солилцох, манай цэргийн албан хаагчид харьцангуй олон тоогоор хамрагдаж, суралцах таатай боломжийг бүрдүүлсэн юм. Мөн 2002 онд Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний стратегийн цугларалтыг энхийг сахиулах ажиллагаа сэдвээр зохион байгуулсан нь удирдах бүрэлдэхүүний хувьд энэ талаарх ойлголтыг өргөжүүлэх, тэдний зүгээс тус тусын чиглэлээр энэхүү ажиллагаанд оролцох зохих бэлтгэлийг хангах урьдчилсан нөхцөл болсон байна.

Монгол Улс 2006 онд болох олон үндэстний салаадын

хээрийн сургуулийг өөрийн оронд зохион байгуулах саналыг дэвшүүлээд байгаа бөгөөд тус улс нь энхийг эрхэмлэсэн, төвийг сахисан улс болохын хувьд бүс нутгийн орнуудын дунд цэргийн итгэлцлийг бэхжүүлэх, өөрийн улсын Зэвсэгт хүчнийг олон улсын ЭСА-нд бэлтгэхэд энэ сургуулийн ач холбогдол орших юм.

Тус улс нь ХБНГУ, Канад, Нидерланд, Ирланд, Швед, Финлянд, Балбын Вант Улс, Малайз Улсад байдаг энхийг сахиулах хүчний олон улсын сургалтын төвүүдээс цэргийн ажиглагч, штабын болон ар талын ажилтан бэлтгэх талаар санал хүлээн авч байгаа боловч санхүүгийн хүндрэлийн улмаас зөвхөн сургалтын болон тээврийн зардлыг бүрэн даасан тохиолдолд л цэргийн албан хаагчдаа суралцуулж буй юм. Одоогийн байдлаар 11 цэргийн албан хаагч, 2 энгийн албан хаагчийг ХБНГУ, Ирланд, Нидерланд, АНУ, Канад, Швейцарь, Иран Улс дахь энхийг сахиулах хүчний сургалтын төвүүдэд сургаж бэлтгээд байна.

Дотооддоо ЭСА-ны сургалт нь манай Зэвсэгт хүчний сургалтын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болж, ингэснээр зарим салбар, офицер, ахлагч нар энхийг сахиулах ажиллагаанд оролцох бэлтгэлтэй болов. Зэвсэгт хүчний бүхий л анги, салбаруудад ЭСА-ны чиглэлээр заах хичээлийн хөтөлбөрийг ЭСА-ны сургалтын стандарт өөрчлөгдөж байгаатай холбоотойгоор шинэчлэн боловсруулан мөрдүүлж эхлээд байна. Мөн НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагааны газраас бэлтгэн гаргадаг тактикийн төвшний сургалтын гарын авлагуудыг монгол хэлнээ орчуулан анги, салбаруудын сургалтад ашиглахаар бэлтгэж байна.

АНУ-ын энхийг сахиулах ажиллагааны чадавхийг нэмэгдүүлэх хөтөлбөрийн хүрээнд Зэвсэгт хүчний жанжин штабт англи хэлний лаборатори байгуулан офицер, ахлагч нарын хэлний мэдлэгийг дээшлүүлэхэд ашиглаж байгаа нь цаашид ЭСА-нд оролцох бие бүрэлдэхүүний хэлний мэдлэгийг дээшлүүлэхэд зохих үр дүнгээ өгөх юм. Төв аймгийн Алтанбулаг сумын Таван толгойн районд байрлах Зэвсэгт хүчний сургалтын төвд ЭСА-ны сургалт явуулахад зориулсан хичээлийн цэгүүдийг 2000 оны 4 дүгээр сард

байгуулан тохижуулав. Цаашид ЭСА-ны үед хэрэглэгддэг тактикийн арга, техникүүдээр хичээллэх бололцоотой хичээлийн цэгүүдийг нэмж байгуулахаар төлөвлөж байна.

Цаашид улс төрийн хувьд төвийг сахисан, дотоод байдал нь тогтвортой манай улсад энхийг сахиулах ажиллагааны олон улсын сургалтын төв байгуулбал бүс нутгийн орнуудын энхийг сахиулах ажиллагаанд оролцох бүрэлдэхүүнийг цаг уурын эрс тэс нөхцөлд сургах бололцоог бүрэлдүүлэх юм. Энэ төвийг байгуулсанаар өөрийн цэргийн албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, орчин үеийн байлдааны зэвсэг техник, технологиос сурч эзэмших, цэргийн салбарт гадаад харилцаа, хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой болно.

НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагааны газрын Сургалтын албаны дарга, өөрийн ажилтныхаа хамт Монгол Улсад 2003 оны 2 дугаар сарын 28-наас 3 дугаар сарын 5-ны өдрүүдэд айлчилж, Монгол Улсын энхийг сахиулах ажиллагаанд оролцох талаарх бэлтгэл ажил, цэргийн албан хаагчдын сургалт бэлтгэл, Энхийг сахиулах ажиллагааны сургалтын төвтэй танилцан, Зэвсэгт хүчний удирдлагатай уулзаж тодорхой асуудлуудаар санал бодлоо солилцов.

Ойрын ирээдүйд НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагааны газрын штабт Монгол Улсын Зэвсэгт хүчний төлөөлөгч ажиллуулах, эсвэл Монгол Улсаас НҮБ-д суугаа Байнгын төлөөлөгчийн газарт цэргийн зөвлөхийн орон тоо гаргаж мэргэжлийн офицер томилж ажиллуулах талаар тодорхой алхам хийгээд байна. ЗХЖШ-ын Энхийг сахиулах ажиллагааны газар Монгол Улсын Зэвсэгт хүчнээс НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцох талаар ойрын 5 жилийн хугацаанд баримтлах бодлогын төлөвлөгөө боловсруулахаар ажиллаж байгаа бөгөөд энэхүү төлөвлөгөө гарснаар цаашдын үйл ажиллагааны чиглэл улам бүр тодорхой болох юм.

Тус улс цаашдаа НҮБ-ын ЭСА-ны нөөц хүчний системд цэргийн салбар бүртгүүлж, Монгол Улсын Зэвсэгт хүчин ЭСА-нд цэргийн ажиглагч төдийгүй цэргийн салбар оролцуулах бололцоотой гэдгээ илэрхийлэн, энэ талаар холбогдох бэлтгэлийг ханган цэргийн салбар илгээн үүрэг

гүйцэтгүүлэх талаар ажиллаж байна. Хэдийгээр энэ талаар бэлтгэгдэж байгаа манай цэргийн албан хаагчид үүрэг гүйцэтгэхэд бэлэн байгаа хэдий ч ар тал, санхүүгийн талаар нэлээд хүндрэлтэй байгаа бөгөөд цаашид яаралтай шийдвэрлэх асуудлын нэг болоод байна. Тухайлбал:

- Тээврийн хэрэгсэл, хүн нэг бүрийн хэрэгсэл, ЭСА-ны үед зайлшгүй шаардлагатай байдаг зарим тусгай хэрэгсэл гэх мэт;
- Энхийг сахиулах бие бүрэлдэхүүнийг тээвэрлэх, хүмүүнлэгийн үйл ажиллагааг явуулах зорилгоор АНУ-аас тусламжийн журмаар ачаа тээврийн онгоц /С-130/-ыг авах асуудлыг судалж шийдвэрлэх;
- АНУ-ын Олон улсын энхийг сахиулах хүчний чадавхийг дээшлүүлэх /EPIC/ хөтөлбөрийн хүрээнд энхийг сахиулах хүчний команд-штабын сургуулийн дадлага хийх компьютерийн танхим байгуулах;
- Зэвсгийн чанартай бус цэргийн нэг бүрийн хэрэгсэл /аранз, хорт утааны баг, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хүрз, байрлал тодорхойлогч, эмнэлгийн анхан шатны тусламжийн иж гэх мэт/-ийг тусламжийн хүрээнд бусад улсаас авах асуудлыг судлан шийдвэрлэх;
- Манай цэргийн салбар олон улсын ЭСА-нд амжилттай оролцохын тулд бусад улсын цэргийн хүчинтэй идэвхтэй харилцан ажиллах чадвартай байх учиртай. Үүнд нөлөөлөх гол хүчин зүйл нь холбооны адил төвшний хэрэгсэлтэй, түүнийгээ сайтар эзэмшсэн байх ёстой юм. Иймээс энэ асуудлыг АНУ, ХБНГУ, Канад, БНСУ зэрэг эдийн засгийн өндөр чадавхтай улсуудад хандан тавьж тодорхой үе шаттайгаар шийдвэрлүүлэх зэрэг болно.

Монгол Улс НҮБ-ын ЭСА-нд оролцсоноор олон улсын энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах тухай гадаад бодлогынхоо нэг зорилт, чиглэлийг хэрэгжүүлэхэд чиглэсэн тодорхой алхам болох бөгөөд энэ нь Монгол Улсыг сурталчлах, Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадвар, ерөнхий мэдлэгийг дээшлүүлэх, тэдний зүгээс орчин үеийн технологи,



байлдааны зэвсэг техникийг сурч эзэмших, цэргийн салбар дахь олон улсын харилцааг гүнзгийрүүлэхэд тус дөхөм үзүүлэх ач холбогдолтой юм Түүнчлэн НҮБ-ын зохих журмын дагуу энхийг сахиулах бодит ажиллагаанд оролцуулсан цэргийн албан хаагчид, зэвсэг техникийн түрээсэнд зохих нөхөн төлбөр авснаар ямар нэг хэмжээгээр батлан хамгаалах зардлыг хөнгөвчлөх, цэргийн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, цаашилбал улсын төсөвт тодорхой хэмжээгээр хувь нэмэр болно.

Ийнхүү Монгол Улсын батлан хамгаалах салбарын гадаад харилцаа 1990-ээд оноос ихээхэн эрчимжиж чанарын шинэ төвшинд гарав. Өнөөгийн байдлаар батлан хамгаалахын атташег байнга буюу хавсран суулгах төвшинд 15 оронтой цэргийн салбарт шууд харилцаа тогтоогоод байна. Монгол Улсаас ОХУ, БНХАУ, АНУ, Бельгийн Вант улсад батлан хамгаалахын атташе байнга сууж байгаа бөгөөд БНСУ-ыг Бээжингээс, Канадыг АНУ-аас, ХБНГУ, Франц, Италийг Бельгиэс хавсран ажиллаж байна. ОХУ, БНХАУ, АНУ-ын батлан хамгаалахын атташе манай оронд байнга сууж, ХБНГУ, Англи, Польш, Израиль, БНСУ, Канад, Бельги, Швейцар, Итали, Турк, Японы батлан хамгаалахын атташе нар Бээжингээс хавсран дипломат үүргээ гүйцэтгэж байна.

Монгол Улсын батлан хамгаалах салбарын гадаад харилцаа нь хөрш хоёр орон болон дэлхийн улс төрийн бодлогод нөлөө бүхий орнуудтай цэргийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх, бүс нутгийн аюулгүй байдлыг хангахад нөлөө бүхий бөгөөд манай улсын ардчилсан өөрчлөлтийг дэмждэг, хамтын ажиллагаа явуулж байгаа орнуудтай батлан хамгаалах салбарын харилцаа холбоог хөгжүүлэх, мөн манай улсыг сонирхогч бусад орнуудтай харилцаа холбоо тогтоох, дэлхийн хамтын нийгэмлэгийн цэргийн салбарт хамтран ажиллах, НҮБ-ын энхийг сахиулах хүчний үйл ажиллагаанд оролцох гэсэн үндсэн чиглэлээр хэрэгжиж ирэв.

Монгол Улсаас дэлхийн улс орнуудтай тогтоосон эл харилцаа нь зэвсэгт хүчний хөгжил, бэхжилтэд тодорхой хувь нэмэр болж буй төдийгүй төр, засгаас дэвшүүлсэн цэргийн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд чухал хүчин зүйл болж байна. Шинэ зуунд батлан хамгаалах салбарын гадаад харилцааг

улам идэвхжүүлж, өргөтгөх, одоогийн харилцаанд голлож буй хэлбэр, агуулгыг баяжуулах нь улс төр, дипломатын аргаар улс орныхоо аюулгүй байдлыг хангах төрийн бодлогыг хэрэгжүүлж, улмаар Монголын цэргийн шинэчлэлийг эрчимжүүлэхэд үр нөлөөгөө үзүүлэх нь дамжиггүй юм.

**АШИГЛАСАН НОМ, БҮТЭЭЛ, СУРВАЛЖ,  
СУДАЛГААНЫ МАТЕРИАЛ**

1. Монгол Улсын Батлан хамгаалахын цагаан ном. 1997-1998 он. УБ., 1998.
2. Зэвсэгт хүчний түүх. 1990-1997 он. УБ., 1997. (БХЭШХ-ийн номын санд буй эрдэм шинжилгээний төслийн ажлын тайлан).
3. Монгол Улсын цэрэг дипломатын харилцаа. УБ., 1998. (БХЭШХ-ийн номын санд буй эрдэм шинжилгээний төслийн ажлын тайлан).
4. Ардын эрх сонин. 1998.12.12. №298.
5. Ардын эрх сонин. 1995. №198.
6. Монгол Улсын Батлан хамгаалах яам (түүхийн тойм). УБ., 2001.
7. Ардын эрх сонин. 1998.05.04. №103.
8. Соёмбо сонин. 2002.06.10-18. №24, 25.
9. Монгол Улсын Зэвсэгт хүчний эрх зүйн үндэс. Хууль тогтоомж, эрхийн актын эмхтгэл. УБ., 2002.

ДОЛООДУГААР БҮЛЭГ.  
**ИРГЭНИЙ НИЙГМИЙН ТӨЛӨВШИЛ,  
ЦЭРЭГ - ИРГЭНИЙ ХАРИЛЦАА**

*Ph.D Ч.Эрдэнэчулуун*  
/БХЭШХ-ийн дэд захирал,  
эрдэмтэн нарийн бичгийн дарга  
*Б.Содбилэг*  
/Цэрэг, иргэний харилцааны  
судалгааны төвийн эрдэм  
шинжилгээний ажилтан/

**1. Монголын иргэний нийгмийн төлөвшил**

Монгол Улсын иргэний нийгмийн төлөвшил, хөгжлийн талаар эрдэмтэн, судлаачид дараахь чиг үүргүүдийг онцлон үзэх болжээ. Үүнд:

1. Өөрийгөө зохицуулах;
2. Нийгмийн интеграцчлал;
3. Иргэний нийгмийн субьектүүдийн өөрөө өөрийгөө хөгжүүлж буй байдал;
4. Нийгмийн харилцааны нөхцлийг гомогенизид оруулах зэрэг ойлголтууд багтаж байна.

Иргэний нийгмийн өнөө, хэтийн дүр төрх, төлөвийг тодорхойлох дараахь гол шинжүүд монголын уламжлалт болон орчин үеийн ахуй, ухамсрын харилцаанд төлөвшиж, улмаар үндэсний өвөрмөц онцлог, арга замаар хөгжиж байна.

Иргэдийнхээ үндэс угсаа, нийгмийн гарлыг ялгаварлахгүйгээр ардчилсан эрх, эрх чөлөөг дээдлэн эрх, үүрэг, хариуцлагын зохистой нэгдлийг хуулийн хүрээнд хүн бүхэнд адил тэгш байдлаар эдлүүлэх нь иргэний нийгмийн гол шинж билээ.

Энэ утгаараа Монголын ахуй, ухамсар, оюун санааны уламжлалд, эрх чөлөө, үүрэг хариуцлагын нэгдэл нь аж ахуйн анхдагч микро төвшний харилцаанд төрийн зохицуулалт, хяналтаас чөлөөтэй, харин макро төвшний хувьд төрийн аядуу зохицуулалтад байсан гэж үзэх бүрэн үндэстэй юм. Энэ нь иргэний нийгмийн эрх, эрх чөлөөний тулгуур зарчим

монголд хөгжих бодит үндэс болсон юм.

Монголчуудын амьжиргааны эх сурвалж, амьдралын орчин нь үндсэндээ мал аж ахуй байв. Малчид малаа маллаж, өсгөж үржүүлэх, түүхий эд, үр шимийг нь ашиглах, нүүдэл хийх зэрэг үйлдвэрлэлийн шинжтэй үйл ажиллагааны аль ч төрөлд тэдний эрх, эрх чөлөөг хязгаарласан төрийн албадлагын шинжтэй зохицуулалт үгүй байсан бөгөөд үүрэг, хариуцлагын хувьд ч эрх, эрх чөлөөний хэм хэмжээтэй нийцсэн, бүх зүйл малчин хүн өөрөөс нь хамаарах шинжтэй байсан байна (Тоталитар тогтолцоонд байснаас бусад он жилүүдэд).

1990 оноос өмнө ард иргэд Үндсэн хуулиар олгогдсон эрхийнхээ дагуу олон нийтийн байгууллагад хамрагдан үйл ажиллагаанд нь оролцдог байсан хэдий ч эдгээр байгууллагууд нь иргэдийн эрх ашиг, сонирхлыг илэрхийлэгч бус харин төржсөн намын үзэл суртлын зэвсэг болж байсан байна.

Тухайлбал, Монголын залуучуудын цорын ганц байгууллага болох “Монголын Хувьсгалт Залуучуудын Эвлэл” нь өөрийн дүрмэндээ *“Монголын Хувьсгалт Залуучуудын Эвлэл бол Монгол Ардын Хувьсгалт Намын дайчин туслагч, бэлтгэл хүчин мөн”* хэмээн зааж, залуу үеийг социализм, коммунизмыг байгуулах үйлсэд бүх хүч, авъяас, чадвараа дайчлан оролцуулагч болгон хүмүүжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж байв. Үүнтэй адил “Монголын ахмадын хороо”, “Монголын үйлдвэрчний эвлэл”, “Хүүхдийн төлөө үндэсний фонд” зэрэг байгууллагууд ч мөн л үзэл сурталчсан, намын бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байсан юм.

Харин 1990 оны нийгэм, улс төрийн хүрээнд гарсан эргэлтийн чанартай өөрчлөлтүүд нь зөвхөн Монгол Ардын Хувьсгалт Намыг шинэчлэгдэхэд хүргэсэн төдийгүй намын шууд харъяанд байсан олон нийтийн байгууллагууд ч өөрчлөгдөн шинэчлэгдэх нөхцлийг бий болгосон юм.

Харин 1990 оны ардчилсан хувьсгалын дүнд бүхнийг нам, төрөөс удирдан зохицуулдаг байсан тоталитар

тогтолцооноос татгалзан хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлсийг эрхэмлэдэг, нээлттэй, бие даасан тогтолцоонд шилжиж 1992 онд шинэ Үндсэн хуулиа шинэчлэн баталсан билээ. Энэхүү Үндсэн хуулинд “. . . эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно” [1. 3] гэж тунхагласан байдаг. Дээрх зорилгыг үндэслэн иргэний нийгэм хөгжиж, төлөвших үндэс суурь болох хүний эрх, эрх чөлөөг хуульчлан баталгаажуулсан. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн хоёрдугаар бүлгийн:

- 16 дугаар зүйлийн 3-т “Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө;
- 16 дугаар зүйлийн 7-д “Сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно. Иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллуулж болно;
- 16 дугаар зүйлийн 8-д “Соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй. Зохиогч, шинэ бүтээл, нээлтийн эрхийг хуулиар хамгаална;
- 16 дугаар зүйлийн 9-д “Шууд буюу төлөөлөгчийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно;
- 16 дугаар зүйлийн 10-д “Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний хувьд хүнийг ялгаварлан

гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Төрийн зарим төрлийн албан хаагчийн намын гишүүнийг түдгэлзүүлж болно;

- 16 дугаар зүйлийн 16-д “Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал цуглаан хийх журмыг хуулиар тогтооно [1. 8-9].

Үндсэн хуулийн дээр дурьдсан заалтуудаас гадна иргэний нийгмийн харилцааг “Төрийн бус байгууллагын тухай”, “Улс төрийн намын тухай”, “Төр, сүм хийдийн харилцааны тухай”, “Үйлдвэрчний эвлэлийн тухай”, “Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” зэрэг хууль, эрх зүйн актуудаар баталгаажуулж өгсөн.

Эдгээр хуулиудаас 1997 онд батлагдсан “Төрийн бус байгууллагын тухай” хуулийг онцлон авч үзье. “Төрийн бус байгууллагын тухай” хуулийн зорилтыг “Монгол Улсын Үндсэн Хууль болон Монгол улсын олон улсын гэрээгээр тодорхойлсон хүний эрхийг хэрэгжүүлэх зорилгоор иргэд эвлэлдэн нэгдэх, төрийн бус байгууллагыг үүсгэн байгуулах болон төрийн бус байгууллагын үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” [2] гэж тодорхойлжээ. Энэ хуулийн нэгдүгээр бүлгийн дөрөвдүгээр зүйлийн 1-д “төрийн бус байгууллага гэж иргэд, төрийн байгууллага (хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллага)-аас бусад хуулийн этгээдээс нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр байгуулагдан үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг ашгийн төлөө бус байгууллагыг хэлнэ” [2] гэж заасан байна.

Төрийн бус олон нийтийн байгууллагууд нь төр засгаас хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааг ард иргэдэд хүргэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд төр засаг, ард иргэдийг хооронд нь холбож өгдөг “гүүр” юм. Тухайлбал, “Ядуурлыг бууруулах үндэсний төв” (1996-2000 он хүртэл Засгийн газраас баталсан “Ядуурлыг бууруулах үндэсний

хөтөлбөр”-ийг хэрэгжүүлсэн), “Монголын ахмадын холбоо”, “Монголын хүүхдийн эрхийг хамгаалах үндэсний төв”, “Монголын эмэгтэйчүүдийн холбоо”, “Монголын залуучуудын холбоо” зэрэг байгууллагууд нь төр засгаас тодорхой хэмжээний санхүүжилт авч гишүүд, дэмжигчдэдээ төрийн үйлчилгээг үзүүлдэг. Төрөөс хөрөнгө санхүүгийн дэмжлэг авч бодлого, үйл ажиллагаагаа явуулдаг эдгээр байгууллагуудаас гадна бие даан гишүүд дэмжигчдэдээ үйлчилдэг төрөл бүрийн чиглэлийн төрийн бус байгууллагууд үйл ажиллагаагаа явуулж байна.

Энэ бүх төрийн бус олон нийтийн байгууллагын бодлого, үйл ажиллагааг “Төрийн бус байгууллагын тухай” хуулиар зохицуулдаг.

Одоогийн байдлаар Монгол Улсад Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгэлтэй 2100 гаруй төрийн бус байгууллагууд (Хууль зүй, дотоод хэргийн яамны мэдээлэл, 2001 оны 6 сарын байдлаар) үйл ажиллагаагаа явуулж байна. Дээрх тоо нь 1996 оны тоотой харьцуулахад даруй 3 дахин өсчээ. Эдгээр төрийн бус байгууллагууд бодлого, үйл ажиллагааны чиглэл, нийгэмд гүйцэтгэж буй үүргээрээ системлэг, нэгдмэл чанартай болж төлөвшиж байна.

Хэдийгээр манай улсад үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудын тооны өсөлт өндөр байгаа нь сайшаалтай боловч тэдгээр байгууллагуудын чадавхи, нөөц бололцоог дээшлүүлэх бэхжүүлэх асуудалд төрийн дэмжлэг зайлшгүй шаардлагатай байна. Төрийн бус байгууллагууд нь иргэний нийгмийн институцийн хувьд төр, түүний байгууллагуудад хяналт тавих, гишүүд болон иргэдийн эрх, ашиг сонирхлыг идэвхтэй илэрхийлэх, хамгаалах, энэ үүднээсээ төрд дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ мөн шахалт үзүүлэх зэрэг үйл ажиллагаа нь Монгол Улсын иргэний нийгмийн төлөвшилд зохих хувь нэмэр болж байна.

Монгол улсын иргэн, төрийн байгууллагаас бусад хуулийн этгээд төрийн байгууллагаас зөвшөөрөл авахгүйгээр өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс дангаараа буюу хамтран төрийн бус байгууллага байгуулах эрхтэй. Гэхдээ Хууль зүй, дотоод хэргийн яам болон Улсын



бүртгэлийн газар бүртгүүлснээр үйл ажиллагаагаа албан ёсоор явуулах эрхтэй болдог. Мөн төрийн бус байгууллагын үйл ажиллагаа нь олон түмэнд нээлттэй ил тод байх ба түүний гишүүд болон иргэд хэн ч тухайн байгууллагын тайлантай танилцаж болох эрхийг хуулиар баталгаажуулсан байдаг.

Төрийн бус байгууллагыг хууль ёсны гэж хүлээн зөвшөөрөх дараахь нөхцлүүд байдаг. Үүнд:

- Төрийн бус байгууллагыг бүртгэх журмын дагуу уг төрийн бус байгууллагад Хууль зүй, дотоод хэргийн яамнаас үйл ажиллагаагаа явуулах албан ёсны зөвшөөрөл, гэрчилгээ олгодог,
- Хууль зүй, дотоод хэргийн яам нь зохих шаардлага хангасан баримт бичгийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор дараахь шийдвэрийн аль нэгийг гаргадаг
  - *төрийн бус байгууллагыг улсын бүртгэлд бүртгэх;*
  - *дор дурьдсан тохиолдолд улсын бүртгэлд бүртгэхээс татгалзах (тухайн байгууллагын зорилго нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцээгүй тохиолдолд)*
- Үүсгэн байгуулагчдаас төрийн бус байгууллага байгуулах шийдвэр гаргаж байгууллагын дүрмийг баталснаар төрийн бус байгууллагыг үүсгэн байгуулсанд тооцох бөгөөд улсын бүртгэлд бүртгүүлснээр хуулийн этгээдийн эрх эдэлдэг [2].

Улсын Их Хурал болон Засгийн газраас батлагдсан хууль, эрх зүйн баримт бичиг, хөтөлбөрүүд нь төрөөс иргэний нийгэмтэй харилцах “зураглал”-ыг тодорхойлж байдаг. Монгол Улсын хувьд төрөөс төрийн бус байгууллагуудтай харилцахдаа дараахь хуулийн заалтуудыг баримталдаг. Үүнд:

- Төрөөс төрийн бус байгууллагын хууль ёсны эрхийг хамгаална.
- Төрийн бус байгууллага нь төрөөс хараат бус байна.

- Төрийн байгууллага нь төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн болон бусад хэлбэрийн дэмжлэг үзүүлж болно.
- Төрийн байгууллагын үйл ажиллагаатай холбогдсон төрийн нууцад үл хамаарах мэдээлэл төрийн бус байгууллагуудад нээлттэй байна.
- Хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас гаргах шийдвэрийн төсөл боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд саналыг нь үндэслэн төрийн бус байгууллагыг оролцуулж болно.
- Төрийн бус байгууллага нь төрийн байгууллагын талаар гаргасан шийдвэрийн талаар байр сууриа илэрхийлж мэдэгдэл хийж болно [2].

*Дээрх хуулийн заалтууд нь төрийн бус байгууллагын үйл ажиллагааг нээлттэй ардчилсан болгох хийгээд төрөөс хараат байх, төртэй харилцах байр суурийг тодорхойлж байдаг. Мөн уг хуулийн дөрөв болон зургаадугаар заалт нь иргэний нийгмийн байгууллагуудад төр, засгийн бодлогын бүхий л баримт бичгүүдтэй (төрийн нууцаас бусад) танилцах, түүнд үнэлэлт дүгнэлт өгөх, мэдэгдэл хийх, өөрсдийн байр сууриа илэрхийлэх боломжийг олгож байгаа юм.*

*Төр-төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг нягтруулах, төрөөс төрийн бус байгууллагыг үйл ажиллагааг дэмжих, татварын хөнгөлөлт үзүүлэх тухай Төрийн бус байгууллагын тухай хуулийн дөрөвдүгээр бүлгийн 21 зүйлд дараахь заалтууд байдаг. Үүнд:*

- *Нийгэмд үйлчилдэг улсын бүртгэлтэй төрийн бус байгууллагад өргөсөн хандив, гишүүний татвар, өвлүүлсэн хөрөнгө, дүрмийн зорилтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлогыг албан татвараас чөлөөлнө;*
- *Гишүүддээ үйлчилдэг улсын бүртгэлтэй төрийн бус байгууллагын гишүүний татвар,*

*хандиваас олсон орлогыг албан татвараас чөлөөлнө;*

- *Улсын бүртгэлд бүртгүүлсэн төрийн бус байгууллагад энэ хуульд зааснаас бусад хөнгөлөлт үзүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна [2].*

*Төрөөс төрийн бус байгууллагад үзүүлж буй дээрх хөнгөлөлтүүд нь төрийн бус байгууллагын үйл ажиллагаа явуулах таатай нөхцлийг бүрдүүлж байна.*

Монгол Улсын иргэний нийгмийн төлөвшил нь эрдэмтэн, судлаачдын анхаарлыг ихэд татах болсон нь энэ чиглэлийн судалгаа, шинжилгээний ажил эрчимтэй хөгжих нэг үндэс болсон гэж үзэж болно.

Эдгээр судлаачид монголын төрийн байгуулал, бүтэц зохион байгуулалт, хууль эрх зүйн эх сурвалж, монголын уламжлалт нийгмийн ахуй, амьдралын хэв маяг зэрэг ойлголтуудыг судалгаа шинжилгээний ажлын үндсэн суурь болгож судалсны үндсэн дээр Монголд 1920 он хүртэл иргэний нийгмийн уламжлалт бүрдэл хэсгүүд байсан гэж үзжээ. Харин төржсөн намын дэглэм улам хүчтэй болж, бүхнийг цагдан захиргаадагч тоталитар тогтолцоо тогтон ард олны хувийн аж ахуйг устгаж, эдийн засгийн бүхий л эрх мэдлийг төр бүхэлд нь гартаа атгасан үеэс 1990 он хүртэлх он жилүүдэд иргэний нийгмийн олон шинжүүд бүдгэрсэн байна.

Ардчилсан хувьсгалын үйл явцад улс төр, эдийн засаг, оюун санааны зэрэг нийгмийн бүхий л хүрээнд гарсан өөрчлөлтийн үр дүнд манай улсад иргэний нийгэм хөгжиж төлөвших нөхцлүүд үндсэндээ бүрэлдсэн байна. Улс төрийн шинэ тогтолцоо бүрэлдэн, төрийн дээд байгууллагуудыг чөлөөт ардчилсан сонгуулиар сонгодог механизм үйлчилж, олон нам, улс төрийн хүчнүүд зэрэгцэн оршиж, үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн нь иргэдийн үүсгэл санаачлагын олон байгууллага үйл ажиллагаагаа төрөөс хараат бус байдлаар явуулах боломжийг олгосон. Үүний зэрэгцээ эдийн засгийн хүрээн дэх аж ахуйн харилцааг зохицуулах эрх зүйн үндсийг бий болгон улсын болон

хоршооллын өмчийг хувьчлах, суурь үнийг чөлөөлөх, хувийн хэвшлийг дэмжих, банк санхүүгийн тогтолцоог өөрчлөх зэрэг зах зээлийн эдийн засагт шилжих цогцолбор арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд иргэн хүн өмчийн “эзэн субъект” болж өмчлөх эрхээ бодитойгоор хэрэгжүүлж эхэлсэн юм. Харин оюун санааны хүрээнд иргэдийн үнэт зүйлсийн баримжаалал, соёлын хэм хэмжээнд шинэ хэв маяг бүрэлдэн тогтож байгаа нь нийгмийн хөгжлийн чиг хандлагад нөлөөлсөн гэж үзэж болно. Энэ үйл явц нь дэлхий нийтийн оюуны болон эд өлгийн соёлтой танилцах, уламжлан авч баяжуулах, үндэсний зан заншилд тулгуурлан хөгжүүлэх боломжийг нээсэн. Гэхдээ иргэний нийгэм төлөвшиж хөгжих нь олон хүчин зүйлээс хамааралтай бөгөөд энд хоёр зүйлийн нөлөөлөл өнөө үед манай нийгэмд чухал буйг онцлон дурьдъя:

**Нэгдүгээрт.** Иргэд хоорондын болон төр иргэний хоорондын харилцааны бүх талыг хуульчлах, хуулийн өмнө тэгш эрхтэй байх зарчмыг тууштай хэрэгжүүлэх;

**Хоёрдугаарт.** Нийгмийг ардчилах үйл явц явагдаж буй нөхцөлд гаргасан шийдвэрийнхээ төлөө нийгмийн гишүүн бүрийн хүлээх хариуцлага нэмэгдэж, тэдэнд иргэний ухамсар, соёл төлөвшүүлэх шаардлага, ач холбогдол улам бүр өсч байна.

Иргэний соёлгүйгээр иргэн хүний тухай, иргэний нийгмийн тухай ярихад төвөгтэй бөгөөд “иргэний соёл” нь “улс төрийн соёлоос” өргөн ойлголт хийгээд иргэн хүн нийгмийн тулгамдсан асуудал, нийгмийн ач холбогдолтой зорилтуудыг хэр зэрэг ухамсарлан ойлгож, түүнийг хэрэгжүүлэхийн тулд хэр зэрэг идэвхтэй үйл ажиллагаа явуулж буйг илэрхийлнэ. Түүнээс гадна бидний туулж өнгөрсөн нийгмийн баялгийг тэгшитгэх механизм бүхий социализм нь нийгмийн бэлэнчлэх сэтгэлгээг бий болгож хүнийг эрх мэдэл, өмчөөс хүнийссэн байдалд дасгасан учраас хүн өөрийнхөө хувь заяаг хариуцан шударга өрсөлдөөний нөхцөлд бие даан амьдрах зүй тогтол бүхий зах зээлийн нийгмийн харилцаанд сөрөг байдлаар хандаж байгаа нь манай улсад иргэний нийгэм төлөвшихөд тодорхой хэмжээнд саад болж байна.

Өнөөдрийн байдлаар иргэний нийгмийн хөгжил

төлөвшлийн талаар онолын хүрээнд анализ хийж байснаас биш шинжлэх ухааны тодорхой судалгааг саяхнаас явуулж эхлээд байна. Монголын социологич, нийгмийн сэтгэл зүйч залуучуудын “Аслис” холбооноос 2002 онд төрийн бус байгууллагын гишүүд, дэмжигчдийн дунд социологийн судалгаа явуулжээ. Энэхүү социологийн судалгаанд 163 төрийн бус байгууллагын 3230 гишүүд, дэмжигчид хамрагдсан байна. Судалгаанд оролцогчдоос төрийн бус байгууллагын өмнө тулгамдаж буй бэрхшээлийг асуухад *давхардсан тоогоор* тэдний 52.4% нь “Хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр олдохгүй байх”, 28.1% нь “Төр засгийн дэмжлэг тусалцаа байхгүй”, 22.1% нь “Ажлын орчин муу, байр сууцны түрээс өндөр байх”, 19.5% нь “Гишүүдийн нийгмийн идэвх, оролцоо сул”, 19.3% нь “техник тоног төхөөрөмжийн шинэчлэл муу”, 19.1% нь “Бусад төрийн бус байгууллагатай хамтран ажиллах нөхцөл бололцоо бүрэлдэхгүй байх”, 17.7% нь “Төрийн бус байгууллагын тухай хууль” бодит байдалтай нийцэхгүй байх”, 11.3% нь “Манай байгууллагын удирдлагын бодлого, үйл ажиллагааны үр дүн бодитой биш”, 10.5% нь “Ажиллах боловсон хүчний олдоц ховор байх”, 0.3% нь “Дээрх бүх зовлон бэрхшээл бүгд байдаг” гэж тус тус хариулжээ.

Дээр дүнгээс үзэхэд өнөөгийн төрийн бус байгууллагуудад нийтлэг тохиолддог хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр (52.4%) болон төр засгийн зүгээс төрийн бус байгууллагуудад үзүүлж буй дэмжлэг тусалцааны хомсдол (28.1%) зэрэг саад бэрхшээл эхний байрт орж байна. Өнөөдөр төрийн бус байгууллагуудад хөрөнгө санхүүгийн бэрхшээл тулгарч байгаа нь тогтвортой тасралтгүй үйл ажиллагаа явуулах боломж нөхцлийг хязгаарлахад хүргэдэг. Мөн судалгаанд оролцогчид төр засгийн зүгээс тодорхой дэмжлэг тусалцаа авч чадахгүй байна гэж дүгнэсэн нь монголын нийгэмд “төр – төрийн бус байгууллага – иргэд” гэсэн гурвалсан харилцаа холбоо хараахан төлөвшиж амжаагүй байгаагийн нэг илрэл юм. Үүний зэрэгцээ төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаагаа явуулах хууль эрх зүйн орчинг шинэчилж боловсронгуй болгох (17.7%) шаардлагатай байгааг судалгаанд оролцогчид дүгнэн үзсэн байна [3.12].

Орчин үеийн хөгжингүй иргэний нийгмийн шинж

чанарыг тодорхойлогч “нийгмийн капитал” “нийгмийн ой, санамж” “ардчилсан менталитет” гэсэн ухагдахуунуудыг шинжлэх ухааны эргэлтэнд оруулж ул суурьтай шинжлэн судлахын зэрэгцээ мөн сургалт, сурталчилгааны ажилд ч хүмүүсийн анхаарлыг хандуулах нь зүйтэй юм.

Нийгмийн ой санамжийн асуудал посткоммунист орон болох манай орны хувьд анхаарал татсан асуудал юм. Манай нийгмийн санах байгууламж, ой ихээхэн багтаамж муутай, тоталитар тогтолцоо, захиргаадалт коммунизмын бүтэлгүй туршилтын тухай мэдлэг дулихан залуу үе өсч өндийж, “шар хэвлэл”, аль эсвэл ямар нэг улс төрийн хүчний хяналтанд байдаг хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарч буй нэг талыг хэт барьсан мэдээлэл зэрэг нь иргэний нийгмийн төлөвшилд сөргөөр нөлөөлж байна [4. 218].

Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж буй сонирхлын бүлэг төрийн бус байгууллагууд нь иргэд, төр хоёрыг хооронд нь холбох үүрэг гүйцэтгэдэг нэг гол гүүр болж байдаг. Сонирхлыг хэрэгжүүлэхийн тулд төрийн бус байгууллагууд нь парламент, засгийн газар зэрэг шийдвэр гаргах эрх бүхий байгууллагад хандан хүсэлт, шаардлага тавьдаг ба энэ нь ихэвчлэн хөтөлбөрийн шинжтэй баримт бичигт болон хуулинд оруулах тодорхой санал зэрэг хэлбэрээр илэрхийлэгддэг. Мөн шийдвэр гаргах эрх бүхий байгууллагад хандан шаардлагын агуулгыг танилцуулах, түүнийг хангах талаар холбогдох шийдвэр гаргах нь чухал болохыг үндэслэх, зарим тохиолдолд жагсаал цуглаан хийх, өлсгөлөн зарлах байдлаар илэрдэг [4.210].

Манай орны хувьд төрийн бус байгууллагын үйл ажиллагаа чөлөөтэй, төрөөс хараат бус явуулах эрх зүйн орчин үндсэндээ бүрдсэн боловч Улсын Их Хурал, эсвэл тодорхой нэг байнгын хорооны онцгой хурал дээр төрийн бус байгууллагын судалгааны тайлан, мэргэжилтэн, шинжээчдээс зөвлөмж, мэдээлэл авах, зэрэг төр, сонирхлын бүлэг хоорондын хамтран ажиллах чадвар, иргэний нийгмийн оролцоо төлөвшиж чадаагүй байна.

## **2. Цэрэг, иргэний харилцаа**

Монгол Улс олон улсын харилцааны шинэ уур

амьсгал, дэлхийн улс орнуудын цэргийн байгуулалт, цэргийн ажиллагааг явуулах арга хэлбэрт гарч буй зарчмын өөрчлөлтүүдэд нийцүүлэн Монгол Улсын батлан хамгаалах бодлогыг тодорхойлсон “Төрийн цэргийн бодлогын үндэс” тулгуур баримт бичгийг 1998 онд баталсан юм.

Цэрэг-Улс төрийн энэхүү баримт бичиг нь дэлхийн бүс нутгийн геополитикийн байдал олон улсын харилцааны нааштай өөрчлөлт, Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолтой уялдсан бөгөөд цэргийн бодлого, үйл ажиллагааны, тухайлбал “Монгол Улсын цэргийн байгуулалтын улс төрийн үндэс нь Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналт мөн”, “Монгол Улсын өөрийгөө хамгаалах зарчим нь орон нутгийн хамгаалалтанд үндэслэсэн батлан хамгаалах нэгдмэл тогтолцоонд тулгуурлана”, “Монгол Улс мэргэжлийн чиг баримжаатай Зэвсэгт хүчинтэй байна” [5] зэрэг зарчмын шинэ заалтуудыг өөртөө агуулж байгаагаараа чухал ач холбогдолтой юм.

Мөн “Монгол Улсын Үндэсний Аюулгүй Байдлын үзэл баримтлал” баримт бичигт “. . .Нийгэм-төрийн аюулгүй байдал гэж Монгол Улсын Үндсэн Хуулиар бататгасан төр, нийгэм-эдийн засгийн тогтолцоо, төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмууд, түүнчлэн хүний эрх, эрх чөлөө баталгаажсан байдлыг хэлнэ”, “. . . Иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал гэж бие хүн өөрийн хийгээд нийгэмд эх орон, ард түмнийхээ ашиг сонирхлын төлөө биеийн болон оюуны хүч чадавхиа бүрэн зориулах, олон улсын гэрээний дагуу хүний эрхийн асуудлаар Монгол Улсын хүлээсэн үүрэг хэрэгжих нөхцөл бүрдсэн байдлыг хэлнэ” [6] гэж заасан байдаг.

Дээрх эрх зүйн тулгуур баримт бичгүүд нь Зэвсэгт хүчнийг шинэчлэх, цэрэг, иргэний харилцааны зохистой орчинг бүрдүүлэх үндэслэл юм.

Цэрэг, иргэний харилцааг нэгтгэн холбож байдаг нэг гол шинж нь улс төрийн хувьд төрийн байгуулал, нийгмийн давхаргын хувьд ард түмэн, цэргийнхэн байдаг.

Цэргийнхнийг жирийн иргэдийн нийгмийн салшгүй нэг хэсэг, эх орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, халдашгүй дархан байдлыг гадны түрэмгийллээс сэргийлэн

хамгаалах гол хүчин гэж үздэг.

Монгол Улсын Зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд нийгмийн бүх давхаргын төлөөлөгчид багтдаг нь цэрэг, иргэний харилцааны суурь үнэлэмж болдог.

Цэрэг, иргэний зохистой харилцааг эрх зүй, эдийн засаг, нийгэм оюун санааны хүрээнд төлөвшүүлэхэд зөвхөн цэргийнхний төдийгүй монголын нийгмийн тулгамдсан зорилтуудын нэг болоод байна.

Өнөөгийн монголын нийгэм дэх цэрэг, иргэний харилцаа нь цэргийнхний улс төрийн эрх мэдэл бага, цэргийн мэргэжлийн мэдлэг өндөр байх хэлбэрийг агуулж байна.

Цэрэг, иргэний харилцааны онол, практикийн асуудлууд нь үйл ажиллагаа, практик амьдралын судалгааны шинэ, тулгамдсан асуудлууд байсаар байх ба судалгаа шинжилгээний ажлын төвшинг гүнзгийрүүлэх шаардлагтай байна.

Төр, Зэвсэгт хүчний үйл ажиллагааны талаарх мэдээллийг ил тод, нээлтэй болгож, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг нөхцлийг бүрдүүлэх, улс төрчид, төрийн удирдах албан тушаалтнуудын аюулгүй байдал, батлан хамгаалах боловсролыг системтэй нэмэгдүүлэх, цэрэг, иргэний харилцааны эрх ашгийн харилцан хамаарал, удирдлагыг сайжруулах, иргэд-цэргийнхний харилцааны нэр хүндийг бэхжүүлэх, нийгэм дэх Зэвсэгт хүчний нэр хүндийг өргөх, хүний эрх, эрх чөлөө, хувь хүний үнэлэмжийг цэргийн үйл ажиллагаатай уялдуулан эрх зүйн хүрээнд бодитойгоор авч үзэх асуудал тулгараад байна.

Монгол Улсын батлан хамгаалах салбарын хүрээнд хийгдсэн шинэчлэлийн хүрээнд цэрэг, иргэний харилцааны уламжлалт элементүүд болох Зэвсэгт хүчинд ардчилсан иргэний хяналт тавих, батлан хамгаалах бодлого, төсвийн үйл ажиллагааг хянах эрх зүйн орчинг бүрдүүлж, гүйцэтгэх болон хууль тогтоох байгууллага, Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штабын удирдлагын эрх мэдэл, үүрэг хариуцлагыг хуваарилсан нь цэрэг, иргэний харилцаа



зохистой төлөвших үндэс болсон гэж үзэж болно. Мөн дээрх шинэчлэлийн хүрээнд Батлан хамгаалах яамны удирдлагыг иргэншүүлэх, үндэсний аюулгүй байдлын стратегитай уялдуулан Зэвсэгт хүчний мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа идэвхтэй явагдаж байна.

***Ардчилсан нийгмийн цэрэг, иргэний харилцааны нэг чухал асуудал нь аюулгүй байдал болон батлан хамгаалах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд “иргэний нийгмийн” оролцоог нэмэгдүүлэх явдал мөн [7-206].***

Социализмын үед манай улсад иргэний нийгмийг батлан хамгаалах үйл ажиллагаанд татан оролцуулах явдал байхгүй байсан гэж үзэж болно. Энэ шалтгааны улмаас батлан хамгаалах салбарыг шинэчлэх, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд “туршлага” дутаж байгаа тал бий. Гэхдээ Монгол Улсын цэрэг, иргэний харилцаанд иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд эерэгээр нөлөөлж буй хүчин зүйлс багагүй байгааг дурьдвал:

1. Монгол Улсын олон зууны турш уламжлагдан ирсэн Зэвсэгт хүчин-нийгэм хоёрын уламжлалт, түүхэн харилцааны тухай асуудал юм. Энэ асуудлаар уг бүтээлийн 1 дүгээр бүлэгт тодорхой дурьдагдсан.
2. “Монгол Улсын Үндсэн Хууль”, “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Төрийн цэргийн бодлогын үндэс”, “Батлан хамгаалах тухай хууль”, “Зэвсэгт хүчний тухай хууль”, “Төрийн бус байгууллагын тухай хууль” зэрэг тулгуур хууль, эрх зүйн баримт бичиг батлагдсан нь Монгол улсын аюулгүй байдал болон батлан хамгаалах үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцох боломж, эрх зүйн орчинг нэлээд өндөр хэмжээнд нээж өгсөн;
3. Батлан хамгаалах салбарын шинэчлэл нь улстөр болон нийгмийн сэтгэл зүйд ч эерэг уур амьсгалыг бүрдүүлсэн зэрэг юм.

Дээрхи нааштай хандлагуудын үндсэн дээр Зэвсэгт хүчинд хийгдэж буй шинэчлэлийн дараагийн алхам нь сайн засаглалыг бэхжүүлэх, ил тод байдлыг нэмэгдүүлэх, Зэвсэгт хүчний удирдлага, боловсон хүчнийг чадваржуулах, аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгдэж байна.

*Иргэний нийгэм аюулгүй байдал болон батлан хамгаалах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд идэвхтэй оролцооноор засгийн газрын хяналт, хариуцлагын хүрээг тэлж өргөждөг.*

2002 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдсан “Цэргийн байгуулалтыг 2005 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-т “Цэргийн байгуулалтыг 2005 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөрийн зорилго нь цэргийн шинэчлэлийг анги, салбарт хүргэж, Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналтыг бэхжүүлэн, чадварлаг Зэвсэгт хүчинтэй болох үндсэн нөхцлийг хангахад оршино” [8] гэж заасан байдаг. Энэ заалт нь ойрын хугацаанд цэрэг, иргэний харилцааны зохистой төлөвшлийг бэхжүүлэх асуудлыг төр засгийн зүгээс чухалчлан үзэж байгаагийн илрэл юм.

Хэдийгээр манай улсын хувьд цэрэг, иргэний харилцааг ардчилах үйл явц тодорхой хэмжээнд хэрэгжиж байгаа ч иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд дараахь хүчин зүйлүүд саад болсоор байна. Үүнд:

1. Аюулгүй байдал болон батлан хамгаалах асуудлаар эцсийн шийдвэр гаргагч байгууллагуудаас төрийн бус байгууллага болон судалгааны байгууллагуудтай нягт хамтран ажиллаж чадахгүй байгаа явдал юм. Энэ нь нэг талаас аюулгүй байдал болон батлан хамгаалах асуудлаар дагнан судалгаа явуулдаг төрийн бус байгууллага байхгүйтэй, нөгөө талаас төрийн бус байгууллага болон судалгааны байгууллагуудын батлан хамгаалах асуудлаар судалгаа шинжилгээний ажил явуулах сонирхлыг бий болгох, дэмжих асуудал хангалтгүй байгаатай холбоотой юм.
2. Батлан хамгаалах салбарын талаарх төрийн бус

байгууллагуудын мэдээллийн эх сурвалжийг боловсруулж бодлого, шийдвэр гаргахдаа тусгахад иргэний нийгмийн оролцоо сул;

3. Мэдээллийн хэрэгсэл, албан болон албан бус уулзалт, судалгаа шинжилгээний үр дүнг ашиглах замаар аюулгүй байдлын гол асуудлаар олон нийтийн дунд мэтгэлцээн, хэлэлцүүлэг зохион байгуулах, аюулгүй байдал болон батлан хамгаалах үйл ажиллагаанд төрийн бус байгууллагуудаас хэрэгжүүлэх хяналтын тогтолцоо бүрдээгүй;
4. Аюулгүй байдал болон батлан хамгаалах асуудлаар шийдвэр гаргахдаа олон нийтийн санал бодлыг тусгах, тэдний дэмжлэг хүлээх явдлыг төдийлэн чухалчлан үзэхгүй байгаа;
5. Батлан хамгаалах асуудлаар мэргэшсэн энгийн боловсон хүчин болон шинжээчид дутагдалтай байгаа;
6. Батлан хамгаалах салбарын үйл ажиллагааны үр дүн, төсөв зарцуулалтын талаар “иргэний нийгэм” хяналт тавих механизм төдийлэн бүрэлдэж, төлөвшиж чадаагүй байгаа зэрэг болно.

Иргэний нийгэм нь аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого үйл ажиллагааг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцоход ямар нэгэн бэрхшээлтэй байгаа тохиолдолд цэрэг, иргэний зохисгүй харилцаа бий болж, сайн засаглал бэхжихгүй шинэчлэл удаашрах болно. Тийм учраас юун түрүүнд аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, сургалт судалгааны ажлын өнөөгийн төвшинг шинэ агуулга хэлбэрээр баяжуулж, төр, засгийн болон иргэний нийгмийн зүгээс санхүү хөрөнгийн төдийгүй эрх зүй, удирдлага зохион байгуулалтын өргөн дэмжлэгийг бий болгох шаардлагатай байна.

**АШИГЛАСАН НОМ, БҮТЭЭЛ, СУРВАЛЖ  
СУДАЛГААНЫ ЗОХИОЛ**

1. “Монгол Улсын Үндсэн Хууль” УБ., 1992. -104х
2. “Төрийн бус байгууллагын тухай хууль” УБ., 1997
3. Монголын социологич, нийгмийн сэтгэл зүйч залуучуудын “Аслис” холбоо. “Төрийн бус байгууллагын төлөвшлийн асуудал” сэдэвт судалгааны тайлан. УБ., 2002-154 х
4. Б. Дэлгэрмаа “Улс төр судлал”. УБ., 2000. -221х
5. “Төрийн цэргийн бодлогын үндэс” УБ., 1998
6. “Монголын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал”. УБ., 1994
7. “Цэрэг, иргэний харилцааны онол, практикийн тулгамдсан асуудал” эмхтгэл. УБ. , 2002. -224 х
8. “Цэргийн байгуулалтыг 2005 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”. УБ., 2002.

## ГАРЧИГ

Өмнөх үг.....	3
<b>Нэгдүгээр бүлэг.</b> Монголын цэрэг-иргэний харилцааны түүхэн уламжлал.....	5
<b>Хоёрдугаар бүлэг.</b> Монгол Улсын Зэвсэгт хүчний шинэчлэлийн явц, түүний хөгжлийн чиг хандлага.....	29
<b>Гуравдугаар бүлэг.</b> Монголын цэрэг, иргэний харилцааны эрх зүйн орчны бүрдэлт.....	52
<b>Дөрөвдүгээр бүлэг.</b> Зэвсэгт хүчинд иргэний хяналтыг хэрэгжүүлэхэд улс төрийн субъектүүдийн үүрэг оролцоо.....	79
<b>Тавдугаар бүлэг.</b> Монгол Улс, иргэдийн аюулгүй байдлын орчин.....	116
<b>Зургаадугаар бүлэг.</b> Батлан хамгаалах салбарын гадаад харилцаа, энхийг сахиулах ажиллагаа.....	183
<b>Долоодугаар бүлэг.</b> Иргэний нийгмийн төлөвшил, цэрэг, иргэний харилцаа .....	220